



**Хууль зүй, дотоод
хэргийн яам**



**“Шүүх, эрх зүйн
шинэчлэлт” төсөл**

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ

Гарын авлага

Зөвлөх:

С.Нарангэрэл (*Академич, ScD*)

Боловсруулсан:

Г.Эрдэнэбат (*LLM*)

*Энэхүү гарын авлагыг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хэрэгжүүлж
буй Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн хүрээнд
боловсруулав.*

**Улаанбаатар
2007**

DDC
345.052
Э-739

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ

Гарын авлага

Хөтөлбөр боловсруулсан:

Зөвлөх: С.Нарангэрэл (*Академич, ScD*)

Багийн гишүүд:

Ц.Дарьжав (*Отгонтэнгэр ИС-ийн ХЗС-ийн багш, магистр*)

Ц.Цэлмэг (*Шихихутуг ХЗДС-ийн багш, доктрант*)

Гарын авлага боловсруулсан баг:

Зөвлөх: С.Нарангэрэл (*Академич, ScD*)

Боловсруулсан: Г.Эрдэнэбат (*LLM*)

Хэвлэлийн хэмжээ: 15,6

Номын хэмжээ: В5

Хэвлэсэн газар: “BCI” Хэвлэлийн компани

ISBN: 978-99929-56-26-7



“ШҮҮХ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛТ” ТӨСЛИЙН ТУХАЙ

Хууль зүйн сургуулийн багш, оюутнуудад



*“Шүүх, эрх зүйн шинэчлэлт”
төслийн зохицуулагч
Д.ОЮУНЧИМЭГ*

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төсөл 2002 оноос хэрэгжээд дуусах шатандаа орж байна.

Энэ төслийн хүрээнд эрх зүйн дээд боловсролыг чанаржуулах чиглэлээр эхний шатны зарим ажлыг хийж дуусгалаа. Эдгээр ажлын үр дүн нь таны гар дээр очиж буй энэ гарын авлага юм. Бид энэ ажлыг зохион байгуулахдаа гадаадын зөвлөх гэхээсээ монголчууд бидний оюун ухаанд тулгуурлаж, дотоодын эрдэмтэн, багш нараар хийлгэсэн юм. Энэ номыг бүтээхэд хууль зүйн сургуулиудаас нэр хүндтэй, туршлагатай ахмад багш, нөгөө талаар идэвхтэй, санаачлагатай, хийж бүтээе, өөрийгөө боловсруулъя гэсэн эрмэлзэлтэй залуу багш нарыг баг болгон оролцуулсан юм. Энэ гарын авлагыг бүтээх явцад багш нар хамтран ажиллаж, бие биенээсээ харилцан суралцаж, цаашид судалгаа шинжилгээний ажил, эрх зүйн сургалтын шинэчлэлтийг хамтран хийхэд үр дүнд хүрнэ гэдгийг харуулсан болно.

Оюутанд зориулсан цогц гарын авлага (хичээлийн хөтөлбөр, тойм лекц) нь Монголд анх удаагаа гарч байгаа билээ. Оюутны гарын авлага нь тэдний судалж буй хичээлд хандах хандлагыг өөрчилж, “бэлэнчлэх” сэтгэлгээнээс ангижруулахад хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.

Төсөл бол тодорхой хугацаанд хэрэгжээд дуусдаг жамтай. Харин төсөл хэрэгжүүлэх явцад танилцсан, хамтарч ажилласан багш нар цаашдаа өөрсдийгөө боловсруулах, сургалтынхаа арга барил, чанарыг сайжруулах чиглэлээр хийж эхэлсэн ажлаа үргэлжлүүлнэ гэдэгт найдаж байна. Хичээлийн хөтөлбөр, оюутны гарын авлага бүтээхэд оролцсон 100 орчим эрдэмтэн, багш нар болон энэ ажлыг гардан зохион байгуулж, уялдаа холбоог нь хангах талаар идэвх зүтгэлтэй ажилласан төслийн ажилтан Б.Сарантуяад талархал илэрхийлье.

Үр дүнд чиглэсэн сургалтын хөтөлбөр



*“Шүүх, эрх зүйн шинэчлэлт”
төслийн зөвлөх
У.ТУУЯА*

Оюутан залуус та бүхэнд их мэдлэгийг хуримтлуулах нь чухал уу, харин уг мэдлэгээ ашиглах чадвар, мэргэжлийн үнэт зүйлсийг эзэмших нь чухал уу. Аль замыг чухал гэж сонгосноос таны суралцах арга барил, цаашлаад сургалтад хандах хандлага тань тодорхойлогддог байна. Сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулахад ч энэ хоёр талаас авч үзэх хэрэгтэй болдог.

Бид 2003 оноос Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн “Хууль зүйн бакалаврын боловсролыг сайжруулах” дэд төслийн хүрээнд энэхүү сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсруулахдаа дараах шаардлагыг харгалзсан бөгөөд оюутан таныг ч энэ тухай мэдэж сургалтын хөтөлбөр, гарын авлагаа ашиглахыг зөвлөж байна. Үүнд:

- ❖ Оюутан ямар зорилгоор уг хичээлийг судалж, ямар үр дүнд хүрэхээ мэдэж байх ёстой.
- ❖ Мэргэжлийн мэдлэг нь мэргэжлийн ур чадвар болон хөгжиж, үнэт зүйл болон төлөвшсөн байх нь чухал. Иймээс мэдээлэл болгоныг боловсруулах бие даалтын ажил оюутанд хэрэгтэй.

Гарын авлага боловсруулсан багийн гишүүд



Содовсүрэнгийн Нарангэрэл

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, Шинжлэх ухааны Академийн жинхэнэ гишүүн, академич. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал.

Академич С.Нарангэрэл зөвхөн 2001 оноос хойш "Монголын ба Дэлхийн эрх зүйн тогтолцоо" Улаанбаатар, 2001. 450 хуудас., "Амьд эрх зүй" Улаанбаатар, 2002. 230 хуудас., "Монгол Улсын эрх зүйн тогтолцооны удиртгал" Улаанбаатар, 2003.180 хуудас., "Правовая система Монголий" Москва, 2004, стр 190., "Legal system of Mongolia" Nagoya University, 2004, p 240., "Хууль зүй судлалын Англи-Монгол тайлбар толь", Улаанбаатар, 2005. 980 хуудас., "Эрх зүйн эх толь бичиг" Улаанбаатар, 2007. 690 хуудас зэрэг бүтээл туурвижээ. Профессор С.Нарангэрэлийн зарим бүтээл мөн герман, хятад хэл дээр хэвлэгдсэн.



Ганбатын Эрдэнэбат

Хууль зүйн магистр. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн эрүүгийн эрх зүйн тэнхмийн ахлах багш. Эрүүгийн эрх зүй, Криминологи, Криминал сэтгэл зүй, Харьцуулсан эрүүгийн эрх зүйн чиглэлээр судалгааны ажил эрхэлдэг.

Г.Эрдэнэбат нь Эрүүгийн эрх зүйн чиглэлээр сүүлийн жилүүдэд "Эрүүгийн эрх зүйн удиртгал". УБ. 2004. 240 хуудас., Гэмт хэргийн тулгуур ойлголт. УБ. 2005 150 хуудас, Шүүх шинжилгээ. УБ. 2006 240 хуудас., Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг. УБ. 2007 102 хуудас., Чезаре Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай (орчуулга) УБ. 2007. 80 хуудас зэрэг бүтээл гаргасан.

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн эрүүгийн эрх зүйн тэнхмийн ахлах багш Г.Эрдэнэбат эрүүгийн эрх зүй суралцагчдад нэн хэрэгтэй гарын авлага боловсруулжээ. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн үндсэн ухагдахууны талаархи лекцийг товч тодорхой, үлдэцтэй ойлгохоор бичсэн байна. Зохиогч ойлгомжтой болгох үүднээс бүдүүвч, схем үйлджээ. Онолын ба хуулийн тухай мэдлэгийг батжуулах зорилгоор хяналтын асуулт, тест, кейс, эх сурвалж зэргийг сэдэв бүрт оруулсан байна.

Уг гарын авлагыг Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн “Эрх зүйн боловсролыг сайжруулах дэд төсөл”-ийн хүрээнд хийгдсэн “Эрүүгийн эрх зүй-1” хөтөлбөрийн дагуу боловсруулжээ. Учир иймд гарын авлагыг ашиглахын өмнө нь хөтөлбөрийг сайтар судалж бүлэг, сэдэв бүрийн зорилт, эзэмших мэдлэг, чадвар, хандлагынхаа талаар урьдчилан мэдвэл зохилтой. Мөн та эл гарын авлагыг ашиглахдаа хөтөлбөрийн хэсэгт дурдсан эх сурвалжуудыг заавал судлаарай. Ингэснээрээ та тухайн сэдвийн талаар аль болох бүрэн дүүрэн мэдээлэл олж авах боломжтой болох юм.

Онолын мэдлэг, дасгал хэсгийн сэдэв бүрийн ард тавигдсан хяналтын асуулт, даалгавар, сорил зэргийг оюутан бие даан гүйцэтгэх ёстой. Эдгээр нь оюутныг сэдвээ гүнзгийрүүлэн судлахад туслах ёстой юм.

Мөн хэсэгт буй дасгал хичээл нь оюутан амьдрал дээр тохиолдох хэргийг хичээлээр олсон онолын мэдлэгээ ашиглан бие даан шийдвэрлэх чадвар эзэмшихэд зориулагдсан. Тийм ч учраас дасгал хичээлээр зөвхөн ямар нэгэн хэргийн нөхцлийг дурдаад орхисон буй. Та дасгалын өгөгдөлтэй танилцаад судалж буй сэдэвтэйгээ холбогдуулан шийдвэрлэх асуудлаа бие даан тодорхойлж, дүгнэлт гарган ажиллах шаардлага гарна.

Эл гарын авлага нь өмнө хэвлэгдсэн эрүүгийн эрх зүйн сурах бичиг, гарын авлагаас иж бүрдэл бүхий болсоноороо шинэлэг болжээ. Энэ гарын авлага Монгол Улсын эрүүгийн эрх зүйн сургалтад үр өгөөжөө өгнө гэдэгт итгэлтэй байна.

Акадегич С.Нарангэрэл

ГАРЧИГ

НЭГ. “ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ - 1” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

Тодорхойлолт	7
Төлөвлөгөө	7
Агуулга	11
Заах арга зүй	28
Үнэлгээ	39

ХОЁР. ОНОЛЫН МЭДЛЭГ, ДАСГАЛ

I бүлэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	44
Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан, эрүүгийн эрх зүйн зорилт, хамгаалах зүйл, тогтолцоо	44
Эрүүгийн эрх зүйн зарчим	48
Монгол улсын Эрүүгийн хууль	55
II бүлэг. ГЭМТ ХЭРЭГ	62
Гэмт хэргийн ойлголт, шинж, ангилал	62
Гэмт хэргийн бүрэлдүүн	68
Гэмт хэргийн бүрэлдүүний объект	73
Гэмт хэргийн бүрэлдүүний объектив тал	75
Гэмт хэргийн бүрэлдүүний субъектив тал	84
Гэмт хэргийн бүрэлдүүний субъект	91
Гэмт хэрэг үйлдэх үе шат	97
Гэмт хэрэгт хамтран оролцох	101
Олонлог гэмт хэрэг	107
Гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдал	112
III бүлэг. ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА	121
Эрүүгийн хариуцлагын ойлголт, төрөл, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл	121
Ялын зорилго, тогтолцоо	123
Ял ногдуулах	132
Эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ	144
Эрүүгийн хариуцлага болон ялаас чөлөөлөх	148



НЭГ “ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ - 1” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн Эрх зүйн боловсролыг сайжруулах дэд төсөл. “Эрүүгийн эрх зүй-1” хичээлийн хөтөлбөр боловсруулах ажлын баг.

ТОДОРХОЙЛОЛТ

Хичээлийн танилцуулга

Эрүүгийн эрх зүй нь Монгол Улсын тусгаар тогтнол, төрийн бүрэн эрхт болон үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам, энхтайван, хүн төрөлхтөний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах зорилготой ба гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлсон эрх зүйн тогтолцоонд чухал үүрэг гүйцэтгэдэг салбар эрх зүй мөн.

Эрүүгийн эрх зүй нь хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх чухал арга хэрэгсэл учраас иргэнийг гэмт хэрэг үйлдэхээс болон хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, иргэн нь гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, хууль ёсны эрх ашиг, сонирхлоо хамгаалуулахын тулд Эрүүгийн хуулийг судлан зохих мэдлэгийг эзэмшсэн байх шаардлагатай.

“Эрүүгийн эрх зүй-1” хичээл нь эрх зүйч мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж буй хууль зүйн их, дээд сургуулиудын сонсогч, оюутнуудын хувьд заавал судлах мэргэжлийн суурь хичээл бөгөөд энэ хичээлийг судлахгүйгээр гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч зэрэг албан тушаалтан болон өмгөөлөгч нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй юм.

Эрүүгийн эрх зүй нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүсч буй нийгмийн харилцааг зохицуулах эрх зүйн үндсийг тодорхойлдог материаллаг эрх зүй тул тухайн хичээлийг судалснаар процессын эрх зүй болох Эрүүгийн Байцаан Шийтгэх Эрх Зүй, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Эрх Зүйн хичээлийг судлах, нөхцөл бүрдэнэ. Эрүүгийн эрх зүй-1 хичээлийг судалсанаар оюутнууд суралцаж буй мэргэжлээрээ бахархах, хуульч мэргэжлийн үүрэг, хариуцлагаа ухамсарлах, хууль зүйн аливаа асуудалд хүмүүнлэг, энэрэнгүй зарчмын үүднээс хандах хандлага төлөвших юм.

Хичээлийн зорилго

Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн ерөнхий ангийн онолын үндсэн асуудал болох гэмт хэрэг, эрүүгийн хариуцлага түүний төрөл, хэмжээний талаар суурь мэдлэгийг олгох, олж авсан онолын мэдлэгээ ашиглан амьдралд үйлдэгдсэн тодорхой хэрэгт Эрүүгийн эрх зүйн үүднээс зөв үнэлэлт, дүгнэлт өгөх, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариулагын үндэслэлийг зөв тогтоох, гэмт хэргийг зөв зүйлчлэх, эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг зөв хэрэглэх, ял ногдуулах, эрүүгийн хариуцлага ба ялаас чөлөөлөх ажиллагааг хуулийн дагуу, зөв хэрэгжүүлэх, хууль зүйн үндэслэлтэй шийдвэр гаргах дадал, чадвар олгох, хандлагыг төлөвшүүлэхэд оршино.

Хичээлийн зорилт

- Эрх зүйн тогтолцоонд Эрүүгийн эрх зүйн эзлэх байр суурь, гүйцэтгэх үүргийг тодорхойлох
- Эрүүгийн эрх зүйн ойлголт, мөн чанар, шинж, зохицуулах зүйл болон хамгаалах зүйл, зохицуулалтын арга ба тогтолцоо, бусад эрх зүйн салбаруудаас ялгагдах болон төсөөтэй талыг тодорхойлох
- Монгол Улсын төрөөс баримтлах “Эрүүгийн бодлого” түүнийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох
- Эрүүгийн эрх зүйн түүхэн хөгжилт, түүний үе шат онцлогийг судлах, эрүүгийн эрх зүйн асуудлыг уламжлал, шинэчлэлийн хүрээнд авч үзэх
- Эрүүгийн хууль тогтоомж, түүний зорилт, зарчим, эрүүгийн хуулийн тогтолцоо, эрүүгийн хуулийн үйлчлэл, хэмжээ хязгаар, эрүүгийн хуулийн хэм хэмжээний бүтэц, төрөл, онцлогын талаар мэдлэгийг эзэмшүүлэх
- Гэмт хэргийн ойлголт, шинж, ангилал, төрөл болон гэмт хэрэгтэй холбоотой бусад эрүүгийн зүйн институтууд /гэмт хэрэг үйлдэх үе шат, гэмт хэрэгт хамтран оролцох, гэмт хэргийн олонлог, гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдлууд г.м/-ын талаар онолын мэдлэг эзэмшүүлэх
- Эрүүгийн хариуцлага, түүний ойлголт, мөн чанар, зорилго, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээ болон ял ногдуулах, эрүүгийн хариуцлага ба ялаас чөлөөлөх үндэслэл, журмыг судлах
- Амьдралд үйлдэгдсэн тодорхой хэрэг явдалд Эрүүгийн эрх зүйн ерөнхий ангийн үүднээс үнэлэлт, дүгнэлт өгөх, улмаар хууль зүйн үндэстэй зөв шийдвэр гаргах дадал, чадвар эзэмшүүлэхэд оршино.

Залгамж холбоо

“Эрүүгийн эрх зүй-1” хичээлийг судлахын өмнө Эрх зүйн онол, Төрийн онол, Төр хууль цаазны түүх, Үндсэн хуулийн эрх зүй, Гүн ухаан, Логик, Эрх зүйн философи зэрэг хичээлүүдийг судалсан байхаас гадна Захиргааны эрх зүй, Иргэний эрх зүй зэрэг хичээлүүдтэй зэрэгцүүлэн судална.



ТӨЛӨВЛӨГӨӨ

No	Бүлгийн нэр	Лекцийн сэдэв	Цаг	Семинарын сэдэв	Цаг	Нийт цаг
1	Нийтлэг үндэслэл	Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан, хамгаалах зүйл, тогтолцоо	2			8
		Эрүүгийн эрх зүйн зарчим	2	Эрүүгийн эрх зүйн зарчим /Шударга ёс ба энэрэнгүй ёс/	2	
		Монгол улсын Эрүүгийн хууль	2			
2	Гэмт хэрэг	Гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж, ангилал	2	Гэмт хэрэг, гэмт хэргийн бүрэлдүүн	2	28
		Гэмт хэргийн бүрэлдүүний ойлголт, шинж, ангилал	2			
		Гэмт хэргийн бүрэлдүүний объект, халдлагын зүйл	2	Гэмт хэргийн бүрэлдүүний объектив шинж	2	
		Гэмт хэргийн бүрэлдүүний объектив тал	2			
		Гэмт хэргийн бүрэлдүүний субъект	2	Гэмт хэргийн бүрэлдүүний субъектив шинж	2	
		Гэмт хэргийн бүрэлдүүний субъектив тал	2			
		Гэмт хэрэг үйлдэх үе шат	2	Гэмт хэрэгтэй холбоотой бусад инситутууд	2	
		Гэмт хэрэгт хамтран оролцох	2			
		Гэмт хэргийн олонлог	2			
			Гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлууд.	2		

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

3	Эрүүгийн хариуцлага	Эрүүгийн хариуцлагын ойлголт, зорилго, үндэслэл, төрөл	2			20
		Ялын ойлголт, шинж, төрөл	2			
		Ял ногдуулах журам, зарчим	4		2	
		Эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ	2			
		Эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх	4		2	
	Нийт цаг		40		16	



АГУУЛГА

I. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.

Бүлгийн зорилго: Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны болон эрүүгийн эрх зүйн тогтолцоо, Эрүүгийн хуулийн талаар суурь мэдлэгтэй болж, Эрүүгийн хуулийн нийтлэг хэм хэмжээг хэрэглэх, эрүүгийн хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт үнэлэлт, дүгнэлт өгөх дадал, чадвар эзэмшинэ.

СЭДЭВ 1. ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН, ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОРИЛТ, ХАМГААЛАХ ЗҮЙЛ, ТОГТОЛЦОО

Сэдвийн зорилго:

Эрүүгийн эрх зүйн ойлголт, зохицуулах зүйл, зохицуулалтын арга, зорилт, тогтолцооны талаар системтэй мэдлэг олгох, эрх зүйн тогтолцоонд эрүүгийн эрх зүйн эзлэх байр суурь, эрх зүйн бусад салбаруудтай холбоотой болон ялгагдах онцлогыг тодорхойлох, эрүүгийн эрх зүйн нийгэм, улс төр, эрх зүйн мөн чанар, онцлогын талаар өөрийн үнэлэлт, дүгнэлт өгөх, гэмт хэрэгт Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны үүднээс дүгнэлт өгөх хандлага төлөвшүүлэхэд оршино.

Агуулга:

Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан: Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны үүсэл, түүний хөгжилт, үе шат, онцлог. Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны зорилго, ач холбогдол. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжил. Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны тулгамдсан асуудал, хөгжлийн хэтийн төлөв.

Эрүүгийн эрх зүй: Эрүүгийн эрх зүйн зорилт, хамгаалах зүйл, тогтолцоо. Эрүүгийн эрх зүйн бусад салбар эрх зүйгээс ялгагдах онцлог. Эрх зүйн тогтолцоонд Эрүүгийн эрх зүйн эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, ач холбогдол. Эрүүгийн эрх зүйн тогтолцооны ойлголт, ач холбогдол. Эрүүгийн эрх зүйн Ерөнхий ба Тусгай ангийн ойлголт, тэдгээрийн уялдаа холбоо. Эрүүгийн эрх зүй болон бусад салбар эрх зүйн харилцан хамаарал (эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, эрүүгийн гүйцэтгэлийн эрх зүй, захиргааны эрх зүй, иргэний эрх зүй). Эрүүгийн эрх зүй ба ёс суртахууны харилцан уялдаа.

Эх сурвалж:

1. Г.Совд. Монгол Улсын эрүүгийн цааз, онолын загвар, Монголын төр, эрх зүй. 1996. №2.
2. С.Нарангэрэл. “Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн чиг хандлага”. Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо (олон улсын симпозиум). УБ. 2000. 158 дахь тал.
3. Г.Совд. Эрүүгийн эрх зүйн оршил. Прокурорын ном. 2001. 273 дах тал.
4. Д.Дэмбэрэлцэрэн. Эрүүгийн хуулийн ерөнхий анги: гол гол өөрчлөлтүүд эдгээрийг хэрэглэх асуудлууд. Монголын төр, эрх зүй. 2002. №2. 49 дэх тал. “Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий анги: өөрчлөлт, шинэчлэлт” Төр, эрх зүйн хуудас-Эргэцүүлэл. №13. 227 дахь тал.

5. Т.Сэнгэдорж. Монголын хууль зүйн шинжлэх ухааны хөгжилд эрүүгийн эрх зүйч эрдэмтдийн оруулсан хувь нэмэр, судалгааны чиг хандлага. “Эрдэм судлал” Улаанбаатар эрдэм судлал коллеж., 2002.25 дахь тал
6. Г.Совд. “Эрүүгийн бодлого” /Шинэ толь/ сэтгүүл 1990 №3. 37-41 дахь тал.

СЭДЭВ 2. ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗАРЧИМ

Сэдвийн зорилго:

Эрүүгийн эрх зүйн зарчмуудын талаар болон эдгээр зарчмууд эрх зүйн хэм хэмжээнд хэрхэн тусгалаа олсоныг мэдэж, тодорхой хэрэг шийдвэрлэхэд Эрүүгийн эрх зүйн зарчмын үүднээс үнэлэлт, дүгнэлт өгөх чадвар эзэмшинэ.

Агуулга:

Эрүүгийн эрх зүйн зарчмын ойлголт, мөн чанар: Эрүүгийн эрх зүйн зарчим, түүний агуулга. Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг эдгээр зарчимд үндэслэн бүтээх шаардлага. Бусад салбар эрх зүйн зарчмуудаас ялгагдах шинж. Эрүүгийн эрх зүйн зарчмуудыг Эрүүгийн хуульд хуульчилсан байдал. Эрүүгийн эрх зүйн зарчим ба эрүүгийн эрх зүйн зорилтын харилцан уялдаа. Эрүүгийн эрх зүйн зорилтыг хэрэгжүүлэхэд эрүүгийн эрх зүйн зарчмын үүрэг.

Эрүүгийн эрх зүйн зарчмууд, тэдгээрийн илрэл, хэрэгжилт: Эрүүгийн эрх зүйн зарчмууд Ерөнхий ба Тусгай ангийн хэм хэмжээнд тусгагдсан байдал. Хэрэгжих онцлог. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болон эрүүгийн эрхийн зарчмуудын харилцан хамаарал.

Эх сурвалж:

1. БНМАУ-ын шүүхийн өөрчлөлт, шинэчлэлийн үндсэн чиглэл. УДШ-ийн БХ-ийн тогтоол. 1990. № 89.
2. Г.Совд. Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх (харьцуулсан эрх зүй) УБ.,1999.
3. С.Нарангэрэл. Р.Чойномд тулгасан ял. УБ., 1990.
4. Гейрхард Даннекер, Кристиан Ф. Штофферс. “ХБНГУ дахь эрүүгийн ба эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн сургалт-эрүүгийн эрх зүй” Төр, эрх зүйн хуудас-Эргэцүүлэл. №2.15 дахь тал.

СЭДЭВ 3. МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ.

Сэдвийн зорилго:

Эрүүгийн эрх зүйн эх сурвалж буюу Эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоо, Монгол Улсын Эрүүгийн хууль, түүний хэм хэмжээний бүтэц, ангилал, Эрүүгийн хуулийн үйлчлэх хэмжээ хязгаар, Эрүүгийн хуулийг тайлбарлах мэдлэгтэй болж, Эрүүгийн хуулийг зөв хэрэглэх, тайлбарлах чадвар эзэмшинэ.

Агуулга:

Эрүүгийн эрх зүйн эх сурвалж: Эрх зүйн эх сурвалжын ойлголт, төрлүүд. Эрүүгийн эрх зүйн эх сурвалжийн онцлог. Монгол Улсын Эрүүгийн хуулийн материаллаг эх сурвалжууд. Үндсэн хууль ба Олон улсын эрх зүйн хэм хэмжээнд Эрүүгийн хууль



үндэслэхийн учир холбогдол. Эрүүгийн эрх зүйн эх сурвалж болон Монгол Улсын Дээд Шүүхийн тайлбар.

Монгол Улсын Эрүүгийн хууль: Монгол улсын Эрүүгийн хуулийн ойлголт, үндсэн шинж, зорилт, тогтолцоо бусад хуулиудаас ялгагдах онцлог. Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хангах, төр, нийгмийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах, нийгмийн дэг журмыг хангах, хууль ёсыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд Эрүүгийн хуулийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдол.

Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ ба Эрүүгийн хуулийн зүйл, заалт: Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний ойлголт, ангилал. Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний бүтэц. Эрүүгийн хуулийн зүйл заалтад эрх зүйн хэм хэмжээг тусгах онцлог.

Эрүүгийн хууль үйлчлэх орон зай, хамаарах этгээд: Эрүүгийн хуулийн үйлчлэх орон зайн хэмжээ хязгаар, ойлголт, зарчмууд /Эрүүгийн хууль үйлчлэх нутаг дэвсгэрийн, иргэний харъяаллын болон түгээмэл ба бодит зарчим/. Эрүүгийн хууль Монгол улсын нутаг дэвсгэрт болон хилийн гадна үйлдэгдсэн гэмт хэрэгт үйлчлэх үндэслэл, журам онцлог. Гэмт этгээдийг шилжүүлэх эрх зүйн зохицуулалт, үндэслэл, журам.

Эрүүгийн хууль үйлчлэх цаг хугацаа: Монгол Улсын Эрүүгийн хуулийн үйлчлэх цаг хугацаа түүнийг хуульчилсан байдал. Эрүүгийн хууль үйлчилж эхлэх болон хуулийн хүчин чадал дуусгавар болох хугацаа, түүнийг тогтоох. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаа. Монгол Улсын Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх. Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх болон буцаан хэрэглэхгүй байх үндэслэл, журам, онцлог.

Эрүүгийн хуулийг тайлбар: Эрүүгийн хуулийг тайлбарлах тухай ойлголт, шаардлага. Эрүүгийн хуулийн тайлбарын ангилал, төрөл. Албан ёсны ба албан бус тайлбар. Эрүүгийн хуулийг тайлбарлахад баримтлах зарчмууд.

Эх сурвалж:

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948)
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966)
3. Дипломат харилцааны тухай “Венийн” конвенц (1961)
4. Консулын харилцааны тухай “Венийн” конвенц (1961)
5. Монгол улсаас бусад улсуудтай байгуулсан эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээнүүд. УБ хот. 2003 он.
6. Монгол Улсын хилийн тухай хууль ТМ-1993 он, №4-5
7. Харьяатын тухай хууль “Ардын эрх” сонин, 1995 он, № 139
8. Монгол Улсын Эрүүгийн шинэ хуулийг дагаж мөрдөх журмын тухай. УДШ-ийн БХ-ийн тогтоол. 2002. №264
9. Г.Совд. “Эрүүгийн хуулийн буцаж үйлчлэх журмын тухай асуудал” /Социалист хууль ёс/ сэтгүүл №2.22-26 дахь тал
10. Г.Совд “Хууль хэрэглэхэд шүүхийн тайлбарын ач холбогдол” /Шүүх эрх мэдэл-шинэ зуун/ эмхтгэл 150-154
11. С.Нарангэрэл. Р.Чойномд тулгасан ял. УБ., 1990.
12. Г.Совд. Улсын “Их Хурал хууль тайлбарлах уу”. Монголын төр, эрх зүй., 1998. №2. 29 дэх тал.
13. С.Жанцан. “Эрх зүйт төр-шинэ Эрүүгийн хууль” Эрэгцүүлэл 2002 .№13.
14. Ж.Эрдэнэбулган. гэмт хэрэгтэнийг шилжүүлэх эрүүгийн эрх зүйн зохицуулалт. Эрх зүй. №2-3., УБ., 2000.89 дэх тал

II. ГЭМТХЭРЭГ.

Бүлгийн зорилго: Гэмт хэрэг, түүнтэй холбоотой институтүүдийн /гэмт хэрэг үйлдэх үе шат, гэмт хэрэгт хамтран оролцох, олонлог гэмт хэрэг г.м/ талаар онолын мэдлэг олох, эрүүгийн хэргийг зүйлчлэхэд гэмт хэргийн нийтлэг үндэслэлийг зөв хэрэглэх дадал, чадвар эзэмших, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдлийг зөв зүйлчлэх хандлагатай болох.

СЭДЭВ 1. ГЭМТ ХЭРГИЙН ОЙЛГОЛТ, ҮНДСЭН ШИНЖ, АНГИЛАЛ

Сэдвийн зорилго:

Гэмт хэргийн ойлголт, түүний мөн чанар, үндсэн шинж, ангилалын талаар болон гэмт хэрэгт тооцох, гэмт хэрэгт үл тооцох зүй тогтлыг мэдэж, хэрэг, тохиолдолд Эрүүгийн эрх зүйн үүднээс үнэлэлт дүгнэлт өгөх, гэмт хэрэг мөн эсэхийг зөв тогтоох, бусад эрх зүйн зөрчлөөс ялгах, гэмт хэргийн ангилалыг тодорхойлох чадвартай болно.

Агуулга:

Гэмт хэргийн ойлголт: Гэмт хэргийн тодорхойлолт. Гэмт хэрэгт тооцох болон гэмт хэрэгт үл тооцох үйл явцын тухай ойлголт. Гэмт хэргийг эрх зүйн бусад зөрчлийн ялгаа. Ялимгүй үйлдэл, эс үйлдэхүй, гэмт хэрэгт тооцохгүй байх үндэслэл.*Гэмт хэргийн шинж:* Гэмт хэргийн объектив ба субъектив шинж. Гэмт хэргийн объектив болон субъектив шинжийг Эрүүгийн хуульд тодорхойлсон байдал.

Гэмт хэргийн ангилал: Гэмт хэргийн ангилал, шалгуур. Эрүүгийн хуульд гэмт хэргийн ангилалыг хуульчилсан байдал. Гэмт хэргийг ангилахын хууль зүйн учир холбогдол.

Эх сурвалж:

1. Н.Жанцан. Криминологи. УБ., 2000.
2. Х.Тэмүүжин. Jus frast буюу ёст үг. “Криминаль шинжлэх ухаан болон гэмт хэрэг” УБ., 2000. 55 дахь тал.
3. С.Жанцан, М.Мөнхбаяр. Гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж” Монголын төр, эрх зүй., 1996. №1. 6 дахь тал.
4. Д.Ганзориг. Захиргааны эрх зүй. УБ., 2002. 58 дахь тал
5. Д.Батсайхан. Эрүүгийн шинэ хуулийн ерөнхий ангийн гол гол өөрчлөлт тэдгээрийг хэрэглэх асуудал. “Эрдэм судлал” Улаанбаатар эрдэм судлал коллеж., 2002.31дэхтал.
6. Г.Совд. “Гэмт хэргийн тухай” /Монголын төр, эрх зүй/ сэтгүүл №4. 28-36 дахь тал
7. С.Жанцан. “Гэмт хэрэг ба эрх зүйн ёс суртахууны шинжтэй зөрчил”. Монголын төр, эрх зүй. 1997. №4. 27 дахь тал.



СЭДЭВ 2. ГЭМТ ХЭРГИЙН БҮРЭЛДҮҮН

Сэдвийн зорилго:

Эрүүгийн харицлага хүлээлгэх үндэслэл болох гэмт хэргийн бүрэлдүүний талаар мэдлэг авч, тодорхой гэмт хэргийн бүрэлдүүнийг тодорхойлох, гэмт хэргийг бусад эрх зүйн зөрчлөөс ялгах чадвар эзэмшинэ.

Агуулга:

Гэмт хэргийн бүрэлдэхүүний ойлголт: Гэмтхэргийн бүрэлдүүн, түүнийг тодорхойлох шаардлага. Гэмт хэрэг ба гэмт хэргийн бүрэлдүүний хоорондын харьцаа.

Гэмт хэргийн бүрэлдүүний талууд: Гэмт хэргийн бүрэлдүүний талууд /объект, объектив тал, субъект, субъектив тал/.

Гэмт хэргийн бүрэлдүүний ангилал: Гэмт хэргийн үндсэн болон хөнгөрүүлэх, хүндрүүлэх бүрэлдүүн. Гэмт хэргийн бүрэлдүүний үндсэн болон нэмэгдэл шинж. Материаллаг ба хэлбэрийн бүрэлдүүнтэй гэмт хэрэг. Гэмт хэргийн бүрэлдүүнийг зөв тогтоох шаардлага.

Эх сурвалж:

1. С.Нарангэрэл. Гэмт хэрэг зүйлчлэх шинжлэх ухааны үндэс. УБ., 1988.
2. Б.Ганболд. Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх гэмт хэрэг зүйлчлэлийн онол. УБ., 2001.
3. Г.Гантөмөр. Гэмт хэргийн бүрэлдэхүүний онол. УБ., 2003. 6-33 тал.

СЭДЭВ 3. ГЭМТ ХЭРГИЙН БҮРЭЛДҮҮНИЙ ОБЪЕКТ

Сэдвийн зорилго:

Гэмт хэргийн бүрэлдүүний объектын талаархи онолын мэдлэгтэй болж, эрүүгийн хэргийг шийдвэрлэх явцад гэмт хэргийн үндсэн ба нэмэгдэл объект, халдлагын зүйлийг зөв тодорхойлох чадвартай болно.

Агуулга:

Гэмт хэргийн бүрэлдүүний объектын ойлголт: Гэмт хэргийн объектын ойлголт. Гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээ, шинж чанарыг тодорхойлоход гэмт хэргийн объектийн учир холбогдол.

Гэмт хэргийн объектийн төрөл: Гэмт хэргийн ерөнхий, төрлийн, шууд объект. Эрүүгийн хуулийн тусгай ангийн тогтолцоог бүрдүүлэхэд төрлийн объектийн ач холбогдол. Гэмт хэргийн үндсэн болон нэмэгдэл объектын учир холбогдол.

Гэмт хэргийн халдлагын зүйл ба хохирогч: Гэмт хэргийн халдлагын зүйл ба гэмт хэргийн объектын харилцан хамаарал. Гэмт хэргийн зүйлчлэлд халдлагын зүйлийн нөлөөлөл.

Эх сурвалж:

1. С.Нарангэрэл. Гэмт хэрэг зүйлчлэх шинжлэх ухааны үндэс. УБ., 1988.
2. Б.Ганболд. Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх гэмт хэрэг зүйлчлэлийн онол. УБ., 2001.
3. Г.Гантөмөр. Гэмт хэргийн бүрэлдүүний онол. УБ., 2003. 34-55 тал.

СЭДЭВ 4. ГЭМТ ХЭРГИЙН БҮРЭЛДҮҮНИЙ ОБЪЕКТИВ ТАЛ

Сэдвийн зорилго:

Гэмт хэргийн бүрэлдүүний объектив талын талаар мэдлэгтэй болж, тодорхой гэмт хэргийн объектив талын шинжийг тодорхойлох, түүнд үнэлэлт, дүгнэлт өгөх чадвар эзэмшинэ.

Агуулга:

Гэмт хэргийн бүрэлдүүний объектив талын ойлголт, шинж: Гэмт хэргийн объектив талын ойлголт түүний учир холбогдол. Объектив талын агуулга. Объектив талын шинж.

Гэмт үйлдэл, эс үйлдэхүй: Нийгэмд аюултай үйлдэл нь хэрэг хариуцах чадвартай хүний зан үйлийн гадаад шинж болох нь. Гэмт хэргийн бүрэлдүүний объектив талын үндсэн элемент болох үйлдэл, эс үйлдэхүйн ойлголт, үндсэн шинж. Гэмт үйлдэл, эс үйлдэхүйд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл. Гэмт үйлдлийн ойлголт, үндсэн шинж. Гэмт эс үйлдэхүйн ойлголт шинж, тэдгээрийн ялгаатай тал, илрэх хэлбэр, төрөл /нэг удаагийн үйлдэл, удааширсан, үргэлжилсэн, нэгдмэл, давтан үйлдэл, эс үйлдэхүйн ойлголт, шинж, тэдгээрийн ялгаа/.

Гэмт хор уршиг: Хор уршгийн ойлголт, төрөл. (материалаг болон материаллаг бус, үндсэн болон нэмэгдэл хор уршиг) Гэмт хэргийн ангилал болон бүрэлдүүнд хор уршгийн хэрхэн авч үзэх. Үнэлж хэрэглэх хор уршиг

Гэмт хэргийн шалтгаант холбоо: Үйлдэл, эс үйлдэхүй болон гэмт хор уршгын шалтгаант холбооны ойлголт түүний учир холбогдол. Гэмт хэргийн шалтгаант холбооны талаархи онолууд.

Гэмт хэргийн объектив талын нэтэгдэл шинж: Гэмт хэрэг үйлдсэн арга, цаг, газар, нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан зэвсэг, хэрэгсэл тэдгээрийн эрүүгийн эрх зүйн учир холбогдол.

Эх сурвалж:

1. Эрүүгийн хуулийн 32 дугаар зүйлийг нэг мөр ойлгон зөв хэрэглэх тухай” УДШ-ийн БХ-ын тогтоол. 1994. №30.
2. С.Нарангэрэл. Гэмт хэрэг зүйлчлэх шинжлэх ухааны үндэс. УБ., 1988.
3. Б.Ганболд. Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх гэмт хэрэг зүйлчлэлийн онол. УБ., 2001.
4. Г.Гантөмөр. Гэмт хэргийн бүрэлдэхүүний онол. УБ., 2003. 56-117 тал

СЭДЭВ 5. ГЭМТ ХЭРГИЙН БҮРЭЛДҮҮНИЙ СУБЪЕКТИВ ТАЛ

Сэдвийн зорилго:

Гэмт хэргийн бүрэлдүүний субъектив талыг мэдлэг олж, тодорхой хэрэгт субъектив талын шинжийг зөв тодорхойлох чадвар эзэмшинэ.

Агуулга:

Тодорхойлолт, шинж: Гэмт хэргийн бүрэлдүүний субъектив талын ойлголт, агуулга, Эрүүгийн эрх зүйн учир холбогдол. Түүний үндсэн болон нэмэгдэл шинж. Гэм буруугийн ойлголт.



Гэм буруугийн хэлбэр: Гэм буруугийн санаатай ба болгоомжгүй хэлбэр. Гэмт хэргийг зүйлчлэх, ял ногдуулахад түүний учир холбогдол.

Гэм буруугийн санаатай хэлбэр: Санаатай гэм буруугийн хүсэл зоригийн болон оюун санааны шалгуур. Санаатай гэм буруугийн төрөл: шууд ба шууд бус санаа, урьдаас төлөвлөсөн шууд санаа, гэнэт үүссэн санаа, тодорхой бус санаа, сонгох санаа.

Гэм буруугийн болгоомжгүй хэлбэр: Ойлголт төрөл. Хөнгөмсөгөөр найдах, түүний оюун санааны болон хүсэл зоригийн шалгуур. Хөнгөмсөгөөр найдах болон шууд бус санааны ялгаа. Хайхрамжгүй хандах, түүний объектив болон субъектив шалгуур. Хайхрамжгүй хандах болон хөнгөмсөгөөр найдах ба хор уршиг гэм буруугүйгээр учруулахын ялгаа.

Гэм буруугийн хоёр хэлбэр: Хоёр хэлбэр бүхий гэмт хэргийн бүрэлдүүний онцлог. Гэм буруугийн хоёр хэлбэрээр үйлдсэн гэмт хэрэгт ял ногдуулах онцлог.

Хор уршиг гэм буруугүйгээр (тохиолдол)учруулах: Тохиолдоог хайхрамжгүй хандахаас ялгах нь. Давагдашгүй хүчин зүйлийн эрүүгийн эрх зүйн учир холбогдол.

Гэмт хэргийн сэдэлт, зорилго: Гэмт хэргийн сэдэлт зорилгын ойлголт, тэдгээрийн мөн чанар, төсөөтэй болон ялгагдах онцлог, тодорхой гэмт хэргийн бүрэлдүүнд болон гэмт хэргийн зүйлчлэлд үзүүлэх нөлөө. Гэмт хэрэг үйлдсэн сэдэлт, зорилгыг зөв тогтоохын Эрүүгийн эрх зүйн учир холбогдол.

Гэм буруугийн андуурал: Гэм буруугийн андуурал түүний ойлголт, мөн чанар, Эрүүгийн эрх зүйн учир холбогдол, төрөл. Хууль цаазын болон бодит байдлын андуурлын ойлголт, шинж, төрөл. Гэм буруугийн андуурлын гэмт хэргийн зүйлчлэлд үзүүлэх нөлөө.

Эх сурвалж:

1. Г.Совд. БНМАУ-ын Эрүүгийн эрх зүй дэх гэм буруугийн асуудал. УБ., 1966.
2. С.Нарангэрэл. Гэмт хэрэг зүйлчлэх шинжлэх ухааны үндэс. УБ., 1988.
3. Б.Ганболд. Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх гэмт хэрэг зүйлчлэлийн онол. УБ., 2001.
4. Г.Гантөмөр. Гэмт хэргийн бүрэлдэхүүний онол. УБ. 2003
5. Б.Ганболд. Гэм буруугүйгээр хор уршиг учруулах. Монголын төр,эрх зүй. 2002.№4

СЭДЭВ 6. ГЭМТ ХЭРГИЙН БҮРЭЛДҮҮНИЙ СУБЪЕКТ

Сэдвийн зорилго:

Гэмт хэргийн бүрэлдүүний субъектийн талаар мэдлэгтэй болж, тодорхой гэмт хэргийн субъектын шинжийг зөв тодорхойлох чадвар эзэмшинэ.

Агуулга:

Гэмт хэргийн бүрэлдүүний субъектын ойлголт, шинж: Гэмт хэргийн бүрэлдүүний субъектын ойлголт, үндсэн шинж шалгуур. Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх зөвхөн хувь этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үзэл баримтлал. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх онолын асуудал. Хэрэг хариуцах чадвартай, тодорхой насанд хүрсэн бие хүн байх нь гэмт хэргийн бүрэлдүүний субъектыг тодорхойлох үндсэн шинж болох нь.

Хэрэг хариуцах чадвар: Хэрэг хариуцах чадварын ойлголт. Хэрэг хариуцах чадваргүй байдлын эмнэлэгийн болон хууль зүйн шалгуур. Хэрэг хариуцах чадваргүй этгээдээс үйлдсэн нийгэмд аюултай үйлдлийн хууль зүйн үр дагавар. Хэрэг хариуцах хязгаарлагдмал чадвар. Согтуурсан буюу мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцдага хүлээлгэх асуудал.

Эрүүгийн хариуцлага хүлээх нас: Гэмт хэргийн субъектын эрүүгийн хариуцлага хүлээх насны шалгуур. Тодорхой төрлийн зарим гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээх насыг хуульд тусгайлан заасан үндэслэл.

Гэмт хэргийн тусгай субъект: Тусгай субъектийн ойлголт, шинж. Тусгай субъектын нэмэгдэл шинжүүд, тэдгээрийн ангилал /иргэний харьяалал, албан тушаал, ажил мэргэжил, хүйс г.м/. Тусгай субъекттэй гэмт хэрэг түүнийг зөв тогтоож, зүйлчлэх асуудал

Онц аюултай гэмт хэрэгтэн: Онц аюултай гэмт хэрэгтний тухай ойлголт, шинж. Онц аюултай гэмт хэрэгтэн тусгай субъект болох нь. Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцох үндэслэл, журам. Онц аюултай гэмт хэрэгтэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх журам. Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсноос үүсэх эрх зүйн үр дагавар.

Эх сурвалж

1. “Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцох тухай” УДШ-ийн БХ-ийн тогтоол. 1987. №26
2. С.Нарангэрэл. Гэмт хэрэг зүйлчлэх шинжлэх ухааны үндэс. УБ., 1988.
3. С.Бямбасүрэн. Ш.Дорждамба. Шүүхийн сэтгэц гэм судлал. УБ., 1990.
4. Л. Эрдэнэбаяр. Шүүхийн сэтгэц гэм судлалын дадлагын хичээлийн гарын авлага. УБ., 2000.
5. Б.Ганболд. Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх гэмт хэрэг зүйлчлэлийн онол. УБ., 2001.
6. С.Жанцан. Рецидив гэмт хэрэгтэй хийх тэмцлийн эрүүгийн эрх зүйн асуудал. УБ., 1988
7. Г.Гантөмөр. Гэмт хэргийн бүрэлдэхүүний онол. УБ. 2003.118-177 тал
8. Рецидив гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тэмцэл. УБ., 1988
9. Г.Совд. “Онц аюултай рецидив гэмт хэрэгтэнд тооцох тухай” /Социалист хууль ёс/ сэтгүүл №3. 24-28 дахь тал
10. Г.Гантөмөр. “Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын асуудал” Гэмт явдалтай тэмцэх асуудал: онол, арга зүйн сэтгүүл. 2002. №1. 20 дахь тал.

СЭДЭВ 7. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭХ ҮЕ ШАТ

Сэдвийн зорилго:

Гэмт хэрэг үйлдэх үе шатны талаар болон гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзах тухай мэдлэг олж, үйлдэгдсэн гэмт хэргийн үе шатыг зөв тогтоох чадвар эзэмшинэ.

Агуулга:

Төгссөн гэмт хэрэг: Төгссөн гэмт хэргийн ойлголт. Тодорхой гэмт хэрэг төгссөнийг тодорхойлоход гэмт хэргийн бүрэлдүүний ангиллын ач холбогдол. Төгсөөгүй гэмт хэргийн ойлголт, төрөл. Төгссөн болон төгсөөгүй гэмт хэргийг



ялгах хууль зүйн учир холбогдол Төгсөөгүй гэмт хэргийн зүйлчлэл.

Төгсөөгүй гэмт хэрэг: Төгсөөгүй гэмт хэргийн ойлголт, шинж, төрөл. Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэх үе шатны ойлголт шинж, Эрүүгийн хуульд хуульчилсан байдал. Бэлтгэх үеийг гэмт санаа төрөхөөс ялгах нь. Бэлтгэх үйл ажиллагааны хэлбэрүүд. Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх онцлог. Гэмт хэрэг үйлдэхээр завдах үе шатны ойлголт, шинж, гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэх болон төгссөн гэмт хэргээс ялгагдах онцлог. Завдалтын үеийн объектив болон субъектив шинж. Завдалт ба бэлтгэлийн ялгаа. Төгссөн болон төгсөөгүй завдалтын шинжүүд. Төгссөн завдалт болон төгссөн гэмт хэргийн ялгаа. Ашиггүй завдалт, түүнд ногдуулах ял. Гэмт хэрэгт завдсанд хүлээлгэх эрүүгийн хариуцлага.

Гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзах: Гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзахын эрүүгийн эрх зүйн үр дагавар. Хэргээ илчлэн ирэхийг сайн дураараа татгалзахаас ялгах. Гэмт хэрэгт хамтран оролцогчид гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзах онцлог. Зохион байгуулагч, хатгагч, хамжигчийг гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзсаныг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл.

СЭДЭВ 8. ГЭМТ ХЭРЭГТ ХАМТРАН ОРОЛЦОХ

Сэдвийн зорилго:

Гэмт хэрэгт хамтран оролцохын объектив болон субъектив шинж, хамтран оролцохын төрөл, хэлбэрийн талаар онолын мэдлэгтэй болж, хамтран үйлдсэн гэмт хэргийг зөв шийдвэрлэх дадал чадвар эзэмшинэ.

Агуулга:

Тодорхойлолт: Гэмт хэрэгт хамтран оролцох ойлголт, түүний мөн чанар. Гэмт хэрэгт хамтран оролцохын объектив ба субъектив шинж, түүнийг зөв тогтоохын Эрүүгийн эрх зүйн учир холбогдол.

Гэмт хэрэгт хамтран оролцогчдын төрөл: Гэмт хэрэгт хамтран оролцогчдын төрлийг Эрүүгийн хуульд хуульчилсан байдал. /Захиалагч, зохион байгуулагч, гүйцэтгэгч, хатгагч, хамжигч/ тэдгээрт эрүүгийн хариуцлага хүлээлгэх журам, онцлог.

Гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэр: Гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэр, ангилах шалгуур. Гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэрийг Эрүүгийн хуульд хуульчилсан байдал. Бүлэглэн гүйцэтгэх, урьдчилсан үгсэн тохирсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлийн ойлголт, тэдгээрийн шинж, ялгагдах онцлог. Бүлэглэн гүйцэтгэх, урьдчилсан үгсэн тохирсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх /ял ногдуулах/ үндэслэл, журам, онцлог.

Гэмт хэрэгт хамаарагсад: Гэмт хэрэгт хамаарагсадын ойлголт, шинж, тэдгээрийн гэмт хэрэгт хамтран оролцогчдоос ялгагдах онцлог, төрөл, тэдгээрийг Эрүүгийн хуульд хуульчилсан байдал. Гэмт хэргийг үл мэдээлэх, нуун далдлах ойлголт шинж, тэдгээрт эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, журам, онцлог.

Эх сурвалж:

1. МУ-ын ЭХ-ийн 34,35,36,37-р зүйлийн заалтыг тайлбарлах тухай. УДШ-ийн БХ-ын тогтоол. 2003. №16.

2. “Эрүүгийн хуулийн 161-р зүйлийг практикт хэрэглэх тухай” УДШ-ийн БХ-ын тогтоол. 1994. №35.
3. С.Нарангэрэл. Зохион байгуулалттай гэмт явдал. УБ., 1991.
4. Н.Баатаржав. Гэмт хэрэгт хамаарагсад. УБ., 1968.
5. Н.Баатаржав. Гэмт хэрэгт хамаарагсадын ойлголтыг тодорхойлох эрх зүйн ач холбогдол. УБ., 1989.
6. С.Нарангэрэл. Зохион байгуулалттай бүлэг гэж юу вэ? Ардын эрх. 1993. 127/627/
7. Г.Эрдэнэбат. “Зохион байгуулалттай гэмт хэргийн зүйлчлэлийн асуудал”. Эрх зүй. №6-7., УБ., 2001.
8. Г.Эрдэнэбат. “Гэмт хэргийг захиалагчийн тухайд”. Эрх зүй. №8-9., УБ., 2002.
9. Т.Сүхбаатар. Гэмт хэрэг хамтран үйлдэх төрөл хэлбэр, зарим онцлог. “Эрдэм судлал” Улаанбаатар эрдэм судлал коллеж., 2002. 38 дахь тал.

СЭДЭВ 9. ОЛОНЛОГ ГЭМТ ХЭРЭГ

Сэдвийн зорилго:

Олонлог гэмт хэргийн суурь мэдлэгтэй болж, амьдралд үйлдэгдсэн гэмт хэрэгт олонлог гэмт хэргийн шинж, төрлийг зөв тогтоох, нэгдмэл гэмт хэргээс ялган зүйлчлэх чадвар эзэмшинэ.

Агуулга:

Нэгдмэл ба олонлог гэмт хэрэг: Олонлог гэмт хэргийн ойлголт. Олонлог гэмт хэргийн нийгмийн болон хууль зүйн шинж. Олонлог гэмт хэргийг нэгдмэл гэмт хэргээс (үргэлжилсэн, удааширсан, нэгдмэл гэмт хэрэг) ялгах нь. Олонлог гэмт хэргийн төрөл, тэдгээрийг Монгол Улсын Эрүүгийн хуульд хуульчилсан байдал.

Нийлмэл гэмт хэрэг: Нийлмэл гэмт хэргийн ойлголт, түүний шинж, олонлог гэмт хэргийн бусад төрлүүдээс болон нэгдмэл гэмт хэргээс ялгах онцлог. Нийлмэл гэмт хэргийн төрөл. Хэд хэдэн үйлдэлтэй болон нэг үйлдэлтэй нийлмэл гэмт хэрэг, тэдгээрийн ойлголт, шинж, ялгагдах онцлог. Нийлмэл гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх /зүйлчлэх, ял ногдуулах / журам, онцлог.

Давтан гэмт хэрэг: Давтан гэмт хэргийн ойлголт, шинж, нийлмэл гэмт хэргээс ялгагдах онцлог. Давтан гэмт хэргийн төрөл, түүнийг Эрүүгийн хуульд хуульчилсан байдал. Давтан гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх журам онцлог.

Эх сурвалж:

1. С.Нарангэрэл. Гэмт хэрэг зүйлчлэх шинжлэх ухааны үндэс. УБ., 1988.
2. С.Жанцан. Гэмт хэргийн олонлог. УБ., 1990.
3. С.Жанцан. Рецидив гэмт хэрэгтэй хийх тэмцлийн эрүүгийн эрх зүйн асуудал. УБ., 1988.
4. Ч.Хүрэлбаатар. “Хэд хэдэн гэмт хэргийн ойлголт” Социалист хууль ёс. 1972 он. №1. 60 дах тал.



СЭДЭВ 10. ГЭМТ ХЭРГИЙН НИЙГМИЙН АЮУЛЫГ НӨХЦӨЛ БАЙДЛУУД

ҮГҮЙСГЭХ

Сэдвийн зорилго:

Гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлын талаар онолын мэдлэгтэй болж, амьдралд гарсан хэрэгт гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдал байгаа эсэхийг тогтоох чадвар эзэмшинэ.

Агуулга

Тодорхойлолт, ийнж: Гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдал, түүний ойлголт шинж, төрөл, тэдгээрийг Эрүүгийн хуульд хуульчилсан байдал. Эрүүгийн хуульд заагдаагүй боловч онолын хувьд байх боломжтой нөхцөл байдлууд./ өөрийн эрхээ хэрэгжүүлэх, хохирогчийн зөвшөөрлөөр үйлдэл хийх, спорт уралдааны тэмцээний үе дэх эрсдэл г.м/

Аргагүй хамгаалалт: Аргагүй хамгаалалтын ойлголт, түүний хууль цаазны мөн чанар. Аргагүй хамгаалалт хийх эрх ба хамгаалалт, довтолгоонд тавигдах нөхцөл, шалгуур, үр дагавар.

Гарцаагүй байдал: Гарцаагүй байдлын ойлголт, шинж, шалгуур. Аргагүй хамгаалалтаас ялгагдах онцлог, үр дагавар

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах: Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах тухай ойлголт, мөн чанар, нөхцөл, шалгуур, үр дагавар. Баривчлах, албадан саатуулах ажиллагааны хэр хэмжээ.

Үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдэл: Үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдэлийн тухай ойлголт, мөн чанар, үр дагавар, эрсдэлийг үндэслэлтэйд тооцох шалгуурууд.

Тушаал захирамж биелүүлэх: Тушаал, захирамж биелүүлэх ойлголт, түүний мөн чанар, тавигдах шалгуур, үр дагавар. Илт хууль бус тушаал, захирамж биелүүлсэний хууль зүйн үр дагавар

Эх сурвалж:

1. Х. Түдэв. БНМАУ-ын эрүүгийн эрх зүй дэх аргагүй хамгаалалтын асуудал УБ., 1972.
2. Х. Түдэв. Аргагүй хамгаалалт УБ., 1982.
3. Ж. Авхиа. Аргагүй хамгаалалт Хууль ёс, 1992 №4.

III. ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА.

Бүлгийн зорилго: Эрүүгийн хариуцлага, түүний зорилго, эрүүгийн хариуцлага хүлээлгэх, ял ногдуулах болон эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх үндэслэл, журмын талаар онолын мэдлэгтэй болж, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх дадал, чадвар эзэмшиж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй холбоотой хэм хэмжээг зөв хэрэглэх хандлага төлөвшинө.

СЭДЭВ 1. ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГЫН ОЙЛГОЛТ, ТӨРӨЛ, ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ ҮНДЭСЛЭЛ

Сэдвийн зорилго:

Эрүүгийн хариуцлагын ойлголт, мөн чанар, зорилго хүлээлгэх үндэслэл, эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний талаар онолын мэдлэгтэй болж, олж авсан мэдлэгтээ тулгуурлан эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийдвэрт онолын үүднээс үнэлэлт, дүгнэлт өгөх чадвар эзэмшинэ.

Агуулга:

Эрүүгийн хариуцлагын ойлголт: Эрүүгийн хариуцлагын ойлголт, түүний мөн чанар. Эрүүгийн хариуцлагын төрөл. Эрүүгийн хариуцлага ба ялын харьцаа, уялдаа холбоо.

Эрүүгийн хариуцлагын зорилго: Эрүүгийн хариуцлагын зорилго, түүнийг Эрүүгийн хуульд хуульчилсан байдал. Эрүүгийн хариуцлагын иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, цээрлүүлэх, хүмүүжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилго, тэдгээрийн хэрэгжих нөхцөл, арга зам.

Эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл: Эрүүгийн хариуцлагын үндэслэл, түүнийг Эрүүгийн хуульд хуульчилсан байдал. Эрүүгийн хуульд заасан тодорхой гэмт хэргийн бүрэлдүүн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болох нь

Эрүүгийн хариуцлагыг хэрэгжүүлэх үе шат хэлбэр: эрүүгийн хариуцлагыг хэрэгжүүлэх үе шат / эрүүгийн хариуцлагад татах, эрүүгийн хариуцлага хүлээлгэх, эрүүгийн хариуцлагыг хэрэгжүүлэх/. Эрүүгийн хариуцлага хэрэгжих хэлбэр /ялгүй ба ялтай эрүүгийн хариуцлага/

Эх сурвалж:

1. Г.Совд. “Эрүүгийн хариуцлага: уламжлал, шинэчлэлийн асуудал”. Хууль зүйн шинжлэх ухааны докторын диссертаци 1993 он. Улсын нийтийн номын сан.
2. С.Нарангэрэл. “Р.Чойномд тулгасан ял.” УБ., 1990.
3. А.Съез. “Ялын ойлголт, зорилго, үр нөлөө”. Эрх зүй. 2001. №67., 143 дахь тал.
4. ТДэндэв. “БНМАУ-ын Эрүүгийн эрх зүй дэх ял шийтгэлийн тухай асуудал”. УБ., 1975
5. Р.Уранбилэг. “Эрх зүйн социологи” УБ, 2002 он
6. Н.Баатаржав. “Эрүүгийн шинэ хуулийн ялын бодлогын зарим асуудал”. “Эрдэм судлал” Улаанбаатар эрдэм судлал коллеж., 2002.45 дахь тал.



СЭДЭВ 2. ЯЛЫН ЗОРИЛГО, ТОГТОЛЦОО

Сэдвийн зорилго:

Эрүүгийн хариуцлагын нэг төрөл болох ялын ойлголт, мөн чанар, шинж, тодорхой төрлийн ялууд, тэдгээрийг ногдуулах, эдлүүлэх үндэслэл, журмын талаар мэдлэгтэй болж, ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолд онолын үүднээс үнэлэлт дүгнэлт өгөх чадвар эзэмшинэ.

Агуулга:

Ялын ойлголт, зорилго: Ялын ойлголт. Эрүүгийн хариуцлага ба ялын харьцаа. Ялын зорилго.

Ялын тогтолцоо: Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх ялын төрөл, тэдгээрийг эрэмбэлсэн байдал. Үндсэн ба нэмэгдэл ял. Ялын тогтолцооны практик ач холбогдол.

Ялын төрөл: Эрүүгийн хуулиар тогтоосон ялын төрөл. Торгох ялын ойлголт, түүний шинж, торгуулийн хэмжээ, цээрлэл. Эрүүгийн шинэ хуулиар торгох ялд орсон өөрчлөлт, шалтгаан, учир холбогдол. Торгох ялыг ногдуулах, торгох ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэх үндэслэл, журам. Торгох ялаас зайлсхийсэн тохиолдолд үүсэх үр дагавар. Тодорхой албан тушаал эрхлэх буюу үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялын ойлголт, түүний шинж, цээрлэл, хугацаа. Уг ялд Эрүүгийн хуулиар орсон өөрчлөлт, шалтгаан, учир холбогдол. Тодорхой албан тушаал эрхлэх буюу үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг ногдуулах болон уг ялыг оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэх үндэслэл, журам, онцлог. Эд хөрөнгө хураах ялын ойлголт, түүний шинж, цээрлэл. Эд хөрөнгө хураах ялд Эрүүгийн хуулиар орсон өөрчлөлт, шалтгаан, ач холбогдол. Эд хөрөнгө хураах ялыг ногдуулах болон уг ялыг оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэх үндэслэл, журам, онцлог. Албадан ажил хийлгэх ялын ойлголт, түүний мөн чанар, шинж, цээрлэл, хугацаа. Албадан ажил хийлгэх ялыг Эрүүгийн хуульд ялын төрөл болгон хуульчилсан шалтгаан. Албадан ажил хийлгэх ялыг ногдуулах болон уг ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэх үндэслэл, нөхцөл, журам, онцлог. Баривчлах ялын ойлголт, түүний шинж, цээрлэл, хугацаа. Баривчлах ялыг Эрүүгийн хуулиар ялын төрөл болгон хуульчилсан шалтгаан. Баривчлах ялыг ногдуулах болон уг ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэх үндэслэл, нөхцөл, журам, онцлог. Хорих ялын ойлголт, түүний мөн чанар, шинж, хорих ялын цээрлэл. Хорих ялд Эрүүгийн хуулиар орсон нэмэлт өөрчлөлт, тэдгээрийн шалтгаан. Хорих ялын хугацаа, хорих анги, тэдгээрийн дэглэм, түүнийг сонгон хэрэглэх үндэслэл, журам. Хорих ял ногдуулах болон эдлүүлэх нөхцөл, журам, онцлог. Цаазаар авах ялын ойлголт, түүний мөн чанар, цээрлэл. Цаазаар авах ялд Эрүүгийн шинэ хуулиар орсон өөрчлөлт. Цаазаар авах ялыг ногдуулах үндэслэл, нөхцөл, уг ялыг биелүүлэх журам. Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд хорих ялаар солих үндэслэл, журам.

Эх сурвалж:

1. "Эрүүгийн хуулийн 32 дугаар зүйлийг нэг мөр ойлгон зөв хэрэглэх тухай". УДШ-ийн БХ-ын тогтоол. 1994 он. № 30.
2. орч Н.Энхтуяа. "Цаазаар авах ял, эсрэг тэсрэг үзэл бодол". Монголын төр эрх зүй сэтгүүл. 1995 он №1., 58 дахь тал.

3. Н.Тогтохбаяр. Ялын дээд хэмжээг халах цаг болсон уу? Ардын эрх. 1996.11 28 №237/1455
4. С.Нарангэрэл. “Бүх насаар нь хорих уу?” Ардын эрх. 1993.8.14. №128/628
5. Д.Зүмбэрэлхам. “Албаданажил хийлгэх, баривчлахялыг эдлүүлэхтэй холбоотой зарим асуудал.” “Эрдэм суддал” Улаанбаатар эрдэм судлал коллеж., 2002.97 дахь тал.
6. Ж.Энхнасан. “Албадан ажил хийлгэх ялын асуудал”. Монголын төр,эрх зүй 2002. № 4
7. Д.Бадам. “Prison буюу “Хар гэр”. Эрх зүй. №2-3., УБ., 2000. 93 дахь тал
8. Л.Оюун. “Ял шийтгэлийн төрлийн талаар шийдвэрлэх зарим асуудлууд” МУИС, ДЗДС. Эрдэм шинжилгээний бичиг 1996. 30 дахь тал.

СЭДЭВ 3. ЯЛ НОГДУУЛАХ

Сэдвийн зорилго:

Ял ногдуулах ойлголт, шинж, нийтлэг зарчим, журмын талаар онолын мэдлэгтэй болж, олж авсан мэдлэгтээ тулгуурлан ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолд хууль зүйн үүднээс үнэлэлт дүгнэлт өгөх чадвар эзэмшинэ.

Агуулга:

Ял ногдуулах нийтлэг үндэслэл, зарчим: Ял ногдуулах тухай ойлголт, түүний хууль зүйн шинж, ял ногдуулах нийтлэг зарчим, журам, түүнийг Эрүүгийн хуульд хуульчилсан байдал. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал зэргийг тогтоох шалгуур.

Ялыг хөнгөрүүлэх ба хүндрүүлэх нөхцөл байдлууд: Ялыг хөнгөрүүлэх ба хүндрүүлэх нөхцөл байдал, тэдгээрийн ойлголт, мөн чанар. Эрүүгийн хуулиар орсон нэмэлт өөрчлөлт, шалтгаан.

Хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял ногдуулах журам: Хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял ногдуулах журам, ойлголт. Уг журмыг хэрэглэх үндэслэл, зарчим /багтаах, нэмж нэгтгэх/ ялуудыг хооронд нэмж нэгтгэх журам, нөхцөл, хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял ногдуулахаас ялгагдах онцлог

Хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял ногдуулах: Хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял ногдуулах журам, ойлголт, хэрэглэх үндэслэл /тохиолдол/, зарчим. Хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял ногдуулахаас ялгагдах онцлог.

Цагдан хоригдсон хугацааг тооцох: Цагдан хоригдсон хугацааг тооцох тухай ойлголт, хууль цаазны учир холбогдол. Цагдан хоригдсон хугацааг тооцох үндэслэл, журам, нөхцөл онцлог.

Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэх болон завдсан үйлдэлд ял ногдуулах: Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэх болон завдсан үйлдэлд ял ногдуулахад харгалзах нөхцөл байдлууд, ял ногдуулах журам, нөхцөл, онцлог тэдгээрийг Эрүүгийн хуульд хуульчилсан байдал.

Ял тэнсэх тухай ойлголт, түүний хууль цаазны учир холбогдол: Хорих ялыг тэнсэх үндэслэл, журам, тэдгээрт Эрүүгийн хуулиар орсон нэмэлт өөрчлөлт. Ял тэнсэх хугацаа, ял тэнсэгдсэн этгээдэд хэрэглэх албадлагын арга хэмжээ. Ял тэнсээнийг хүчингүй болгох үндэслэл, журам



Ял хойшлуулах: Насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулах үндэслэл, журам, хугацаа. Жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулах үндэслэл, журам, хугацаа, ял хойшлуулсныг хүчингүй болгох нөхцөл.

Эх сурвалж:

1. Шүүхийн тухай хууль. ТМ-2002 он
2. Прокурорын байгууллагын тухай хууль. ТМ- 2002 он
3. “Хорих ял шийтгүүлсэн этгээдийн ял эдлэх дэглэмийг зөв тогтооход анхаарах зарим асуудлын тухай”. УДШ-ийн БХ-ын тогтоол. 1987 он. № 27.
4. “БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 37, 38-р зүйлийг шүүн таслах ажиллагаанд зөв хэрэглэх тухай” УДШ-ийн БХ-ын тогтоол. 1989 он. № 42.
5. “Төрийн эрүүгийн ял шийтгэлийн бодлогыг шүүхээс хэрэгжүүлэхэд анхаарах зарим асуудлын тухай”. УДШ-ийн БХ-ын тогтоол. 1994 он. № 51.
6. “Эрүүгийн ял шийтгэлийг зөв ногдуулах тухай”. УДШ-ийн БХ-ын тогтоол. 1990 он. № 88.
7. Гэмт хэргийн уршгаас учирсан материалын хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбогдсон хууль тогтоомжийн заалтыг зөв хэрэгжүүлэх тухай” УДШ-ийн БХ-ын тогтоол. 1984 он. № 44.
8. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай” УДШ-ийн БХ-ын тогтоол. 2000 он. № 3.
9. Г.Совд.”Ял хариуцлага ногдуулах тухай” /Монголын төр, эрх зүй/ сэтгүүл №1. 31-41 дахь тал.
10. С.Нарангэрэл. “Ямар эд хөрөнгийг хураах вэ?” Ардын эрх. 1993.8.17. №129/629
11. С.Нарангэрэл. “БНМАУ-ын засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн эрх зүйн үндсэн асуудал”. УБ., 1985.
12. А.Лхагваа, С.Жанцан. “Хорих ял эдлүүлэх эрх зүй.” УБ., 1996.
13. Ц.Дарьжав. “Хугацаагүй хорих ялыг хэн ногдуулах вэ?” Монголын төр, эрх зүй. №3. 61.дах тал.
14. Д.Алтангэрэл. “Хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял ногдуулах зарим асуудал”. Социалист хууль ёс. 1988. №1. 25 дахь тал.

СЭДЭВ 4. ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГЫН БУСАД АРГА ХЭМЖЭЭ

Сэдвийн зорилго:

Эмнэлгийн болон хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний ойлголт түүнийг ногдуулах, хэрэгжүүлэх талаар онолын мэдлэгтэй болж, олж авсан мэдлэгтээ тулгуурлан эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг оногдуулсан шүүхийн шийдвэрт хууль зүйн үүднээс үнэлэлт дүгнэлт өгөх чадвар эзэмшинэ.

Агуулга:

Эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээний ойлголт, төрөл: Эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээний ойлголт, түүний мөн чанар, хууль цаазны учир холбогдол. Эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээний үндсэн шинж, ялаас ялгагдах онцлог, төрөл, тэдгээрийг Эрүүгийн хуульд хуульчилсан байдал .

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний ойлголт, мөн чанар, зорилго: Уг арга хэмжээг ногдуулах, өөрчлөх, зогсоох үндэслэл, журам, түүнийг хэрэглэсэн хугацааг ялын хугацаанд оруулан тооцох. Гэмт хэрэг үйлдсэн архаг архичин буюу мансуурах донтой этгээдэд хэрэглэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ. Гэмт хэрэг үйлдсэн архаг архичин буюу мансуурах донтой этгээдэд хэрэглэх эмнэлгийн чанартай албадлын арга хэмжээний ойлголт, түүний мөн чанар, ногдуулах болон хэрэглэх үндэслэл, журам

Насанд хүрээгүй этгээдэд хэрэглэх хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ: Насанд хүрээгүй этгээдэд хэрэглэх хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний ойлголт, түүний мөн чанар, хууль цаазны ба хүмүүжлийн ач холбогдол, зорилго, төрөл. Уг арга хэмжээг ногдуулах болон хэрэглэх үндэслэл, журам, онцлог.

Эх сурвалж:

1. “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, түүнийг өөрчлөх буюу зогсоох талаархи хуулийн заалтыг зөв хэрэглэх тухай” УДШ-ийн бүгд хурлын тогтоол. 1987. №42.
2. Л.Эрдэнэбаяр. “Мансуурал судлалын үндэс”. УБ., 2001

СЭДЭВ 5. ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА БОЛОН ЯЛААС ЧӨЛӨӨЛӨХ

Сэдвийн зорилго:

Эрүүгийн хариуцлага ба ялаас чөлөөлөх тухай ойлголт, үндэслэл, журам, ялгаатай тал, эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх тодорхой төрлүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх талаар онолын мэдлэг олгох, олж авсан мэдлэгтээ тулгуурлан эрүүгийн хариуцлага ба ялаас чөлөөлөх журмыг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаанд хэрэгжүүлж буй байдалд хууль зүйн үүднээс үнэлэлт, дүгнэлт өгөх чадвар эзэмшүүлэх, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох хэм хэмжээг зөв хэрэглэх хандлага төлөвшүүлэхэд оршино.

Агуулга:

Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх ойлголт, үндэслэл, төрөл: Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх ойлголт, түүний хууль цаазны мөн чанар, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхийн шинж, эрүүгийн ялаас чөлөөлөхөөс ялгагдах онцлог. Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, төрөл, тэдгээрийг Монгол улсын Эрүүгийн хуульд хуульчилсан байдал.

Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх төрлүүд: Эрүүгийн хариуцлагаас заавал чөлөөлөх болон сонгох үндэслэлүүд. Эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа өнгөрснөөр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, журам. Эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа, тоолох журам, онцлог. Үйлдсэн гэмт хэргээ илчилж ирсэн, Хохирогчтой эвлэрсэн, Цаг үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй холбоотойгоор эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, журам, онцлог.

Ялаас чөлөөлөх ойлголт, ийнж, төрөл: Ялаас чөлөөлөх ойлголт, хууль цаазны мөн чанар, шинж, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхөөс ялгагдах онцлог. Ялаас чөлөөлөх үндэслэл, төрөл тэдгээрийг Эрүүгийн хуульд хуульчилсан байдал. Хорих



ял эдэхээс хугацааны өмнө тэнсэн суллах ойлголт, үндэслэл, журам. Өвчний учир ялаас чөлөөлөх ойлголт, үндэслэл, журам. Шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэх хугацаа өнгөрсөн тохиолдолд ялаас чөлөөлөх ойлголт, үндэслэл, журам. Шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааг тоолох журам.

Өршөөл, уучлал үзүүлж эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх: Өршөөл, түүний хууль зүйн учир холбогдол, өршөөлийн нөхцөл, өршөөлийн хэлбэр. Өршөөл үзүүлж эрүүгийн хариуцлага ба ялаас чөлөөлөх журам, онцлог. Уучлал, түүний мөн чанар, өршөөлөөс ялгагдах онцлог. Уучлалын хэлбэр, уучлал үзүүлэх журам, уучлал үзүүлж ял эдлэхээс чөлөөлөх

Ялтай байдал, ялгүй болох ба ялгүйд тооцох: Ялтай байдал ойлголт, хууль цаазны мөн чанар. Ялгүй болох хугацааг Эрүүгийн хуулинд хуульчилсан байдал. Ялгүй болох хугацааг тоолох журам. Ялгүйд тооцох үндэслэл, журам, ялгүй болохоос ялгагдах онцлог.

Эх сурвалж:

1. “Эрүүгийн хуулийн 44,45 дугаар зүйлийн заалтыг зөв хэрэглэх тухай” УДШ-ийн БХ-ын тогтоол. 1988., №11.
2. Өршөөл үзүүлэх тухай хууль. 2000.
3. Өршөөл үзүүлэх тухай Монгол Улсын хуулийн зарим заалтыг хэрэглэх тухай УДШ-ийн БХ-ын тогтоол. 2000 он., №244.
4. “Ялтныг ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу ялыг хөнгөн ялаар солих талаархи Эрүүгийн хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай” УДШ-ийн БХ-ын тогтоол. 1995 он. № 390.
5. “Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай”. УДШ-ийн БХ-ын тогтоол. 1998. № 29.
6. “Эрүүгийн хуулийн 40 дүгээр зүйлийг зөв хэрэглэх тухай”. УДШ-ийн БХ-ын тогтоол. 1998. № 315.
7. Ялтныг өвчний учир хугацаанаас өмнө ял эдлэхээс чөлөөлөх талаарх хуулийн заалтыг тайлбарлах тухай. УДШ-ийн БХ-ын тогтоол. 1992 он. № 71.
8. Г.Совд. Ял тэнсэх ба шүүхийн практик. (Эдийн засаг эрхийн асуудал) сэтгүүл. №6 72-76 дахь тал.
9. Г.Совд, С.Нарангэрэл. “БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 34-р зүйлийн хэм хэмжээг хэрэглэх асуудалд” Социалист хууль ёс. 1982. №2.47 дах тал.
10. С.Батхүлэг. “Ял тэнсэх асуудалд”. Монголын төр эрх зүй 2003. № 4

ЗААХ АРГА ЗҮЙ

Хичээлийн арга зүйд тавигдах шаардлага

Эрүүгийн эрх зүй-1 хичээлийг судлах үндэслэл, хичээлийн зорилго зорилттой уялдан уг хичээлийг заах арга зүйд дараахь шаардлага тавигдна. Үүнд:

Хичээлийн зорилгыг хангахуйц арга, хэлбэрийг сонгох, тэр нь хичээлийн агуулгад тохирсон байх,

Эрүүгийн эрх зүй-1 хичээлээр гэмт хэрэг ба эрүүгийн хариуцлагын талаархи мэдлэг бүтээх, бүтээсэн мэдлэгээ амьдралд хэрэглэх, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх чадвар суулгах нөхцөл боломжийг хангах,

Оюутнууд хичээлд жигд, идэвхитэй оролцох боломж, нөхцөлийг бүрдүүлэх,

Хичээлийн арга зүй нь амьдрал, практикт нийцсэн, шүүхийн практикийг харгалзсан, тунхагласан хэлбэрээс аль болохоор татгалзсан байх.

Мэдээлэл түгээх аргууд

Лекц /Lecture/

Лекцийн арга нь сэтгэлгээний мэдлэг, ойлголтын түвшний зорилтыг хангахад тохиромжтой байдаг бөгөөд Эрүүгийн эрх зүйн Ерөнхий ангийг судлахад лекцийн аргыг өргөнөөр ашигладаг. Гэмт хэргийн ойлголт бүрэлдэхүүн эрүүгийн хариуцлага ба ялын ойлголтууд зэрэг онолын асуудлыг лекцийн аргаар заах нь илүү үр дүнтэй.

“Эрүүгийн эрх зүй-1” хичээлийн зарим сэдвүүд тухайлбал, гэмт хэрэг үйлдэх үе шат, гэмт хэрэгт хамтран оролцох, гэмт хэргийн олонлог, эрүүгийн ял оногдуулах болон эрүүгийн хариуцлага ба ялаас чөлөөлөх зэрэг сэдвүүдийг зөвхөн лекцийн аргаар заах нь төдий л тохиромжтой биш байдаг учир / case study / буюу тохиолдол шинжлэх аргыг хослуулан ашиглах хэрэгтэй.

Лекцийн аргыг хэрэглэхэд анхаарах зүйлс:

Хүн анхаарлаа дунджаар 15-20 минут төвлөрүүлдэг тул лекц урт хугацаагаар үргэлжлэх зохимжгүй бөгөөд боломжтой нөхцөлд сургалтын үр ашгийг дээшлүүлэх үүднээс хэлэлцүүлэг, эвлүүлгийн болон бусад аргыг нэмж ашиглах нь зүйтэй.

Хүн нэг зэрэг долоогоос илүүгүй мэдээллийг л тогтоох боломжтой гэж судлаачид дүгнэсэн байдаг. Оюутнуудын 60-65 хувийнх нь харааны ой, 20-25 хувийнх нь сонсох ой илүү хөгжсөн байдаг ба хүмүүсийн 15-20 хувь нь үйл хөдлөлөөр дамжуулж сурдаг байна. Багш ярихын хажуугаар үзүүлэн таниулах материал ашигласан тохиолдолд суралцагчдын тогтоох мэдээллийн хэмжээ 25 хүртэл хувиар нэмэгддэг бол заалгасан зүйлээ туршиж хэрэглэсэн нөхцөлд энэ үзүүлэлт 70 хувь хүртэл өсдөгийг багш бүр анхаарах шаардлагатай.

Эвлүүлгийн арга /Jacksaw/

Энэ арга нь оролцогчдод богино хугацаанд их мэдээлэл олж авах боломж олгодог ба лекцийг орлуулахад ашигладаг. Тухайлбал, гэмт хэргийн ойлголт, гэмт хэргийн бүрэлдэхүүний талаар ойлголт өгөхөд ашиглаж болох юм. Эвлүүлгийн аргын зорилго нь оюутнууд бие биедээ заах, сургах боломж олгодог ба тухайн хичээлээр мэдээлэл олж авахад хүндрэлтэй хичээлийг тайлбарлах, асуулт тавих, бусадтай харилцах ба сонсох чадварыг хөгжүүлэхэд илүү үр дүнтэй.



Эрүүгийн эрх зүйн Ерөнхий ангийн зарим сэдвийг судлахад оюутнуудад дэлгэрэнгүй мэдээлэл шаардагддаг ба энэ тохиолдолд тухайн мэдээлэл лекцийн агуулга болон бусад нэмэлт хэрэглэгдэхүүнийг жижиг багийн тоогоор хувааж бэлтгэсэн байна. Бэлтгэсэн материалаа нэг дугтуйд хийж багуудад тараан өгнө. Эвлүүлгийн аргыг хэрэглэхдээ баг тус бүрт нэг ижил даалгавар /материал/ өгөх бөгөөд тодорхой асуудлын талаар мэдлэг бүтээх зорилготой.

Багийн гишүүд өгөгдсөн сэдвийн дагуу өөр өөрсдийн санал бодлыг цаасан дээр бичнэ. Тэдэнд санал бодлоо бичих, илэрхийлэхэд хангалттай хугацаа өгөх хэрэгтэй ба багш баг бүрт очиж материалаа ойлгож байгаа эсэх талаар асууж арга зүйн туслалцаа үзүүлэх хэрэгтэй.

Багууд дотроо тухайн асуудлаар ярилцан үзэл бодлоо илэрхийлэх үндэслэлгээ гаргаж, нэгдсэн тайлбараа гаргахад бэлтгэнэ.

Үүний дараа баг бүр өөрсдийн санал бодлоо бусад багуудад тайлбарлах, багуудаас гарсан асуултанд хариулах, харилцан мэтгэлцэх замаар мэдлэг бүтээх ба оюутнуудаас гарсан асуултад багш хариулах, харилцан ярилцах, маргаантай асуудлыг тайлбарлах, шийдвэр гаргах замаар мэдлэгийг цэгцлэнэ. Хичээлийн эцэст багш багуудын хариултыг дүгнэж, идэвхтэй оролцсон оюутнуудад үнэлгээ өгнө.

Хүн бүр багш /Each one teach one/

Бүлэг сэдвийг танилцуулахад болон үзсэн сэдвийн агуулга ухагдахуунуудыг дүгнэх, лекцийн агуулгыг оюутнуудад хүргэхэд энэ аргыг гол төлөв хэрэглэнэ.

Энэ аргын зорилго нь сургалтын үйл явцад идэвхтэй оролцох болон бие биетэйгээ санаа бодлоо солилцоход оролцогчдод ихээхэн ач холбогдолтой болно. Хүн бүр багш аргыг хэрэглэснээр хичээлээр заавал эзэмших ёстой агуулга болон ухагдахууны талаар ерөнхий ойлголт өгөх ба оюутнуудын сонирхлыг өдөөж, асуулт тавихад хүргэнэ.

Хэрэгжүүлэх дараалал:

- Лекцийн агуулга, мэдээллийг утгат хэсгээр нь хувааж, оюутан бүрд тарааж өгөх зорилгоор жижиг цаасан дээр бичиж бэлдэнэ. Энэ нь таны сургалтад оролцогчдын тоогоор байх ёстойг анхаарч оролцогч бүрт тараана.
- Оролцогчид мэдээллийг уншсаны дараа уг уншсан зүйлийнхээ агуулгыг ярих, зураглал, бүдүүвчээр илэрхийлэх зэргээр бусдад түгээх бэлтгэлээ хийнэ. Энэ үед багш тусламж шаардлагатай хүн дээр очиж зөвлөгөө өгч, тайлбарлаж болно.
- Бэлтгэх хугацаа дууссаны дараа тэд мэдээллээ бие биедээ танилцуулж ангиа тойрон явна. Хүн бүр өөрт буй мэдээллээ танилцуулж, бусдаас мэдээлэл авч дуустал энэ ажил үргэлжилнэ. Зорилго нь бусадтай мэдээлэл солилцох буюу өөрт буй мэдээллээ бусдад тарааж, шинэ мэдээлэл бусдаас олж авахад оршино.
- Энэ ажлыг дууссаны дараа багш бие биенээсээ юу мэдсэн, ямар шинэ мэдээлэл авсан тухай, уг мэдээллийг юу гэж ойлгож байгаа тухай, энэ мэдсэн зүйл өөрт нь ямар хэрэг болох тухай ярилцуулна.
- Ярилцлагын явцад оюутнуудад юу хэрэгтэй байгаа, тэдний бие биеэсээ авсан мэдээллийг хэрхэн цэгцлэх шаардлагатайг багш ажиглаж, тэр дагуу нэмэлт мэдээллийг өгнө.

Оролцооны аргууд

Тохиолдол шинжлэх /case study/

Энэ арга нь суралцагчдад эрх зүйн хэм хэмжээг амьдралын тодорхой жишээн дээр үндэслэн хэрэглэж сурахад туслахад чиглэгдсэн асуултын аргад тулгуурласан хэлбэр юм. Тодорхой жишээ гэдэг нь бодит болон зохиомол хэрэг /үйл явдал/, хэрэг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр зэрэг суралцагчдад эрүүгийн эрх зүйн талаар шинэлэг ойлголт, мэдээлэл, мэдлэг өгөх асуудалд олон талаас нь шүүмжлэлтэй, нухацтай хандах, хууль зүйн үндэстэй шийдвэр гаргах сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэгдсэн хэрэглэгдэхүүн юм.

Сургалтын тохиолдлууд нь ихэвчлэн эх бичвэрийн /ЭБШАжиллагааны бичиг баримт тухайлбал, эрүүгийн хэрэг үүсгэх тогтоол, яллагдагчаар татах тогтоол ялын дүгнэлт, шүүхийн шийтгэх болон цагаатгах тогтоол г.м/ хэлбэртэй байдаг боловч сургалтын кино болон дүрс бичлэг, дуу хураагчид бичигдсэн казус, дүр бүтээж тоглосон болон бусад хэлбэртэй байж болно.

Тохиолдол шинжлэх аргыг хэрэглэхийн тулд амьдрал, практикт гарч байсан гэмт хэргийн талаарх янз бүрийн материал /хавтаст хэрэг г.м/, Эрүүгийн хууль болон бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд, холбогдох гарын авлагуудыг бэлтгэсэн байх зайлшгүй шаардлагатай.

Зорилго: Сургалтын энэ арга нь суралцагчийг амьдралд үйлдэгдсэн тодорхой хэргийн нөхцөл байдлуудыг бүх талаас бүрэн бодитой шинжлэх түүнд Эрүүгийн эрх зүйн үүднээс үнэлэлт дүгнэлт өгөх замаар хуулийн үндэстэй шийдвэр гаргах дадал, чадварыг эзэмшүүлэх зорилготой.

Тохиолдлыг шинжлэх явцад оюутнууд нь амьдралд үйлдэгдсэн хэргийн нөхцөл байдал, болон түүнд хэрэглэх Эрүүгийн хуулийн хэм хэмжээний мөн чанарыг таньж мэдэх, тэдгээрийг хооронд нь харьцуулах замаар сэтгэхүйн болон логик үйл ажиллагааг хөгжүүлэх, хууль хэрэглэх арга ажиллагаанд суралцана.

Түүнчлэн энэ арга нь оюутнуудын уг хичээлийг сонирхон суддах, сурах идэвхийг өрнүүлэх, чөлөөт сэтгэлгээг хөгжүүлэх, эрх зүйч мэргэжлийн мөн чанар, онцлогийг ойлгох, мэргэжлийн үүрэг хариуцлагаа ухамсарлах, мэргэжлийн чиг баримжаатай болох, сонгож буй мэргэжлээрээ бахархах үзэл санааг төлөвшүүлэхэд ач холбогдолтой юм.

Тохиолдол шинжлэх аргыг яагаад хэрэглэдэг вэ?

- Тоймлосон дүгнэлт, тодорхой үзэл, санааг гаргадаг.
- Харьцангуй өндөр түвшинд хийсвэрлэн сэтгэх боломжийг хангадаг.
- Суралцагчдын сэтгэлгээг хөгжүүлэн заддан шинжлэх, сэтгэн бодох дадал эзэмшүүлэн, шийдвэр гаргах чадвартай болгоно.
- Хуулийг хэрэглэгчийн сэтгэхүй, сэтгэл зүйн онцлог, сэтгэл хөдлөл мэдрэмжийг таниулахын зэрэгцээ суралцагчдын дүрслэн бодох сонирхол, логик сэтгэлгээг өдөөж сурах идэвхийг өрнүүлдэг.
- Танхимд суралцаж буй суралцагчдыг хуульд үндэслэсэн сэтгэлгээг амьдралын туршлага, жишээ, бодит сэтгэлгээний хувьд холбоотой байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Суралцагчдад мэдсэн, сурсанаа хэрэглэх боломж олгохын зэрэгцээ Эрүүгийн эрх зүйн салбарт шинэ үзэл санаа, ойлголт, зарчмыг хөгжүүлэхэд нөлөөлнө.



Тохиолдол шинжлэх аргыг хэрэглэхэд тавих хязгаарлалт болон санамж:

Хэдийгээр авч байгаа тохиолдол нь бодит байдлын тусгал болдог ч жинхэнэ бодит байдал хараахан биш юм. Нэг ч жишээ жинхэнэ бодит байдлыг орлохгүйг санах хэрэгтэй. Зарим тохиолдолд жинхэнэ байдал дээр шийдвэр гаргахдаа танхимын сургалтын жишээнд үзүүлж хэрэглэх аргагүй тийм үл мэдэгдэм, үл ойлгогдох баримтад үндэслэхэд хүрдэг ч бий.

Сургалтад хэрэглэгдэж буй жишээ бүр нь өөрийн тодорхой үзэл бодол мэргэжлийн түвшин бүхий хүн (багш)-ээр дамжиж суралцагчдад хүрдгийг мартах аргагүй. Уг аргыг хэрэглэх нь үлэмж цаг хугацаа шаардана. Энэ чанараараа бусад хичээл, сэдвийн цагт эсрэгээр нөлөөлдөг. Иймээс тохиолдол нь маш сайн шилж авсан, баялаг агуулгатай, өгөөжтэй суралцагчдын дадлага, чадварыг үнэхээр хөгжүүлэхэд чиглэгдсэн байх ёстой.

Зөвхөн ганцхан тохиолдлыг шинжилснээр суралцагчид маш том дүгнэлт гаргаж болох юм. Мөн нэг сэдэв дээр хэд хэдэн жишээ, эсвэл өгсөн жишээн дээрх статистик тоо баримт дээр ажиллах боломжтой.

Ердийн танхимын нөхцөлд багш нь энэ аргаар хичээл явуулахад лектор биш, ярилцлагыг хөтлөгчийн дүрд тоглох болно. Гэтэл багш бүхэн энэ үүрэгтээ бэлэн бил үү? Зарим тохиолдолд хууль эрх зүй тэр бүр ойлгомжтой биш, тэгээд ч хийдэлтэй байдаг. Батлагдсан хуулиудын эдгээр дутагдал нь сургалтын жишээг танхимын нөхцөлд заахад хүндрэлтэй. Ийм тохиолдолд багш, суралцагчид ямар хууль батлагдсан байх ёстой байсан, хуулийг хэрхэн өөрчлөн сайжруулж болох, ийнхүү өөрчлөн сайжруулахад оролцох арга замуудын талаар ярилцахад хүрдэг.

Энэ аргыг хэрэглэхдээ нэг багшид 20-с илүүгүй оюутан оногдохоор тооцоолох хэрэгтэй бөгөөд илүү олон оюутантай багш нэгэн зэрэг ажилласан тохиолдолд хичээлийн зорилго, үр дүнд муугаар нөлөөлдөг.

Холбогдох гарын авлага /бодлого, дасгалын хураамж г.м./, материал, хууль тогтоомжоор зайлшгүй хангагдсан байх ёстой бөгөөд энэ шаардлага хангагдаагүй тохиолдолд хичээлийг үр дүнтэй явуулах боломж багатай.

Тохиолдлыг бэлтгэх: Тохиолдлыг сонгож авах болон боловсруулахдаа дараах шалгууруудыг анхаарах хэрэгтэй.

Хүмүүсийн амьдрал, Эрүүгийн эрх зүйн практикт олонтоо тохиолддог асуултуудыг тусгасан өөрөөр хэлбэл, бодит байдалд нийцсэн эсэх.

Суралцагчдад сонирхолтой бөгөөд зохимжтой эсэх.

Суралцагчдын мэргэшил, мэдлэг боловсролын түвшинд нийцэж байгаа эсэх

Тохиолдолд авсан нөхцөл нь суралцагчдын зүгээс задлан шинжилгээ хийж өөрсдийн эргэцүүлээ бодож боловсруулах боломж олгохуйц байгаа эсэх.

Эерэг, сөрөг баримт нотолгоог гаргаж болохуйц тэнцлийг хангаж чадсан эсэх.

Тухайн хичээлийн зорилго, агуулга, арга, үр дүнд тохирсон эсэх.

Үе шат : А. Шийдвэр гаргахад бэлтгэх үе

Аливаа шийдвэрийг гаргахад хангалттай сайн мэдээлэл, баримт, нотолгоо цуглуулж боловсруулах хэрэгтэй байдаг. Үүний нэг адил тохиолдлыг шинжилж шийдвэр гаргахын тулд ч бэлтгэл ажил хэрэгтэй. Үүнд:

Тухайн тохиолдлыг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг өгөх. Мэдээллийг өгөх олон янзын арга байдаг. Тухайлбал, сургалтын материал тараах, бага хэмжээний лекц сонсох, видео бичлэг үзэх гэх мэт.

Тохиолдлыг уншуулах. Энэ үед тэдэнд тохиолдол /уг хэргийг шүүхээр хэрхэн шийдвэрлэсэн талаар/-ын эцсийн үр дүн, шийдвэрийг мэдээлэхгүй байх хэрэгтэй. Уг асуудлын бодит төгсгөлийг нилээд хожим нь авч үзэх болно.

Цаашдаа суралцагчдын анхаарлыг бодит баримтын учрыг олоход чиглүүлэх хэрэгтэй. Юуны түрүүнд тохиолдлын үйл явдлыг сайтар ойлгуулах нь чухал. Дараахь асуултуудад хариулт авах замаар тэдний ойлголтыг гүнзгийрүүлж болдог.

Уг тохиолдол (шүүхээр хянан хэлэлцэх ажиллагаа)- д чухам юу болсон бэ?

Уг хэрэгт (эсвэл зөрчилдөөнд) ямар хүмүүс, аль аль талууд оролцсон болох?

Оролцсон талууд болон хүмүүсийн үйлдсэн, хийсэн зүйл нь чухам ямар учир шалтгааны улмаас үйлдэгдсэн болох?

Чухам ямар ямар баримтууд нь чухал болох, ямар баримт, юу дутагдаж байна вэ?

Хичээлийн энэ үед бүх суралцагчид бүгд нэг ижил баримтад тулгуурлах ёстой бөгөөд энэ үндсэн дээрээ идэвхтэй ажиллах ёстой тул энэ шатанд анхааралтай байх ёстой. Үүний хамт уншлагын дадал суугаагүй суралцагчдад энэ үе нь их ач холбогдол, нөлөөлөлтэй байдаг. Багшийн зүгээс өөрөө асуулт боловсруулж суралцагчдад тавьж болно, эсвэл өөр нэг хувилбар нь тэднээр өөрсдөөр ажиллуулж, асуулт боловсруулж болно. Ингэхдээ хоёр хоёроор нь ажиллуулах бөгөөд нэг нь чухал баримтууд дээд товч дүгнэлт хийж байхад хоёрдахь нь асуултуудыг боловсруулан бэлтгэж байх юм.

Б. Шийдвэр гаргах үе

Суралцагчид хэрэгтэй мэдээллээ авч, тохиолдлыг хангалттай сайн судалж, ойлгосны үндсэн дээр шийдвэр гаргах үйл ажиллагаандаа орно. Тэдний шийдвэр гаргах үйл явцыг багш олон аргаар зохион байгуулж болно.

Эрүүгийн эрх зүйн хичээл нь амьдралд харьцангуй ойрхон, практикаар байнга шалгагдаж байдаг учир энэ хичээлийг заах гол арга нь тохиолдол шинжлэх арга байх учиртай. Энэ аргыг хэрэглэхийн тулд эхлээд оюутнуудад тухайн сэдвээр лекцийн хичээл орж тодорхой ойлголт өгсөн байх нь манай өнөөгийн нөхцөлд тохиромжтой.

Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг явуулах арга

Энэарга нь эсрэг, тэсрэг үзэл бодлыг оюутнууд хамтран хэлэлцэх өөрийн санал бодол, байр суурийг илэрхийлэх, хамгаалах, мэдээлэл солилцох, соёлтой мэтгэлцэх, өрсөлдөгчийн үзэл бодлыг хүлээн зөвшөөрөх чадвартай болгох зорилготой.

Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг хийх аргаар хичээлийг явуулахад оюутанд эсрэг, тэсрэг үзэл бодлыг хүлээн зөвшөөрч, ойлгож, няцаах, нотолгоог дэвшүүлэх чадвар хөгжих, байр суурь, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх чадвар, хандлага төлөвших боломжтой.

Суралцагчдаас, уг хэрэгт тэдний үзэж байгаагаар хамгийн чухал маргаантай асуудлууд нь юу болохыг асууснаар багш уг сэдэвт холбогдолтой хэлэлцүүлэг ярилцлагаа эхэлж болох юм. Хичээлийн явц, дүнгээс шалтгаалаад олон төрлийн (хууль эрх зүйн, төр-нийгмийн бодлогын эсвэл ёс суртахууны эсвэл практикийн холбогдолтой гэх мэт) асуудлууд гарч болох юм. Хууль зүйн ажиллагаанд асуултууд нь гол төлөв хууль эрх зүйтэй холбогдолтой байдаг. Гэвч үүний хамт, дээр дурьдсан бусад төрлийн асуултуудыг ч нэгэн адил авч үзнэ. Суралцагчид эхлээд авч үзэж буй тохиолдлын хамгийн маргаантай болох гол зүйлийг нь л ойлгох нь чухал бөгөөд үүнгүйгээр тэдэнд уг тохиолдлын бусад зүйлийг ойлгоход бэрхтэй болно. Багшийн



зүгээс суралцагчдын түвшин болон уг аргаар ажиллах дадлага туршлага зэргийг харгалзан өөрөө уг жишээний гол маргаантай хэсгийг нь тайлбарлан ярьж ч болох талтай. Ингэж багшийн эсвэл суралцагчдын өөрсдийн хүчээр тодорхой ойлгож авсан асуудлын гол хэсгийг дараа дараагийн үзэх зүйлүүдээсээ гоц ялган салгах нь чухал юм.

Үүний дараа суралцагчид баримт, нотолгоо олох, боловсруулах болно. Тэдний гаргасан баримт нотолгоо нь нэг үзэл санааг дэмжиж, нөгөөг эсэргүүцэх нь ойлгомжтой. Энэ явцдаа тэд олон талыг хамарсан дараах асуудлуудыг хөндөн ярилцаж болно.

Хоёр талын үзэл санаа бүрийг дэмжих буюу эсэргүүцэх ямар баримт, учир шалтгаан байж болох? Аль нь үнэмшил муутай болох? Яагаад?

Энэ асуудлыг өөр ямар арга замаар шийдвэрлэж болох?

Нийгэм болоод маргалдагч талуудын хувьд энэхүү асуудлыг яаж, хэрхэн шийдвэрлэснээр ямар үр дагавар учирч болох?

Баримт нотолгоо, учир шалтгаан болон шийдвэр бүрийн давуу тал нь юу болох?

Суралцагчдыг хууль зүйн баримт, шалтгааныг ашиглах, мөн хуулийн ойлголт, үндэсний хууль тогтоомж болон олон улсын гэрээг уг сэдэвтэй холбон үзэж судалж чадаж байгаагийн төлөө, мэдэж байгаагийнх нь хувьд шалгаж урам өгөх нь чухал. Янз бүрийн нотолгоо, баримт, учир шалтгааныг тодруулж хэлэлцэх явцад бусдын буюу өөр нотолгоо, үндэслэлд хүлээцтэй, тэвчээртэй хандах, мөн хэлэлцүүлгийн ил тод байдлыг хангасан тийм уур амьсгал бүрдүүлэх нь зохистой байдаг.

Суралцагчдаас шүүн хэлэлцэж буй ямар ч асуудал, санаа бодол, хүсэлт нь эвтэй эетэй байдал, маргаан зөрүүтэй аль ч үед адил тэгшээр хэлэлцэгдэж яригдах ёстойг ойлгосон байх ёстой. Өөрөөр хэлбэл, суралцагчид бусдыгаа сонсдог, үзэл санааг нь хүндэтгэдэг, бодит хандаж, үнэлэлт өгөх чадвартай байна гэсэн үг.

Энэ үе шатанд тэднийг бүх учир шалтгаан, нотолгоог сонссоны дараа шийдвэр гаргахад анхаарлыг нь төвлөрүүлэх нь зөв бөгөөд тэднээс гаргасан шийдвэрийнх нь үндэслэлийг заавал асуух хэрэгтэй. Хэрэв шийдвэрийг багш гаргасан буюу уншиж сонсгосон бол дараа нь заавал сурагчдаар үнэлэлт өгүүлэх хэрэгтэй. Тэд багшийн уншсан шийдвэртэй санал нийлж байна уу? үгүй юу? Яагаад? Энэ шийдвэр нь уг ажиллагаанд холбогдогч талуудад хэрхэн тусч байна вэ? Нийгэмд ямар үр дагавар авчрах вэ? гэх мэтээр асуух нь тэдний үнэлэлт, дүгнэлтээ хэлэх боломжийг хангана.

Хэрэв шийдвэрийг суралцагчид өөрсдөө гаргасан бол тэд уг шийдвэрийг гаргах болсон шалтгаан, үндэслэлийг хэрхэн тайлбарлаж байгааг анхаарах нь зүйтэй. Энэ бүхний эцэст, хэрэв авсан тохиолдол нь шүүхээр шийдвэрлэгдсэн бодит хэрэг байсан бол багш шүүхийн шийдвэрийг нь хэлж өгөх нь зүйтэй. Үүнийг хийхдээ, суралцагчид зөвхөн байгаа баримтад тулгуурлан өөр шийдвэр гаргаснаараа буруутай мэтээр өөрсдийгөө ойлгох тийм байдал гаргахааргүйгээр хийх нь чухал. Үүний тулд багш дараах загвар асуултуудаас ашиглаж болох юм. Үүнд:

Суралцагчдын гаргасан болон хуулийн байгууллагын гаргасан шийдвэрүүдийг харьцуулан үзэж, аль юуны учир илүү давуутай болохыг хэлнэ үү?

Шүүх яагаад өөр шийдвэр биш, чухам тэрхүү шийдвэрийг гаргах болов?

Энэхүү шийдвэрийг гаргахад ямар учир шалтгаан нөлөөлөв?

Та нар энэ шийдвэртэй санал хэрхэн нийлж байна вэ? Танд энэ шийдвэр хэрхэн нөлөөлж байна? Бусад хүмүүст бол яаж нөлөөлөх вэ? Энэ шийдвэрийн нөлөө, ач холбогдол ямар байх вэ? гэх мэт.

Хичээлээр хэлэлцэх маргаантай асуудлыг сонгох шалгуур:

- Асуудлыг олон талаас нь авч хэлэлцэх боломжтой, үнэхээр маргаантай асуудал мөн эсэх
- Хуулийг дээдлэх, хүний эрхийг хангахад энэхүү асуудал нь чухал ач холбогдолтой
- Энэ асуудал нь тухайн ангид хэлэлцэхэд тохиромжтой болон суралцагчдын хувьд / хүсэл сонирхол, мэргэшил/ ач холбогдолтой эсэх

Маргаантай асуудлыг хэлэлцэхэд баримтлах дүрэм:

Маргаантай асуудлыг хэлэлцэхэд хувь хүний үзэл бодлыг хөндөх ба сэтгэлийн хөдөлгөөн үүсгэдэг учраас заримдаа түүнийг зохион байгуулалттай дарааллаар хэрэглэхэд хүндрэлтэй байдаг. Иймээс хичээлийг зохион байгуулалт сайтай явуулах, үүссэн маргаантай байдлыг хяналтандаа байлгахад дараахь дүрэм нь багшид тус болно. Дүрмийг зөвшилцөж гаргаад бүгд биелүүлнэ.

Нотолгоо болон баттай мэдээлэл дээр анхаарлаа төвлөрүүлнэ.

Цаг барьж, ганцаараа ярихаас зайлсхийнэ.

Уриа хэрэглэхээс зайлсхийнэ.

Маргааныг хийсвэр түвшинд хүргэхээсээ өмнө тодорхой асуудлуудаар ярилцана.

Таны байр сууринд эргэлзэх бололцоог бусдадаа олгоно.

Өөрийн байр суурийн эргэлзээтэй зүйл, хүнд хэцүү болон сул талуудыг хүлээн зөвшөөрнө.

Бусдын санааг өөрчлөн хэлэх замаар ойлгож сурна. Ийм дадалтай болгохын тулд бусдаас сонссоноо өөрчлөн хэлж сурна.

Бусдын үзэл бодол болгонд хүндэтгэлтэй хандана.

Хэрэгжүүлэх дараалал:

Ангийн танхмийн буланд хэлэлцэх асуудлын сэдвээс хамааран “Санал бүрэн нийлж байна”, “Санал нийлж байна”, “Шийдээгүй буюу эргэлзэж байна”, санал нийлэхгүй байна гэсэн бичиг бүхий цаасыг дээрх дарааллаар байрлуулсан байна.

Энэ дасгал ажлыг хэрхэн хийх талаар дүрэм зохиогоод түүнийгээ хэлэлцэж батлана.

Хэлэлцэж буй асуудлын хүрээнд суралцагчид өөрсдийн байр суурийг илтгэсэн бичиг бүхий буланд очиж зогсоно.

Суралцагчдыг өөрсдийн байр суурийг тодруулж тайлбарлахыг хүснэ. Бүх суралцагчдыг хамруулах үүднээс ижил сонголттой сурагчид нэг багийг үүсгэж ярилцаад байр сууриа танилцуулж болно.

Өөрсдийн байр сууриа тайлбарласны дараа хэн нэг нь байр сууриа өөрчилж өөр буланд очихыг хүсэж байгаа эсэхийг асууна. Хэрэв өөрчлөх хүсэлтэй хүн гарвал яагаад ингэх болсон шалтгааныг асууна.

Эсрэг баримтлалуудын дэвшүүлсэн үндэслэлээс аль нь хамгийн үнэмшилтэй байсныг асууна.

Жижиг багаар ажиллах /Group work/

Энэхүү арга нь бусдыг анхааралтай сонсох нэгдсэн дүгнэлтэнд хүрэх, мэдээлэл солилцох, хамтран ажиллах, багаа төлөөлөх, багийн төлөө хариуцлага үүрэг, хүлээх, зэрэг чадварыг амьдралд хэрэглэх боломжийг оюутанд олгодог.



Энэхүү аргын зорилго нь хамтран ажиллах болон бусдыг ойлгох зэрэг чухал чадваруудыг эзэмших боломжийг олгодоггоос гадна өөр хоорондоо зөрүүтэй бодол санааг нэгтгэхэд тусалдаг. Багаар ажиллахад дасгал дээр ажиллуулах шаардлага зүй ёсоор тулгардаг.

Энэ тохиолдолд оюутнууд Эрүүгийн эрх зүйн онолын хичээлээр үзсэн мэдлэгээ амьдралд хэрэглэх чадварыг эзэмшүүлэхийн тулд жишээлбэл, Эрүүгийн хуулийн хэм хэмжээний бүтэц, түүний төрлүүд, гэмт хэргийн бүрэлдэхүүний ангилалт, шалгуур гэх мэт сэдвийн хүрээнд дасгал ажиллаж болно.

Жижиг багаар ажиллуулахад юу анхаарах хэрэгтэй вэ?

Суралцагчид тухайн даалгавар, дасгалыг гүйцэтгэх мэдлэг, дадал, чадвар эзэмшсэн эсэх. Эзэмшээгүй тохиолдолд тэд тухайн даалгаврыг хийж гүйцэтгэх ямар ч сонирхолгүй байдаг.

Багт ажлын зааварчилгааг маш тодорхой өгөх. Нэг дор хоёроос дээш зааварчилгаа өгөхгүй байхыг анхаараарай.

Жижиг багт тухайн даалгавар, дасгалыг хийж гүйцэтгэхэд хангалттай цаг хугацаа олгох. Түрүүлж ажлаа дуусгасан багийг бусдадаа саад болгохгүйн тулд тэднээр юу хийлгэхээ сайтар төлөвлөсөн байна.

Баг 3-6 гишүүнтэй байна. Жижиг багийн хувьд 6 гишүүнтэй байх нь хамгийн дээд хэмжээ байна.

Бие дааж болон хамтаараа ажиллах чадварыг зэрэг хөгжүүлэх буюу тэнцвэртэй байлгахыг зорьсон асуудал, даалгаврыг өгөх ёсгүй. Учир нь жижиг багаар ажиллах аргыг ширээ тойрон сууж, бие даан ажиллах чадварыг бус зөвхөн хамтаар ажиллах чадварыг хөгжүүлэхэд л ашиглах нь илүү тохиромжтой байдаг.

Энэ аргыг тодорхой зорилготойгоор, тохиромжтой үед, дүрмийн дагуу хэрэглэх ёстой болохоос биш зөвхөн лекцийг орлуулах нэгэн арга болгон ашиглаж үл болно.

Баг доторхи удирдлагын асуудлыг мөн тооцож үзэх ёстой. Багаас нэг гишүүн хийсэн зүйлээ танилцуулах тохиолдолд тэр суралцагчийг шударгаар сонгоход анхаарах.

Багаар ажиллах үед гарах дуу чимээг хүлээн зөвшөөрөх ёстой.

Гишүүн тус бүр бусад гишүүдээ төвөггүйгээр харж, харьцах ёстой.

Сургалтын шүүх ажиллагаа /мини шүүх/

Энэ арга нь Эрүүгийн эрх зүйн Ерөнхий ангийн тодорхой сэдвээр оюутнуудыг дүрд тоглуулах замаар уг сэдвийн агуулгыг нээн харуулах зорилготой. Тухайлбал, Гэмт хэрэгт хамтран оролцогчдыг тэдгээрийн гүйцэтгэсэн үүргийг харгалзан тодорхой төрлүүдэд хувааж гүйцэтгэгч, хамжигч захиалагч, хатгагч, зохион байгуулагч гэсэн дүрүүдэд оюутнуудыг тоглуулах замаар хичээлийн агуулгыг гаргах боломжтой юм.

Мөн шүүх хурал явуулах замаар зарим сэдвээр оюутнуудад өөрсдөө мэдлэг бүтээх боломжийг олгодог. Жишээ нь, ял оногдуулах нийтлэг зарчим, хорих ялыг тэнсэх болон ял хойшлуулах үндэслэл, журам, эрүүгийн хариуцлага болон ялаас чөлөөлөх үндэслэл, журмын талаар шүүх хурал явуулах нь лекц унших аргаар хичээлийг явуулсанаас илүү үр дүнтэй байдаг. Шүүх хуралд шүүгдэгч эсвэл хариуцагч хохирогч эсвэл нэхэмжлэгч, шүүгч нараас гадна гэрч, өмгөөлөгч, шинжээч зэрэг тухайн тохиолдлыг шүүхээс хянан шийдвэрлэхэд шаардагдах бүх дүрүүдийг хуваарилаж бэлтгэх хэрэгтэй.

Мөн анги танхимаа шүүхийн танхимийн байдлаар засах хэрэгтэй учир эс дээрх арга нь илүү бэлтгэл, цаг хугацааг шаарддаг. Шүүх ажиллагааны дарааллыг шүүгч нар болон бусад оролцогчдод урьдчилан хэлж өгсөн байна. Хичээлийн анги танхимыг урьдчилан бэлдсэн, хаягийг тавьсан байна. Жишээ нь: шүүгчид, шүүгдэгчид, улсын яллагч, нарийн бичгийн дарга, индэр гэх мэт.

Шүүх хуралдааны дараалал : Шүүгчдийг шүүх хуралдаан болох танхимд орж ирэхэд хуралдаанд оролцогчид босно. Хурлыг даргалагч шүүгч оролцогчдын ирцийг шалгаж, тус бүрийг нь танилцуулах ба эрх, үүргийг нь тайлбарлаж өгсөний дараа шүүгч болон бусад этгээдийг татгалзах хүсэлт байгаа эсэхийг асууна. Шүүхийн хэлэлцүүлэг прокурор яллах дүгнэлт уншсанаар эхэлнэ. Яллах дүгнэлтэд шүүгчдэгчийн үйлдсэн гэх хэргийн тухай, түүний гэм бурууг нотлох баримт, учруулсан хохирол зэргийг бичдэг. Шүүхийн хэлэлцүүлгийн үеэр мөрдөн байцаалтын үеэр шүүгчдэгч, хохирогч, гэрчийн өгсөн тайлбар мэдүүлгийг дахин сонсох, уг хэрэгт цугларсан нотлох баримт бүрийг дахин үзэж, шалгадаг. Шүүхийн хэлэлцүүлгийг дуусгахын өмнө шүүгч хэргийн оролцогчдоос нэмж гаргах санал байгаа эсэхийг асууж, хэрэв тийм санал гаргавал түүнийг хэлэлцэж шийдвэрлэнэ. Ийнхүү шүүгч шүүхийн хэлэлцүүлэг дууссаныг мэдэгдэнэ.

Шүүх хуралдааны шүүмжлэл нь яллагч, хохирогч, өмгөөлөгчийн (хэрэв өмгөөлөгч оролцоогүй бол шүүгчдэгчийн) хэлэх үгээс тус тус бүрдэнэ. Шүүмжлэлийн үеэр оролцогч талууд тухайн хэргийн талаар өөр өөрсдийн бодол, байр суурийг шүүхэд илэрхийлдэг. Тухайлбал, шүүгчдэгчийн гэм бурууг нотолсон эсэх, цугларсан нотлох баримт үнэн зөв, бүрэн дүүрэн эсэх, шүүхээс ямар шийдвэр гаргах саналтай байгаа г.м. Шүүмжлэлийн үеэр оролцогчид үг хэлж дууссаны дараа тэд шүүмжлэлд яригдсан зүйлийн талаар тус бүр нэг удаа тайлбар хэлж болно.

Шүүгчдэгчийн эцсийн үгийг сонссоны дараа шүүгч (шүүх бүрэлдэхүүн) шийдвэрээ гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орно. Зөвлөлдөх тасалгаанд шүүгчдээс өөр хүмүүс байж болохгүй ба зөвлөлдөх үед хэлэлцсэн зүйлийг задруулж болохгүй. Шүүхээс гарах тогтоол нь шийтгэх буюу цагаатгах хэлбэртэй байдаг.

Хэрэв шүүх хурлын үеэр шүүгчдэгч гэм буруутай болохыг улсын яллагч нотолсон бол шүүгч “шийтгэх тогтоол” гаргаж, эрүүгийн хариуцлага оногдуулдаг. Гэмт хэрэг гарсан нь тогтоогдоогүй, эсхүл шүүгчдэгчийн үйлдэл нь гэмт хэрэг биш, эсхүл шүүгчдэгч гэмт хэрэгт оролцсон нь нотлогдоогүй бол шүүх “цагаатгах тогтоол” гаргаж, шүүгчдэгчийг баривчилсан байвал тэр даруй сулладаг. Шүүээс гаргасан тогтоолыг танилцуулна.

Шүүх хурлын дараа дүгнэлт хийхдээ ашиглаж болох асуулт:

Шүүгчдэд шийдвэр гаргахад хэцүү байв уу? Яагаад?

Ямар үндэслэлийг хамгийн сайн болсон гэж үзэж байна вэ?

Хэрэг ингэж шийдэгдэхэд ямар үндэслэл гол нөлөө үзүүлсэн бэ?

Ямар үндэслэл хэлсэн бол илүү сайн болох байсан бэ? Яагаад?

Шүүхийн шийдвэр шударга бус байсан уу? Өөр ямар шийдвэр гаргаж болох байсан бэ?

Энэ хэргийг шүүхээс өөр аргаар шийдэж болох уу?

Энэ шүүх ажиллагааны явцад хүний эрх зөрчигдсөн үү?

Шүүх ажиллагаанд оролцогчид ямар эрх эдэлж, үүрэг хүлээдэг вэ?

Бүх оролцогчид эрхээ эдэлж, үүргээ биелүүлж чадсан уу?



Загвар хичээл /Семинар/

Сэдэв: Гэмт хэрэгт хамтран оролцогчдын ойлголт, төрөл

Хичээлийн зорилго: Гэмт хэрэгт хамтран оролцох талаар лекцээр авсан онолын мэдлэгийг бататгах, амьдралд үйлдэгдсэн тодорхой хэргүүдэд хамтран оролцогчдын төрлийг зөв тогтоох, гэмт хэрэгт хамтран оролцогчдын үйлдлийг төрлөөр нь журамлан зүйлчлэх, гэмт хэрэгт хамтран оролцогчдод эрүүгийн хариуцлага хүлээлгэх /ял оногдуулах/ талаарх Эрүүгийн хуулийн хэм хэмжээг зөв хэрэглэх дадал **чадвар эзэмшихэд** оршино.

Агуулга:

- Гэмт хэрэгт хамтран оролцогчдын ойлголт
- Гэмт хэрэгт хамтран оролцогчдын төрөл
- Захиалагч, гүйцэтгэгч
- Зохион байгуулагч
- Хамжигч, хатгагч
- Зөрчин гүйцэтгэх
- Гэмт хэрэгт хамтран оролцогчдод хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг Эрүүгийн хуульд тусгасан байдал.

Хэлэлцэх асуудал

- Гэмт хэрэгт хамтран оролцогчдын ойлголт, төрөл, төрлүүдэд ангилах шалгуурыг тодорхойлох /гүйцэтгэсэн үүрэг, оролцсон байдал, хэр хэмжээ/
- Захиалагч, түүний үйлдлийн объектив ба субъектив шинж
- Захиалагч, хатгагч хоёрын зааг ялгааг гаргах /өмнөх болон шинэ Эрүүгийн хуулийг харьцуулах/
- Зохион байгуулагч, түүний үйлдлийн объектив ба субъектив шинж
- Гүйцэтгэгч, түүний үйлдлийн объектив ба субъектив шинж
- Хатгагч, түүний үйлдлийн объектив ба субъектив шинж
- Хамжигч, түүний үйлдлийн объектив ба субъектив шинж болон хамжигч нуун далдлагч хоёрын үйлдлийн ялгаатай талыг тодорхойлох
- Хамтран оролцогчдод эрүүгийн хариуцлага хүлээлгэх /ял оногдуулах/ онцлогийг тодорхойлох
- Гэмт хэрэгт хамтран оролцогчдын талаар Монголын эрдэмтэн судлаачдын үзэл баримтлалын талаар хэлэлцэх

Дүгнэлтэд ашиглах асуулт

- Хамтран оролцогчдын төрлийн талаар таны авсан мэдээллүүд танд өмнө нь байгаагүй ямар мэдлэг, чадвар, хандлага бий болгосон бэ?
- Энэ сэдвийг судлах нь Эрүүгийн эрх зүйн хичээлээр ямар сэдвийг цааш гүнзгийрүүлэн судлахад тустай вэ?

Санал болгож буй арга:

Тохиолдол шинжлэх

Жижиг багаар ажиллах

Үйл ажиллагааны дараалал. /Жижиг багаар ажиллах болон тохиолдол шинжлэх аргуудыг сонгон авлаа./

Энэ сэдвээр семинарын хичээлийг явуулахын өмнө лекцийн хичээлээр тодорхой онолын мэдлэг өгсөн байх шаардлагатай бөгөөд хичээл эхлэхийн өмнө багш оюутнууд сэдвийн агуулгыг хэрхэн эзэмшсэн байдлыг тестээр /10-аас илүүгүй нөхцөлтэй/ шалгана.

Хичээлийн явцад олж авсан мэдлэгийг бататгах, холбогдох хуулийн заалтыг хэрэглэх дадал, чадвар олгох зорилгоор тохиолдол шинжлэх аргыг ашиглах нь илүү үр дүнтэй.

Хичээлийн эхэнд оюутнуудыг жижиг багуудад хуваах ба суралцагчдын тоо нэг багшид 20-с хэтрэхгүй байвал зохино.6-с дээшгүй хүнтэй 3 баг байвал тохиромжтой.

Багш бэлтгэсэн даалгавраа /казус-тохиолдол/ дугтуйд хийж багуудад тараан өгнө. Гэхдээ багуудад өгч байгаа даалгавар /казус-тохиолдол/ нь нэг ижил байх шаардлагатай.

Багш баг бүрт очиж даалгавраа ойлгож байгаа эсэх, хүндрэлтэй зүйл гарч байгаа эсэхийг асууж, тайлбарлаж өгнө.

Тараах материалын агуулга: Багшаас баг тус бүрд гэмт хэрэгт хамтран оролцогчдод эрүүгийн хариуцлага хүлээлгэх журам, онцлогтой холбоотой даалгавар /тохиолдол-казус/ өгнө.

Тохиолдол: 2003 оны 3-р сарын18-ны өдөр “Ц” өөрийн найз “Б”, “В”, Т нарыг гэртээ урьж цэргийн баярыг тэмдэглэн дайлж цайлсан байна.Тэд 01 цагийн үед “Ц”-гийнхээс гарч дэлгүүрээс 2 шил архи авч цэцэрлэг дотор ууж суух зуур Т” нь ойролцоох барьцаалан зээлдүүлэх газрыг зааж “энд миний таньдаг хүн ажилладаг юм. Ойрд ажиллахгүй байгаа. Тэр хөдөө явсан сурагтай байна билээ” гэж ярьжээ. “Т”-ийн энэ яриаг сонсоод эзгүй байгаа ломбарднаас эд зүйл хулгайлах санаа “В”-д төрж энэ тухайгаа “Б”-д хэлсэн ба “Ц”, “Т” нарыг та хоёр хариад гэртээ байж бай бид хоёр хүнтэй уулзчихаад араас чинь очъё гэж явуулаад “В” нь нөгөө ломбардны цонхоор орж 2,5 сая төгрөний эд зүйл хулгайлав. Энэ үед “Б” нь ломбардны гадна хүн харж зогсож байсан ба үүнээс өмнө ломбарданд хэрхэн орох, эд зүйл хадгалсан сейфийг эвдэх, юуг хулгайлах, ул мөрөө хэрхэн арилгах талаар “В”-д зөвлөсөн байна. Шөнө 03 цагийн үед “Б”, “В” нар хулгайлсан эд зүйлээ авч “Ц”, “Т” нартай уулзан хулгай хийсэн тухайгаа хэлж хамт Дархан хот руу явсан байна. Тэд Дархан хотод очоод буудалд байрлан хулгайн эд зүйлээ борлуулан мөнгөөр нь архидах зэргээр хэрэглэж дуусгажээ.

Даалгавар:

“Ц”, “Б”, “В”, “Т” нарын үйлдэлд /гэмт хэрэгт хамтран оролцогчидын үүднээс/ ЭЭЗүйн үүднээс дүгнэлт өгнө үү?

Гэмт хэрэг хамтран оролцогчдын төрлийг тодорхойлж, тэдэнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг тодорхойлно уу?

Анхаарах зүйл:

Баг нь хоорондоо зөвлөлдөх, ярилцах, зураглал, бүдүүвчээр илэрхийлэх зэрэг хэлбэрээр казус-тохиолдлын шийдлийг /хариу/ бусдад түгээх тайлбарлах бэлтгэл хийлгэнэ.



Багууд өгөгдлийг харилцан ярилцсаны үндсэн дээр эцсийн шийдлийг боловсруулан нэгтгэж, улмаар нэг гишүүн нь гарч тайлбарлахаас гадна багийн гишүүдээс нэмэлт тайлбарыг хийж болно.

Баг нь бусад багаас гарсан асуултанд хариулах, харилцан мэтгэлцэх /асуултыг няцаах/ замаар мэдээллийг солилцоно.

Бусад багууд дарааллын дагуу дээрх зарчмаар бодлогын шийдлийг тайлбарлана.

Бүх багууд өөрсдийн шийдлийг хэлэлцүүлсэний дараа бусад багуудын шийдэлд үнэлэлт, дүгнэлт өгч харилцан мэтгэлцэнэ.

Дараа нь багш багуудын гаргасан шийдлийг сонссоны дараа тайлбар хийж үнэлэлт, дүгнэлт өгнө.

Багш семинарын хичээлийн эцэст хичээлийн явцад гарсан алдаа, дутагдал, ололттой талыг тэмдэглэн идэвхтэй оролцсон баг болон оюутнуудыг үнэлнэ.

ҮНЭЛГЭЭ

Үнэлгээний зорилго

“Эрүүгийн эрх зүй-1” хичээлээр олж авсан мэдлэгийн хэр хэмжээ, түвшинг тогтоох, оюутнуудын гэмт хэрэг болон эрүүгийн хариуцлагын талаар мэдлэг чадварын баримжаалалд гарсан өөрчлөлтийг бодитойгоор үнэлэх нь уг хичээлийн үнэлгээний гол зорилго болно. Үнэлгээ нь бүхэлдээ зорилгодоо хүрч чадсан эсэхийг илрүүлэхэд чиглэгдэнэ.

Багш оюутнуудын сурч боловсрох эрмэлзлэлийг идэвхжүүлэх сургалтын үр дүнд хүрэх явцад оюутны мэдлэг, чадвар чухам ямар түвшинд байгааг тэдэнд мэдэгдэх, оюутнуудад өөрийгөө үнэлэх боломж олгох, багш өөрийнхөө мэргэжлийн болон заах арга зүйг үнэлэх зорилгыг мөн тавьж ажиллана.

Үнэлгээний журам

Оюутныг үнэлж, дүгнэхдээ доорхи үсгэн дүнг хэрэглэнэ.

“А” үнэлгээ: Сурлагын дээд амжилтыг илтгэх дүн: Эрүүгийн эрх зүйн хичээлийн ухагдахуун, агуулгыг бүрэн дүүрэн ойлгосон, хөтөлбөрт тусгагдсан мэдлэгийг онц сайн эзэмшсэн, бие дааж ном сурах бичиг эх зохиол унших, нэр томьёог оновчтой зөв хэрэглэх, бодлого, тохиолдлыг зөв шийдвэрлэх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай, хичээлд жигд идэвх, санаачлагатай оролцдог, явцын шалгалтанд амжилттай дүн үзүүлсэн болон тодорхой сэдвээр илтгэл тавьсан нийтлэл, өгүүлэл бичсэн байна.

“В” үнэлгээ: Амжилттай суралцсаныг илтгэх дүн: Эрүүгийн эрх зүйн хичээлийн ухагдахуун, агуулгыг сайн ойлгосон, тэдгээрийн мөн чанарыг зөв тайлбарлах, бодлого, тохиолдол бодох, чадвар эзэмшсэн, семинарын хичээлд байнга идэвхтэй оролцдог, явцын шалгалтанд амжилттай дүн үзүүлсэн.

“С” үнэлгээ: Хичээлийн агуулгыг дундаж төвшинд эзэмшсэн байгааг илтгэх дүн: Эрүүгийн эрх зүйн хичээлийн үндсэн ойлголт,- ухагдахууны ихэнхи хэсгийг хангалттай ойлгосон, хялбар бодлого, тохиолдлуудыг шийдвэрлэх чадвартай, семинарын хичээлд идэвхтэй оролцож явцын шалгалтанд хангалттай дүгнэгдсэн.

“D” үнэлгээ: Дундаж төвшнөөс доогуур амжилтыг илтгэх дүн: Эрүүгийн эрх зүйн хичээлийн үндсэн ойлголт, ухагдахууныг жигд ойлгоогүй асуултанд бүрэн

бус хариулсан, семинарын хичээлд жигд бус оролцож явцын шалгалтанд хамрагдсан, хялбар асуулт болон бодлогыг бодох чадвар эзэмшсэн боловч хариулт нь оновчтой бус байна.

F” үнэлгээ: Мэдлэг, чадвар хангалтгүйг илтгэх дүн: тухайн хичээлийн агуулгыг эзэмшиж чадаагүй, хялбархан асуултанд хариулах, бодлого тохиолдол шийдвэрлэх чадваргүйг илтгэнэ. Үсгэн, процентон болон тоо /оноо/-н үнэлгээг дараахь жишгээр нэгээс нөгөөд шилжүүлнэ.

Үсгэн үнэлгээ	Тоон үнэлгээ	Хувь
A	4.0	90-100
B	3.0	80-89
C	2.0	70-79
D	1.0	60-69
F	0	0-59

Жич : Оюутан “F” үнэлгээ авсан тохиолдолд тухайн хичээлийг хангалтгүй судалсанд тооцох, 2 удаа “F” үнэлгээ авсан тохиолдолд хичээлийн агуулгыг дахин судлуулна.

Жишиг үнэлгээ:

Ирц	-	10
Идэвх	-	20
Явцын шалгалт-		20
Бие даалт	-	10

Явцын оноо 60, семестрийн шалгалтын оноо 40 байх, үүнээс босго оноо 40 байвал зохино.

Үнэлгээний шалгуур

Үнэлэх зүйл	Үнэлэх жишиг, шалгуур
Мэдлэг	- Асуудлын мөн чанарыг хэрхэн ойлгож, тусгаж байгаа байдал - Асуудалд онолын үндэстэй хариулж чадаж байгаа эсэх - Мэдлэгээ бусдад түгээх, дамжуулах, тайлбарлаж чадаж байгаа эсэх - Тухайн судлагдахууны тодорхойлолт гаргах, харьцуулалт хийх, харилцан хамаарал, зүй тогтлыг тодорхойлох арга зүйг эзэмшсэн эсэх - Хариулт болон үзэл бодлынхоо үндэслэл, нотолгоог гаргаж байгаа байдал - Асуудалд онолын үндэстэй хариулж чадаж байгаа эсэх
	- Мэдлэгээ бусдад түгээх, дамжуулах, тайлбарлаж чадаж байгаа эсэх - Тухайн судлагдахууны тодорхойлолт гаргах, харьцуулалт хийх, харилцан хамаарал, зүй тогтлыг тодорхойлох арга зүйг эзэмшсэн эсэх - Хариулт болон үзэл бодлынхоо үндэслэл, нотолгоог гаргаж байгаа байдал



Чадвар	- Тодорхой онолын мэдлэгийг ашиглан /үндэслэл, нотолгоо болгох жишээ баримт татах, тайлбарлах/ тухайн асуудлыг тайлбарлаж шийдвэр гаргаж чадаж байгаа эсэх - Бодлого бодох, тохиолдол шийдвэрлэхдээ онолын мэдлэгээ ашиглаж чадаж байгаа эсэх - Баримт бичиг боловсруулах чадварт суралцсан байдал - Амаар болон бичгээр өөрийгөө илэрхийлэх чадварын хөгжлийн түвшин /соёлтой мэтгэлцэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх хамгаалах, эсрэг тэсрэг үзэл бодлыг хүлээн зөвшөөрөх/ - Олж авсан онолын мэдлэгээ практикт хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж байгаа байдал, онол практикийн харилцан уялдаа холбоо, практикт тулгарч байгаа хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлож байгаа байдал /шүүхийн шийтгэх тогтоолд үнэлэлт, дүгнэлт өгөх/ - Дүрд тоглох чадвар, арга барилыг эзэмшсэн байх
Хандлага	- Өөрийн үзэл бодол, байр суурь, үнэлгээ дүгнэлтийг илэрхийлж чадаж байгаа эсэх, ийнхүү илэрхийлэхдээ бусдын үзэл бодол, байр сууринд хүндэтгэлтэй хандаж түүнээс үнэ цэнэтэй зүйлийг олж харж, авч чадаж байгаа эсэх - Багийн гишүүн байх бусдыгаа төлөөлөх чадварын хөгжилт - Ялгаатай үзэл хандлага, байр сууринд хандах хандлага, түүнийг хүлээн зөвшөөрч байгаа байдал

Бүлэг, сэдвийн жишиг үнэлгээ

Сэдэв: Гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж, ангилалт

Сэдвийн зорилго:

- Гэмт хэргийн ойлголт, түүний мөн чанар, үндсэн шинж, ангилалтын талаар онолын мэдлэг олгох
- Амьдралд үйлдэгдсэн хэрэгт /үйл явдалд/ Эрүүгийн эрх зүйн үүднээс үнэлэлт дүгнэлт өгөх, гэмт хэрэг мөн эсэхийг тогтоох
- Эрх зүйн бусад зөрчлөөс гэмт хэргийг ялгах чадвар эзэмшүүлэх
- Гэмт хэргийн ангилалт болон ангилах шалгуурыг тодорхойлох
- Гэмт хэрэгтэй холбоотой Эрүүгийн эрх зүйн бусад институтыг судлах цаашид хэрэглэх хандлага төлөвшүүлэх

Мэдлэгийг үнэлэх шалгуур:

- Гэмт хэргийн мөн чанар, үндсэн шинж, ангилалтын талаар нээлттэй болон хаалттай асуултанд хариулж байгаа байдал. /Агуулга, үнэлгээний асуулт болон нэрлэсэн асуултанд хариулж байгаа байдал/
- Гэмт хэргийн ойлголт, үндсэн шинжүүдийн мөн чанарыг нэг бүрчлэн онолын үүднээс төдийгүй тодорхой жишээн дээр тайлбарлаж байгаа эсэх
- Гэмт хэргийн ангилалтын практик ач холбогдлыг амьдралын жишээн дээр тайлбарлаж чаддаг болсон эсэх
- Бусад асуудлууд, ойлголтуудтай /Гэмт хэрэг ба бусад эрх зүйн зөрчлийн харилцан хамаарал, Эрүүгийн хариуцлага, ялын ойлголттой хэрхэн хамаарах/ холбогдох шинжийг гаргаж чадаж байгаа эсэх.

- Хариулт болон үзэл бодлынхоо үндэслэл, нотолгоог гаргаж байгаа байдал зэргийг үнэлнэ.

Чадварыг үнэлэх шалгуур

- Гэмт хэргийн нийгэм улс төр, эрх зүйн мөн чанарыг тодорхой жишээ үндэслэгээнд тулгуурлан тайлбарлаж чадаж байгаа эсэх,
- Тодорхой жишээн дээр гэмт хэргийн үндсэн шинжүүдийг зөв тайлбарлаж байгаа
- Гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийн ялгааг гаргахдаа тухайн асуудалд хамааралтай жишээ, баримт, үндэслэл, нотолгоог зөв сонгож чадаж байгаа эсэх,
- Гэмт хэргийг эрх зүйн бусад зөрчлөөс ялган зүйлчлэх талаар тодорхой өгөгдлийг /тохиолдлыг/ зөв шийдвэрлэж, хуулийн үндэстэй шийдвэр гаргаж байгаа эсэх,
- Шүүхийн шийдвэрт болон бусад эрх зүйн актад үнэлэлт, дүгнэлт хийх хуулийг зөв хэрэглэх чадвар эзэмшсэн эсэх,

Хандлагыг үнэлэх шалгуур

- Гэмт хэргийн тухай асуудлыг ЭЭЗүйн Ерөнхий ангийн гэмт хэрэгтэй холбоотой бусад асуудалтай хэрхэн холбож байгаа эсэх,
- Гэмт хэргийг эрх зүйн бусад зөрчлөөс ялгах чадвар төлөвшсөн эсэх,
- Гэмт хэрэгтэй холбоотой Эрүүгийн хуулийн хэм хэмжээг зөв хэрэглэх дадал төлөвшсөн эсэх,
- Өөрийн үзэл бодлыг илэрхийлэх, бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандаж байгаа эсэх,
- Эсрэг байр суурь бүхий үзэл бодлыг хүлээн зөвшөөрч чадаж байгаа эсэх
- Аливаа асуудалд хууль ёс, шударга, энэрэнгүй ёсны зарчмын үүднээс хандаж байгаа эсэх
- Бусдаас суралцах эрмэлзлэлтэй болсон эсэх
- Асуудалд тал бүрээс хандах хандлага төлөвшиж байгаа эсэх
- Асуудалд өөрийн гэсэн итгэл үнэмшил бий болж байгаа эсэхийг үнэлнэ.

Жишиг даалгавар:

Даалгаврын хугацаа:

Лекцийн хичээл орсоноос хойш 7 хоног.

Авах оноо:

Асуултанд хариулсан байдалд: 33 хүртэл оноо

Бодлого, тохиолдол шинжлэхэд: 33 хүртэл оноо

Эссе бичих: 33 хүртэл оноо

Нийт авах оноо:

100

НЭГ: Асуулт.

- Гэмт хэргийн үндсэн шинж болон мөн чанарыг тодорхойлно уу?
- Эрх зүйн бусад зөрчлөөс гэмт хэргийг ялгах онцлогуудыг тайлбарлана уу?
- Гэмт хэргийн эрүүгийн хуульд заасан болон нийгэмд аюултай байх, гэм буруутай болон эрүүгийн хариуцлага хүлээх шинжүүдийн аль нь эрүүгийн хуульд тусгагдаагүй вэ?
- Гэмт хэргийн нийгэмд аюултай шинж ямар хүчин зүйлүүдээр тодорхойлогдох вэ?
- Гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан бол овч ялимгүйн учир нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхүйн ойлголт, хууль зүйн үр дагаварыг тодорхойлно уу?
- Гэмт хэргийг ангилах шалгууруудын талаар ярь. Одоогийн хүчин төгөлдөр



үйлчилж байгаа эрүүгийн хуулиар гэмт хэргийг ямар шинжээр нь шалгуур болгон ангилсан бэ?

- Гэмт хэргийг ангилж байсан түүхэн уламжлал болон бусад орнуудын туршлага, онцлогийг ярих.

ХОЁР. Тохиолдол шинжлүүлэх

Гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж, ангилалт сэдвүүдээр оюутан бодлого тохиолдол өгч шинжлүүлэх. Өгөгдсөн тохиолдлыг бодож шийдвэрлэсэн байдлыг үнэлэхдээ оюутан онолын үндэслэлээ хэрхэн гаргаж байгаа байдал мэдлэгээ бусдад түгээж байгаа болон тайлбарлаж байгаа байдал зэргийг харгалзана. Түүнчлэн оюутан өөрийн гаргасан үндэслэгээ, тайлбараа илэрхийлж, хамгаалж байгаа байдал, Эрүүгийн хуулийн хэм хэмжээг зөв хэрэглэж байгаа зэргийг харгалзан үзэж үнэлнэ.

ГУРАВ. Гэмт хэргийн ангилалт, түүний ЭЗЗүйн учир холбогдол сэдвээр эссе бичүүлэх.

Эссег үнэлэх шалгуур.

- Сэдвийнхээ зорилгыг тодорхойлсон байдал Утгын хувьд нэгдмэл, логик дараалалтай байгаа эсэх
- Тухайн асуудлын бичлэг, дүрслэл, найруулгын сонголт, үг хэллэгийн сонголтыг оновчтой хийсэн эсэх
- Өгүүлбэрүүдийн төгсгөл, түүний давталт цөөн байх Мэдлэгт тулгуурласан, оновчтой жишээ ашигласан эсэх Онольш эх сурвалжуудыг ашиглан, өөрийн санал, дүгнэлт хийсэн байх Ялгаатай онол, үзэл баримтлалыг тайлбарласан байх
- Өөрийн санаа, үзэл бодлыг гаргасан, гол санаагаа тодорхой үндэслэлтэй тусгасан байдал
- Дэвшүүлсэн санаагаа гаргахдаа үндэслэл, нотолгоотой хийсэн эсэх Асуудалд шүүмжлэлтэй хандсан байдал
- Шинжлэх ухааны бусад онол, тайлбаруудтай харьцуулж дүгнэлт хийсэн эсэхийг харгалзан үнэлнэ.

ХОЁР. ОНОЛЫН МЭДЛЭГ, ДАСГАЛ

I БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Бүлгийн зорилго: Эрүүгийн эрх зүйн ойлголт, мөн чанар, чиг үүрэг, зохицуулах зүйл, арга, Эрүүгийн хуулийн ойлголт, зорилт, зарчим, тогтолцоо, Эрүүгийн хуулийн үйлчлэх хэмжээ хязгаарын талаар суурь мэдлэгтэй болж, Эрүүгийн хуулийн нийтлэг хэм хэмжээг хэрэглэх, эрүүгийн хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт үнэлэлт дүгнэлт өгөх дадал, чадвар эзэмгийж, Эрүүгийн эрх зүйн ерөнхий ангийн бусад институт болон тусгай ангийн хэм хэмжээг хэрэглэх бэлтгэлтэй болох хандлага төлөвшинө.

СЭДЭВ 1. ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН. ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОРИЛТ, ХАМГААЛАХ ЗҮЙЛ, ТОГТОЛЦОО

Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан

Эрүүгийн эрх зүй бол эрүүгийн хууль, түүний нийгмийн амьдралаас нөхцөлдсөн байдал, үр нөлөө, эрүүгийн хуулийн хөгжлийн болон төгөлдөржүүлэх зүй тогтол, хандлага, эрүүгийн эрх зүйн зарчим, эрүүгийн хуулийн түүхэн хөгжлийн тухай үзэл санаа, төсөөллийн талаарх тогтолцоо юм¹. Энэ шинжлэх ухаан эрүүгийн эрх зүйн үндсэн зарчмуудыг судлаж, гэмт хэрэг, **эрүүгийн хариуцлага болон бусад институт, хэм хэмжээний агуулга, нийгмийн үнэт зүйлс, нийтлэг эрх ашгийг хамгаалах арга, механизмыг нээн илрүүлэх, эрүүгийн эрх зүйн үр нөлөөг дээшлүүлэх** зорилготой.

Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан нь гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх онол, арга зүйг тодорхойлох шинжлэх ухааны үндэслэлийг сулдаж эрүүгийн хууль тогтоомжийг **боловсронгүй болгох санал, зөвлөмж** боловсруулдаг.

Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны номлол, үзэл баримтлалд тулгуурлан дагаж мөрдөж буй Эрүүгийн хууль тогтоомжийг тайлбарладаг.

Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжлийн үр дүнд үндэсний **эрүүгийн болон ялын бодлого тодорхойлогддог**. Шинжлэх ухааны үндэслэл бүхий эрүүгийн бодлогын тусламжтайгаар нийгэмд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, ямар төрөл, хэмжээний ял, бусад төрлийн эрүүгийн хариуцлага хүлээлгэх, үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохтой холбоотой бусад институтыг хэрхэн бүрдүүлэх үзэл баримтлал тодорхойлогддог бөгөөд ялын бодлогын тусламжтайгаар нийгмийн хөгжил, гэмт явдлын байдал, хандлагад нийцүүлэн гэмт хэрэгт ял ногдуулахад баримтлах үзэл баримтлал төлөвшдөг. Орчин үеийн эрүүгийн эрх зүйд эрүүгийн хариуцлага, ялыг илүү **хүмүүнлэг, энэрэнгүй, үр нөлөөтэй** болгох хандлага давамгайлж байна.

¹ С.Нарангэрэл. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /Ерөнхий анги/. УБ. 1999. 23 дахь тал



Эрүүгийн эрх зүй нь нийгмийн үнэт зүйлс, хүмүүсийн нийтлэг эрх ашгийг хамгаалах эрх зүйн салбар болохын хувьд Монгол Улсад нэлээд хэмжээгээр судлагдаж Р.Гүнсэн, ЖАВХИА, Б.Содовсүрэн, Г.Совд, Б.Ламжав, С.Нарангэрэл, С.Жанцан нарын 30 орчим эрдэмтэд эрүүгийн эрх зүйн чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалж, эрдэм шинжилгээ, сургалтын олон бүтээл туурвисан. Эдгээр эрдэмтэд, судлаачид тухайлбал, Б.Содовсүрэн. “БНМАУ-ын Эрүүгийн эрх/Ерөнхий анги/” УБ. 1964, Г.Совд. “БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс” УБ. 1973, С.Нарангэрэл. “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй” УБ. 1998,1999. С.Жанцан “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /Альбом схем/УБ. 1999 зэрэг олон бүтээл туурвижээ. Түүнчлэн эрүүгийн эрх зүйч эрдэмтэд, практик ажилтануудын оролцоотойгоор Эрүүгийн хуулийн тайлбарыг боловсруулан практик хэрэглээнд ашигладаг.

Сүүлийн жилүүдэд эрүүгийн эрх зүйн харьцуулсан судлалын чиглэл түлхүү хөгжиж, үндэсний эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны онол, практикийг дэлхий дахины жишигт дүйцүүлэх, бусад орны дэвшилтэт үзэл хандлага, оновчтой зохицуулалтыг судлах оролдлого хийгдэж байна.

Эрүүгийн эрх зүйн зорилт

Эрүүгийн эрх зүй бол хүмүүсийн нийтлэг эрх ашгийг хамгаалахад зориулагдсан эрх зүйн салбар юм. Монгол Улсын Эрүүгийн хуульд энэхүү зорилтыг “Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам, энхтайван, хүн төрөлхтөний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалахад оршино”² хэмээн томъёолсон. Энэхүү зорилтыг хангахын тулд хүн, нийгэм, төрд аюултай ямар **үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, түүнд ногдуулах эрүүгийн хариуцлагын болон ялын төрөл хэмжээ, хязгаарыг тогтоосон хэм хэмжээний тогтолцоог эрүүгийн эрх зүй гэдэг.**

Эрүүгийн эрх

Эрүүгийн эрх зүй нь ямар нэг төрлийн нийгмийн харилцааг зохицуулдаггүй, харин нийгмийн бүхий л төрлийн харилцааны амин чухал хэсгийг хамгаалдаг. Хэдийгээр нэг талаас нийгмийн буюу хүмүүсийн нийтлэг эрх ашгийг илэрхийлж, хамгаалах төр - нөгөө талаас тэрхүү нийтлэг эрх ашигт халдаж гэм хор учруулсан гэмт хэрэгтэн хоёрын хооронд үүсэж буй гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын асуудлыг эрүүгийн эрх зүйгээр зохицуулж буй мэт боловч энэхүү зохицуулалтын зорилго нь Үндсэн хууль болон бусад хуулиар тогтоосон **үнэт зүйлс, нийтлэг эрх ашгийг хамгаалах** явдал юм. Улс орнууд эрүүгийн хууль тогтоомжоо хамгаалах ёстой гэж үзсэн эрх ашгаа ач холбогдол, үнэт чанараар нь эрэмблэн системчилдэг. Дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулиар “**Улсын тусгаар тогтол; Үндэсний аюулгүй байдал; Хүний эрх, эрх чөлөө; Нийтийн болон хувийн өмч; Үндэсний баялаг; Байгаль орчин; Эрх зүйн журам; Хүн төрөлхтөний аюулгүй байдал, энхтайван**” гэсэн үнэт зүйлсийг энэ дарааллаар эрэмбэлж хамгаалахаар заасан.

Түүнчлэн эрүүгийн эрх зүй нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй. Хүн, нийгэм, төрд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцож, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл хэмжээг тогтоосноор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийтлэг болон тусгай зорилт биелдэг.

² Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1 дүгээр зүйл. ТМ. 2002. № 5

Эрүүгийн эрх зүйн тогтолцоо

Эрүүгийн эрх зүй нь Ерөнхий ба Тусгай ангиас бүрдэнэ. Ерөнхий ангийн хэм хэмжээгээр Эрүүгийн эрх зүйн зорилт, зарчим болон бусад үндсэн институтыг тогтоож өгдөг. Тухайлбал, Эрүүгийн хууль, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл журам, гэмт хэрэг ба гэм буруугийн асуудал, ял, түүний зорилго, ялын тодорхой төрлүүд болон түүнийг ногдуулах ба ялаас чөлөөлөх журам зэрэг **нийтлэг асуудлууд Ерөнхий ангийн хэм хэмжээнд** тусгагдсан байдаг.

Тусгай ангийн хэм хэмжээгээр тодорхой төрлийн гэмт хэргийн бүрэлдүүн болон ногдуулах ялын төрөл, хэмжээг тогтоодог.

Эрүүгийн эрх зүйн Ерөнхий ба Тусгай анги нь хоорондоо салшгүй холбоотой. Тусгай ангид заасан ямар нэгэн гэмт хэргийн бүрэлдүүнийг Ерөнхий ангид заасан гэмт хэргийн тухай ерөнхий ойлголтыг ашиглахгүйгээр тодорхойлох боломжгүй, түүнчлэн Тусгай ангид заасан тодорхой төрөл, хэмжээний ялыг ногдуулахдаа Ерөнхий ангийн хэм хэмжээгээр тодорхойлсон ялын мөн чанар, зорилгыг ойлгохгүйгээр хэрэглэх боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн эрх зүйн Тусгай ангийг хэрэглэхийн тулд **Ерөнхий ангийн хэм хэмжээг удирдлага** болгодог. Эсрэгээрээ Ерөнхий анги нь тодорхой төрлийн гэмт хэрэг, түүнд ногдуулах ялын шинжийг ерөнхийлөн нэгтгэсэн хэм хэмжээ билээ. Харин амьдрал дээр гарсан гэмт хэрэг, тохиолдлыг дан ганц Ерөнхий ангийн хэм хэмжээг ашиглан шийдвэрлэх боломжгүй. Тийм учраас тодорхой гэмт хэргийн бүрэлдүүний шинжийг тогтоосон **Тусгай ангийг хэм хэмжээг журамлан** шийдвэрлэнэ.



Хяналтын асуулт

1. Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааныг тодорхойлно уу?
2. Эрүүгийн хуулиас өөр хуулиар хориглосон нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйн төлөө хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болох уу?
3. Албан тушаалын байдлаа ашиглан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ хүндрүүлэн үзэх нь “Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчимтай зөрчилдөх үү?”
4. Шударга ёсны болон энэрэнгүй ёсны зарчмын агуулгыг тайлбарла Эдгээр зарчмууд хоорондоо зөрчилдөх үү?
5. Эрүүгийн хуулийг тайлбарлаж байгаа нь түүнийг төсөөтэй хэрэглэж байгаа хэрэг мөн үү?
6. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болох уу?



Сорил

1. Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан нь:
 - a. Эрүүгийн хууль
 - b. Эрдэмтдийн үзэл бодол
 - c. Эрүүгийн эрх зүйн номлол (доктрин)
 - d. Нийгмийн шинжлэх ухаан
2. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны гол төлөөлөгчид
 - a. Г.Совд
 - b. Б.Чимид
 - c. Ж.Амарсанаа
 - d. ЖАвхиа
3. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн анхны сурах бичгийг зохиогч
 - a. Г.Совд
 - b. Ж.Авхиа
 - c. С.Нарангэрэл
 - d. К.Жанцан
 - e. С.Жанцан
 - f. Б.Содовсүрэн
4. Эрүүгийн эрх зүй бол:
 - a. Нийгэмд аюултай ямар үйлдлийг гэмт хэрэгт тооцож ямар ял болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ оногдуулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын болон эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх үндэслэлийг тодорхойлсон салбар эрх зүй
 - b. Бүх төрлийн ял, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулсан салбар эрх зүй
 - c. Эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус харилцааг зохицуулсан салбар эрх зүй
 - d. Нийгэмд аюултай үйлдлийг гэмт хэрэгт тооцож түүнд хүлээлгэх ялыг тодорхойлох эрх зүйн хэм хэмжээний нийлбэр
5. Эрүүгийн эрх зүйн зорилтыг Монгол Улсын Эрүүгийн хуульд дараах агуулгаар томъёолсон (хамааралтайг ол):
 - a. Хүний эрх} эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах
 - b. Нийгмийн харилцааг зохицуулах
 - c. МУ-ын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах
 - d. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг засан хүмүүжүүлэх

СЭДЭВ 2. ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗАРЧИМ

Эрх зүйн зарчим бол хууль тогтоох болон хэрэглэх үйл ажиллагаанд заавал хэрэглэгдэх **суурь үзэл баримтлал** юм. Өөрөөр хэлбэл зарчмуудаар нь уг салбар эрх зүй ямар байх ёстой талаар үзэл баримтлалыг илэрхийлж, бэхжүүлдэг. Энэ үзэл баримтлал нь эрүүгийн эрх зүйн онолоор боловсрогдох бөгөөд Эрүүгийн хуулиар бэхжүүлсэнээр бодит хэлбэрийг олдог юм. Монгол Улсын Эрүүгийн хуульд зарчмуудыг тусгай бүлэг болгон хуульчилсаны дээр Монгол Улсын Үндсэн хуульд эрүүгийн эрх зүйн материаллаг болон процессын зарим зарчмыг тусгасан. Тухайбал, Үндсэн хуулийн 16.15 дугаар зүйлд гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болох талаар болон гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглох зэрэг зарчмыг бэхжүүлжээ.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 3-9-р зүйлд хууль ёсны, гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, шударга ёсны, энэрэнгүй ёсны, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зэрэг зарчмууд бэхжүүлэгдсэн.

Хууль ёсны зарчим

Эрүүгийн эрх зүйн анхдагч, тулгуур зарчим. Латины *Nul-lum crimen sine lege* буюу Хуулиар хориглоогүй бол гэмт хэрэг биш гэсэнтөмъёоллоор илэрхийлдэг. Энэ зарчим нь:

- Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох эсэхийг зөвхөн хуулиар тогтооно;
- Зөвхөн хэрэг үйлдэгдэхээс өмнө хуулиар урьдчилан бүрэлдүүнийг нь тогтоосон үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцно. Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлсэн буюу чөлөөлсөнөөс бусад тохиолдолд хуулийг буцааж хэрэглэхгүй;
- Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй. Эрүүгийн хуулийг тайлбарлах, хэрэглэхдээ хуулийн тодорхойлолтыг яв цав баримтлана гэсэн мөрдлөгүүдийг агуулдаг.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2 дугаар зүйлд. Эрүүгийн хууль тогтоомж нь энэ хуулиас бүрдэнэ. Үйлдэл, эс үйлдэхүйг шинээр гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага тогтоосон Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль энэ хуулийн бүрэлдүүн хэсэг болно. Мөн хуулийн 3 дугаар зүйлд “Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, түүнд ногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг зөвхөн энэ хуулиар тодорхойлно” гэж тус тус заасан.

Гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарчим

Эрүүгийн эрх зүй нь хүний эрх ашгийг хамгаалах зорилгоор хүний эрх, эрх чөлөөнд халдаж хамгийн хүнд хууль зүйн хариуцлага ногдуулж байдаг учраас зөвхөн **гэмт хэрэг үйлдсэн**

гэм буруугай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарчмыг баримталдаг. Хуулиар тогтоосон журмын дагуу гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь тогтоогдоогүй болон гэм буруугүйгээр эрүүгийн хуульд заасан хор уршиг учруулсаныг гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй. Энэ зарчмыг латины *actus non facit reus mens sit rea* буюу *гэм буруутай үйлдэл болон гэм буруутай хүсэл зоригийн нэгдэл байхгүй бол эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохгүй* гэсэн томъёололоор илэрхийлдэг.



Зөвхөн Эрүүгийн хуульд заасан гэм буруугийн **санаатай** болон **болгоомжгүй** хэлбэрээр гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хүлээлгэнэ. Тодорхой хэрэг, тохиолдол бүрийг Эрүүгийн хуульд заасан гэм буруугийн хэлбэрээр үйлдэгдсэн байхыг шаардана. Тухайлбал, Эрүүгийн хуульд зөвхөн гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдсэн тохиолдолд гэмт хэрэгт тооцохоор заасан үйлдлийг болгоомжгүйгээр үйлдэж гэм хор учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй. Жишээ: Монгол Улсын Эрүүгийн хуулийн 153 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх. Харин гэм буруугүйгээр бусдад гэм хор учруулсан байвал эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал яригдахгүй. Бүр эртний Римийн эрх зүйд “*Casus a nullo praestantur*” буюу “*тохиолдлын төлөө хэнд ч хариуцлага хүлээлгэж болохгүй*” гэсэн мөрдлөгийг баримталдаг байсан нь ийнхүү эрүүгийн эрх зүйн зарчим болжээ.

Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим

Энэхүү зарчим нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд заасан “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн зарчимд үндэслэсэн.

Хүн бүр хуулийн өмнө тэгш эрхтэй. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд түүний **үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролыг үл харгалзан** эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Тэдгээрийг зөвхөн хуульд заасан үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

Дархан эрх, эрх ямба эдэлж буй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал нь энэ зарчимтай зөрчилдөхгүй. Дархан эрх, эрх ямба нь тухайн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй зөвхөн ийм хүмүүсийг эрүүгийн хариуцлагад татах тусгай журам тогтоосоноор нийтийн ашиг тусын төлөө явуулж буй үйл ажиллагаагаа баталгаатай явуулах нөхцөлөөр хангаж өгдөг.

Шударга ёсны зарчим

Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь тухай этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон буюу **гэмт хэргийн нийгмийн аюулын шинж**

чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалд тохирсон байх ёстой. Энэ зарчим нь анх talio esto буюу нүдийг нүдээр гэх талионы зарчмыг халан гэмт хэрэг үйлдсэн этгээд үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон ял ногдуулах (тохирсон хариу арга хэмжээ биш) үзэл баримтлалаас үүсэн гарсан гэдэг.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь гэмт хэрэг бүрд харилцан адилгүй, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд **хувьд нь тохирсон буюу ялгамжтай** байх нь шударга юм. Нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ болон харилцан адилгүй нөхцөл байдалд гэмт хэрэг үйлдсэн хүмүүст ижил төрлийн ял ногдуулах нь шударга бус юм. Түүнчлэн хэдийгээр үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал нь ойролцоо байвч гэмт хэрэг үйлдсэн хүн бүрт ижил төрөл, хэмжээтэй эрүүгийн хариуцлага хүлээлгэх (тухайлбал адилхан гэмт хэрэг үйлдсэн насанд хүрсэн хүн болон хүүхдэд ижил ял ногдуулах) нь шударга бус юм.

Хуульд ялын хэд хэдэн төрлөөс болон ялын дээд доод хэмжээний хүрээнд сонголт хийх хангалттай боломжтойгоор тогтоох нь ялыг ялгамжтай ногдуулах боломж олгож шударга ёсны шаардлагыг хангадаг.

Шударга ёсны зарчмын бас нэг агуулга нь Латины Non bis in idem буюу Нэг гэмт хэрэгт хоёр удаа хариуцлага хүлээлгэхгүй гэсэн томъёоллоор илэрхийлдэг. Үүнийг Монгол Улсын Эрүүгийн хуульд Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тухайн гэмт хэрэгт нь зөвхөн нэг удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” хэмээн томъёолсон. Энэ томъёолол нь **гэмт хэрэг үйлдсэн этгээдэд зөвхөн нэг удаа** хариуцлага хүлээлгэнэ гэсэн утга санааг илэрхийлнэ.

Энэрэнгүй ёсны зарчим

Энэрэнгүй ёсны зарчим нь гэм буруутай этгээдийг цээрлүүлэхийн зэрэгцээ **гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны болон материаллаг хохирлыг нөхөн төлүүлж** учруулсан гэм хороо арилгасан тохиолдолд **нийгмээс тусгаарлахгүйгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх** ёстой.

Гэмт хэрэгтэн идэвхгүйгээр шийтгэл хүлээхээс идэвхтэйгээр хохирлоо төлөх нь чухал. Түүнчлэн учруулсан гэм хороо арилгасан тохиолдолд гэмт хэргийн нийгмийн аюул үгүйсгэгдэх буюу багасч түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын арга хэмжээ хөнгөрөх учиртай.

Энэ зарчмын дагуу гэмт хэрэг үйлдсэн этгээд гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн, хохирогчтой эвлэрсэн тохиолдолд *эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, ял хөнгөрүүлэх, ял хойшлуулах, ял тэнсэх болон хорих ял эдлэхээс хугацаанаас өмнө тэнсэн суллах* үндэслэл бий болдог.

Энэ зарчмыг Монгол Улсын Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төр, алдар хүндийг нь гутаах зорилго, хэлбэр агуулж болохгүй” хэмээн томъёолсон.

Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх зарчим

Эх газрын эрх зүйн бүлийн орнуудад **эрүүгийн хариуцлагыг зөвхөн** гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай **хувь хүнд** хүлээлгэдэг. Хэн нэгэн этгээдийн гэм буруутай үйлдэлд түүний ойр дотны хүмүүс тухайлбал, эцэг, эх, үр хүүхэд, эхнэр, нөхөр, төрөл садан, ойр төрлийн хүмүүс нь давхар шийтгүүлэх ёсгүй юм. Эл зарчмыг Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 -т “Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно” гэсэн томъёоллоор оруулсан.

Түүнчлэн энэ зарчим гэм буруутай үйлдлийг зөвхөн хувь хүнд холбогдуулж хэрэглэхийг шаарддаг. Нэг гэмт хэргийг хэд хэдэн хүн хамтран үйлдсэн тохиолдолд хамтран оролцогчдын хэрэг бүрт нь тохирсон ялыг ногдуулна.

Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим

Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд эрүүгийн хариуцлагаас зайлсхийх, ял завших явдал гарах ёсгүй. Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим нь хуульд заасан журмын дагуу эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх, ял хойшлуулах, тэнсэх зэрэг журмыг хэрэглэхэд саад болохгүй. Зөвхөн хуульд заасан журмын дагуу эрүүгийн хариуцлага ялаас чөлөөлж, ял хойшлуулж, тэнсэж байгаа нь хууль ёсны зарчим болон энэ зарчимтай нийцэж байгаа хэрэг.



Анхаарах зүйл

Эрүүгийн эрх зүйн зарчмууд нь хууль тогтоогчид болон хууль сахиулагчдад зориулагдсан. Эдгээр зарчмууд нь хууль тогтоогчийн хувьд тодорхой эрх зүйн зохицуулалт хийхдээ баримтлах чиг баримжаа болдог. Хууль сахиулагчийн хувьд Эрүүгийн хуулийн тодорхой хэм хэмжээг тайлбарлах, утга санааг тодорхой болгоход баримтлах чиг баримжаа болно.



Хяналтын асуулт

1. Эрүүгийн хуулиас өөр хуулиар хориглосон нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйн төлөө хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болох уу?
2. Албан тушаалын байдлаа ашиглан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ хүндрүүлэн үзэх нь “Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим” -тай зөрчилдөх үү?
3. Шударга ёсны болон энэрэнгүй ёсны зарчмын агуулгыг тайлбарла. Эдгээр зарчмууд хоорондоо зөрчилдөх үү?
4. Эрүүгийн хуулийг тайлбарлаж байгаа нь түүнийг төсөөтэй хэрэглэж байгаа хэрэг мөн үү?
5. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болох уу?



Сорил

1. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн зарчмыг ол.

- a. Нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцох
- b. Хуулийг ёсны
- c. Мэтгэлцэх
- d. Ардчилсан ёс

2. Хууль ёсны зарчмын агуулга:

- a. Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, туунд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэтжээг зөвхөн Эрүүгийн хуулиар тодорхойлж, эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхийг хориглоно
- b. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ
- c. Гэмт хэрэг үйлдсэн гэмт буруутай этгээдэд түүний үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролыг үл харгалзан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.
- d. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тухайн гэмт хэрэгт нь зөвхөн нэг удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ

3. Доорх тайлбаруудын аль нь энэрэнгүй ёсны зарчмын агуулгатай нийцэж байна вэ?

- a. Эрүүгийн хууль нь хүний аюулгүй байдлыг хангана*
- b. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял, үү хариуцлагын бусад арга хэмжээ нь хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төр, алдар хүндийг нь гутаах зорилго, хэлбэр агуулж болохгүй*
- c. Ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэтжээ нь гэмт хэргийн нийгмийн аюулын ийнж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалд тохирсон байна*
- d. эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхийг хориглоно*



ДАСТАЛ 1. ШУДАРГА ЁС УУ ЭСХҮЛ ЭНЭРЭНГҮЙ ЁС УУ?

(Маргаантай асуудлаар явуулах хэлэлцүүлэг)

Эрүүгийн эрх зүйн зарчмуудын дотроос шударга ёсны зарчим болон энэрэнгүй ёсны зарчим нь агуулгын хувьд эсрэг тэсрэг шинжтэй.

Шударга ёсны зарчим нь эрүүгийн эрх зүйн сонгодог сургаалийн цээрлүүлэх (**re-tributive justice**) үзэл баримтлалаас үүдэлтэй бөгөөд “гэмт хэрэг нь нийгмийн ёс суртахууны хүрээг ноцтой хэлбэрээр эвдэж хүмүүсийн нийгмээр аж төрөх ёсонд аюул заналхийлж байдаг тул түүнд цээрлэл ногдуулах нь зүйтэй” гэсэн үзэл санаанд суурилдаг. Тухайлбал, Г.Гегель гэмт хэрэг нь хууль, эрх зүйг үгүйсгэсэн хэрэг бөгөөд ял нь уг үгүйсгэлийг үгүйсгэх замаар хууль эрх зүйг эргүүлэн тогтоож буй хэрэг” гэсэн байдаг.

Энэрэнгүй ёсны зарчим нь гэмт хэргийн улмаас хүмүүст учирсан гэм хорыг арилгах нь чухал гэсэн нөхөн сэргээх (**restorative justice**) үзэл баримтлалыг чухалчлан “гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд идэвхгүйгээр шийтгэл хүлээгээд өнгөрөх бус идэвхтэйгээр хувь хүн, нийгэмд учруулсан хохиролоо нөхөн төлсөнөөр нийгмээс тусгаарлагдахгүйгээр засарч хүмүүжүүжих нь ялын зорилго гэсэн үзэл санаанаас үүдэлтэй. Жишээлбэл Зехор Гэмт хэрэг гэдэг нь хүмүүсийг, хүмүүс хоорондын харилцааг зөрчиж байгаа хэрэг. Өөрөөр хэлбэл хэн нэгэн хүн нөгөө хүний эрхийг зөрчсөн тухай асуудал. Гэмт хэрэг үйлдэгдсэнээр зөвхөн хохирогч хүн л хохирдог болохоос улс хохирдоггүй. Тэгэхлээр хэрэгтэн улсаас гаргасан шийтгэлийг амсаж “өрийг улсад” төлөх биш, харин учруулсан хохирлоо нөхөхүйц сайн үйлс хохирогчийн төлөө хийж гэм буруугаа цайруулах хэрэгтэй” гэжээ.

Шударга ёсны зарчим	Энэрэнгүй ёсны зарчим
1. Гэмт хэрэг бол нийгэмд аюултай зан үйл 2. Ял ногдуулахдаа гэмт хэргийн нийгмийн аюул, гэмт хэрэгтэний хувийн байдлыг харгалзан ялгамжтай хандана 3. Ял нь гэмт хэрэгтэнээс хохирогч өшөө авах зэргээр нийгмээр аж төрөх ёсны хүрээ эвдэгдэхээс хамгаалж байдаг. “Talio esto” буюу нүдийг нүдээр, шүдийг шүдээр гэх Талионы зарчмын харгис гэх уламжлалаар халах ёстой. Тийм учраас ял нь нийтлэг пшнжтэй, нийгмийн өмнөөс цээрлүүлдэг байх ёстой.	Гэмт хэрэг бол хувь хүмүүсийн хоорондын зөрчил Аливаа гэмт хэргийн хор аюулыг хохирогчид учруулсан гэм хороор хэмжинэ Гэмт хэрэгтэн хохирогчоос уучлал гуйж, учруулсан хохиролоо нөхөн төлсөн, гэм хороо арилгасан тохиолдолд гэмт хэргийн хор аюул үгүйсгэгдэнэ
4. Шүүх ял ногдуулахдаа ямар нэгэн сэтгэлийн хөдөлгөөн, өс хонзон, хувийн харьцаа зэргээс ангид байна 5. Гэмт хэрэг болон ялын хэмжээ хоорондоо тохирсон байх ёстой	Эрүүгийн эрх зүй нь гэмт хэргийг цээрлүүлэхэд бус хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад зориулагдана Гэмт хэрэгтэн учруулсан гэм хороо арилгасан тохиолдолд түүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ

6. Эрүүгийн хариуцлагыг зөвхөн нэг удаа хүлээлгэнэ	Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн буруутай үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээснээр эргээд түүнийг нийгэм хамт олныхоо дунд эргэн орох боломжоор хангагдах ёстой
--	--

1. Эдгээр зарчмуудын эсрэг тэсрэг агуулгад дүн шинжилгээ хийж өөрийн дэмжиж буй байр суурийг илэрхийл.
2. Байр сууриа илэрхийлэхдээ ингэж үзэх болсон үндэслэлээ тайлбарлана.
3. Өөрийн байр суурийг хамгаалж эсрэг байр суурьт няцаалт өгөхөд бэлтгэ.



Анхаарах зүйл

Анх баримталж байсан үзэл бодол, байр сууринаасаа өөрчлөгдөх нь тийм ч муу зүйл биш бөгөөд, шинэ мэдлэгт хүрсэнээрээ байр сууриа өөрчилж байгаа нь дэвшил юм.



СЭДЭВ 3. МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

Эрүүгийн эрх зүйн эх сурвалж ба эрүүгийн хууль

Өргөн утгаараа эрх зүйн уг үндсийг бүрдүүлэгч гадаад хэлбэрийг эрх зүйн эх сурвалжид тооцдог. Эрх зүйн эх сурвалж нь материаллаг, түүхэн, хууль зүйн гэсэн 3 үндсэн эх сурвалжаас бүрдэнэ. Хууль зүйн эх сурвалжид

а) эрх зүйн хэм хэмжээний акт; б) зан заншил в) шүүхийн жишиг; г) хэм хэмжээ тогтоосон гэрээ хамаардаг. Явцуу утгаараа эрх зүйн хэм хэмжээний хууль зүйн актаар илэрхийлэгдсэн байдал, түүний илрэн гарах хэлбэрийг эх сурвалжид тооцно. Өөрөөр хэлбэл эрүүгийн эрх зүйн эх сурвалж нь эрх зүйн хэм хэмжээг агуулсан хууль зүйн бичиг баримт юм. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн үндсэн эх сурвалж нь эрх зүйн хэм хэмжээний акт болох **Эрүүгийн (төрөлжүүлсэн)** хууль болно.

Монгол Улсад тодорхой хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр эрүүгийн эрх зүйн эх сурвалжид тооцдоггүй боловч Улсын Дээд Шүүх давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх, Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах эрхтэй байдаг. Монгол Улсын эрүүгийн эрх зүйд заншлын хэм хэмжээ, шүүхийн прецедент, хэм хэмжээ тогтоосон гэрээг эрүүгийн эрх зүйн эх сурвалжид тооцдоггүй. Түүнчлэн өршөөл уучлал үзүүлсэн хууль, зарлиг, улс төрийн орогнол олгосон бичиг баримт, гэмт хэрэгтэнийг шилжүүлэн өгөх акт зэрэг нь эрх зүйн хэм хэмжээг хэрэглэсэн акт бөгөөд эрх зүйн эх сурвалжид тооцогдохгүй. Эдгээр бичиг баримт нь нэг бүрчилсэн шинжтэй, тодорхой этгээдэд буюу тодорхой хүрээний хүмүүст зориулагдсан байдаг. Харин эрх зүйн эх сурвалж нь бүх хүн амд, нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд үйлчлэхээр зориулагдсан байдаг.

Эрүүгийн хууль бол эрүүгийн хариуцлагын үндэслэл, зарчмыг тогтоож, хүн, нийгэм, төрд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэж үзэх, түүнд ногдуулах эрүүгийн хариуцлагын болон ялын төрөл хэмжээ, хязгаарыг тогтоож, хууль тогтоох байгууллагаас баталсан эрх зүйн баримт бичиг юм. Монгол Улсад Эрүүгийн хууль тогтоомжийг Эрүүгийн хууль төлөөлөх бөгөөд үйлдэл, эс үйлдэхүйг шинээр гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага тогтоосон Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль эрүүгийн хуулийн бүрэлдүүн хэсэг болдог.

Эрүүгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд үндэслэнэ. Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээ гэдэгт олон улсын конвенц, түүний протокол, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолыг ойлгоно. Монгол Улсын Үндсэн хуулийн 10.3 дугаар зүйлд “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан боловч олон улсын эрх зүйн хэм хэмжээг эрүүгийн эрх зүйн эх сурвалжид тооцоход зарим нэг онцлог бий. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2 дугаар зүйлд “Эрүүгийн хууль тогтоомж нь энэ хуулиас бүрдэнэ. Үйлдэл, эс үйлдэхүйг шинээр гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага тогтоосон Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль энэ хуулийн бүрэлдүүн хэсэг болно” гэж заасан учраас олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээ нь эрүүгийн эрх зүйн шууд эх сурвалж болж чадахгүй бөгөөд үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохын тулд заавал Эрүүгийн хуульд бэхжүүлсэн байх шаардлага тавигдана.

Эрүүгийн төрөлжсөн анхны хууль нь 1926 онд Шүүх цаазны бичиг нэртэйгээр батлагдсан. Үүнээс хойш 1929, 1934, 1942, 1961, 1986, 2002 онуудад тус тус эрүүгийн шинэ хууль батлагдан гарсан.

**Эрүүгийн хуулийн
тогтолцоо, хэм
хэмжээний бүтэц**

Монгол Улсын Эрүүгийн хууль нь нийтлэг үндэслэл, зарчмыг тодорхойлсон **Ерөнхий анги** болон тодорхой төрлийн гэмт хэргийн бүрэлдүүн, ногдуулах ялыг тогтоосон **Тусгай ангиас бүрдэнэ**. Ангиуд дотроо хэсэг, бүлэг, зүйлд хуваагдах бөгөөд одоо дагаж мөрдөж буй Эрүүгийн хууль 11 хэсэг, 31 бүлэг, 305 зүйлээс бүрдэж байна.

Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн зүйл, заалт нь үндсэндээ эрх зүйн хэм хэмжээний гипотезийг Тусгай ангийн зүйл, заалт нь диспозиц, санкцийг агуулдаг онцлогтой. Диспозиц нь ердийн (зөвхөн гэмт хэргийг нэрлэсэн), тодорхойлох (гэмт хэргийн шинжийг зааж өгсөн), иш татсан (Эрүүгийн хуулийн өөр зүйл хэсгийг ишлэл болгосон), бланкет (Эрүүгийн хуулиас өөр хуулийн зүйл, хэсгийг алгасуулан иш татсан) төрлүүдтэй байна. Санкц нь харьцангуй тодорхой (ялын дээд доод хэмжээг буюу дээд хэмжээг тодорхойлсон), туйлын тодорхой (ялын төрөл хэмжээг сонгох боломжгүй маш тодорхой заасан), сонгох (хэд хэдэн ялаас аль нэгийг нь сонгон хэрэгжүүлж болох) гэсэн төрлүүдтэй. Эрүүгийн хуулийн нэг зүйлд эрүүгийн эрх зүйн хэд хэдэн хэм хэмжээг бэхжүүлсэн эсхүл эрх зүйн нэг хэм хэмжээ Эрүүгийн хуулийн хэд хэдэн зүйл, заалтад тусгагдсан байж болно.

**Эрүүгийн хууль
үйлчлэх орон зай**

Эрүүгийн хуулийн үйлчлэх орон зайн хэмжээ хязгаарыг **нутаг дэвсгэрийн, харьяаллын, бодит, түгээмэл зарчмуудаар** тодорхойлно.

Нутаг дэвсгэрийн зарчмын дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн этгээдэд Эрүүгийн хууль үйлчилнэ. Монгол Улсын нутаг дэвсгэр гэдэг нь Улсын хилээс дотогш орших нутаг дэвсгэр юм. Монгол Улсын Хилийн тухай хуулийн 3 дугаар зүйлд “Монгол Улсын нутаг дэвсгэрийн хязгаарыг газрын гадаргуу, усны мандал дээр хил залгаа улсын нутаг дэвсгэрийн хязгаараас зааглаж Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлж, тогтоосон шугамыг Монгол Улсын хил гэнэ. Уг шугамаас эгц дээш агаарын, мөн шугамаас эгц доош газрын хэвлийн хил байна”. Үүнээс гадна Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.3 дугаар зүйлд заасны дагуу хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоц, агаарын хөлөг Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарна” гэж заасан.

Энэ зарчмыг хэрэглэхэд **гэмт хэрэг үйлдсэн газар** чухал ач холбогдолтой. Гэмт хэрэг үйлдсэн газар гэдэг нь гэмт хэргийн бүрэлдүүний объектив талын үйлдлийг хийсэн газар бөгөөд хор уршиг хаана учирсанаас үл хамааран үйлдэл хийсэн газраар тогтоогдоно. Хэрэв гэмт хэргийг хэд хэдэн улсын нутаг дэвсгэр дамжин үйлдсэн бол гэмт хэрэг үйлдэгдэж төгссөн буюу таслан зогсоогдсон улсын хуулиар эрүүгийн хариуцлагад татна. Хэрэв захиалагч, зохион байгуулагч болон бусад хамтран оролцогчид нэг улсын нутаг дэвсгэр дээр харин гүйцэтгэгч өөр улсын нутаг дэвсгэр байвал бүх хамтран оролцогчдыг гүйцэтгэгчийн байгаа нутаг дэвсгэрийн хуулиар эрүүгийн хариуцлагад татна.

Уг зарчмаар **Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн бүх этгээдэд**

Монгол Улсын Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэнэ. Өөрийн нутаг дэвсгэрт буй дипломат, халдашгүй эрх ямба эдэлж буй хүмүүс гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хуульд үл хамаарах зарчмын дагуу эдгээр хүмүүсийг шууд эрүүгийн хариуцлагад татахгүй, дипломат шугамаар зохицуулдаг нь олон улсын гэрээ, конвенциудаар тогтоосон нийтлэг зарчим бөгөөд нутаг дэвсгэрийн зарчимтай харшилдаггүй.



Дипломат харилцааны тухай Венийн 1961 оны конвенцид заасны дагуу дипломат төлөөлөгчдийн тэргүүн (элчин сайд, итгэмжлэгдсэн төлөөлөгч, түр хамаарагч), төлөөлөгчдийн газрын ажилтанууд, зөвлөх, цэргийн болон бусад атташе, тэдгээрийн туслах, нэг, хоёр, гуравдугаар нарийн бичгийн дарга, бичиг хэргийн-архивын эрхлэгч болон тэдгээрийн гэр бүлийн хүмүүс өөрийнх нь болон төлөөлж буй улсын зөвшөөрөлгүйгээр баривчлах, цагдан хорих, байцаалт авах зэргээр эрүүгийн хариуцлагад татах үйлдэл хийж болохгүй. Мөн гадаад улсын төрийн тэргүүн, парламентын болон засгийн газрын гишүүд, олон улсын гэрээ, хэлэлцээрт оролцох буюу бусад албан ёсны даалгавраар ирсэн гадаад улсын төлөөлөгчид, тэдгээрийн дагалдан яваа гэр бүлийн хүмүүс, дипломат халдашгүй эрх эдлүүлэхээр заасан төрийн бус байгууллагын албан тушаалтан, олон улсын олон талт гэрээгээр заасан байгууллагын гадаад улсын төлөөлөгчид Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирсэн буюу дамжин өнгөрөх үед дипломат халдашгүй эрх эдэлнэ. Түүнчлэн Монгол Улс тодорхой улстай байгуулсан хоёр талын гэрээндээ тодорхой албан тушаалтанд дипломат халдашгүй эрх ямба эдлүүлэхээр зааж болно. Консулын харилцааны тухай 1963 оны конвенцид заасны дагуу консулын албаны төлөөлөгчид дипломат халдашгүй эрхийг бүрэн буюу хязгаарлагдмал байдлаар эдлүүлж болно.

Харьяаллын зарчмын агуулга нь хаана үйлдсэнээс үл хамааран **Монгол Улсад харьяалагддаг хэн бүхэн** гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд Монгол Улсын хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд оршино. Уг зарчмын дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдээгүй боловч Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суудаг харьяалалгүй хүн а) гадаад улсад Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн; б) тухайн хэрэгтээ ял шийтгүүлээгүй бол Монгол Улсын хуулиар эрүүгийн хариуцлага хүлээнэ. Энэ зарчмын дагуу ял шийтгэгдэж буй этгээд хэрэв үйлдсэн гэмт хэрэгтээ гадаад улсад ял шийтгүүлсэн бол Монгол Улсын шүүх түүнд ногдуулсан ялыг Монгол Улсын Эрүүгийн хуулийн дагуу хөнгөрүүлэх буюу ялаас чөлөөлж болно. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол шүүх тухайн этгээдийг энэ хуульд заасан үндэслэлээр гэм буруугүйд тооцож болно.

Монгол Улсын харьяат гэж Монгол Улсын харьяатын тухай хуульд заасны дагуу тус улсын харьяатаар тооцогдсон хүнийг, гадаадын иргэн гэж гадаад улсын харьяат мөн болохыг гэрчилсэн хууль ёсны нотолгоотой хүнийг, харьяалалгүй хүн гэдэгт Монгол Улсын болон гадаад улсын харьяалалгүй хүнийг тус тус ойлгодог.

Харьяаллын зарчмыг хэрэгжүүлэх шаардлагаас үүдэн эрүүгийн эрх зүйд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэн өгөх (экстрадиц) асуудлыг зохицуулах шаардлагатай болдог. Энэ бол гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх буюу ял эдлүүлэхээр өөр улсын эрх мэдэлд шилжүүлэх үйл ажиллагаа. Гэмт хэрэгтэнийг шилжүүлэх ажиллагаа нь хоёр талын буюу олон талт олон улсын гэрээнд үндэслэн явагдана. Монгол Улсын Үндсэн хуулийн 15.2 дугаар зүйлд “Монгол Улсын иргэнийг харьяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглоно” гэснийг үндэслэн Эрүүгийн хуулийн 15.1 дугаар зүйлд “Монгол Улсын иргэнийг эрүүгийн хэрэгт мөрдүүлэх буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр гадаад улсад шилжүүлж өгөхгүй” гэж заасан.

Бодит зарчмыг Монгол Улсын Эрүүгийн хуульд (2002) шинээр хуульчилагдсан. Энэ зарчим нь **Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна, тус улсад харьяалагдахгүй иргэдийн** үйлдсэн гэмт хэргээс Монгол Улсын ашиг сонирхолыг хамгаалах зорилготой. Монгол Улсын ЭХ-ийн 14.5-д зааснаар а) Монгол Улсад байнга оршин суудаггүй гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн тус улсын хилийн гадна **Монгол**

Улсын ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн; б) тэрхүү гэмт хэрэгтээ гадаад улсад ял шиттүүлээгүй нөхцөлд бодит зарчим үйлчилнэ.

Түгээмэл зарчим нь олон улсын гэмт хэрэг болон олон улсын шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх ашиг сонирхоос үүдэлтэй зарчим болно. Уг зарчмын дагуу улс орнууд зөвхөн өөрийн орны ашигсонирхолд халдсан гэмтхэрэгт эрүүгийнхариуцлага хүлээлгээд зогсохгүй бусад улсын эрх ашигт халдсан гэмт хэрэгт уг хэрэг хаана үйлдэгдсэнээс нь хамаарахгүйгээр өөрийн эрүүгийн хуулийг хэрэглэх ёстой болно. Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх үүднээс энэ зарчмыг хуульчилсан. ЭХ-ийн 14.4-д зааснаар **Монгол Улсын хилийн гадна гэют хэрэг үйлдсэн** гадаад улсын иргэн, харъяалалгүй хүнд зөвхөн Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бол энэ хуулиар хариуцлага хүлээлгэнэ.

Эрүүгийн хуулийн үйлчлэх цаг хугацаа Эрүүгийн хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхээс үйлчлэх цаг хугацаа хүчингүй болох хүртэлх үеийг эрүүгийн хуулийн гэсэн ойлголтоор илэрхийлэх бөгөөд

нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхийг хэрэг үйлдэх үед дагаж мөрдөж байсан Эрүүгийн хуулиар дагуу шийдвэрлэдэг. Гэхдээ үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон буюу ногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэх ба үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт шинээр тооцсон буюу ногдуулах ялыг хүндрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэх

Хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхэд 3 төрлийн журам үйлчилдэг.

- Үндсэн хуулийн журмаар хүчин төгөлдөр болох: “Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол ийнхүү нийтэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно” (ҮХ 26.3);
- Хүчин төгөлдөр болох хугацаа тусгай хуулиар тогтоох;
- Хуулинд өөрт нь хүчин төгөлдөр болох хугацааг тогтоох: “Энэ хуулийг 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” (ЭХ 305.1).

Эрүүгийн хуулийн үйлчлэх цаг хугацааг тодорхойлоход **гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаа** хэмээх ойлголт шийдвэрлэх ач холбогдолтой. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаа гэдэг бол **гэмт хэргийн бүрэлдүүнийг бүрдүүлж эхэлсэнээс гэмт хэргийг үйлдэж дуусах буюу таслан зогсоогдох хүртлэх үеийг** хэлнэ. Эрүүгийн хуулийн үйлчлэх цаг хугацааг тогтоож, эрүүгийн хариуцлагад татахын тулд хэдий үеэс гэмт хэргийн бүрэлдүүнийг бүрэлдсэнд тооцох нь чухал юм. Эрүүгийн эрх зүйд гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацааг гэмт хэрэг үйлдсэн үеэр тооцох, хор уршиг учирсан үеэр тооцох хоёр үзэл байдаг. Монгол Улсын Эрүүгийн хуульд зааснаар гэмт хэргийн **хор уршиг хэзээ илэрснээс үл хамааран тухайн гэмт хэрэг үйлдсэн үеийг** гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаанд тооцно. Гэмт хэрэгт хамтран оролцогчдын гэмт хэрэг үйлдсэн цаг хугацааг тус бүрд нь тооцно. Ихэвчлэн хамтран оролцогчдын гэмт хэрэг үйлдсэн цаг хугацаа харилцан адилгүй байна. Жишээлбэл, хатгагч гүйцэтгэгчийн үйлдлээ эхлэхээс өмнө гэмт үйл ажиллагаагаа дуусгасан байдаг. Үргэлжилсэн болон удааширсан гэмт хэргийн цаг хугацааг тогтоохдоо гэмт хэргийг үйлдэж дууссан, таслан зогсоосон буюу хэргээ илчилж ирсэн үеийг гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаанд тооцно.



Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх нь шинээр батлагдсан хууль дагаж мөрдөгдхөөс өмнө үйлдэгдсэн гэмт хэрэгт шинэ болон хуучин үйлчилж байсан хуулиудын аль хөнгөнийг хэрэглэх явдал юм. Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхэд *ex post facto* буюу *шинэ хуулийг хуучинд хэрэглэх* гэсэн мөрдлөгийг удирдлага болгон үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон буюу ногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ. **Гэмт хэрэгт тооцохгүй болсон үйлдэл, эс үйлдэхүй** гэдэг нь урьд нь гэмт хэрэгт тооцогдож байсан хэрэг шинэ хуулиар гэмт хэрэгт тооцогдохоо больж хүчингүй болж хасагдсаныг ойлгоно. Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт шинээр тооцсон буюу ногдуулах ялыг хүндрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн нь хорих ялын дэглэм хөнгөрсөн, эрүүгийн хариуцлага болон ялаас чөлөөлөх шинэ нөхцлүүдийг нэмсэн, ялгүй болох хугацааг багасгасан байдлаар илэрнэ. **Ял хөнгөрүүлсэн хууль** гэдэгт тухайн гэмт хэрэгт ногдуулах ялын дээд доод хугацааг багасгасан, өмнө үйлчилж байсан хуульд зааснаас хөнгөн ялыг хуульчилсан, хөнгөн ял хэрэглэж болох сонгох санкцыг тогтоосон хуулийг ойлгоно. Ялыг хөнгөрүүлсэн хуулийг ял шийтгэгдэх буюу ял шийтгүүлсэн этгээдэд хамааруулна. Шинэ хуулиар тухайн гэмт хэрэгт ногдуулах ялын дээд хэмжээг багасгасан тохиолдолд урьд нь үүнээс дээгүүр ял шийтгүүлсэн этгээдийн ялыг шүүх уг дээд хэмжээнд нийцүүлэн хасна. Шинэ хуулиар тухайн гэмт хэрэгт ногдуулах ялын доод хэмжээг багасгасан тохиолдолд урьд нь үүнээс дээгүүр ял шийтгүүлсэн этгээдийн ялыг шүүх уг доод хэмжээнд нийцүүлэн хасна. **Ял хүндрүүлсэн хууль** бол урьд дагаж мөрдөж байсан хуулиас хатуу санц тогтоосон хууль юм. Энэ нь ялын хэрэглэж болох хугацааны дээд хэмжээг нэмсэн, доод хэмжээг нэмсэн, эсвэл дээд, доод хэмжээг аль алиныг нэмсэн, үндсэн ялын зэрэгцээ нэмэгдэл ял хэрэглэхээр нэмсэн, хүнд төрлийн сонгох санкц хуульчилсан байдлаар илэрнэ.

Эрүүгийн хуулийн тайлбар

Эрүүгийн хуулийн хэм хэмжээний болон хуульд хэрэглэсэн нэр томъёо, зарчмын утгыг тодорхой болгон хууль тогтоогчийн тогтоосон санааг утга тодруулах үйл ажиллагаа.

Хуулийг нэг мөр зөв ойлгож хэрэглэхийн тулд тайлбарладаг. Хуулийн нэр томъёо, ойлголт хэдий боловсронгуй байх тусам хуулийн тайлбарлах шаардлага өсдөг.

Эрүүгийн хуулийн агуулгыг тайлбарлаж буй аргаар нь тайлбарыг шууд утгын, дэлгэрэнгүй, үгчилсэн тайлбар гэж ангилна. Хуулийн ойлголт, нэр томъёо шууд нэг утгаар ойлгох шаардлагатай (жишээ нь: Үндсэн хуулинд тодорхойлогдсон ойлголт) байвал шууд утгын тайлбар хийнэ. Харин хэм хэмжээний агуулгыг тодорхой болгохын тулд хуулийн зорилт, бусад хэм хэмжээтэй холбогдох байдал зэрэг тайлбарлаж буюу нэр томъёо, ойлголтын хүрээнээс хальж тайлбарласан бол утгыг нь өргөтгөсөн буюу дэлгэрэнгүй тайлбар болно. Хуулинд хэрэглэсэн үг хэллэг, нэр томъёог хэд хэдэн янзаар ойлгож болох тохиолдолд хуулинд уг нэр томъёо, үг хэллэгийг ямар агуулгаар хэрэглэсэнийг тайлбарласаныг үгчилсэн тайлбар гэнэ.

Түүнчлэн тайлбарыг гаргаж буй субъектээс нь шалтгаалж албан ёсны ба албан ёсны бус гэж ангилна. Албан ёсны тайлбарыг Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар УДШ гаргана. Албан ёсны бус буюу онолын тайлбар нь Эрүүгийн хуулийн хэм хэмжээний талаар хуульчид, эрдэмтдийн туурвисан бүтээлд тусгалаа олдог. Албан ёсны бус тайлбар нь албан ёсны тайлбар гаргах үндэс болдог.

Эрүүгийн хуулийг тайлбарлахад дараах зарчмууд мөрдөгдөнө.

- Эргэлзээтэй бүх асуудлыг яллагдагчид ашигтайгаар тайлбарлана.
- Нийтлэг зарчим, хэм хэмжээнээс гадуур эргэлзээ төрүүлсэн хэм хэмжээг шууд утгаар нь тайлбарлана.
- Ерөнхий ангийн хэм хэмжээтэй зөрчилдсөн тусгай ангийн хэм хэмжээг шууд утгаар тайлбарлана.
- Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлсэн, чөлөөлсөн хуулийн утгыг нь өргөтгөн (дэлгэрэнгүй) тайлбарлана.
- Хариуидагыг хүндрүүлсэн, шинээр бий болгосон хуулийг шууд утгаар нь тайлбарлана.
- Хуулийг тайлбарлахдаа эрүүгийн хуулийн зарчим, зорилтыг удирдлага болгоно.



Даалгавар:

1. Монгол Улсын 1926, 1929, 1934 онуудад батлагдсан Шүүх цаазын бичиг, 1942, 1961, 1986, 2002 онуудад батлагдан гарсан Эрүүгийн хуулийн агуулга, үзэл баримтлалын ялгаа, өөрчлөлтийг тодорхойл.
2. Эрүүгийн хуулийн бланкет (алгасуулан иш татсан) хэм хэмжээний жишээ дурдана уу.



Сорил

1. Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэж байсан хуулийг ол.
 - a. 1942 оны Эрүүгийн хууль
 - b. 1961 оны Эрүүгийн хууль
 - c. 1987 оны шинэчлэн найруулсан эрүүгийн хууль
 - d. 2002 оны эрүүгийн хууль
2. Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх нь:
 - a. Үйлчлэн буй эрүүгийн хуулийг хүчингүй болгох, өөрчлөхийг хэлнэ
 - b. Шинээр гэмт хэрэгт тооцохыг хэлнэ
 - c. Шинээр хүчин төгөлдөр болсон хуулиас өмнө үйлдэгдсэн хэрэгт хуучин хуулиар ял оногдуулахыг хэлнэ
 - d. Хуульд зааснаас хөнгөн ял оногдуулж байгаа, хорих ялын хугацааг багасгаж байгааг хэлнэ
3. Эрүүгийн хуулийн үйлчлэх нутаг дэвсгэрийн зарчмын дагуу:
 - a. Гэмт хэргийг үйлдэгдсэн газрын хуулиар шийдвэрлэнэ
 - b. Монгол Улсын иргэд хаана ч гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын эрүүгийн хуулиар ял шийтгэгдэнэ
 - c. Гэмт хэргийг таслан зогсоосон газрын эрүүгийн хуулийг хэрэглэнэ
 - d. Гэмт хэргийн хор уршиг учирсан газрын хуулийг хэрэглэнэ
 - e. Гэмт хэрэг үйлдэгдэж, хор уршиг учирсан газрын хуулийг хэрэглэнэ



4. Монгол Улсын Эрүүгийн шинэ хууль нь:

- a. Батлагдсан өдрөөсөө эхлэн дагаж мөрдөгдөж эхэлнэ*
- b. Монгол Улсын Ерөнхийлөгч соёрхсон өдрөөс хүчин төгөлдөр болно*
- c. Хүчин төгөлдөр болох хугацааг хуульд заасан*
- d. Хүчин төгөлдөр төрдөгдөж эхлэх хугацааг тусгай хуульд заасан*
- e. Албан ёсоор хэвлэгдсэн өдрөөс хойш 10 хоног өнгөрсөний дараа хүчин төгөлдөр болно*

5. Гэмт хэрэг үйлдсэн цаг хугацаа нь:

- a. Гэмт хэрэг үйлдэгдэж эхэлсэнээс дуусах хүртлэх цаг хугацаа*
- b. Нийгэмд аюултай үйлдэл хийгдэж хор уршиг учирсан хугацаа*
- c. Гэмт хэрэг үйлдэгдсэн нь хууль сахиулах байгууллагад тэдэгдсэн хугацаа*
- d. Хор уршиг хэзээ учирсанаас үл хамааран гэмт үйлдэл хийгдсэн хугацаа*
- e. Хохирогч хууль сахиулах байгууллагад гомдол гаргасан хугацаа*

6. 2002 оны Эрүүгийн хууль хүчин төгөлдөр болсон цаг хугацаа

- a. 2002.01.03*
- b. 2002.07.01*
- c. 2002.09.01*
- d. 2002.12.31*

7. Монгол Улсын шинэ Эрүүгийн хуульд эрүүгийн хуулийн үйлчлэх нутаг дэвсгэр, хамаарах этгээдийн талаар дараах зарчим бэхжүүлэгдээгүй

- a. Нутаг дэвсгэрийн*
- b. Иргэнчлэлийн*
- c. Ивээлдээ байлгах*
- d. Дипломат халдашгүй эрхийн*

8. Гэмт хэрэг үйлдсэн гадаадын иргэн болон харьяалалгүй этгээдийг гадаад улсад шилжүүлэн өгч болно

- a. Болно*
- b. Болохгүй*
- c. Энэ талаар олон улсын гэрээнд заасан тохиолдолд болно*

9. Монгол улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд тус улсын эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэж болохгүй хүмүүс.

- a. гадаадын иргэн*
- b. жуулчин*
- c. цэргийн атташе*

II БҮЛЭГ. ГЭМТ ХЭРЭГ

Бүлгийн зорилго: Гэмт хэрэг, түүнтэй холбоотой институтийн талаар /гэмт хэрэг үйлдэх үе шат, гэмт хэрэгт хамтран оролцох, олонлог гэмт хэрэг г.т/ онолын мэдлэг олж, үйлдэгдсэн тодорхой хэрэг /тохиолдол/, эрүүгийн хэрэг шийдвэрлэсэн эрүүгийн шийтгэх тогтоол, тагадлалд хууль зүйн үндэстэй үнэлэлт, дүгнэлт өгөх, шийдвэр гаргах дадал, чадвар эзэмшиж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдлийг зөв зүйлчлэх, эрүүгийн хариуцлага хүлээлгэх /ял ногдуулах/-тэй холбоотой нийтлэг үндэслэлүүдийг судлах, хэрэглэх хандлага төлөвшинө.

СЭДЭВ 1. ГЭМТ ХЭРГИЙН ОЙЛГОЛТ, ШИНЖ, АНГИЛАЛ

Гэмт хэргийн ойлголт

Эрх зүйн зөрчлийн нэг төрөл. Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэдэг. Гэмт хэрэг нь Эрүүгийн хуулиар хориглосон, нийгэмд аюултай гэсэн объектив, гэм буруутай гэсэн субъектив шинжүүдтэй.

Эрүүгийн хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдэхүй. Гэмт хэргийг Эрүүгийн хуулиар заавал хуульчлах бөгөөд түүнийг үйлдсэн тохиолдолд ял оногдуулахаар заана. Нийгэмд аюултай хор хохирол учруулсан үйлдэл эс үйлдлийг хийсэн боловч гэмт хэрэгт тооцон гэж Эрүүгийн хуульд заагаагүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцдоггүй. Энэ утгаараа хэдийгээр нийгэмд ноцтой аюул учруулсан үйлдэл, эс үйлдэхүй байвч түүнийг Эрүүгийн хуульд гэмт хэрэгт тооцон ял ногдуулахаар заагаагүй бол гэмт хэрэг гэж үзэх буюу Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхийг хориглоно.

Нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй. Нийгэмд аюултай байх нь гэмт хэргийн агуулгын шинж бөгөөд энэ нь Эрүүгийн хуулиар хамгаалсан эрх ашигт бодит хохирол учруулсанаар илэрнэ. Эрүүгийн хуулийн Тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүйн учир нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй. Гэмт хэргийн нийгмийн аюул нь түүний хор уршгаар үнэлэгдэх бөгөөд тэрхүү хор уршиг нь материаллаг болон хэлбэрийн шинжтэй байж болно.


Гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй. Зөвхөн гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцно. Гэмт хэрэг нь гэм буруугийн санаатай болон болгоомжгүйн аль нэг хэлбэрээр үйлдэгдэх ба гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Гэм буруугүйгээр эрүүгийн хуульд заасан хор уршиг учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй. Өөрөөр хэлбэл нийгэмд аюултай хор уршиг учирна гэдгийг урьдаас мэдээгүй, мэдэх боломжгүй нөхцөл байдалд Эрүүгийн хуульд заасан хор уршиг учруулсаныг гэмт хэрэгт тооцохгүй. Түүнчлэн аливаа үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохдоо зөвхөн Эрүүгийн хуульд заасан гэм буруугийн хэлбэрээр үйлдэгдсэн байхыг шаардана¹.

¹ Гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарчмыг харна уу.




Эдгээрээс гадна судлаачид гэмт хэрэг **эрүүгийн хариуцлага хүлээх** шинжээрээ бусад эрх зүйн зөрчлөөс ялгаатай гэж үздэг. Зөвхөн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх бөгөөд Эрүүгийн хуульд үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохоор заасан боловч тэрхүү гэмт хэрэгт ногдуулах ялын төрөл, хэмжээг тогтоож өгөөгүй бол гэмт хэрэгт тооцох боломжгүй юм.

Гэмт хэргийн шинж Гэмт хэрэг нь хүмүүсийн эрх ашигт **бодитой хор уршиг** учруулсан **гэм буруутай** үйлдэл, эс үйлдэхүй учраас **объектив** болон **субъектив** шинжтэй байдаг.



Гэмт хэргийн ангилал Гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд хөнгөнийг харгалзан гэмт хэргийг **хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд** гэж ангилна. Гэмт хэрэг нь харилцан адилгүй эрх ашигт өөр өөр үйлдэл, эс үйлдэхүйгээр, гэм буруугийн янз бүрийн хэлбэрээр халдаж их бага янз бүрийн хор уршиг учруулж байдаг буюу **нийгмийн хор аюулаар харилцан адилгүй** байдаг учраас ийнхүү ангилдаг.

Эдгээр шалтгааныг эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөний байдал хэмээн томъёолдог. Гэхдээ дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулиар гэмт хэргийг зөвхөн **оногдуулж болох ялын хэр хэмжээг** шалгуур болгон хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилсан. Урьд нь гэмт хэргийг ангилахдаа гэм бурууг шалгуур болгон авч үздэг байсныг 2002 оноос эхлэн үйлчилж буй Монгол Улсын Эрүүгийн хуулиар хассан юм. Өөрөөр хэлбэл болгоомжгүй гэмт хэрэг ямар ч өндөр санкцтай байсан хүнд гэмт хэргийн ангилалд хамаардаггүй байдаг байсан бол одоогийн хуулиар гэм буруугийн хэлбэрийг харгалзахгүй болсоноор болгоомжгүй үйлдсэн гэмт хэрэг хүнд гэмт хэргийн ангилалд хамаарах болсон.



Гэмт хэргийг ангилах нь шүүхийн практикт гэмт хэрэг үйлдсэн этгээд бүрт эрүүгийн хариуцлагыг ялгамжтай оногдуулах, тухайлбал:

- Эрүүгийн хариуцлага болон ялаас чөлөөлөх (ЭХ § 69,70,71, 73); Хөөн хэлэлцэх хугацааг ялгамжтай хэрэглэх (ЭХ § 72);
- Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах (ЭХ §63);
- Хорих ялыг эдлүүлэх дэглэмийг тодорхойлох (ЭХ § 52);
- Ял хөнгөрүүлэх нөхцөл байдлыг тооцох (ЭХ §55);
- Ял тэнсэх болон хугацаанаас нь өмнө тэнсэн суллах (ЭХ § 61,74);
- Ялгүй болох (ЭХ § 78) зэрэг журмыг хэрэглэхэд ач холбогдолтой байдаг.



Сорил

1. Гэмт хэргийг ангилах шалгуур нь:

- a. Гэм буруугийн хэлбэр
- b. Учруулсан хохирлын хэмжээ
- c. Нийгмийн хор аюул
- d. Ялын хэмжээ

2. Гэмт хэрэг иргэний эрх зүйн зөрчлөөс ялгах шинж

- a. Учирсан хохирлын байдал
- b. Сэдэлт зорилго
- c. Эрүүгийн хуульд заасан шинж

3. Дараах гэмт хэргийн ангилалтыг тодорхойл

...бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс дал дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ

- a. Хүнд гэмт хэрэг
- b. Хүндэвтэр гэмт хэрэг
- c. Хөнгөн гэмт хэрэг
- d. Онц хүнд гэмт хэрэг

4. Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 251-500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял тогтоосон гэмт хэрэг нь

- a. Хөнгөн гэмт хэрэг
- b. Хүндэвтэр гэмт хэрэг
- c. Хүнд гэмт хэрэг
- d. Онц хүнд гэмт хэрэг

ДАСГАЛ 1. ГЭМТ ХЭРЭГ МӨН, БИШ

(Тохиолдол шинжлэх)

- Тохиолдол 1. “Р” гэгч эхнэр “О”-г байнга зоддог, эрүүл мэндийг нь сарниулсан хөнгөн гэмтэл учруулсан гэж Эрүүгийн хуулийн 100 дугаар зүйлд зааснаар БГД-н шүүхээр 1 жилийн хорих ялаар шийтгэгдсэн байна. Ялтан “Р” -ийн өмгөөлөгч давж заалдсан өргөдөлдөө “...Т” -ийн эхнэр “О” байнга нөхрөө харддаг, уураа барьж чаддаггүйгээс хэрүүл үүсгэн нөхрөө дайрч доромжлон гартаа тааралдсан зүйлээр цохидог. Тэрээр хэд хэдэн удаа Р-н нүүрийг нь урж маажсан ба түүний довтолгооноос биеэ хамгаалахын тулд “Р” гараас нь барьж зогсоох үед цус хурсан байж болзошгүй, түүнээс биш хэзээ ч эхнэрээ санаатай зодож байгаагүй, шүүхийн шийдвэр нь “О” болон түүний найз хүүхнүүд, ах дүү нарынх нь мэдүүлэг болон 3 удаагийн шүүх эмнэлгийн магадлагааг үндэслэн гарсан. Харин “Р”-г нүүрэндээ хумсны сорвитой явахыг нь түүний хөрш “М” хэд хэдэн удаа харсан гэсэн мэдүүлгийг анхан шатны шүүх харгалзан үзээгүй байх учир шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож өгөх хүсэлтийг давж заалдах шатны шүүхэд гаргажээ.
- Тохиолдол 2. “Э” гэгч нь байрныхаа орчимд нохойгоо хошуувч, хүзүүвч, уяагүйгээр зугаалуулдаг байсныг хөршүүд нь байнга сануулдаг байсан боловч тоодоггүй байв. Нэг удаа ут нохой 7 настай “Д” гэдэг хүүхэд рүү дайрсан ба “Д” нохойноос зугтааж яваад, хурд хэтрүүлж явсан жолооч “С” -ийн машинд дайрагдан хүнд гэмтэл авсан байна.
- Тохиолдол 3. “Ж”, “Ү” нар жилийн өмнө ханилан суусан ба “Ж”-н цалингаар “Ү” өөртөө хувцас гоёл чимэглэлийн зүйл авлагаас гадна эцэг эхдээ илүүчилдэг байв. Удалгүй тэр 2 хэрэлдэж “Ү” төрхөмдөө буцаж хэд хонох хооронд нь “Ж” хурим хийхэд хадмынхаа бэлгэнд өгсөн үнээ, тугалыг худалдаж мөнгөөр нь идэж ууж, наргиж дуусгасан байсанд “Ү” гомдож хуулийн байгууллагад хандсан байна. Цагдаагийн байгууллага “Ж”-г Эрүүгийн хуулийн 145-р зүйлд зааснаар хулгай хийсэн гэж эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж эхэлсэн ба харин Ж прокурорт хандан гэмт хэрэг үйлдээгүй учир хэргийг хэрэгсэхгүй болгож өгөхийг хүссэн өргөдөл гаргажээ.
- Тохиолдол 4. Сумын төвд тракторын жолооч ажилтай “Б” гэгч 15 настай “А” охиныг гэрт чинь хүргэж өгье хэмээн кабиндаа суулган явж байгаад, замдаа хурьцал үйлдсэн байна. Эцгийн гомдлоор эрүүгийн хэрэг үүссэн ба мөрдөн байцаалтанд “Б” мэдүүлэхдээ... “А” бид хоёр тохирч хурьцал үйлдсэн, би түүнийг 15 настай гэж мэдээгүй гэсэн бол “А” мөн тохиролцож бэлгийн харьцаанд орсоноо хүлээсэн байна.
- Тохиолдол 5. Гэр оронгүй хэсүүчлэн амьдардаг “Б”, “Т” нар нэгэн ТҮЦ-ээс юм худалдаж авах дүр үзүүлж байснаа ууттай чихэр байсныг аваад зугтсан учир худалдагч нь хойноос нь хөөсөөр “Б”-г нь барьж цагдаад өгсөн. Хэргийг шалгах явцад ууттай чихэр нь 5000 төгрөгийн үнэтэй зөөлөн чихэр байсан бөгөөд тоо ёсоор нь эзэнд



нь хүлээлгэн өгсөн байна. Хэрэг бүртгэгч “С” дээрх 2 хүүхдэд ЭХ-н 146-р зүйлд зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн сэжигтэнээр татан хэргийг прокурорт шилжүүлсэн. Насыг тогтоосон баримт байхгүй байсан учир шинжээчийн дүгнэлт гаргуулахад тэднийг 14-15 настай гэсэн дүгнэлт гаргасан байна.

Тохиолдол 6.

Малчин ‘Т’ өглөө хадлан хадаж байсан газраа ирж бухалдсан өвсөө нуруулдаж эхэлсэн байна. Тэгээд нэгэн том бухлыг сэрээдтэл хүн орилж цус оргилсон учир “С”-н хамт өвсийг ярж үзэхэд сумын эмч “Ө” цээжиндээ нэвт сэрээдүүлэн үхэж байхыг олсон. Тэгээд яаравчлан хэсгийн төлөөлөгч болон эмнэлэгт мэдэгдэж хэргийн шалгалт эхэлсэн. Мөрдөн байцаалтын явцад “Ө” урьд орой нь өвчтэй хүн үзээд нэлээд халамцуу сумын төв орохоор явсан ба замдаа мориноосоо унаад бухал өвсөнд хоносон болох нь тогтоогдсоноос гадна хэргийн газарт үзлэг хийсэн, туршилт явуулж үзэхэд бухал өвсөнд хүн байгаа талаар мэдэх боломжгүй зэрэг нөхцөл байдлууд илэрчээ.



Анхаарах зүйл

Эрүүгийн хэргийг шийдвэрлэх эхний алхам нь тухайн тохиолдол гэмт хэрэг мөн эсэхийг шалгахаас эхэлдэг. Өгөгдсөн тохиолдлыг энэ удаад эцэслэн шийдвэрлэхийг зорихгүй, зөвхөн гэмт хэрэгт тооцох буюу тооцохгүй гэж үзэх үндэслэл, өөрөөр хэлбэл ямар шинжийг шалгуур болгож байгааг тайлбарласанаар зорилт хангагдсан гэж үзнэ.

СЭДЭВ 2. ГЭМТ ХЭРГИЙН БҮРЭЛДҮҮН

Гэмт хэргийн бүрэлдүүний ойлголт

Эрүүгийн эрх зүйд гэмт хэрэг, гэмт хэргийн бүрэлдүүн гэсэн ялгаатай ойлголт байдаг. Гэмт хэрэг бол хуульд тодорхойлсончилон Эрүүгийн хуулиар хориглосон, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй. Энэ тодорхойлолт нь аливаа гэмт зан үйлийн эрх зүй, нийгмийн агуулгыг илэрхийлсэн тодорхойлолт юм. Гэвч энэхүү тодорхойлолтыг ашиглан амьдрал дээр гарсан тодорхой зан үйлийг гэмт хэрэг мөн эсэхийг шалгаж үнэлэх боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, хулгайлах гэмт хэрэг үү? эсхүл дээрэмдэх гэмт хэрэг үү? гэсэн асуултад хариулах боломжгүй юм.

Эрүүгийн хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох **объектив болон субъектив шинжийн нийлбэрийг гэмт хэргийн бүрэлдүүн²** гэнэ. Эрүүгийн хуулийн тусгай ангид тодорхой гэмт хэргийн объектив болон субъектив шинжүүдийг тодорхойлдог бөгөөд эдгээр шинж нь үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, бусад гэмт хэргээс ялгах онцлог шинжийг өөртөө агуулна. Эрүүгийн хуульд заасан эдгээр объектив, субъектив шинжийн аль нэг нь байхгүй аливаа үйлдлийг гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй. Тийм учраас үйлдэл, эс үйлдэхүй гэмт хэргийн бүрэлдүүнтэй байх нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх цорын ганц үндэслэл болдог.

Гэмт хэргийн бүрэлдүүн бол тухайн гэмт хэргийн **нийтлэг, онцлох шинжийг** илэрхийлсэн хууль зүйн тодорхойлолт юм. Тухайлбал бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийг янз бүрийн аргаар гүйцэлдүүлж болох ч тэр аргууд бүхэлдээ итгэл эвдсэн эсхүл хууран мэхэлсэн нийтлэг шинжтэй байдаг. Энэхүү итгэл эвдэх буюу хууран мэхлэх арга нь залилан мэхлэх гэмт хэргийг (хулгайлах -нууц далд аргаар, дээрэмдэх - амь биед аюултай хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж г.м) бусад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс ялгах онцлог шинж нь юм. Ийнхүү тухайн гэмт хэргийг тодорхойлоход хамгийн чухал, гол гэж үзсэн шинжийг шалгуур болгон гэмт хэргийг зүйлчилдэг.

Гэмт хэргийн объектив шинж нь тухайн халдлагаас Эрүүгийн хуулиар хамгаалсан эрх ашиг (объект), тэрхүү эрх ашигт халдаж буй үйлдэл, эс үйлдэхүйн шинж (**объектив тал**) зэрэг гадаад шинжийг, субъектив шинж нь гэмт этгээдийн гэмт хэрэг үйлдэх болсон сэдэлт, зорилго, гэм буруу (**субъектив тал**) зэрэг гэмт хэргийн дотоод агуулгыг илэрхийлдэг.

Гэмт хэргийн бүрэлдүүний хүрээнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд (**субъект**) эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой эсэхийг авч үзнэ.

² Латинаар *Corpus delicti*




Анхаарах зүйл

Эрүүгийн хуульд тодорхой гэмт хэргийн бүрэлдүүнийг заахдаа заавал гэмт хэргийн бүрэлдүүний бүх шинжийг заах албагүй. Тухайлбал, хүнийг болгоомжгүй алах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 94 дүгээр зүйлд тодорхойлохдоо “бусдыг болгоомжгүй алсан бол...” хэмээн зөвхөн гэм буруугийн хэлбэр, болон хор уршгийг тодорхойлоод орхисон байна. Харин гэмт хэргийн бүрэлдүүний бусад хэсгүүд нь Эрүүгийн хуулийн Ерөнхий (Гэмт хэргийн субъект - ЭХ §20, 21) ангийн зохих зүйл, заалтаар тодорхойлогдоно.

Гэмт хэргийн бүрэлдүүний ангилал

Гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж, хэр хэмжээгээр нь **Үндсэн (ердийн), хүндрүүлэх, онц хүндрүүлэх, хөнгөрүүлэх** бүрэлдүүнтэй гэмт хэрэг гэж ангилдаг.



Түүнчлэн гэмт хэргийн бүрэлдүүнийг хор уршиг илрэх байдлаар буюу объектив тал хуульд заасан үйлдийн шинжийг шалгуур болгон материаллаг болон хэлбэрийн бүрэлдүүнтэй гэж ангилдаг гэмт хэргийн улмаас эрүүгийн хуульд заасан **хор уршиг заавал учирсан байхыг шаарддаг гэмт хэргийг материаллаг бүрэлдүүнтэй** гэж үзнэ Ийм гэмт хэрэгт хэрэв хуульд заасан хор уршиг нь учраагүй бол төгссөн гэмт хэрэгт тооцохгүй. Харин Эрүүгийн хуульд заасан тодорхой үйлдэл эс үйлдэхүй хийснээр гэмт хэрэг үйлдсэнд тооцдог заавал бодит **хор уршиг учирсан байхыг шаарддаггүй** гэмт хэрэг нь **хэлбэрийн бүрэлдүүнтэй** гэмт хэрэгт тооцогдоно.



Сорил

1. Гэмт хэргийн бүрэлдүүн нь

- a. Тодорхой үйлдлийн харьцангуй түгээмэл логик-хууль зүйн загвар
- b. Нийгэмд аюултай үйлдлийн хууль зүйн үнэлгээ
- c. Тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив субъектив шинжийн нийлбэр
- d. Эрх зүйн зөрчлийн бүх нөхцөл байдлууд

2. Эрүүгийн хуульд заасан үйлдэл бүрэн хийгдсэнээр төгссөнд тооцогддог гэмт хэрэг нь:

- a. Үндсэн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг
- b. Материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг
- c. Хүндрүүлэх бүүрэлдэхүүнтэй гэмт хэрэг
- d. Хэлбэрийн бүүрэлдэхүүнтэй гэмт хэрэг

3. Материаллаг бүрэлдүүнтэй гэмт хэрэг нь:

- a. Гэмт хэргийн бүрэлдэхүүний хүндрүүлэх шинжгүй байна
- b. Тухайн гэмт хэргийн төгсгөлд Эрүүгийн хуулиар бодит хор уршиг буй болгохоор тогтоосныг хэлнэ
- c. Тусгай субъект тогтоосныг хэлнэ

4. Гэмт хэргийн гадаад байдлыг тодорхойлж буй шинж нь:

- a. Объект
- b. Объектив тал
- c. Субъект
- d. Хор уршиг

5. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл нь:

- a. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруу
- b. Хууль зөрчсөн нийгэмд аюултай үйлдэл
- c. Гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж бүхий хэрэг үйлдэгдсэн
- d. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тогтоох

6. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг тогтоох вэ субъект

- a. Шүүх
- b. Прокурор
- c. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч
- d. Бүгд тогтооно

7. Эрүүгийн хариуцлага нь дараах ойлголтыг өөртөө багтаана (хамааралтайг ол):

- a. Ял ногдуулах
- b. Хууль зүйн хариуцлага
- c. Цагдан хорих
- d. Ёс суртахууны хариуцлага



8. “Уг гэмт хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол” гэсэн заалт гэмт хэргийн бүрэлдүүний ямар талд хамаарах вэ?

- a. Объект*
- b. Объектив тал*
- c. Субъект*
- d. Субъектив тал*

9. Эрүүгийн хариуцлага үүсэх үеийг тодорхойл:

- a. Гэмт хэрэг үйлдсэн үеэс*
- b. Тухайн этгээдийн гэм буруутайг шүүх тогтоож таслан шийдвэрлэх тогтоол гарсанаар*
- c. Ял эдлэж эхэлсэнээр*
- d. Яллагдагчаар татсанаар*

10. Хүнийг эрүүгийн хариуцлагад татах хууль ёсны гол үндэслэлийг ол.

- a. Гэм буруу*
- b. Гэмт хэргийн бүрэлдүүн*
- c. Эрүүгийн хууль зөрчсөн*
- d. Гэмт хэрэг үйлдсэн*

11. Дээрэмдэх гэмт хэрэг ямар бүрэлдүүнтэй вэ?

- a. Хэлбэрийн бүрэлдүүн*
- b. Материаллаг бүрэлдэхүүнтэй*
- c. Энэ хоёрын аль алиныг нь багтаасан шинжтэй*

СЭДЭВ 3. ГЭМТ ХЭРГИЙН ОБЪЕКТ

Тодорхойлолт, шинж

Эрүүгийн эрх зүй нь хүмүүсийн нийтлэг эрх ашгийг гэмт халдлагаас хамгаалах зорилготой. Гэхдээ бүхий л нийтлэг эрх ашиг Эрүүгийн хуулиар хамгаалагдсан гэж үзэх боломжгүй, нийгмийн хөгжлийн явцад шинэ төрлийн харилцаа үүссэнээр хамгаалах шаардлагатай эрх ашиг шинээр үүсч, зарим төрлийн харилцаа эрх зүйн зохицуулалтаас гарсаны улмаас холбогдох эрх ашиг нь эрүүгийн эрх зүйгээр хамгаалагдах шаардлагагүй болдог. Ийм учраас Эрүүгийн хуулиар чухам ямар эрх ашгийг хамгаалах ёстойг тусгайлан зааж өгдөг. Энэхүү **эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашгийг гэмт хэргийн объект** гэнэ.

Бүх гэмт хэрэг нь заавал ямар нэг эрх ашигт халдсан байдаг, өөрөөр хэлбэл объектууд гэмт хэрэг гэж байдаггүй. Ерөнхийдөө Монгол Улсын Эрүүгийн хуулиар хүний эрх, эрх чөлөө бусад нийтлэг (нийгмийн болон төрийн) эрх ашгийг хамгаалахаар заасан.



Анхаарах зүйл

Гэмт хэргийн нийгэмд аюултай шинж нь халдаж буй объектоороо илэрхийлэгддэг. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн объект нь гэмт хэргийг ангилах үндэслэл юм. Ихэнх тохиолдолд гэмт хэргийн улмаас бодит хохирол учирч түүнийг нь үнэлж, хэмжин нийгмийн хор аюулыг нь тодорхойлж болдог авч зарим тохиолдолд ийм боломжгүй байдаг. Тухайлбал, танхайрах, бусдыг гүтгэх, доромжлох зэрэг гэмт хэргийн улмаас учирсан хор уршиг нь материаллаг илэрхийллээр хэмжихэд төвөгтэй. Гэхдээ энэ нь эдгээр гэмт хэргийн улмаас ямар нэг эрх ашиг хөндөгдөөгүй, хүмүүст хор уршиг учраагүй гэсэн үг биш юм.

Гэмт хэргийн объектын төрөл

Гэмт хэргийн объектыг ерөнхий, төрлийн, шууд гэж ангилах бөгөөд Эрүүгийн хуулиар хамгаалагдсан нийт эрх ашиг ерөнхий объект болно. Эрүүгийн хуульд зааснаар “Монгол

Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам, энх тайван, хүн төрөлхтний аюулгүй байдал” нь гэмт хэргийн ерөнхий объект юм.

Төрлийн объект бол агуулгын хувьд ойролцоо, хоорондоо харилцан хамаарал бүхий нэг төрлийн эрх ашиг юм. Эрүүгийн хуулийн Тусгай ангийг төрлийн объектоор системчилэн хэсэг, бүлэгт хуваадаг. Жишээлбэл: Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг гэсэн бүлэгт бусдын өмчлөх эрхэнд халдсан бүх гэмт хэргийг хуульчилсан.

Шууд объект гэдэгт гэмт халдлагад шууд өртөж буй эрх ашгийг ойлгоно. Шууд объект нь Эрүүгийн хуулийн зүйл, заалтыг системчилэх шалгуур болдог. Өөрөөр хэлбэл шууд объектоор нь тодорхой гэмт хэргийн бүрэлдүүнийг хуулийн зүйл болгон системчилдэг.





Нэг гэмт халдлагын явцад Эрүүгийн хуулиар хамгаалсан хэд хэдэн эрх ашигт халдсан байж болох ба ийм байвал уг гэмт хэргийг давхар объектгой гэмт хэрэг гэнэ. Жишээлбэл: бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг нь хүний өмчлөх эрхэд халдсан гэмт хэрэг боловч дээрмийн халдлагын явцад хүний амь бие, эрүүл мэнд, халдашгүй чөлөөтэй байх эрхэд давхар халдаж байдаг. Ийнхүү хэд хэдэн эрх ашигт зэрэг халдсан гэмт хэргийн үед уг гэмт хэргийн сэдэлт, зорилгын улмаас өртөж буй эрх ашгийг үндсэн шууд объект, харин гэмт хэргийг үйлдэх арга, нөхцөл байдлын улмаас давхардан өртөж буй эрх ашгийг нэмэгдэл объект гэдэг.



Анхаарах зүйл

Гэмт хэргийг үндсэн объектоор нь зүйлчилнэ.

Гэмт хэргийн халдлагын зүйл

Зарим гэмт хэрэг материаллаг эд зүйлд чиглэсэн байдаг (эд хөрөнгө хулгайлах, бичиг баримт хуурамчаар үйлдэх г.м).

Гэвч эдгээр материаллаг зүйлсийн цаана хүний эрх ашиг илэрхийлэгдсэн буй. Эрүүгийн эрх зүйд **гэмт халдлагад өртсөн эд зүйлийг гэмт хэргийн халдлагын зүйл** гэдэг. Гэмт хэргийн халдлагын зүйл болон гэмт хэргийн объект нь хоорондоо салшгүй ойлголт боловч эдгээрийг адилтгах буюу хамтатган үзэж болохгүй. Гэмт хэргийн объект бол тодорхой эрх ашг. Халдаагын зүйл бол тэрхүү эрх ашгийг өөртөө шингээсэн төрөл бүрийн материаллаг зүйл юм. Жишээлбэл: бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн объект нь хүний өмчлөх эрх байдаг бол халдлагын зүйл нь хулгайд алдагдсан төрөл бүрийн эд хөрөнгө байна. Гэмт хэргийн улмаас эрх ашиг заавал хөндөгдөнө. Гэхдээ тэрхүү эрх ашиг нь заавал материаллаг зүйлээр дамжин илэрхийлэгдэхгүй байж болно.

Зарим тохиолдолд гэмт хэргийн улмаас гэмт халдлагад өртсөн хүнд өөрт нь бодитой хор уршиг учирсан (хүний бие махбодид гэмтэл учруулах, хүчиндэх г.м) байж болдог. Эрүүгийн эрх зүйд **гэмт халдлагад өртсөн хүнийг хохирогч** гэдэг. Гэмт хэргийн зэвсэг, хэрэгсэл нь гэмт хэрэг үйлдэх зорилгоор ашигласан, бэлтгэсэн, төрөл бүрийн зэвсэг, эд зүйл болон бусад зүйл байдаг бөгөөд зэвсэг хэрэгсэлийг халдлагын зүйлд халдах зорилгоор ашигладаг. Халдлагын зүйл нь гэмт хэргийн объектын шинж байдаг бол зэвсэг хэрэгсэл нь объектив талын шинж юм. Гэхдээ нэг гэмт хэргийн халдлагын зүйл өөр гэмт хэргийн зэвсэг, хэрэгсэл болж болно.



Даалгавар:

1. Гэмт хэргийн объект болон халдлагын зүйлийн ялгааг жишээгээр тайлбарлана уу.
2. Гэмт хэргийн халдлагын зүйл болон зэвсэг хэрэгсэлийн ялгааг жишээгээр тайлбарлана уу. Гэмт хэрэг үйлдсэн зэвсэг хэрэгсэл гэдэгт ямар зүйлсийг хамруулах талаар шүүхийн практикт баримталж буй тайлбарыг судална уу.



Сорил

1. Гэмт хэргийн объект:

- a. Гэмт хэрэгт өртөгдөж байгаа зүйл
- b. Гэмт халдлагад өртөгдөж буй Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашиг
- c. Нийгмийн харилцаа
- d. Хууль зүйн хариуцлага хүлээлгэх заншил, ёс суртахууны болон эрх зүйн хэм хэмжээ

2. Гэмт хэргийн ерөнхий объект:

- a. Эрүүгийн хуулиар хамгаалагдсан бүх эрх ашиг
- b. Эрх зүйн хэм хэмжээгээр хатгаалагдсан эрх ашиг
- c. Эрүүгийн хуулиар хамгаалагдсан нийгмийн харилцаа
- d. Бүх хариулт зөв

3. Шууд объект:

- a. Тодорхой гэмт хэрэгт өртөгдөж буй эрх ашиг
- b. Нэг төрлийн шинжтэй эрх ашгийн нийлбэр
- c. Гэмт халдлагад өртөгдсөн шууд эрх ашиг




СЭДЭВ 4. ГЭМТ ХЭРГИЙН ОБЪЕКТИВ ТАЛ

**Тодорхойлолт,
шинж**

Эрүүгийн хуулиар хамгаалсан эрх ашгийн эсрэг гэмт халдлагын илрэх байдал нь гэмт хэргийн объектив тал болно. Энэхүү гадаад байдал нь нийгэм, хүмүүсийн нийтлэг эрх ашигт хор уршиг учруулах буюу учруулахаар занал хийлж буй хүсэл зоригийн зан үйлээр илэрнэ. Аливаа эрх ашигт янз бүрийн арга, хэлбэрээр халдаж болох бөгөөд зөвхөн гэмт хэргийн объектыг үндэслэн тухайн хэргийн шинж чанарыг тодорхойлох боломжгүй. Нэг эрх ашигт янз бүрийн арга, хэлбэрээр халдаж болох бөгөөд ийм гэмт зан үйлийг ялган зааглах гадаад шалгуур нь гэмт хэргийн объектив тал болдог юм. Тухайлбал, өмчлөх эрхийн эсрэг “бусдын эд хөрөнгийг хулгайлах”, “булаах”, “дээрэмдэх”, “залилан мэхлэх” гэмт хэргүүдийн ялгаа нь эдгээр гэмт хэргийг үйлдэх арга нь байдаг. Тийм ч учраас Эрүүгийн хуульд гэмт хэргийн объектив талын (гадаад) шинжийг дэлгэрэнгүй тодорхойлдог.

Гэмт хэргийн объектив тал нь гэмт үйлдэл, эс үйлдэхүй, түүний улмаас бий болох нийгэмд аюултай хор уршиг, тэдгээрийн хоорондох шалтгаант холбоо, гэмт хэрэг үйлдсэн арга, газар, цаг хугацаа, нөхцөл байдал, зэвсэг, хэрэгсэл зэргийг багтаасан гэмт хэрэгт зайлшгүй байх бүрэлдүүн хэсэг юм. Эдгээр шинжүүдийг үндсэн ба нэмэгдэл гэсэн 2 бүлэгт хуваадаг. Объектив талын үндсэн шинж нь тодорхой гэмт хэрэг заавал байх ёстой шинжүүд бөгөөд уг шинж байхгүй бол гэмт хэрэг үгүйсгэгдэнэ. Харин хууль тогтоогч нэмж зарим нэг шинжийг гэмт хэргийн бүрэлдүүн болгон заасан байвал нэмэгдэл шинж гэж үзнэ. Нэмэгдэл шинж зарим тохиолдолд гэмт хэргийн бүрэлдүүнийг тогтооход, зарим тохиолдолд ял ногдуул ахад харгалзах үндэслэл болно.





Анхаарах зүйл

Гэмт хэргийн объектив талын үндсэн шинж нь бүх гэмт хэрэг заавал байх ёстой бөгөөд хэрэв уг шинж байхгүй байвал гэмт хэргийн бүрэлдэхүүн үгүйсгэгдэнэ. Харин нэмэгдэл шинжийг Эрүүгийн хуульд тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болгон заасан тохиолдолд уг шинж байгаа эсэхийг шалгана.

Гэмт зан үйл (үйлдэл, эс үйлдэхүй) Эрүүгийн хуулиар хориглосон, нийгэмд аюултай, ухамсарлагдсан хүсэл зоригийн зан үйл. Гэмт үйлдэл, эс үйлдэхүй нь дараах шинжүүдтэй: а) хэрэг хариуцах чадвартай этгээдийн зан үйл байна; б) нийгэмд аюултай, бусдад ноцтой хор уршиг учруулах шинжтэй; в) эрүүгийн хуулиар хориглосон, ял шийтгэхээр заналхийлсэн; г) тухайн этгээдийн хүсэл зоригийн зан үйл байна (тухайн этгээд хүсэж үйлдээгүй тухайлбал, рефлексийн улмаас хор уршиг учруулсаныг гэмт үйлдэл, эс үйлдэхүй гэж үзэхгүй). Гэмт зан үйлийг илрэх хэлбэрээр нь үйлдэл, эс үйлдэхүй гэж хуваана. Эрүүгийн хуулиар хориглосон, нийгэмд аюултай **зан үйлийн идэвхтэй хэлбэрийг гэмт үйлдэл** гэнэ. Гэмт үйлдэл нь **хүч хэрэглэсэн** ба **хүч хэрэглээгүй** байж болно. Хэлбэрийн хувьд гэмт үйлдэл нь:

- **үйл хөдлөлөөр** (шууд болон шууд бусаар тухайлбал, зэвсэг хэрэглэх, бага насны хүүхэд болон хэрэг хариуцах чадваргүй хүнээр дамжуулан);
- **үг хэлээр** (бусдыг айлган сүрдүүлэх, доромжлох, нууц мэдээ баримт задруулах)
- **Техник хэрэгсэл, амьтан, бодисын шинжийг ашиглах** (тээврийн хэрэгсэл, зэрлэг болон тэжээвэр амьтан г.м) зэрэг хүн болон бодит ертөнцийн юмсад нөлөөлөх хэлбэртэй байна.

Тодорхой нөхцөлд заавал хийх ёстой, хийж болох байсан үйлдлийг хийгээгүй **идэвхгүй зан үйлийг гэмт эс үйлдэхүй** гэнэ. Идэвхгүй зан үйл бүхэн гэмт эс үйлдэхүйд тооцоггүй бөгөөд тодорхой нөхцөл шаардана. Гэмт эс үйлдэхүйд тооцоход:

- Мэргэжлийн болон албаны дагуу, эсхүл хуулиар тодорхой үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээлгэсэн;
- Энэхүү үүргийг биелүүлэх бодит боломжтой байсан;
- Тухайн этгээд энэхүү үүргийг биелүүлээгүй тохиолдолд ял заналхийлсэн байх шаардлага тавигдана.

Хэрэв тодорхой үйлдэл хийх боломж нь гадны хүчин зүйлээс (байгалийн гамшиг, мэдлэг туршлага дутагдсан г.м) болж хязгаарлагдсан, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үүргээ биелүүлээгүй, үүргээ биелүүлэх бодит боломж байгаагүй эс үйлдэхүйд эрүүгийн хариуудага хүлээлгэхгүй. Тодорхой үйлдлийг хийх үүрэг нь дараах байдлаар илэрнэ. Үүнд:

- Хууль тогтоомжоор оногдуулсан (цэргийн алба хаах, татвар төлөх г.м)
- Гэр бүл, төрөл саднаа асран тэтгэх (Сургуулийн өмнөх насны хүүхдийг халамжлах үүрэгт ажилдаа хайнга хандах)
- Гэрээ хэлцлээр оногдсон үүрэг (ЭХ §154)



- ёс суртахууны хэм хэмжээ (ЭХ §107)
- Мэргэжлийн болон албаны үйл ажиллагаа (ЭХ §106)

Эс үйлдэхүй нь дээрх байдлаар оногдсон үүргээ биелүүлээгүй, албан үүрэгтээ хайхрамжгүй цалгар назгай хандсан, зохих ёсоор биелүүлээгүй зэргээр илрэх ба аль ч тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл үүснэ.



Анхаарах зүйл

Гэмт хэргийн бүрэлдүүний байдлаас хамаарч үйлдэл, эс үйлдэхүйг төгссөнд тооцох нь харилцан адилгүй. Хэлбэрийн бүрэлдүүнтэй гэмт хэрэгт гэмт хэргийн хор уршиг хэдийд үүсэхээс үл хамааран үйлдэл хийгдсэн үеэс гэмт хэрэг үйлдэгдэж төгссөнд тооцно. Харин материаллаг бүрэлдүүнтэй гэмт хэрэгт үйлдэл хэзээ эхэлсэн, төгссөнөөс үл хамааран хор уршиг учирч эхэлсэн үеэс гэмт хэрэг үйлдэгдэж төгссөнд тооцно.

Гэмт хор уршиг Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашигт халдсан нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бий болох хуульд гэмт хэргийн заавал байх шинж болгон заасан бодит үр дагаварыг хор уршиг гэнэ. Хор уршиггүй гэмт хэрэг байхгүй боловч хуулинд бүх гэмт хэргийн улмаас учрах хор уршигийг заадаггүй. Учир нь хэлбэрийн бүрэлдүүнтэй гэмт хэрэгт үйлдэл, эс үйлдэхүй гэмт хэрэг мөн эсэхийг тогтооход учирсан хор уршигийг үнэлэх шаардлагагүй байдаг. Харин материаллаг бүрэлдүүнтэй хэргийн хувьд бодитойгоор учирч буй хор уршиг нь үйлдэл, эс үйлдэхүйг Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэгт тооцох эсэхийг үнэлэх шалгуур болдог.

Гэмт хор уршиг:

Гэмт үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бий болох бодит үр дагавар

Үнэлж
хэрэглэх
хор уршиг


Хохирол

Үндсэнхоруршиг: Тодорхойгэмтхэргийнбүрэлдэхүүний
объектив талын заавал байх шинж бөгөөд тухайн зүйл ангид
заасан гэмт хэргийн улмаас заавал учирдаг үр дагавар.

Материаллаг



Материаллаг
бус

Нэмэгдэл хор уршиг: Тухайн
гэмт хэргийн бүрэлдэхүүний агуулгад
багтдаг дотоод шинж бөгөөд зайлшгүй
байхшаардлагагүйтодорхойтохиолдолд
учирч болох үр дагавар.



Гэмт хэргийн улмаас учирсан хор уршгийн хэмжээг тогтооход тодорхой үзүүлэлтүүдийг ашиглах шаардлагатай болдог. Ийм үзүүлэлтэд хоёр буюу түүнээс олон хүнийг (ЭХ 91.2.16), хөдөлмөрийн чадварын гуравны нэгээс дээшгүйг алдагдуулсан (ЭХ 98.1), их хэмжээний хохирол учирсан (ЭХ 145.3) гэх зэргээр хэмжээ тогтоосон хор уршиг хамаарна. Харин “хүнд хор уршиг”, “гэм хор” г.м үнэлж хэрэглэх хор уршгийг тусгай ухагдахуун хэрэглэн хууль сахиулагч дотоод итгэлээрээ үнэлж тогтооно.

Үнэлж хэрэглэх хор уршиг
Эрүүгийн хуульд шалгуурыг тодорхойлоогүй үр дагавар.





Гэмт хэргийн шалтгаант холбоо

Гэмт үйлдэл, эс үйлдэхүй болон нийгэмд аюултай хор уршиг хооронд тогтсон объектив, дотоод, зайлшгүй харилцан хамаарлыг гэмт хэргийн шалтгаант холбоо гэдэг. Ерөнхийд нь шалтгаант холбооны агуулгыг латины *sine qua non* буюу *хэрэв тэгээгүй бол...* гэсэн томъёололоор илэрхийл нь бий.

Эрүүгийн эрх зүй дэх гэмт хэргийн шалтгаант холбоо дараах шинжүүдтэй:

- Гэмт хэргийн шалтгаант холбоо нь объектив шинжтэй. Шалтгаант холбоо нь бодитойгоор оршин байх ёстой өөрөөр хэлбэл гэмт хэргийн субъектийн хүсэл зоригоос ангид байна.
- Энэхүү холбоо нь дурын үзэгдлийн хооронд бус Эрүүгийн хуульд заасан гэмт үйлдэл, эс үйлдэхүй болон хор уршигийн хоорондын холбоо байна.
- Үйлдэл болон хор уршиг хоорондоо цаг хугацааны хувьд дараалсан шинжтэй байна.
- Гэмт үйлдэл, эс үйлдэхүй нь хор уршигт зайлшгүй хүргэх нөхцөл болсон байх ёстой.



Анхаарах зүйл

Материаллаг бүрэлдүүнтэй гэмт хэрэгт шалтгаант холбоог заавал тогтооно.

Гэмт хэргийн объектив талын нэмэгдэл шинж

Зэвсэг хэрэгсэл: Гэмт этгээдийн ашигласан галт болон хүйтэн зэвсэг, зодооны хэрэгсэл, химийн бодис, багаж хэрэгсэл, техник тоног төхөөрөмжүүд

Арга: Гэмт этгээдээс тодорхой үйлдлээ хэрэгжүүлэхийн тулд хэрэглэж байгаа үйл ажиллагааны хэлбэр

Нөхцөл байдал: Гэмт хэргийн нийгэмд аюултай байдлыг ихэсгэх, багасгахад нөлөөлж буй объектив шинжтэй нөхцөл байдлууд

Гэмт хэргийн объектив талын нэмэгдэл шинж

Цаг үе: Гэмт хэрэг үйлдэгдсэн болон эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд ямар нэг байдлаар нөлөөлөх үйл явдал болж өнгөрсөн тодорхой цаг үе

Газар: Гэмт хэрэг үйлдэгдсэн, эхэлсэн дууссан, хор уршиг учирсан тодорхой нутаг дэвсгэр



Анхаарах зүйл

Эдгээр нэмэгдэл шинжийг Эрүүгийн хуулийн тусгай ангид тухайлан заасан бол уг шинж нь объектив талын заавал байх шинж болж зүйлчлэлд нөлөөлөх бөгөөд хуульд заагаагүй тохиолдолд гэмт хэргийн бүрэлдүүн, зүйлчлэлд нөлөөлдөггүй учир нэмэгдэл шинж гэж нэрлэдэг. Гэхдээ эдгээр нөхцөл байдлуудыг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг нэг бүр дээр тодруулан тогтоох шаардлагатай бөгөөд доорхи нөхцөл байдлуудыг нарийн зөв тогтоох нь эцэстээ хэргийг үнэн зөв шийдвэрлэх, ялыг ялгамжтай оногдуулахад харгалзан үзэх чухал үндэслэл болдог.



Хяналтын асуулт

1. Гэмт хэргийн бүрэлдүүний объектив талын ойлголтыг тодорхойл
2. Гэмт хэргийн бүрэлдүүний объектив талын бүтцийг тодорхойл
3. Гэмт үйлдэл гэж юу вэ? Гэмт үйлдлийн эс үйлдэхүйгээс ялгагдах онцлогийг жишээн дээр тайлбарла
4. Гэмт үйлдэл, эс үйлдэхүйн төрлийг тодорхой жишээн дээр тайлбарла
5. Гэмт хэргийн шалтгаант холбоо, түүний Эрүүгийн эрх зүйн учир холбогдлыг тодорхой жишээн дээр тайлбарла
6. Гэмт хэргийн бүрэлдүүний объектив талын нэмэгдэл шинжүүд, тэдгээрийн Эрүүгийн эрх зүйн учир холбогдлыг тодорхой жишээн дээр тайлбарла



Сорил

1. **Гэмт хэргийн объектив тал нь:**
 - a. Шалтгаант холбоо, гэм буруу, гэмт хор уршиг, гэмт хэрэг үйлдсэн арга, зорилго
 - b. Гэмт хэрэг үйлдсэн газар, цаг, нөхцөл байдал, гэмт хор уршиг, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн нас, гэмт хэрэг үйлдсэн цаг хугацаа,
 - c. Гэмт үйлдэл, эс үйлдэхүй, шалтгаант холбоо, хор уршиг, гэмт хэрэг үйлдсэн арга, гэмт хэрэг үйлдсэн цаг хугацаа
 - d. Гэмт хор уршиг, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, зорилго, гэмт хэрэг үйлдсэн цаг хугацаа
2. **Гэмт хор уршиг:**
 - a. Гэмт халдлагад өртсөн эрх ашигт гарсан өөрчлөлт
 - b. Нийгмийн харилцаанд гарсан хор уршиг бүхий өөрчлөлт
 - c. Материаллаг болон оюун санааны хохирол
 - d. Иргэн, нийгэм, төрд учруулсан хор уршиг
 - e. Бүх хариулт зөв



- 3. Гэмт эс үйлдэхүүд эрүүгийн хариуцдагд хүлээлгэх үндэслэл нь:**
- a. Тухайн этгээд үйлдэл хийх үүрэгтэй байсан*
 - b. Эс үйлдэхүйн улмаас гэмт хор уршиг учирсан*
 - c. Эрүүгийн хуульд заасан эс үйлдэхүй*
 - d. Дээр өгүүлсэн бүх байна*
- 4. Гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын заавал байх үндсэн шинжийг тодорхойл:**
- a. Хор уршиг*
 - b. Шалтгаант холбоо*
 - c. Үйлдэл эс үйлдэл*
 - d. Арга*
- 5. Гэмт үйлдлийн арга нь:**
- a. Гэм буруутай этгээдийн үйлдлийн арга, техник*
 - b. Гэмт хэрэг үлдэхэд ашигласан зэвсэг хэрэгсэл*
 - c. Гэмт хэрэг үйлдсэн цаг уе*
 - d. Гэмт хэргийг хамтран үйлдсэн*

ДАСГАЛ 2. ГЭМТ ХЭРГИЙН ОБЪЕКТИВ ШИНЖ

(Тохиолдол шинжлэх)

- Тохиолдол 1. А, Х нар Ховд аймгийн төвд байх “Тулга” зочид буудалд хөдөө сумаас ирсэн “Э”-г дагуулан орж архи уун наргиж цэнгэж эхлэв. Тэд өөрсдөө бага ууж ихэнхи архийг “Э”-д шахаж өгсөөр согтоосоны дараа түүний биеэ хамгаалж чадахгүй байдлыг нь далимдуулан эхлээд “А” дараа нь “Х” хурьцал үйлдсэн байна. Дараа нь тэд хариуцлагаас айгаад “Э”-г буудлын гадаа дан хувцастай нь гаргаж тавьсанаас өвлийн хүйтэнд Э хөлдөж нас барсан байсныг буудлын жижүүр олоод цагдаад мэдэгджээ.
- Тохиолдол 2. 2001 оны 5 сард БГД-н цагдаагийн хэлтэст -р хорооны иргэн “А” дараах утгатай өргөдөл гаргасаныг товчилбол ...би жилийн өмнө 45 настай “Б” гэгчтэй ханилан суухад охин маань 18 настай байсан юм. Гэтэл “Б” охиныг намайг ажилтай, эзгүй байхад эрхшээлдээ оруулж хүчирхийлээд байх шиг байна, шалгаж өгнө үү гэсний дагуу эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцаалтын ажиллагаа эхлүүлсэн. 19 настай “Э” охиныг хохирогчоор тогтоож байцаахад тэрээр мэдүүлэхдээ...жилийн өмнө хойд эцэг “Б” намайг хүчээр эзэмдэж бэлгийн ажил хийсэн, түүний дараагаас бид харилцан зохицоод бэлгийн харьцаанд ордог болсон, гомдол саналгүй гэсэн байна.
- Тохиолдол 3. Байнга зодож тарчлаадаг нөхөр “С”-с салахаар шийдсэн “Э” бүсгүй шүүхэд удаа дараа хандсан боловч тухай бүр нь “С” ална гэж заналхийлэн өргөддийг нь буцаалгадаг байв. Цаашид энэ хэвээр амьдрах аргагүй болсон “Э” хүнсний захаас уксус худалдан авч түүнийгээ хоосон архины шилэнд юүлээд нүдэнд харагдах газар тавиад найзындаа хонохоор явжээ. Маргааш өглөө нь найзынхаа хамт гэртээ ирэхэд “С” амьтай голтой таталдаж байхаар нь түргэн дуудаж эмнэлэгт хэвтүүлсэн боловч 2 хоноод С нас барсан байна. Шүүх эмнэлгийн дүгнэлтэнд ...хохирогч нь улаан хоолойн хурц түлэгдэлт, ходоод нь цоорсоны улмаас нас барсан, хүнд зэргийн согтолттой байсан гэжээ.
- Тохиолдол 4. Гадаадын нэгэн орны элчин сайд П-г нутаг буцахаар онгоцны буудал дээр ирэх үед Р гэгч этгээд буудаж хүндээр шархдуулсан байна. Эмч нар зөвлөлдөөд амь биед аюултай хүнд гэмтэл учир даруй нутаг буцаахаар шийдвэрлэж элчинг онгоцонд нь оруулсан. Хагас цагийн дараа онгоц хөөрсөн ба цагийн дараа нисэгчдийн буруутай ажиллагаанаас болж уг онгоц агаарт сүйрэн нэг ч хүн амьд үлдээгүй байна.
- Тохиолдол 5. Нэгэн оёдлын үйлдвэрт хамт ажилладаг “Б”, “Ө” нар таарамж муутай үргэлж хэрэлддэг байв. Нэгэн удаа тэдний байгууллага амралтанд явсан ба “Б” бусдын нүдийг хариулж байгаад “Ө”-н



аягатай цайнд хор хийсэн байна. Гэтэл тэдний байгууллагын нэгэн ажилтан П ихэд согтуугаар “Ө”-тэй маргалдаж эхэлсэн ба улмаар хутга авч түүний цээжин тус газар хутгалсаны улмаас хорны үйлчлэл эхлэхээс өмнө “Ө” нас барсан байна.

- Тохиолдол 6. Орон гэргүй тэнүүчлэн амьдардаг 2 этгээд амь зуухын эрхээр оршуулгын газар барааддаг байв. Эхэндээ тэд шинэхэн оршуулганд тавьсан идээ будааг хүртдэг байснаа дараа нь булш ухаж дотор нь тавьсан архийг ууж бусад эд зүйлсийг зарж амьдардаг болсон. Хүмүүсийн мэдээллээр дээрх хүмүүсийг баривчлан шалгахад тэд 30 орчим булшийг ухсанаа хүлээгээд хариуцлага хүлээхэд бэлэн байгаагаа мэдэгдсэн.
- Тохиолдол 7. Эрхэлсэн ажилгүй “Ч”, “Н” нар нэгэн эмийн сангийн дохиоллын системийг урьдчилан ажиллагаагүй болгоод цонхоор нь орж 2 сая төгрөгийн үнэ бүхий эм бэлдмэл хулгайлсан байна. Тэдгээр алдагдсан эм бэлдмэлийн дотор эрүүл мэндийн сайдын тушаалаар тусгай жороор худалдах учиртай хар тамхины найрлагатай эм тарианууд байсан байна.
- Тохиолдол 8. Эрхэлсэн ажилгүй хэсэг залуус шинэ жилийн баяраар хэрхэн мөнгөтэй болох талаар ярилцан Богд ууланд гарч гацуур мод огтолж зарахаар шийджээ. Тэгээд ачааны машинаар Богд уулнаас 19 ширхэг гацуур мод огтлон оруулж ирээд байгууллага, хувь хүмүүст 1 ширхэгийг нь 50-200,0 төгрөгөөр худалдсан байна. Маргааш нь амташсан залуус хүүхдийн соёл амралтын төвийн хашаанаас дахин 5 ширхэг гацуур мод огтолж байгаад баригдсан.

СЭДЭВ 5. ГЭМТ ХЭРГИЙН СУБЪЕКТИВ ТАЛ

Тодорхойлолт, шинж

Гэмт хэргийн бүрэлдүүний субъектив талд гэм буруу, сэдэлт, зорилго хамаарах бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйд болон түүний улмаас учирсан хор уршигт хандаж буй ухамсар, хүсэл зоригийн байдлыг илэрхийлнэ.


Гэм буруу нь санаатай эсхүл болгоомжгүй хэлбэрээр илрэх ба субъектив талын заавал байх үндсэн шинж бөгөөд гэм буруугүйгээр хор уршиг учруулсан бол гэмт хэргийн бүрэлдүүн үгүйсгэгдэж улмаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл байхгүй болно. Энэ талаар бүр Римийн эрх зүйгээс “Causa a nullo praestantur” буюу “тохиолдлын төлөө хэн ч хариуцлага хүлээхгүй” гэсэн мөрддөгөөг баримталж ирсэн юм.

Сэдэлт, зорилго нь хуульд тусгайлан заасан тохиолдолд субъектив талын нэмэгдэл шинж юм.

Гэмт хэргийн бүрэлдүүний субъектив тал нь хэн нэгний, тухайлбал, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн ухамсараас ангид бодитойгоор оршин байдаг учраас объектив шинжтэй юм. Өөрөөр хэлбэл **субъектив талын шинжийг тогтоохдоо хэн нэгний ухамсараас шалтгаалахгүй хэрэгт холбогдуулан цуглуулсан нотлох баримтыг үнэлэх замаар тогтооно.**

Гэм буруу Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүй түүний улмаас бий болох **хор уршигт хандах сэтгэхүйн хандлага** юм.

Гэм буруу нь гэм буруутай этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүй түүний улмаас бий болох хор уршигт хандах сэтгэхүйн харилцаа болох хувьдаа а) үйлдлийнхээ шинж чанар болон түүнээс үүдэн гарах үр дагаварыг ухамсарласан байдал буюу **оюун санааны**, б) тухайн зан үйлдээ хэрхэн хандсан байдал буюу **хүсэл зоригийн** талуудын нэгдэл байдаг. Энэхүү оюун санааны болон хүсэл зоригийн талуудын янз бүрийн хослолоор гэм буруугийн хэлбэрүүд тодорхойлогдох бөгөөд Эрүүгийн хуульд гэм буруугийн санаатай, болгоомжгүй гэсэн хоёр хэлбэрийг тодорхойлсон.





Анхаарах зүйл

Болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд гэмт хэрэгт тооцогдоно.

Гэм буруутай этгээдийн өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн шинж, тодорхой гэмт хэргийн бүрэлдүүний объектив талын нэмэгдэл шинж болгон заасан (газар, цаг үе, нөхцөл байдал зэрэг) шинжийг, материаллаг бүрэлдүүнтэй гэмт хэрэг учирч болох хор уршгийг ухамсарласан байх зэрэг нь гэм буруугийн оюун санааны элементийг илэрхийлнэ.

Санаатай гэм буруу Хүсэл зоригийн талын ялгаатай шинжийг үндэслэн санаатай гэм бурууг шууд санаа, шууд бус санаа гэж ангилна. Санаатай гэм буруу нь оюун санааны хувьд 1) гэмт хэрэг үйлдэж буй этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн **хор аюулыг ухамсарласан**, 2) учирч болох **хор уршгийг урьдчилан мэдсэн**; хүсэл зоригийн хувьд тэрхүү хор уршгийг зориуд хүсэж үйлдсэн бол **шууд санаа**, **хор уршгийг хүсээгүй боловч зориуд хүргэсэн** буюу **ялгаагүй хандсан** бол **шууд бус санаа** гэж үзнэ.



Анхаарах зүйл

Шууд санаатай гэмт хэрэг үйлдэж буй этгээд зайлшгүй учрах нийгэмд аюултай хор уршгийг мэдэж хүсэж үйлддэг бол шууд бус санаа нь учирч болох хор уршгийг мэдсэн байдгаараа ялгаатай. Хэрэв субъект хор уршиг гарцаагүй учрахыг мэдсэн бол шууд санаатай гэм буруу болно.

Гэмт хэргийн улмаас учирсан хор уршигт үндэслэн гэм бурууг тодорхойлох нь зөвхөн материаллаг гэмт хэрэгт боломжтой. Харин **хэлбэрийн бүрэлдүүнтэй гэмт хэрэгт** субъектийн хүсэл зоригийн талыг зөвхөн **үйлдлээр нь тогтоох шаардлагатай** болдог. Иймд санаатай гэм бурууг хэлбэрийн бүрэлдүүнтэй гэмт хэрэгт тогтоохдоо субъект өөрийн үйлдлийн нийгмийн хор аюулыг ухамсарласан байдал болон түүнийг хүсэж үйлдсэн байдлыг шалгуур болгоно.

Цочрон давчдалт Тодорхой нөхцөл байдлын улмаас хүчтэй цочмог үүсэж, агшин зуур явагддаг сэтгэцийн байдал. Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэрэг нь санаа сэтгэл нь хүчтэй цочрон давчидсаны улмаас үйлдэгдсэн байдаг бөгөөд ийм байдлаар үйлдэгдсэн бол хөнгөрүүлэх бүрэлдүүнтэй гэмт хэрэг болно. Эрүүгийн хуульд хохирогчид хүчээр дарлагдсан буюу хүндээр доромжлогдсон, эсхүл түүний хууль бус бусад үйлдлээс өөрт нь буюу ойр дотных нь хүмүүст хүнд хор уршиг учирсан, учирч болох байснаас санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчидсан үедээ бусдыг санаатай алсан үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан. Энэ гэмт хэрэг нь хохирогчийн хууль бус ажиллагаанаас болож гэм буруутай этгээдийн санаа сэтгэл гэнэт хүчтэй цочрон давчдсанаас өөрийн үйл ажиллагаанд хяналт тавих боломж алдсан сэтгэлийн онцлог цочролын үед үйлдэгдэнэ. **Хүндээр доромжлох** гэдэгт хохирогч гэмт буруутай этгээдийн **нэр төр, алдар хүндийг** амаар буюу бичгээр ноцтой **гутаасан**, түүнчлэн **угсаа гарал, үндэсний онцлог, бие эрхтний гажиг, зохисгүй байдал, өвчин эмгэгээр нь илтэд тохуурхан доромжилсон** үйлдлийг хамруулна. **Хүчээр дарлах нь хүч хэрэглэж** бусдын бие эрхтэнд халдан зодож **гэмтэл учруулах, айлган сүрдүүлж** санаа сэтгэл, эд материал, ахуйн талаар хүчтэй **дарамт үзүүлэх**, хүч чадлаар давамгайлж **дээрэлхэх** үйлдэл байна.



Анхаарах зүйл

Цочрон давчидсан санаа нь эмгэг биш ердийн цочрон давчдалт байна

Болгоомжгүй гэм буруу Эрүүгийн эрх зүйд болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бусдад гэм хор учруулж байгааг латины *Culpa lata dolo comparator, culpa lata dolo proxima est* буюу **хэтэрхий хайхрамжгүй хандах нь санаатай үйлдсэнтэй утга ойролцоо** гэсэн үндэслэлийн улмаас гэм буруугийн хэлбэрт тооцогддог.

Гэмт хэрэг болгоомжгүй үйлдэх нь **хөнгөмсгөөр найдсан**, эсхүл **хайхрамжгүй хандсан** гэсэн хоёр хэлбэртэй байна. Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаж, түүний улмаас нийгэмд аюултай **хор уршиг учрах боломжтойг урьдчилан мэдсэн боловч түүнийг гаргахгүй байж чадна гэж тооцон үйлдсэн** бол **хөнгөмсгөөр найдсан** харин гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаж, түүний улмаас нийгэмд аюултай **хор уршиг учрах боломжтойг урьдчилан мэдэх ёстой, мэдэх боломжтой байсан боловч мэдэлгүй үйлдсэн** бол **хайхрамжгүй хандсан** гэнэ.



ШУУД бус санаа болон хөнгөмсөгөөр найдсан гэм буруугийн ялгаа

Шууд бус санаатай гэм буруу нь бодитойгоор учирч болзошгүй хор уршгийг мэдсэн байдаг бол хөнгөмсөгөөр найдах үед учирч болох болох хор уршгийг хийсвэр байдлаар урьдчилан мэдсэн байдаг, мөн шууд бус санаа нь хор уршигт яасан ч яахав гэсэн байдлаар буюу ялгаагүй хандсаны улмаас хор уршигт хүргэсэн байдаг бол хөнгөмсөгөөр найдсан үед хор уршигт хүрэхгүй байж чадна гэж найдсан байдгаараа ялгаатай.

Хор уршгийг гэм буруугүйгээр учруулах

Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн хор аюулын шинж чанарыг **ухамсарлаагүй, хэргийн нөхцөл байдлын улмаас ухамсарлах боломжгүй байсан**, түүнчлэн учирч болох нийгэмд аюултай хор уршгийг урьдчилан мэдэх боломжгүй, мэдэх ёсгүй байсныг хор уршиг гэм буруугүйгээр учруулсан гэнэ. Эрүүгийн эрх зүйн онолд хор уршгийг гэм буруугүйгээр учруулсаныг **тохиолдол** гэдэг. Тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

Гэм буруугүйгээр хор уршиг учруулах

Тохиолдол

Оюун санааны шинж

Үйлдэл, эс үйлдэхүйн хор аюулыг ухамсарлаагүй, ухамсарлах боломжгүй

Учирч болох хор уршгийг мэдэх боломжгүй, мэдсэн байх ёсгүй байсан

Хүсэл зоригийн шинж

Нийгэмд аюултай үйлдэл хийж хор уршиг учруулах хүсэл зориг байхгүй

Гэм буруугийн хоёр хэлбэр

Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдсэн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй түүнийг дагалдан бий болж байгаа хор уршигт сэтгэхүйн хувьд өөр өөр байдлаар хандаж байгаа хэлбэр. Тодруулбал, эхний гэмт хэрэгтээ санаатай хандсан боловч түүний улмаас гарах үр дагаварыг урьдчилан хараагүй, болгоомжгүй хандсан тохиолдолд гэм буруугийн хоёр хэлбэрийн асуудал үүснэ. Гэм буруугийн хоёр хэлбэр нь зөвхөн хүндрүүлэх бүрэлдүүнтэй гэмт хэрэгт гарч ирдэг.

Сэдэлт, зорилго

Гэмт хэргийн **сэдэлт** бол субъектийг гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн дотоод **өдөөгч ашиг сонирхол, эрэлт, хэрэгцээ** юм. Объектив хэрэгцээнд үндэслэгдсэн сэдэлт нь өөрөө гэмт хэргийн субъектив эх сурвалж болдог. Сэдэлт нь гэмт хэргийн бүрэлдүүний субъектив талын нэмэгдэл шинж болно.

Гэм хэргийн **зорилго** нь тухайн этгээд гэмт хэрэг үйлдэх явцад **хүрэхийг хүссэн үр дүн**. Гэмт хэргийн зорилгыг Эрүүгийн хуульд тодорхой гэмт хэргийн бүрэлдүүний субъектив талын үндсэн болон нэмэгдэл шинж болгон заасан байна. Зарим төрлийн гэмт хэрэг нь зөвхөн зорилгоороо ялгагдан зүйлчлэгдэнэ. Жишээлбэл, ердийн бүрэлдүүнтэй хүн амины гэмт хэрэг нь өөр бусад жигшүүрт зорилгоор үйлдэгдсэн хүндрүүлэх бүрэлдүүнтэй хүн амины гэмт хэргээс зорилгоороо ялгагдана. Зорилго нь хэдийгээр тодорхой үр дүнд хүрэх эрмэлзэл боловч гэмт хэргийн зорилго болон учирсан хор уршиг хоорондоо заавал тохирох шаардлагагүй. Гэмт хэрэг үйлдсэн этгээд зорилгодоо хүрээгүй, эсхүл тавьсан зорилгоосоо илүү хор уршиг учруулсан байж болно.

Гэмт хэргийн сэдэлт, зорилгыг хуульчилахын учир холбогдол

Гэмт хэргийн сэдэлтийг хуулинд зааж байгаа нь уг хэрэг санаатай гэмт хэрэг болохыг илэрхийлдэг бол гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжид зорилгыг заасан байвал уг гэмт хэрэг зөвхөн шууд санаатай үйлдэгдэхийг зааж байгаа хэрэг. Харин болгоомжгүй гэмт хэргийн бүрэлдэхүүнд сэдэлт, зорилго заахгүй.

Эрүүгийн эрх зүй дэх гэм буруугийн андуурал

Гэм буруугийн андуурал нь өөрийн хийсэн үйл ажиллагааны нөхцөл байдал, нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, хор уршиг, хууль зүйн учир холбогдлын талаар буруугаар төсөөлөх явдал юм. Андуурал нь үйл ажиллагааны буюу

бодит байдлын болон хууль зүйн андуурал гэсэн хоёр хэлбэртэй байна.

Бодит байдлын андуурал

Гэмт хэргийн шинж, учрах хор уршиг, бусад нөхцөл байдлын талаар буруу төсөөлсөн

- объектыг андуурах
- халдлагын зүйлийг андуурах
- хохирогчийг андуурах
- үйлдэл, эс үйлдэхүйн шинжийг андуурах
- хор уршигийг андуурах
- шалтгаант холбооны хөгжилтийг андуурах
- хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдлыг андуурах

Хууль зүйн андуурал

Гэмт хэргийн хууль зүйн шинж, үр дагаварыг буруу төсөөлсөн

- эрүүгийн эрх зүйн хоригийг андуурах
- үйлдэл, эс үйлдэхүйгээ гэмт хэрэг гэж андуурах
- үйлдсэн гэмт хэргийнхээ хууль зүйн үр дагаварыг андуурах



Сорил

1. Гэмт хэргийн субъектив талын шинж нь (хамааралтайг ол):

- a. Үйлдэл, хэрэг хариуцах чадвар, шалтгаант холбоо
- b. Халдлагын зүйл, субъект, объект
- c. Сэдэлт, зорилго
- d. Хор уришиг, үйлдэл, шалтгаант холбоо
- e. Гэм буруу

2. Аль нь субъектав талын нэмэгдэл шинжид хамаарах вэ? (хамааралтайг ол):

- a. Үйлдэл, хор уришиг
- b. Сэдэлт
- c. Зорилго
- d. Хор уришиг, эс үйлдэхүй
- e. Гэм буруу

6. Гэм бурууг тодорхойл:

- a. Гэм буруу- гэмт хэрэг үйлдсэн этгээдээс шүүхийн шийдвэрт хандах хандлага
- b. Гэм буруу-өөрийн үйлдлийн хор аюул, нийгэмд аюултай шинжийг ухамсарлан ойлгож, түүнийг удирдах чадвар
- c. Гэм буруу-гэмт хэрэгтэн этгээдийн гэмт ур дагаварт хүрэх гэсэн эрмэлзэл
- d. Гэм буруу-эрүүгийн хуулиар хориглосон үйлдэл (эс үйлдэхүй), түүний улмаас буй болгосон хор уришигт санаатай буюу болгоомжгүй хандсан сэтгэхүйн харьцаа

4. Гэмт хэргийн сэдэлтийг тодорхой зааж өгсөн бол хэргийн зүйлчлэл

- A хүндэрч зүйлчлэгдэнэ
- B. хөнгөрнө
- B. ердийн байдлаар зүйлчлэгдэнэ

5. Гэмт хэргийн субъектив талын зайлшгүй байх шинж:

- a. Үйлдэл
- b. Сэдэлт
- c. Зорилго
- d. Гэм буруу
- e. Хэрэг хариуцах чадвар
- f. Шалтгаант холбоо

6. Гэм буруугийн хэлбэр:

- a. Санаатай ба болгоотжгүй
- b. Санаатай ба хайхрамжгүй хандах

- с. Санаатай ба тохиолдол*
- д. Болгоомжгүй, санаатай, гэм буруугийн давхар хэлбэр*

7. Болгоомжгүй гэм буруугийн хэлбэр:

- а. Хайнга хандах ба хайхрамжгүй хандах*
- б. Гэнэт үүссэн, урьдчилан төлөвлөсөн*
- с. Хайхратжгүй хандах, хөнгөтсөгөөр найдах*
- д. Шууд бус болгоомжгүй, шууд болгоотжгүй*

8. Урьдчилан төлөвлөсөн санаа нь:

- а. Шууд бус санаа*
- б. Шууд санаа*
- с. Хөнгөмсөгөөр найдсан санаа*
- д. Хайхрамжгүй хандсан санаа*

9. Гэмт хэргийг шунахай сэдэлтээр үйлдвэл

- а. Субъектэд хатаарна*
- б. Субъектив талд хамаарна*
- с. Объектив талд хатаарна*

10. Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн хэргийн нийгэмд аюултай шинж, түүнээс бий болох хор уршгийг ухамсарлан мэдэж байсан боловч тэр хор уршигт зориуд хүргэсэн нь

- а. Шууд санаа*
- б. Гэнэт үүссэн санаа*
- с. Шууд бус санаа*
- д. Хайхрамжгүй хандсан байдал*



СЭДЭВ 6. ГЭМТ ХЭРГИЙН СУБЪЕКТ

Тодорхойлолт, шинж Эрүүгийн хуульд заасан нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй хийсэн, гэм буруутай, эрүүгийн хариуцлага хүлээх тодорхой насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай бие хүн. Гэмт хэргийн субъект нь нийтлэг болон тусгай гэж ангилагдана. **Нийтлэг субъект** нь дээр дурьдсан шинжийг агуулсан байна. **Тусгай субъект** нь нийтлэг шинжээс гадна хуульд заасан нэмэлт шинжийг шаардаж байдаг. Энэ байдал нь тухайн этгээдийн ажил мэргэжил, албан тушаал, иргэний харъяалал, хүйс, зэргээс хамааралтай.

Гэмт хэргийн субъектийн үндсэн шинж

Хуулиар тогтоосон насанд хүрсэн байх	Хэрэг хариуцах чадвартай байх
- Гэмт хэрэг үйлдэх үедээ 16 насанд хүрсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. 14 - 16 хүртэл насны этгээд: Хүнийг санаатай алах, Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах, Хүчиндэх, Бусдын эд хөрөнгийг хулгайлах, Бусдын эд хөрөнгийг булаах, Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх, Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар танхайрах гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ - Зарим төрлийн гэмт хэрэгт тодорхой насанд хүрсэн этгээдийг субъектээр тооцно. Тухайлбал, цэргийн болон албан тушаалын гэмт хэргүүд, Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах, Насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэл, гуйланчлалд татан оруулах зэрэг гэмт хэргийн субъект 18 насанд хүрсэн байхыг шаардлагатай.	- Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдлийг хариуцах буюу жолоодох чадвар - Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй, өөрөөр хэлбэл, сэтгэцийн архаг өвчтэй, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, эсхүл оюун ухааны хомсдолтой буюу өөр бусад хүнд өвчний улмаас сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлах буюу үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадваргүй болсон этгээдэд ял оногдуулахгүй.

Хэрэг хариуцах чадвар Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдлийг хариуцах буюу жолоодох чадвар. Монгол Улсын эрүүгийн хуулинд хэрэг хариуцах чадваргүй байдлыг тодорхойлох замаар хэрэг хариуцах чадварын агуулгыг тодорхойлсон (ЭХ 22). Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдлийг хариуцаж буюу жолоодож чадахгүй болсныг ойлгоно. Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй, өөрөөр хэлбэл, сэтгэцийн архаг өвчтэй, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, эсхүл оюун ухааны хомсдолтой буюу өөр бусад хүнд өвчний улмаас сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлах буюу үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадваргүй болсон этгээдэд ял оногдуулахгүй. Ийм этгээдэд шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэнэ. Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадвартай байсан боловч шүүх хэргийг шийдвэрлэх үед сэтгэцийн өвчтэй, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, эсхүл өөр бусад хүнд өвчний улмаас сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлах буюу үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадваргүй болсон этгээдэд ял оногдуулахгүй. Ийм этгээдэд энэ хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж, эдгэрсний нь дараа ял оногдуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэг хариуцах чадваргүй байдлыг **хууль зүйн** (сэтгэл зүйн) болон **эмнэлгийн** (биологийн) гэсэн хоёр шалгуураар тогтооно. Хэрэг хариуцах чадваргүй байх нь тухайн этгээдийн үйлдлийн гэмт хэргийн бүрэлдүүний шинжийг үгүйсгэдэг, өөрөөр хэлбэл, хэрэг хариуцах чадваргүй байдал эрүүгийн хариуцлагыг үгүйсгэх үндэслэл болно. Гэм буруутай этгээдийн хэрэг хариуцах чадвартай эсэхийг шүүх эмнэлэгийн шинжээчийн дүгнэлтийг үндэслэн шүүх тогтооно.

Гэмт хэрэг үйлдэх үедээ согтуурсан, мансууруулах бодис хэрэглэсэн буюу бусад замаар мансуурлын байдалд орсон нь тухайн этгээд өөрийн зан үйлээ удирдах, хянах чадварыг алдагдуулахгүй гэж үздэг учраас согтуурал буюу мансуурлын байдалд байхдаа гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхгүй.

Эрүүгийн хариуцлага хүлээх нас Эрүүгийн хуулиар гэмт хэргийн субъектийг тодорхой насанд хүрсэн байхыг шаарддаг. Энэ нь хүүхдийн үйл ажиллагааныхаа учир) холбогдлыг ойлгон ухамсарлах сэтгэхүйн хөгжлийн чадамжид үндэслэдэг. Учир нь гэмт хэрэг нийгмийн харилцааны энгийнээс нарийн төвөгтөйг хүртэл хамардаг учир хэрэг бүрийн нийгмийн учир холбогдол, хор уршгийг бага насны хүүхэд тэр бүр ойлгон ухамсарлах чадваргүй байдаг тул 16 наснаас эхлэн эрүүгийн хариуцлага хүлээлгэж эхэлдэг. Харин хүүхэд нийгмийн учир холбогдол, хор уршигийг нь ойлгоход төвөггүй, нийгэмд аюултай болохыг нь ухамсарлах боломжтой зарим гэмт хэргийн хувьд субъектийн насыг 14 наснаас эхлэхээр тогтоосон. Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-г эдгээр гэмт хэргийн төрлийг тоочсон буй. Харин зарим төрлийн гэмт хэрэгт хуулийн шууд заагаагүй боловч 18 насанд хүрсэн этгээдийг субъектээр тооцох шаардлага тавигдана. Тухайлбал, цэргийн болон албан тушаалын гэмт хэргүүдэд (ЭХ-ийн 28,29 дүгээр бүлэг), Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах (ЭХ 114), Насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэл, гуйланчлалд татан оруулах (ЭХ115) зэрэг гэмт хэрэг нь тухайн этгээдийг 18 насанд хүрсэн байхыг шаардана. Мөн зарим гэмт хэрэгт субъект нь заавал тодорхой насанд хүрсэн байхыг шаардана. Жишээ нь: шүүхээс хууль бус шийдвэр гаргах (ЭХ 250) гэмт хэргийн субъект нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу 25, 35 насанд хүрсэн байх ёстой.



Эрүүгийн хариуцдага хүлээх этгээдийн насыг тогтоох

Насанд хүрсэн эсэхийг тогтоохдоо төрсөний гэрчилгээ, иргэний үнэмлэх дэх албан ёсны бичлэгийг баримтлана. Хэрэв эдгээр бичиг баримтаар тогтоох боломжгүй бол шүүх эмнэлэгийн шинжилгээ хийлгэх замаар тогтоож болно. Шинжилгээ хийлгэж тогтоохдоо шинжээчийн заасан өдрүүдийн хамгийн сүүлчийн өдрийг субъектын төрсөн өдөр гэж үзнэ.

Гэмт хэргийн тусгай субъект Эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн ерөнхий субъектын зэрэгцээ тусгай субъектын асуудлыг авч үзнэ. Тусгай субъект нь ерөнхий субъектэд тавигддаг насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай байх зэрэг шинжүүдээс гадна нэмэгдэл бусад шинжүүдийг шаардаж байдаг Эрүүгийн хуулийн тусгай ангийн зарим бүлэг болон зүйлд гүйцэтгэгч нь заавал тусгай субъект байх гэмт хэрэг цөөнгүй байдаг.

Тусгай субъектээр тооцоход иргэний харьяалал (ЭХ 79: Монгол Улсын иргэн, 80: гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн); хүйс (ЭХ 126 эрэгтэй хүн); нас (ЭХ 115 18 насанд хүрсэн этгээд); албан тушаалын болон мэргэжлийн онцлог (ЭХ 102 эмч, эмнэлэгийн ажилтан, 263 албан тушаалтан); хүмүүсийн гэр бүлийн болон төрөл садны байдал (ЭХ118, эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигч); урьд нь гэмт хэрэг үйлдэж байсан эсэх (ЭХ 91.2) зэрэг шинжийг шалгуур болгоно.

Онц аюултай гэмт хэрэгтэн Энэ нэг төрлийн тусгай субъект юм. Эрүүгийн эрх зүйд урьд санаатай гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн этгээд уг ялаа эдлээд ял шийтгэлгүйд тооцох хугацаа өнгөрөөгүй байхад дахин санаатай гэмт хэрэг үйлдсэнийг давтан гэмт хэрэг гэж үздэг бөгөөд давтан гэмт хэргийн ноцтой хэлбэр нь онц аюултай гэмт хэрэгтэн юм. Эрүүгийн хуульд зааснаар дараах этгээдийг шүүх онц аюултай гэмт хэрэгтнээр тооцно.

- урьд нь хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ялаар хоёр удаа шийтгүүлж, уг ялаа эдэлж байхдаа буюу эдэлсний дараа дахин хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн этгээд;
- урьд нь хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлж, уг ялаа эдэлж байхдаа буюу эдэлсний дараа дахин онц хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн этгээд;
- урьд нь хорих ял шийтгүүлж байгаагүй боловч онц хүнд гэмт хэрэг давтан үйлдэж хорих ял шийтгүүлсэн этгээд;
- гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн, гэмт бүлэглэлийн гишүүн.

Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцоход насанд хүрээгүй байхдаа үйлдсэн гэмт хэрэг болон энэ хуульд заасан үндэслэлээр ялгүй болсон, ялгүйд тооцогдсон гэмт хэрэг хамаарахгүй. Ийм этгээд гэмт хэрэг үйлдсэнийг ял хүндрүүлэх нөхцөл байдал болгон заасан Эрүүгийн хуулийн тусгай ангийн хэм хэмжээг уг этгээд тухайн хэргийг үйлдэхээс өмнө хуульд заасан үндэслэлээр онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон тохиолдолд хэрэглэнэ. Шүүх тухайн этгээдийг онц аюултай гэмт хэрэгтнээр тооцох болсон үндэслэлээ шийтгэх тогтоолд заана. Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцсон шүүхийн шийдвэр нь уг этгээд сүүлчийн гэмт хэрэгтээ ялгүй болсон, ялгүйд тооцогдсон үед хүчингүй болно.



Анхаарах зүйл

Онц аюултай гэмт хэрэгтэн гэмт хэрэг үйлдсэн гэсэн үндэслэлээр хэргийг зүйлчлэн хүндрүүлэн үзэж байгаа тохиолдолд уг этгээд энэ хэрэг үйлдэхээсээ өмнө хуульд заасан журмын дагуу онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон байх ёстой.



Хяналтын асуулт

1. Гэм буруу, түүний Эрүүгийн эрх зүйн учир холбогдол.
2. Гэм буруугийн хоёр хэлбэр, түүний онцлог
3. Гэмт хэрэг үйлдэх үеийн гэмт этгээдийн сэтгэл санааны байдал, түүний Эрүүгийн эрх зүйн учир холбогдлыг тодорхой жишээн тайлбарлана уу?
 1. Гэмт хэргийн нийтлэг субъектын шинжийг тодорхойлоно уу?
 2. Хэрэг хариуцах чадвартай байдал гэж юу вэ?
 3. Хэрэг хариуцах чадваргүй байдлын эмнэлгийн болон хууль цаазны шалгуурыг тодорхойлно уу?
 4. Хэрэг хариуцах чадваргүй байдлын ойлголт, шалгуур, үр дагаварыг тайлбарла
 5. Гэмт хэргийн бүрэлдүүний субъектын нас, түүнийг Эрүүгийн хуульд хуульчилсан байдал
 6. Гэмт хэргийн бүрэлдүүний тусгай субъект, түүний шинжийг тодорхой жишээн дээр тайлбарлах
 7. Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх онцлог
 8. Согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх онцлог
 9. Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцох үндэслэл, журам, үр дагавар



ДАСГАЛ 3. ГЭМТ ХЭРГИЙН СУБЪЕКТИВ ШИНЖ

(Тохиолдол шинжлэх)

- Тохиолдол 1. Орон сууцны барилгын дээвэр хийж байсан ажилчдын өдрийн амралтын үеэр “Н” гэгч өөрийн хэсгийн ажилчин эмэгтэй “О”-г бэлхүүсээр нь тэвэрч том торхтой буцламтгай хар тосны аман дээр барих үедээ эргэн тойронд нь асгарсан тосон дээр халтирч “О”-г торхтой тос руу алдсан байна. Хүмүүс яаран “О”-г гаргаж авсан боловч бүх бие нь гүн түлэгдсэний улмаас тэрээр эмнэлэгт очоод нас барсан байна.
- Тохиолдол 2. Хувцас загварын уралдааны шүүгчээр ажиллаж байсан “Т” уг тэмцээнд оролцож байсан “Л”-ээс өөрийнх загварт өндөр оноо тавьж түрүүлэхэд нь тусална гэж амлан 300 ам доллар авсан боловч амалснаа биелүүлээгүй байна. Мөрдөн байцаалтад мэдүүлэхдээ “Т” анхнаасаа ийм үйлдэл хийх бодолгүй байснаа хүлээжээ.
- Тохиолдол 3. Нөхөр Д-ийн байнга архидан согтуурч зүй бусаар авирлахыг нь тэсвэрлэхээ больсон “Ж” нэг орой “Д”-ийн хоолонд нь хор хийсэн боловч нөхрийнх нь бие муудан эмнэлэгт хэвтээд эдгэрчээ. Шинжилгээгээр “Ж” хордуулах чанар нь алдагдсан хор хэрэглэсэн болох нь илэрсэн.
- Тохиолдол 4. Улсын мөрдөн байцаах газрын архивын ажилтан “Ц” бичиг хэргээ эмхэлж байхдаа хэрэггүй гэж үзсэн зарим бичиг баримтыг устгажээ. Гэтэл анхааралгүй байдлаасаа болж төрийн нууцад холбогдох 2 албан бичиг, мөрдөн байцаалтанд байгаа 3 хавтаст хэргийг устгасан байна.
- Тохиолдол 5. Эрхэлсэн ажилгүй “Ж”, “Н”, “Ө” нар хэрхэн мөнгөтэй болохоор ярилцаж байгаад өөрийнх нь байранд амьдардаг ченж “Ү” гэдэг эмэгтэйд дээрэмдэхээр шийдэж, түүний ажилдаа явдаг, ирдэг цаг, хэнтэй хамт явдаг зэргийг нарийвчлан судалсан байна. Нэгэн орой 3 найз нэг шил архи хувааж уугаад “Ж” нь “би өнөөдөр ченжийн зах дээр “Ү”-тэй таарлаа, тэрээр их мөнгөтэй доллар авна гээд л орилоод явна, удахгүй гэртээ ирэх болж байна, түүний хүүг нь “Ө” чи саатуулж бай, бид цэцэрлэг дотор дээрэмдэнэ” гэж тохирсон. Тэгээд “Ө” нь орцноосоо гарч явсан “Ү”-н хүүг дуудаж ээж чинь намайг дулаан хувцас аваад ир гээд явууллаа, чи гэртээ ороод аваад ир би энд хүлээж байя гэж саатуулах хооронд “Ж”, “Н” нар цэцэрлэгт “Ү”-г айлган сүрдүүлж түрийвчийг нь дээрэмдсэн байна. Түүний түрийвчийг үзэхэд ердөө 10,0 төгрөг гарсанд учиргүй уурссан “Ж” түүнийг газарт унаган өшиглөж байхад нь цагдаад саатуулжээ.
- Тохиолдол 6. Дунд сургуулийн сурагч болох Бат 15 настай, түүний дүү Олдох 14 настай, 16 настай Сүрэн нар нийлж иргэн “Ч”-н гаражнаас BMW маркийн машиныг нь дур мэдэн авч зугтаан, 13-р хорооллоос Толгойт

хүртэл яваад буухдаа уг машины магнитофон, запас дугуй, багаж зэргийг тонон авч машиныг шатааж байгаад баригдсан байна.

- Тохиолдол 7. Төрийн өмч давамгайлсан хувьцаат компанийн захирал “Н” өөрийн ажиллагсадаас мөнгө, эд зүйл авч албан тушаал дэвшүүлсэн, шагналд тодорхойлсон зэрэг үйлдэл удаа дараа хийсэн “Н”-д цагдаагийн байгууллагаас ЭХ-ийн 268-р зүйлээр эрүүгийн хэрэг үүсгэжээ.
- Тохиолдол 8. Хөнгөн зэргийн оюуны хомсдолтой “Б”-г улсын хилээр хар тамхи, мансууруулах бодис хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан хэргээр баривчилсан. Мөрдөн байцаалтанд тэрээр мэдүүлэхдээ ...хил дээр ирэхийн өмнөхөн нэгэн өндөр залуу хүрч ирээд чи хаашаа явж байгаа юм гэхээр нь би Хөх хот орж эмчлүүлэхээр яваа гэхэд тэрээр надад ууттай зүйл өгч... энэ бол ховор бараа байгаа юм, чи хил давуулаад өгвөл чамд 50,0 төгрөг өгнө гэхээр нь би цүнхэндээ хийсэн, юу байсныг мэдээгүй гэжээ.
- Тохиолдол 9. 2002 онд ЭХ-ийн 145-р зүйлийн 145.2-р 1 жил тэнсэгдэж байсан “Ч” гэгч нь хянан харгалзах хугацаанд иргэн “Ц”-ийн гэрээс 120000 төгрөгний эд зүйл хулгайлсан гэмт хэрэг үйлджээ. “Ч” нь өмнө нь Сэтгэцийн эмгэг суддал, наркологийн төвийн хяналтанд байдаг нь хэрэг шалгах явцад тогтоогдсон. Түүнийг хэрэг хариуцах чадвартай эсэхэд дүгнэлт гаргуулахад “Ч” нь 2000 оноос “оюуны хөнгөн саатал” оношоор хяналтанд байдаг байсан. Түүний өвчин нь төрөлхийн оюуны хөнгөн саатал буюу оюун ухааны дутуу хөгжилтэй гэсэн дүгнэлт гарсан байна.




СЭДЭВ 7. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭХ ҮЕ ШАТ

Төгссөн ба төгсөөгүй гэмт хэрэг Санаатайгаар үйлдэгдэж буй гэмт хэрэг нь тодорхой үе шатыг дамжин эцсийн үр дүндээ хүрдэг. Эрүүгийн эрх зүйд гэмт хэрэг үйлдэх нь. Гэмт хэрэгт бэлтгэх; Гэмт хэрэгт завдах; Гэмт хэрэг үйлдэж төгсгөх гэсэн үе шаттай байна.



Үйлдэл, эс үйлдэхүй нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн бүрэлдүүний бүх шинжийг агуулсан байвал гэмт хэрэг үйлдэгдэж төгссөнд тооцно. Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн, завдсаныг төгсөөгүй гэмт хэрэг гэж үзнэ.

Гэмт хэрэгт бэлтгэхүй Гэмт хэрэг үйлдэх урьдчилсан үе шат бөгөөд гэмт хэрэг үйлдэх гэж буй этгээд зэвсэг, хэрэгслийг хайж олсон, шинээр хийсэн, төхөөрч тохируулсан, хамтран оролцогчийг сонгож авсан, гэмт хэрэг үйлдэх талаар үгсэж тохиролцсон, түүнчлэн гэмт хэрэг үйлдэх бусад нөхцөл, боломжийг санаатай бүрдүүлсэн үйлдлийг гэмт хэрэг бэлтгэх гэнэ.



Гэмт хэрэгт бэлтгэх нь **объектив шинжийн хувьд** а) гэмт хэрэг үйлдэх, түүнийгээ хөнгөвчлөх зорилгоор хэрэглэх **техник, багаж хэрэгсэл, зэвсэг химийн болон бусад бодис сэлтийг хайж олсон, цуглуулсан**; б) гэмт хэрэг үйлдэхийн тулд зэвсэг хэрэгсэл **шинээр хийсэн**; в) зэвсэг хэрэгсэлийг гэмт хэрэг үйлдэх зорилгодоо нийцүүлэн **засаж өөрчилсөн**; г) гэмт хэргийн **хамтран оролцогчдыг сонгож авсан**; д) гэмт хэрэг үйлдэх талаар **үгсэж тохиролцсон**; е) гэмт хэрэг үйлдэх **бусад нөхцөл боломжийг бүрдүүлсэн** (хохирогчийн байдлыг, хэрэг үйлдэх газраа урьдчилан судлах г.м) зэрэг үйлдэл байна.

Харин **субъектав шинжийн хувьд зөвхөн шууд санаатай хэлбэрээр** үйлдэгдэнэ.

Гэмт хэрэгт бэлтгэсэн тохиолдолд Эрүүгийн хуулийн 31 дүгээр зүйлийг журамлан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Харин гэмт хэрэгт бэлтгэсэн үйлдэл нь өөр гэмт хэргийн бүрэлдүүнийг агуулсан байвал төгссөн гэмт хэрэг үйлдсэнээр тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.



Анхаарах зүйл

Хөнгөн гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн этгээдийн үйлдэлд өөр гэмт хэргийн бүрэлдүүн байхгүй бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

Гэмт хэрэгт завдах

Гэмт хэрэг үйлдэхэд шууд чиглэсэн үйлдэл буюу эс үйлдэхүйг санаатай хийсэн боловч тухайн этгээдийн хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас **гэмт хэрэг туйлдаа хүрээгүй**

байхыг гэмт хэрэгт завдах гэнэ.

Объектив шинжийн хувьд гэмт хэрэгт завдах нь **идэвхтэй үйлдлээр**, гэмт хэргийн бүрэлдүүний **объектив талын шинжийг гүйцэтгэх байдлаар илэрнэ**. Завдалтын үед Эрүүгийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд бодит аюул заналхийлсэн байдаг.

Субъектив шинжийн хувьд гэмт хэрэгт завдах нь .

Завдалтыг төгссөн ба төгсөөгүй, ашиггүй завдалт гэж ангилдаг. Гэмт хэрэг үйлдэхэд чиглэсэн үйлдэл, эс үйлдэхүйг бүрэн хийсэн гэж тухайн этгээд ойлгосон боловч түүний хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг туйлдаа хүрээгүй бол **төгссөн завдалт**, гэмт хэрэг үйлдэхэд чиглэсэн үйлдэл, эс үйлдэхүйг бүрэн хийгээгүйгээ тухайн этгээд ойлгосон бөгөөд түүний хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг туйлдаа хүрээгүй бол **төгсөөгүй завдалт** гэнэ.




ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭХЭЭР ЗАВДАХ

Санаатай үйлдэл байна

Гэмт хэрэг үйлдэхэд шууд чиглэсэн үйлдэл, эс үйлдэхүй

Тухайн этгээдийн хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг туйлдаа хүрээгүй

ТӨГСӨӨГҮЙ ГЭМТ ХЭРГИЙГ ЗҮЙЛЧЛЭХ



Гэмт хэрэг үйлдэхэд чиглэсэн үйлдэл, эс үйлдэхүйг бүрэн хийсэн боловч буруу зэвсэг, хэрэгсэл ашигласан, эсхүл андуурлын улмаас гэмт хэрэг туйлдаа хүрээгүй бол **ашиггүй завдалт** гэнэ. Ашиггүй завдалтыг ашиггүй объектод завдах, ашиггүй хэрэгсэлээр завдах гэж ангилна. Субъект тодорхой гэм хор учруулахыг хүссэн боловч объектоо андуурч бодит гэм хор учруулж чадаагүй байхыг ашиггүй объектод завдах, буруу зэвсэг хэрэгсэл ашигласаны улмаас хүссэн хор уршигаа учруулж чадаагүй байхыг ашиггүй хэрэгсэлээр завдах гэнэ. Ашиггүй завдалт нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Гэмт хэргийн завдалтын үед субъект тодорхой үр дүнд хүрэхэд чиглэсэн үйлдэл хийж байдаг бол бэлтгэх үед ирээдүйд гэмт хэрэг үйлдэх нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдагаараа гэмт хэргийн завдалт болон бэлтгэх шат ялгагдана. Түүнчлэн бэлтгэх шатанд хуулиар хамгаалсан ямар нэгэн ашиг сонирхолд халдаагүй байдаг бол завдалтын үед нэгэнт бодит аюул заналхийлж эхэлсэн байдаг.

Төгссөн гэмт хэрэг Субъектийн үйлдэл, эс үйлдэхүй гэмт хэргийн бүрэлдүүний бүх шинжийг агуулсан байвал төгссөн гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийг төгссөнд тооцох шалгуур нь тухайн гэмт хэргийг хуульчилсан байдлаас шалтгаална. Хэлбэрийн бүрэлдүүнтэй хэргийн хувьд объектив талын шинжид заасан үйлдэл хийсэн үеэс гэмт хэрэг төгссөнд тооцогдох бол материаллаг бүрэлдүүнтэй хэргийн хувьд хуульд заасан гэмт хор уршиг учирч эхэлсэн мөчөөс гэмт хэрэг төгссөнд тооцогдоно. Харин **таслан зогсоогдсон** гэмт хэргийн хувьд бэлтгэсэн, завдсан үеэс төгссөнд тооцно. **Удааширсан** гэмт хэрэг нь гэмт үйлдэл, эс үйлдэхүй хийгдсэнээр эхэлж гэм буруутай этгээд өөрөө гэмт үйлдлээ зогсоосон буюу гэмт хэргийг таслан зогсоосноор дуусна. **Үргэлжилсэн** гэмт хэргийг эхний үйлдлээ хийсэн үеэс эхэлсэнд тооцож хамгийн сүүлчийн үйлдлээ хийсэн мөчөөр төгссөнд тооцно.



Анхаарах зүйл

Гэмт хэргийг төгссөн болон төгсөөгүй шинжээр нь ялгаатай авч үзэх нь хэргийг зүйлчлэх, ял оногдуулах болон эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа тоолох, гэмт хэрэгт хамтран оролцогчдын асуудлыг шийдвэрлэх, өршөөлийн хуулийг хэрэглэх зэрэгт харгалзан үзэх хууль зүйн ач холбогдолтой юм.

Гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзах Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу завдсан этгээд гэмт хэргээ туйлд нь хүргэх боломжтойг ойлгож байсан боловч тийнхүү туйлд нь хүргэхээс сайн дураараа, төгс татгалзах явдал. Гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзсан нь эрүүгийн хариуцдагаас чөлөөлөх үндэслэл болно. Үйлдсэн гэмт хэргээ илчлэн ирэх бол он сайн дураараа татгал зах нь ялгаатай. Эхний тохиолдол нь гэмт хэрэг үйлдсэний дараа хийгдэх зан үйл өөрөөр хэлбэл төгссөн гэмт хэрэгт яригдах ухагдахуун байдаг бол сайн дураараа татгалзах нь гэмт хэрэг үйлдэж төгсөхийн өмнөх шатанд байна.




Анхаарах зүйл

Гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзсан шалтгаан нь ямар ч байж болно.



СЭДЭВ 8. ГЭМТ ХЭРЭГТ ХАМТРАН ОРОЛЦОХ

Тодорхойлолт Гэмт хэрэг санаатай үйлдэхэд хоёр буюу түүнээс дээш этгээ нэгдсэнийг хамтран оролцох гэнэ. Хуульд гэмт хэрэгт хамтран оролцохыг а) хоёр буюу түүнээс дээш тооны этгээд; б) санаатай гэмт хэрэг үйлдэхэд; в) гэмт хэрэг үйлдэхэд нэгдсэн зэрэг шинжүүдээр тодорхойлсон. Эрүүгийн эрх зүйд гэмт хэрэгт хамтран оролцохыг объектив, субъектив болон тооны, чанарын шинжүүдээр тодорхойлдог.



Гэмт хэрэгт хамтран үйлдсэнийг хүндрүүлэн үзэх үндэслэл

Гэмт хэрэг хамтран үйлдэж байгаа нь 1) нэг хүний үйлдэж чадахгүй хэргийг хамтын хүчээр үйлддэг; 2) нэг хүний үйлдсэн хэрэгтэй харьцуулахад нийгмийн хор аюулаар их; 3) хамтран оролцогчид гэмт хэргийн ул мөрийг баллаж, хэргийг илрүүлэхэд саад учруулдаг; 4) гэмт хэрэгт хамтран оролцох нь цаашдаа хуулийн эсрэг гэмт бүлэглэл, нийгмийн эсрэг хүмүүсийн нэгддийг даамжруулах учраас хамтран үйлдсэн гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь илүү хүнд байх ёстой гэж үздэг.

Хамтран оролцогчдын төрөл

Монгол Улсын Эрүүгийн эрх зүйд гэмт хэрэгт хамтран оролцогчыг захиалагч, зохион байгуулагч, хаттагч, гүйцэтгэгч, хамжигч гэсэн төрөлд хуваадаг.

Захиалагч	Гэмт хэрэг үйлдүүлэхээр бусдыг хөлсөлсөн этгээд. Захиалагчид түүний захиалсан гэмт хэргийн гүйцэтгэгчид оногдуулсан ялаас доогуур ял оногдуулж болохгүй.
Зохион байгуулагч	Гэмт хэрэг үйлдэхийг гардан зохион байгуулсан буюу удирдсан, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл байгуулж, үйл ажиллагааг нь чиглүүлж удирдсан этгээд. Зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлийн удирдагчид ийм бүлэг, бүлэглэл байгуулсаны төлөө болон уг бүлэг, бүлэглэлийн үйлдсэн бүх гэмт хэргийн төлөө хариуцлага хүлээлгэнэ.
Гүйцэтгэгч	Гэмт хэргийг гардан үйлдсэн (бусадтай хамтран үйлдсэн) этгээд. Гүйцэтгэгч нь өөрийн болон гэмт хэрэгт хамтран оролцож буй бусад оролцогчийн хүсэж байсан хор уршгийг шууд бий болгосон байна. Эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрээгүй хүн, хэрэг хариуцах чадваргүй этгээд болон бусад нөхцөл байдлуудыг (тэжээвэр болон адгуусан амьтан г.м) ашиглаж гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гүйцэтгэгч гэж үзнэ.
Хатгагч	Гэмт хэрэг үйлдүүлэхийн тулд бусдыг ятгах, заналхийлэх, хуурч мэхлэх болон бусад аргаар өдөөн түлхсэн, зоригжуулсан этгээд. Хатгагчийг эрүүгийн хуулийн ерөнхий ангийг журамлан гүйцэтгэгчийн үйлдсэн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.
Хамжигч	Зааж зөвлөх, зэвсэг, хэргсэл өгөх, учрах саадыг арилгах, унаа, орон байраар хангах зэргээр гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлсэн, түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн этгээд болон гэмт хэрэг үйлдэхэ хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг нуун далдлаах, зарж борлуулах, гэмт хэргийн ул мөрийг баллахаар урьдчилан амалсан этгээд. Хамжигчид түүний гүйцэтгэсэн үүрэг, үйлдлийн шинж чанар, хэр хэмжээг харгалзан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн зохих хэм хэмжээг журамлан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Хамжигчаар оролцох хэлбэрүүд

Гэмт хэрэгт хамжигчаар оролцох нь оюун санааны болон биечлэн хамжих гэсэн хэлбэртэй. Оюун санааны хувьд хамжих гэдэг нь гэмт хэрэг үйлдэх талаар зааж зөвлөх, мэдээлэл өгөх, гэмт хэрэгтэн болон гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг хэрэгсэл, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг нуун далдлах, гэм хэргийн ул мөрийг балласнаар илэрч болно. Биечлэн дэмжлэг үзүүлж хамжих гэдэг нь гэмт хэрэг үйлдэх зэвсэг хэрэгсэлийг олж өгөх, учрах саадыг арилгах зэрэг хэлбэртэй байна.



Зөрчиж гүйцэтгэх



Гэмт хэрэгт хамтран оролцогчдын хэлбэр

Гэмт хэрэгт хамтран оролцогчдыг гэмт хэрэгт оролцсон оролцооны хэр хэмжээ, хамтарсан үйлдлийн шинж, тэдний хоорондын тохиролцоо, холбоо, үйлдэл зэргийг харгалзан хэлбэрүүдэд хуваана. Гэмт хэрэгт хамтран оролцогчдыг хамтран оролцох энгийн (урьдчилан үгсэж тохиролцоогүй бүлэг) ба хамтран оролцох төвөгтэй хэлбэр (урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг) гэсэн 2 түвшинд хэд хэдэн хэлбэрт хуваана.

Гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэрүүд

Бүлэглэн гүйцэтгэх	Урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг	Зохион байгуулалттай бүлэг	Гэмт бүлэглэл
Гэмт хэрэг үйлдэхэд санаатай нэгдсэн	Гэмт хэрэг үйлдэхэд санаатай нэгдсэн	Гэмт хэрэг үйлдэхэд санаатай нэгдсэн	Гэмт хэрэг үйлдэхэд санаатай нэгдсэн
Урьдчилан үгсэж тохиролцоогүй	Урьдчилан үгсэж тохиролцсон	Урьдчилан нэгдсэн	Ашиг олох зорилготой
Хоёр буюу түүнээс дээш этгээд	Хоёр буюу түүнээс дээш этгээд	Тогтвортой бүлэг	Бүтэц, зохион байгуулалт бүхий нэгдэл

Зөрчиж гүйцэтгэх

Гэмт хэргийг гардан гүйцэтгэж буй этгээд бусад оролцогчын мэдээгүй, өөрөөр хэлбэл түүнтэй тохиролцоогүй гэмт хэрэг үйлдэх явдал. Гэмт хэргийг зөрчиж гүйцэтгэсэн бол бусад хамтран оролцогчдод эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

Гэмт хэрэгт Эрүүгийн эрх зүйд нуун далдлагч, үл мэдээлэгч нь гэмт хамаарагсад хэрэгт **хамаарагсад** байна. Гэмт хэрэгт хамаарагсад нь гэмт хэрэг үйлдсэнтэй шууд холбоогүй бөгөөд гэмт хэрэг үйлдэх гэж байгааг болон үйлдсэнийг мэдсээр байж зохих газар мэдэгдээгүй эсвэл гэмт хэрэг үйлдэгдсэний дараа урьдчилан амлалгүйгээр тодорхой үйлдэл хийсэн байдаг бөгөөд энэ шинжээрээ гэмт хэргийн хамтран оролцогчдоос ялгагдана.

Гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүний хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг **урьдчилан амлахгүйгээр** санаатай нуух зэргээр **гэмт хэргийн үл мөрийг арилгасан этгээдийг нуун далдлагч** гэнэ. Гэмт хэрэг үйлдэгдсэний дараа урьдчилан амлалгүйгээр дээрх үйлдлүүдийг хийсэн байдаг учир гэмт хэргийн хор уршигтай шууд шалтгаант холбоогүй. Эрүүгийн хуулийн тусгай ангийн зохих зүйлд заасан гэмт хэргүүдийг нуун далдалсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Үүнд: (Хүнийг санаатай алах), (Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах), (Хүн хулгайлах), (Хүнийг барьцаалах), (Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх), (Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг хулгайлах), (Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг булаах), (Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх), (Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх), (Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх), (Мөнгөн тэмдэгт, үнэт цаасыг хуурамчаар үйлдэх, борлуулах), (Зандалчлах), (Агаарын хөлөг авч зугатаах), (Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хээл хахууль авах, өгөх, зуучлах), (Эх орноосоо урвах), (Тагнуул хийх), (Төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах), (Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулах), (Хорлон сүйтгэх), (Хорлон саатуулах), (Хар тамхи, мансууруулах болон хордуулах бодис, галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх) гэмт хэргүүд хамаарна.

Гэмт хэрэг үйлдэх гэж байгааг болон гэмт хэрэг үйлдсэнийг мэдсээр байж зохих байгууллага, албан тушаалтанд мэдэгдээгүй этгээдийг үл мэдээлэгч гэнэ. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан дараах гэмт хэргүүдийг үл мэдээлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. (Хүнийг санаатай алах), (Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах), (Хүн хулгайлах), (Хүнийг барьцаалах), (Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх), (Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг хулгайлах), (Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг булаах), (Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх), (Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх), (Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх), (Мөнгөн тэмдэгт, үнэт цаасыг хуурамчаар үйлдэх, борлуулах), (Зандалчлах), (Агаарын хөлөг авч зугатаах), (Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хээл хахууль авах, өгөх, зуучлах), (Эх орноосоо урвах), (Тагнуул хийх), (Төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах), (Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулах), (Хорлон сүйтгэх), (Хорлон саатуулах)



Хяналтын асуулт

1. Гэмт хэрэгт хамтран оролцохын объектив ба субьектив шинж
2. Зөрчиж гүйцэтгэх гэдэгт юуг ойлгох болон зөрчин гүйцэтгэгчид эрүүгийн хариуцлага хэрхэн хүлээлгэх вэ?
3. Гэмт хэрэгт хамтран оролцогчдод эрүүгийн хариуцлага хүлээлгэх журам, онцлогийг тайлбарла
4. Гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэр гэж юу вэ? Гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэрийг тодорхойлох шалгуурыг тооч
5. Зохион байгуулалттай бүлэг болон гэмт бүлэглэлийн ялгааг ол
6. Гэмт хэрэгт хамаарагсад гэж хэнийг хэлэх вэ? Гэмт хэрэгт хамтран оролцогчдоос ялгагдах онцлогийг тодорхойл



Сорил

1. Гэмт хэрэгт хамтран оролцох нь:

- a. Хоёр буюу түүнээс дээш этгээд гэмт хэрэг үйлдэхэд оролцсоныг хэлнэ
- b. Гэмт хэрэг санаатай үйлдэхэд хоёр буюу туунээс дээш этгээд
- c. нэгдсэнийг хэлнэ
- d. Хоёр буюу туунээс дээш этгээд санаатай болон болгоомжгүй гэмт хэрэг үйлдэхэд нэгдсэнийг хэлнэ
- e. Хоёр буюу түүнээс дээш этгээд санаатай болон болгоомжгүй гэмт хэрэг үйлдэхэд санаатай нэгдсэнийг хэлнэ

2. Гэмт хэрэгт хамтран оролцох объектив шинжид:

- a. Хоёр буюу түүнээс дээш тооны этгээд нэгдсэн байх
- b. Гэмт хэрэгт хамтран оролцогчид харилцан бие биенээ мэдсэн байх
- c. Нэгдмэл үр дүнд хүрсэн байх
- d. Бусад хамтран оролцогчид болон гүйцэтгэгчийн үйлдэлд шалтгаант холбоо тогтсон байх
- e. Хоёр буюу түүнээс дээш тооны хэрэг хариуцах чадвартай этгээд нэгдмэл гэмт үр дүнд хүрэхийн төлөө гүйцэтгэгчтэй шалтгаант холбоо бүхий үйлдэл хийсэн байх
- f. Нэгдмэл үр дүнд хүрэхийг эрмэлзсэн байх

3. Болгоомжгүй гэмт хэрэгт хамтран оролцож болох уу?

- a. Болно
- b. Болохгүй
- c. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэгт болно

4. Гэмт хэрэг хамтран үйлдсэн нь уг хэргийн нийгмийн хор аюулыг нэмэгдүүлэх үү?

- a. Тийм
- b. Үгүй
- c. Энэ асуудлыг шүүх шийдвэрлэн
- d. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд өснө

5. Гэмт хэргийн гүйцэтгэгч нь:

- a. Гэмт хэрэг үйлдэхийг гардан зохион байгуулсан буюу удирдсан, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл байгуулж, үйл ажиллагааг нь чиглүүлж удирдсан этгээд*
- b. Ятгах, заналхийлэх болон бусад аргаар гэмт хэрэг үйлдэхэд бусдыг өдөөн түлхсэн, зоригжуулсан этгээд*
- c. Гэмт хэргийг гардан үйлдсэн этгээд*
- d. Гэмт хэрэг үйлдүүлэхээр бусдыг хөлсөлсөн этгээд*
- e. Зааж зөвлөх, зэвсэг, хэрэгсэл өгөх, учрах саадыг арилгах, унаа, орон байраар хангах зэргээр гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлсэн, түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн этгээд болон гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг нуун далдлах, зарж борлуулах, гэм хэргийн ул мөрийг баллахаар урьдчилан амалсан этгээд*

6. Гэмт хэрэгт хамтран оролцогчдын хэлбэрийг тодорхойл.

- a. Гэмт хэрэгт хамжигчаар оролцох*
- b. Гэмт хэргийг булэглэж үйлдэх*
- c. Гэмт хэргийг нуун далдлах*

7. Гэмт хэрэгт хамтран оролцох явдал нь

- a. Зөвхөн санаатай гэмт хэрэгт байна*
- b. Санаатай болон болгоотжгүй гэмт хэрэгт байна*
- c. Гэмт хэргийн ултаас учирсан хохирлын хэмжээг харгалзан хамтран оролцсон байдлыг тогтооно*

8. Гэмт хэрэг үйлдэхэд тусламж дэмжлэг үзүүлсэн, гэмт хэргийн ул мөрийг баллахаар урьдчилан амласан этгээд нь

- a. Нуун далдлагч*
- b. Хатжигч*
- c. Хатгагч*
- d. үл мэдээлэгч*

9. Гэмт хэргийг үл мэдээлэх, нуун далдлах нь:

- a. Эрүүгийн хуульд заасан бүх гэмт хэрэгт хатаарна*
- b. Зөвхөн онц хүнд гэмт хэрэгт хатаарна*
- c. Эрүүгийн хуульд нэрлэж заасан тодорхой гэмт хэрэгт хамаарна*



СЭДЭВ 9. ОЛОНЛОГ ГЭМТ ХЭРЭГ

Ойлголт, төрөл Гэмт этгээд хэд хэдэн гэмт хэргийг нэг дор буюу дараалан үйлдэх, эсвэл өмнө үйлдсэн гэмт хэргийн ялгүй болох хугацаа өнгөрөөгүй байхад дахин гэмт хэрэг үйлдэж хууль зүйн үр дагавар бий болгосныг ойлгоно. Олонлог гэмт хэрэг нь **нийлмэл, давтан, рецидив** гэмт хэрэг гэсэн төрөлтэй. Олонлог гэмт хэргийн эдгээр төрөл нь гэмт хэргийг зүйлчлэх, ял оногдуулахад ач холбогдолтой юм.

Олонлог гэмт хэрэг нь а) хэд хэдэн удаагийн үйлдлээр **хоёр буюу түүнээс дээш гэмт хэрэг** үйлдсэн;; б) эхний гэмт хэргийн ялгүй болох хугацаа өнгөрөөгүй байхад дахин гэмт хэрэг үйлдсэн зэрэг шинжүүдээр нэгдмэл гэмт хэргээс ялгаатай.

Нэг этгээд хоёр буюу түүнээс дээш гэмт хэрэг үйлдсэнийг олонлог гэмт хэрэг гэнэ. Эдгээр гэмт хэрэг бүр нь тусдаа гэмт хэргийн бүрэлдүүний шинжийг агуулах ёстой. Тэрхүү тусдаа гэмт хэргийн бүрэлдүүний шинжийг агуулж буй нэгдмэл үйлдлээр **нэгдмэл хор уршиг учруулсан хэргийг нэгдмэл гэмт хэрэг** гэнэ. Нэг удаагийн үйлдэл, эс үйлдэхүйгээр нэг хор уршиг учруулж буй нь нэгдмэл гэмт хэргийн энгийн хэлбэр юм. Харин практикт а) хэд хэдэн үйлдлээр нэг хор уршиг учруулж байгаа, б) эсхүл нэг үйлдлээр хэд хэдэн хор уршиг учруулж буй, в) хэд хэдэн үйлдлээр хэд хэдэн хор уршиг учруулж буй нэгдмэл гэмт хэрэг түгээмэл тохиолддог. Түүнчлэн үйлдэл болон хор уршгийн хооронд тодорхой цаг хугацааг дамжин өнгөрөх үргэлжилсэн болон удааширсан гэмт хэрэг үйлдэгдэх нь нэгдмэл гэмт хэргийн төрөлд тооцогдоно.


Энэ нь гэмт үйлдэл, эс үйлдэхүй нь **тодорхой цаг хугацаанд тасралтгүй үргэлжилж** нэг гэмт хэргийн бүрэлдүүнийг бий болгож байгаа хэргийг **удааширсан гэмт хэрэг** гэнэ. Ж нь: Хорих газраас оргох.

Гэмт этгээд эхлэл төгсгөл нэгтэй, нэг санаа боддоор, цаг хугацааны хувьд хоорондоо завсарлагатай буюу завсарлагагүй хэд хэдэн үйлдлээр нэг эх сурвалжид үргэлжлэн халдаж эд хөрөнгийг хууль бусаар, үнэ төлбөргүй авч ашиглан шамшигдуулж байгаа үйлдэл. Үргэлжилсэн үйлдэлтэй гэмт хэргийн үед гэмт этгээдийн хэрг үйлдэх санаа нь төгсөөгүй байдаг бөгөөд нийт үйлдлүүдийн улмаас учруулсан хохиролыг хооронд нь нэмж хохиролын хэмжээг тогтооно.



! Анхаарах зүйл

Хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, ялгүй болсон, ялгүйд тооцогдсон этгээд гэмт хэрэг шинээр үйлдсэн нь давтан гэмт хэрэг болохгүй.



Анхаарах зүйл

Нийлмэл гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг бүрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.



Сорил

1. Олонлог гэмт хэргийг тодорхойл:

- Энэ нь хэд хэдэн гэмт хэргийг нэг дор буюу дараалан үйлдэж тэдгээрийнхээ алинд ч ял шийтгэгдээгүй байх явдал
- Энэ нь нийлмэл болон давтан гэмт хэрэг
- Энэ нь хэд хэдэн гэмт хэргийг нэг дор буюу дараалан үйлдсэн явдал бөгөөд үүнд үйлдсэн гэмт хэрэгтээ ял шийтгэгдсэн эсэх нь нөлөөлөхгүй
- Энэ нь эрүүгийн хариуцлагад татаххугацаа дуусаагүй байхад хэд хэдэн гэмт хэргийг нэг дор буюу дараалан үйлдсэн, эсхүл ял шийтгэлгүй болох хугацаа өнгөрөөгүй үед гэмт хэрэг дахин үйлдэх явдал
- Энэ нь гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэн этгээд дахин гэмт хэрэг үйлдэх явдал

2. Олонлог гэмт хэргийн үндсэн шинж:

- Хоёр буюу түүнээс доошгүй гэмт хэрэг үйлдсэн байна
- Гэмт этгээд зөвхөн нэг төрлийн гэмт хэрэг үйлдсэн байна
- Урьд нь ямар нэгэн гэмт хэрэгт ял шийтгэгдээгүй байна
- Олонлог гэмт хэрэг нь хөнгөн гэмт хэрэгт байж болохгүй

3. Нийлмэл гэмт хэрэг нь:

- Гэмт хэрэг үйлдсэн боловч түүндээ урьд нь ял шийтгэгдэж байгаагүй этгээд ялгүй болох буюу ялгүйд тооцогдох хугацааны дотор дахин гэмт хэрэг үйлдсэн
- Ялгүй болох буюу ялгүйд тооцогдох хугацаа нь дуусаагүй байхад дахин гэмт хэрэг үйлдсэн
- Хоёр буюу түүнээс дээш удаа үйлдэгдсэн бүх гэмт хэрэг

4. Давтан гэмт хэргийн төрлийг ол:

- Нэг үйлдэлтэй, хэд хэдэн үйлдэлтэй
- Ерөнхий, тусгай, удаа дараа, байнга
- Ердийн, аюултай, онц аюултай



5. Олонлог гэмт хэргийн хэлбэрийг ол:

- a. Нийлмэл, давтан*
- b. Нэгдмэл, нийлмэл, давтан, рецидив гэмт хэрэг*
- c. Нийлмэл, давтан, удаа дараа, байнга үйлдсэн*
- d. Давтан, рецидив*

6. Нэг үйлдэлг нийлмэл гэмт хэрэг нь:

- a. Эрүүгийн хуулийн хоёр буюу түүнээс дээш өөр зүйлд заасан гэмт хэргийг үйлдсэнийг хэлнэ*
- b. Эрүүгийн хуулийн нэг зүйлд заасан гэмт хэргийг хоёр буюу түүнээс дээш удаа үйлдсэнийг хэлнэ*
- c. Эрүүгийн хуулийн хоёр буюу түүнээс дээш өөр зүйлд заасан гэмт хэргийг үйлдээд тэдгээрийнхээ алинд ч ял шийтгэгддэггүй байхыг хэлнэ.*
- d. Эрүүгийн хуулийн хоёр буюу түүнээс дээш өөр зүйлд заасан гэмт хэргийг үйлдээд тэдгээрийнхээ аль нэгэнд ял шийтгэгддэггүй байхыг хэлнэ*

7. Нэг объектэд нэгдмэл санаагаар удаа дараа халдсан байх нь:

- a. Давтан гэмт хэрэг*
- b. Үргэлжилсэн гэмт хэрэг*
- c. Удааширсан гэмт хэрэг*

ДАСГАЛ 4. ГЭМТ ХЭРЭГ ХАМТРАН ҮЙЛДЭХ, ГЭМТ ХЭРГИЙН ҮЕ ШАТ, ОЛОНЛОГ ГЭМТ ХЭРЭГ

(Тохиолдол шинжлэх)

- Тохиолдол 1. “Сити” таксины жолооч “Л” нь 2002.6.18 өдөр шөнийн 23 цагийн орчим найз “Б”-ийн хамт үйлчилгээнд явж байгаад гарцгүй газраар зам хөнддөн гарч явсан иргэн “П”-г мөргөж амь насанд нь аюултай гэмтэл учруулж хохирогчид эмнэлэгийн тусламж үзүүлэлгүй хэргийн газраас зугтсан байна. Уг хэрэг гарснаас 2 хоногийн дараа хохирогч “П” нас барсан бөгөөд осол гарах үед тэнд байсан гэрчүүдийн мэдүүлгийг үндэслэн осол гаргасан жолоочийг эрэн сурвалжилж 5 хоногийн дараа “Л”-ийг олсон. Хэргийг шалгах явцад дараах нөхцөл байдлууд илэрсэн байна. Үүнд: Жолооч “Л” мөрдөн байцаалтанд мэдүүлэхдээ хохирогчыг мөргөсөний дараа би машинаасаа бууж тусламж үзүүлэх гэсэн боловч надтай хамт явж байсан “Б” ойр хавьд хүн алга хэргийн газраас зугтаа гэсэн, тэгээд машиныг тэдний хашаанд аваачиж машин дээр тогтсон цусыг “Б” арилгасан мөн машины эвдрэлийг тэр засаж өгсөн гэсэн бөгөөд дээрх үйлдэл хийснээ “Б” хүлээн зөвшөөрсөн байна.
- Тохиолдол 2. Эрхэлсэн ажилгүй “Х” урьдчилан судалж байгаад гэрийн эзэд нь түр байхгүй байгаа нэгэн байшинд хууль бусаар нэвтэрч өнгөт телевизорыг нь хулгайлжээ. Удалгүй дахин орж хивс, хөгжим, ширээ сандал зэргийг хулгайлсан байна. Энэ мэтээр уг айлд 15 удаа орж 3 сая орчим төгрөгийн эд зүйлсийг нь авсан ба сүүлийн удаа гэрийн эздийг ирсэнийг мэдээгүй явж ороод үйлдэл дээрээ баригджээ.
- Тохиолдол 3. Нэгэн сургуулийн 10-р ангийн сурагчид болох “Т”, “Ц” нар нь 16 настай “Б”-г хүчиндсэн гэмт хэрэг үйлджээ. Хохирогч “Б”-тэй “Т” хурьцал үйлдэж харин “Ц” нь “Т”-д туслан хохирогчын эсэргүүцлийг дарж байжээ. Шүүх “Т”, “Ц” нарыг хүчиндэх гэмт хэргийг бүлэглэн гүйцэтгэсэн гэж үзэж ЭХ-ийн 126-р зүйлийн 126.2-р ял шийтгэснийг “Ц”-ийн өмгөөлөгч эс зөвшөөрч давж заалдсан. Давж заалдсан үндэслэл нь “Ц” нь дээрх хэрэгт хамтран гүйцэтгэгчээр оролцоогүй өөрөөр хэлбэл тэрээр хохирогчтой хурьцал үйлдээгүй тул түүнийг гүйцэтгэгч гэж үзсэн нь буруу байна харин хэрэгт хамжигчаар оролцсон байх тул ЭХ-ийн ЕА-ийн 35-р зүйлийн 36.6-г журамлан шийдэх ёстой байжээ гэсэн.
- Тохиолдол 4. “Х” гэгч нь байнга архидаан согтуурч эхнэр, хүүхдээ зодож гэрээсээ хөөж туудаг байсан. “Х”-ийн энэ байдлыг тэвчихээ больсон эхнэр нь ямар нэг аргаар түүнээс салах бодолтой байсан ба хэрэв өөрөөс нь салвал түүнийг болон хүүхдүүдээ ална гэж “Х” нь байнга заналхийлдэг байсан учраас энэ байдлаас нь айж эхнэр “Ө” нь хэн нэгэнд ханддаггүй байжээ. “Х”-ийн энэ байдлыг тэвчихээ байсан эхнэр нь “Х”-г согтуу



ирж архи нэхэн зүй бусаар авирлахад нь урьд архины шилэнд найруулсан уксусийг түүнд өгсөн байна. Дээрх үйлдлээс болж “Х”-ийн улаан хоолой, ходоод нь их хэмжээгээр түлэгдэн хүнд гэмтжээ.

Тохиолдол 5.

“Баянлиг” ХХК-ны түүхий эдийн агуулахад манаач ажилтай “Ө” нь 2003 6-р сараас 10 -р сар хүртэл нийт таван удаагийн үйлдлээр “Э”, “Л” нартай хамтран 5 сая гаруй төгрөгний эд зүйлийг хулгайлсан гэмт хэрэг үйлджээ. Дээрх үйлдлүүдийн эхний 2 удаагийн үйлдэлд нь “Ө” “Э”, “Л” нартай урьдчилан тохиролцож ажлын байраа зориуд орхин явж энэ хооронд нь “Э”, “Л” нар нь агуулахад орж арьс, шир хулгайлсан харин сүүлийн үйлдлүүдэд нь “Ө” өөрөө биечлэн оролцож агуулахаас арьс шир бусад зүйлийг ачилцаж зах дээр аваачин зарж борлуулсан нь мөрдөн байцаалтын шатанд тогтоогджээ. “Э”, “Л” нар нь урьд нь хорих ял эдлэж байгаад уг ялаас 6 сарын өмнө тэнсэн суллагдсан байжээ. Энэ гэмт хэрэгт “Э”, “Л” нарыг гэмт хэргийн гүйцэтгэгч харин “Ө”-г гэмт хэрэгт хамжсан гэж прокурор ял төлөвлөсөн байна.

Тохиолдол 6.

“О” танхайрах гэмт хэрэгт ял эдлэж байхдаа хорих байгууллагын даргад энэ гэмт хэрэгт ял шийтгэгдэхээсээ өмнө бусадтай хамтран хулгайн гэмт хэрэг үйлдсэнээ хүлээж, хаанаас хичнээн хэмжээний эд зүйл хулгайлсан, хулгайлсан эд зүйлээ хаана нуусан болон гэмт хэргийн хамтрагчидаа зааж өгсөн. Мөрдөн байцаалтын явцад энэ бүхнийг “О” үнэн зөв мэдүүлсэн болох нь тогтоогджээ.

Тохиолдол 7.

Дээрмийн гэмт хэрэг үйлдэн 5 жилийн хорих ял шийтгэгдсэн “Ж” Амгалангийн хорих ангид ял эдлэж байхдаа удаа дараа хорих ангийн дэглэм, журмыг зөрчиж хоригдлуудыг дээрэлхэн, тэдэнтэй зүй бусаар харьцдаг байв. Нэгэн удаа өөрийнх нь хэрцгий авирыг эсэргүүцсэн ялтан “А”-г зодож биед нь хүнд гэмтэл учруулсан байна.

СЭДЭВ 10. ГЭМТ ХЭРГИЙН НИЙГМИЙН АЮУЛЫГ ҮГҮЙСГЭХ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Тодорхойлолт, шинж

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн хувьд агуулсан боловч үйлдэгдэх болсон онцгой нөхцөл, нийгэмд ашигтай сэдэлтийн улмаас гэмт хэрэгт тооцохгүй эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байхаар хуульд заасан онцлог нөхцөл байдлууд Монгол Улсын Эрүүгийн эрх зүйд **Аргагүй хамгаалалт, Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах, Гарцаагүй байдал, Үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдэл, Тушаал, захирамж биелүүлэх** зэргийг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд хамруулсан.


Эрүүгийн эрх зүйд аливаа үйлдэл, эс үйлдэхүйн:

- нийгэмд ашигтай чанар,
- үйлдэх болсон сэдэлт,
- Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхолд гэм хор учруулах

шинжгүй байгааг үндэслэн гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлыг тогтоодог.

Аргагүй хамгаалалт

Эрүүгийн хуулиар хамгаалагдсан төр, нийгмийн ашиг сонирхол, өөрийн болон бусдын амьд явах, халдашгүй чөлөөтэй байх, түүнчлэн бусад эрх, эрх чөлөөг нийгэмд аюултай халдлагаас хамгаалахдаа Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан үйлдэл хийж, халдагч этгээдэд гэм хор учруулсаныг аргагүй хамгаалалтад тооцно. Хамгаалагч нийгэмд аюултай халдлагаас зайлсхийх, төрийн байгууллага, албан тушаалтан, бусад хүмүүсээс тусламж хүсэх боломжтой байсан эсэх нь аргагүй хамгаалалт хийх эрхэд нөлөөлөхгүй.



Анхаарах зүйл

Аргагүй хамгаалалтыг а) нийгэмд аюултай, б) бодит халдлагын эсрэг хийсэн бол хууль ёсны гэж үзнэ.



Халдлага нийгэмд аюултай байх гэж хамгаалагчийн эсрэг Эрүүгийн хуулийн тусгай ангиар хориглосон үйлдэл хийгдсэн байхыг ойлгоно. Халдлага үйлдэж буй этгээд нь насанд хүрээгүй, хэрэг хариуцах чадваргүй эсэх нь хамгаалалт хийхэд нөлөөлөхгүй.

Халдлага бодитой байх гэдэг нь халдлага хийгдэж эхэлсэн буюу тэр даруйхан эхлэх байсныг ойлгох бөгөөд ингэхдээ халдлага хийгдэж дуусаагүй байх ёстой. Өөрөөр хэлбэл халдлага эхлээгүй буюу нэгэнт дууссан хойно аргагүй хамгаалалт байж болохгүй. Түүнчлэн халдлага бодитой байх гэдэг нь халдлага хэн нэгний бодол санаанд бус харин илтэд болж буй нөхцөл байдал байхыг хэлнэ. Өөрөөр хэлбэл хамгаалалт худал биш байх ёстой.


Худал хамгаалалт гэж нийгэмд аюултай гэмт халдлага болоогүй байхад тийм халдлага бодиттой боллоо гэж андуурч хамгаалалт хийхийг ойлгоно. Худал хамгаалалт нь хамгаалалт хийж буй этгээд хохирогчийн үйл ажиллагааг нийгэмд аюултай халдлага гэж андуурч алдаа гаргасан, халдлага хийгээгүй өөр бусад хүний эсрэг хамгаалалт хийсэн, халдлага нэгэнт өнгөрсөн хойно энэ байдал нь тодорхой байгаа тохиолдолд хамгаалалтыг хэрэгжүүлсэн байдлаар илэрнэ.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах

Гэмт хэрэг үйлдсэн этгээд болон оргосон ялтан шинээр гэмт хэрэг үйлдэх боломжийг таслан зогсоох, түүнийг төрийн байгууллагад хүргэхийн тулд баривчлах, саатуулах үед энэ хуулийн тусгай ангид заасан үйлдлийг хийж гэм хор учруулсан гэмт хэрэгт тооцохгүй.


Баривчлах саатуулах үед гэм хор учруулах үйлдлийг

- гэмт хэрэг үйлдэж буй этгээдийг саатуулах үед гэм хор учруулах;
- гэмт хэрэг үйлдсэн этгээд, оргосон ялтанг баривчлах үед гэм хор учруулах хэмээн ангилж үзнэ.




Гэмт хэрэг үйлдэж буй этгээдийг саатуулах үйл ажиллагаа нь уг этгээдийн үйлдсэн гэмт хэрэг цаазаар авах, хорих, баривчлах ялаар шийтгэгдэх тохиолдолд хэрэгжинэ. Өөрөөр хэлбэл ямар нэгэн байдлаар эрх чөлөөг нь хязгаарлах ял заналхийлсэн хэргийн хувьд тийм гэмт хэрэг үйлдэж буй этгээдийн үйл ажиллагааг таслан зогсоохын тулд гэм хор учруулж буй нь хууль ёсны гэж үзэх нөхцөл болдог. Түүнээс гадна баривчлах саатуулах үйл ажиллагаа нь зөвхөн гэм хор учруулан баривчлах, саатуулахаас өөр аргагүй болсон нөхцөлд хэрэгжих ёстой. Гэмт хэрэг үйлдсэн этгээд болон оргосон ялтанг баривчлах үед гэм хор учруулах үйл ажиллагаа нь тухайн этгээдийг шинээр гэмт хэрэг үйлдэх боломжийг таслан зогсоох, түүнийг төрийн байгууллагад хүргэх зорилгоор, энэ зорилгод хүрэхэд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд гэм хор учруулахаас өөр аргагүй байсан, шаардлагатай хэр хэмжээний хүрээнд хийгдсэн тохиолдолд хууль ёсны гэж үзнэ.

Гарцаагүй байдал Эрүүгийн хуулиар хамгаалагдсан төр, нийгмийн ашиг сонирхол, өөрийн болон бусдын амьд явах эрх, халдашгүй чөлөөтэй байх, түүнчлэн бусад эрх, эрх чөлөөнд тулгарсан аюулыг зайлуулахын тулд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан үйлдлийг хийж, учруулсан хохирол нь учирч болох байсан хохирлоос бага бөгөөд уг аюулыг тухайн нөхцөл байдалд өөр аргаар зайлуулах боломжгүй байсныг гарцаагүй байдал гэнэ. Гарцаагүй байдлын улмаас хийсэн үйлдэл нь хуулиар зөвшөөрөгдсөн ийгэмд ашигтай байдаг тул гэмт хэрэгт тооцоггүй.




Дараах нөхцөлд гарцаагүй байдлыг хууль ёсны гэж үзнэ:

- Эрүүгийн хуулиар хамгаалагдсан төр, нийгмийн ашиг сонирхол, өөрийн болон бусдын эрх, эрх чөлөөнд аюул заналхийлсэн;
- Тэрхүү аюул нь байгалийн үзэгдэл, хүний биеийн физиологи үйлдэл, машин механизмын болон үйлдвэрлэлийн үйл явц, аргагүй хамгаалалтын нөхцөлд хамаарахгүй хүний гэмт үйл ажиллагаа болон бусад нийгэмд аюултай үйл явдлаас эх сурвалжтай;
- Тулгарсан аюул бодитой;
- Тулгарсан аюулыг гэм хор учруулахгүйгээр (өөр аргаар) зайлуулах боломжгүй;
- Учруулсан хохирол нь учирч болох байсан хохирлоос бага байна.




Аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал нь хэд хэдэн шинжээр ялгаатай. Юуны өмнө аргагүй хамгаалалтыг үүсгэх эх сурвалж нь нийгэмд аюултай гэмт халдлага байдаг бол гарцаагүй байдлын эх сурвалж нь байгалийн хүч, хүн нийгэмд аюултай техник, машин механизмын ажиллагаа, хүний физиологи үйлдэл (ухамсарт захирагдахгүй үйлдэл), бусдын хууль ёсны болон хууль бус зан үйл байдаг. Аргагүй хамгаалалтыг халдлага үйлдэж буй этгээдийн эсрэг хэрэглэдэг бол гарцаагүй байдал нь халдлагад хамаарахгүй бусдын хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд хохирол учруулах замаар хэрэгжинэ. Аргагүй хамгаалалтын хэр хэмжээг хуулиар тодорхойлоогүй бол гарцаагүй байдлын үед учруулсан хохирол нь учирч болох байсан хохиролоос ямагт бага байх шаардлага тавигдана.

Үйлдвэрлэл, шинжилгээ судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдэл Эрсдэл гэдэг нь хохирол амсах, аюултай байдалд орох гэсэн утгатай. Хууль зүйн шинжлэх ухаанд хүний үйл ажиллагааны улмаас аюултай нөхцөл байдал үүсэхийг эрсдэл гэж үзнэ. Эрсдэл нь аж ахуйн, үйлдвэрлэлийн, мэргэжлийн гэх мэт төрлүүдтэй байна. Эрүүгийн хуулиар нийгэмд ашигтай зорилгод хүрэхээр хийсэн үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдэлийг гэмт хэрэгт тооцохгүй байхаар хуульчилсан.



Тушаал захирамж биелүүлэх

Тушаал захирамж гэдэгт хуулиар болон бусад хэм хэмжээ тогтоосон акт, захирамжлах эрх бүхий этгээдээс гаргасан шийдвэр болон тухайн этгээдэд үүрэг хүлээлгэсэн хууль зүйн хүчин төгөлдөр актыг ойлгоно. Тушаал захирамжыг амаар болон бичгээр, хууль ёсны болон хууль бус байдлаар гаргасан байж болно. Заавал биелүүлэх тушаал, захирамжийг биелүүлэхдээ энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй. Харин хууль бус тушаал, захирамж өгсөн этгээдэд гэм хор учруулсны төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.



Анхаарах зүйл

Илт хууль бус тушаал, захирамж биелүүлж энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Илт хууль бус тушаал, захирамжийг биелүүлээгүй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

Тушаал захирамж заавал биелүүлэх болон хууль ёсны шинжтэй байх гэдэгт:

- тушаал захирамжыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанаас гаргасан;
- тушаал захирамжыг байгууллага, албан тушаалтан эрх мэдлийнхээ хүрээнд гаргасан;
- хуулиар тогтоосон хэлбэр, журмаар гаргасан;
- гаргасан тушаал захирамж хууль болон бусад хэм хэмжээ тогтоосон актад нийцсэн байх явдлыг ойлгоно.



Сорил

1. Гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлыг ол:
 - a. Хэргийн хөнгөрүүлэх нөхцөл байдал
 - b. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед гэм хор учруулах
 - c. Болгоомжгүй үйлдсэн гэмт хэрэг
 - d. Мэргэжлийн үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан үйлдсэн гэмт хэрэг
2. 2002 оны Эрүүгийн хуулиар тогтоосон гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлууд
 - a. Үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдэл
 - b. Гэмт хэргийг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед гэм хор учруулах
 - c. Тушаал захирамж биелүүлэх
 - d. Бие махбодийн хувьд болон сэтгэл санааны хувьд албадан хавчих
3. Аргагүй хамгаалалтаар хамгаалагдах эрх ашиг (хамааралтай ол):
 - a. Хүний өөрийн амьд явах эрх
 - b. Хүний эрх, эрх чөлөө
 - c. Бусдын амьд явах эрх
 - d. Хүний өөрийн халдашгүй чөлөөтэй байх эрх
4. Нийгэмд аюултай халдлагаас аргагүй хамгаалалтын нөхцөл:
 - a. Халдлага нь нийгэмд аюултай, бодитой буюу шууд тулгарсан нөхцөлд хийгдсэн байна
 - b. Халдлага бодитой буюу учирч болох хор ургийг нь халдлага үйлдсэн этгээдэд учруулсан хохиролтой ижил хэмжээтэй байна
 - c. Халдлага үйлдсэн этгээдэд учруулсан хохирол нь цаг хугацааны хувьд халдлага үйлдсэн цаг хугацаатай нь тохирсон байна
5. Нийгэмд аюултай халдлагаас хамгаалах аргагүй хамгаалалтын нөхцөл:
 - a. Гэмт хор уршиг гуравдагч этгээдийн эсрэг чиглэсэн байна
 - b. Хэрэг хариуцах чадваргүй болон гэм буруугүйгээр нийгэмд аюултай үйлдэл хийсэн этгээдийн эсрэг аргагүй хамгаалалт хийж болохгүй
 - c. Аргагүй хамгаалалтыг зөвхөн хүний амь бие, эрүүл мэндэд аюултай халдлагын эсрэг хэрэглэнэ
 - d. Аргагүй хамгаалалт нь халдлагын нийгмийн аюулын түвшин, шинж чанарт тохирсон байна.
6. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах нөхцөл
 - a. Гэмт хэрэг үйлдсэн этгээд болон оргосон ялтан ийнээр гэмт хэрэг үйлдэх боломжийг таслан зогсоох зорилгоор эрүүгийн хуулийн тусгай ангид заасан үйлдэл хийж гэмт хор учруулсан
 - b. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг өөр аргаар баривчлах боломжгүй бөгөөд түүнийг баривчлах зайлиггүй шаардлагатай байсан арга хэтжээний хэр хэмжээг хэтрүүлээгүй байх
 - c. Гэмт хэрэг үйлдсэн этгээд болон оргосон ялтныг төрийн байгууллагад хүргэхийн тулд баривчлах, саатуулах үед эрүүгийн хуулийн тусгай ангид заасан үйлдэл хийж, гэмт хор учруулсан

7. Аргагүй хамгаалалтыг хуульд заасан хэр хэмжээнд нь үйлдсэн тохиолдолд:

- a. Хариуцлагыг хөнгөрүүлнэ*
- b. Энэ нь гэмт хэргийн шинжтэй тул эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ*
- c. Эрүүгийн хариуцлагад татах, чөлөөлөх асуудал яригдахгүй*
- d. Энэ нь гэмт хэргийн шинжтэй тул эрүүгийн хариуцлага хүлээлгээд чөлөөлнө*

8. Гарцаагүй байдлын нөхцөл:

- a. Заналхийлсэн аюул нь зөвхөн хүний үйлдэл, эс үйлдэхүй байх бөгөөд бодитой, өөр аргаар зойлуулах боломжгүй байна*
- b. Заналхийлж буй аюулыг өөр аргаар зойлуулах боломжгүй, бодитой байх бөгөөд зөвхөн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэүүй байгаад зогсохгүй зэрлэг амынны довтолгоо, байгалийн гатишигт үзэгдэл, техникийн үйл ажиллагаа, хүний бие организмын өвөртөц онцлог, хууль ёсны эсрэг тэсрэг ашиг сонирхол байж болно*
- c. Заналхийлсэн аюул нь зөвхөн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй байгаад зогсохгүй зэрлэг амынны довтолгоо, байглийн гатишигт үзэгдэл, техникийн үйл ажиллагаа, хүний бие организмын өвөрмөц онцлог, хууль ёсны эсрэг тэсрэг ашиг сонирхол байж болно*

9. Гарцаагүй байдлын улмаас бий болсон хохирол нь учирч болох байсан хохирлоос:

- a. Заавал бага байна*
- b. Тэнцүү байна*
- c. Их байж болно*
- d. Ямар байх нь хамаагүй*



ДАСГАЛ 5. ГЭМТ ХЭРГИЙН НИЙГМИЙН АЮУЛЫГ ҮГҮЙСГЭХ НӨХЦӨЛ БАЙДАЛ

(Тохиолдол шинжлэх)

- Тохиолдол 1. 1999 онд нэгэн улсын үйлдвэрийн дарга “Д” өөрийн мэдлэг, туршлагадаа тулгуурлан эх орондоо элсэн чихрийн үйлдвэр байгуулахаар шийдэж төсөл зохион улсаас 500 сая төгрөгийн зээл авсан байна. Юуны өмнө элсэн чихрийн түүхий эд чихрийн манжинг Монголын хөрсөн дээр ургуулахаар гарч болох эрсдэлийг тооцон, 100 га талбайд чихрийн манжин тарьсан боловч байгаль цаг уурын нөхцөл тохироогүйгээс ургац алдаж их хэмжээний хохирол хүлээн төслийн үр дүн гарсангүй. Урьд нь хүлэмжинд тарих үед манжин сайн ургаж байсан боловч мөндөр зэрэг байгалийн давагдашгүй хүчнээс болоод ургац алдсан нь мөрдөн байцаалтын явцад тогтоогджээ. Зээлийн хугацаа болж үйл ажиллагаа явуулж чадаагүй тус газар дампуурлын ирмэгт очсон учир цагдаагийн байгууллагаас “Д”-г ЭХ-н 150-р зүйлд зааснаар эрүүгийн хариуцлагад татсан байна.
- Тохиолдол 2. Хугацаат цэргийн албан хаагч “Э” нь сумангийн дарга ахмад “Ө”-тэй нутаг нэг учир түүний ивээлд багтан гэр орноор нь ирж очин ажил төрөлд нь тусалдаг байв. Нэг өдөр ахмад “Ө” түүнд хандан ...би агуулахаас шуудай элсэн чихэр, 20 кг масло аваад өрөөндөө тавьчихл аа, намайг харуулыг саатуулж байх хооронд чи эдгээрийг сэмхэн зөөгөөд манайд тавьчих гэсэнд “Э” би айж байна, та ингэж болохгүй гэхэд нь “Ө”...би чамд даргын хувьд тушааж байна гэсэн учир “Э” тэдгээр зүйлийг авч гарч байгаад харуулд баригдсан байна. Хэрэг бүртгэлтийн явцад тэдгээр хүнсний зүйлс нь 65,0 төгрөгийн үнэлгээтэй болохыг тогтоосон.
- Тохиолдол 3. Мянгат малчин “Р” нэгэн орой өөрийнхөө хоттой хонио эргэж явтал 2 морьтой залуу хэсэг хонийг нь туугаад, цаашаа явахыг нь хараад ...та нарыг таньж байна, наад хонио тавиад өөрсдөө явцгаа, үгүй бол буудлаа шүү гэж хашгирахад цаадуул нь тоосон шинжгүй хонийг туусаар улам холдсон учир “Р” буугаа гарган хараалж байгаад буудахад нэг нь мориноосоо унан үлдэж, нөгөө нь зугтаасан байна. “Р” газарт унасан хүнийг очиж үзвэл тэдний нутгийн зүс таних залуу “Х” зүрхээрээ нэвт буудагдсан байдалтай амь тавьж байхыг хараад даруй хэсгийн төлөөлөгчийг дуудсан боловч “Х” цагийн дараа шархаа даахгүй нас баржээ.
- Тохиолдол 4. Нэгэн үйлдвэрийн манаач “Б” нэгэн орой объектоо эргээд явж байтал үйлдвэрийн хашаан дотор 2 хүн сүүдэгнээд нуугдахыг хараад, тэдэн лүү буугаа чиглүүлээд ...гараад ирцгээ, үгүй бол буудна шүү гэсэн байна. Гэтэл нуугдсан 2 цааш зугтаахыг харсан “Б” буудлаа гэж дахин нэг хашхираад дээш нь анхааруулж нэг удаа буудсан. Тэгээд зогсохгүй болохоор нь чиглүүлж байгаа

нэгийг нь буудахад тэрээр нэвсхийн унасан ба нөгөө нь зугтан одсон. Газарт унасан хүн дээр очиход нөгөө ээлжийн манаач “С” амь тавьж байсан бөгөөд түүний халааснаас хулгайлсан эд зүйлс цухуйж байсан учир яаравчлан эмнэлэг, цагдаад мэдэгдсэн байна.

Тохиолдол 5. Увс аймгийн нэгэн суманд шинээр ирсэн багш эмэгтэй “И”-г ганцаараа амьдардагийг мэдсэн тус сумын ажилгүй хэдэн залуус хүчирхийлэхээр тохиролцон, гэрт нь очсон байна. Хаалгаа тайлж өгөөгүй учир тэдгээр залуусын нэг “Б” байшингийн араар нь тойрч цонхоор нь орж “И”-г шууд тэврэн авч ор луу чирсэн. Энэ үед “И” ширээн дээр байсан хайчийг шүүрэн авч түүний нуруу орчим газар луу 3 удаа дүрсэний улмаас “Б” нас барсан байна. Аймгийн шүүхээр “И”-г аргагүй хамгаалалтын хэр хэмжээг хэтрүүлсэн гэж ЭХ-н 93-р зүйлд / 1986 оны хууль / зааснаар 2 жилийн хорих ял оноосоныг “Б”-н ар гэрийнхэн ял хөнгөдлөө хэмээн давж заалджээ.

Тохиолдол 6. Мэс заслын эмч “Б” жижүүртэй байхдаа бусдад буудуулсны улмаас их хэмжээний цус алдсан “Х”-г хүлээн авч шинжилгээ хийхэд тэрээр ховор бүлгийн цустай болох нь тогтоогдсон учир донор цусны эрэлд гарсан. Гэтэл аль ч эмнэлэгт түүнд тохирох цус байгаагүй учир “Х” удалгүй үхэх нь тодорхой болсон. Энэ үед эмч “Б” тэдний эмнэлэгт хэвтэж байгаа 70 настай “Ө” эмгэн тийм бүлгийн цустайг гэнэт санаад, тасагт нь очсон. Эмгэн юм ярьж чадахгүй байсан учир сувилагчаа дуудаж, шаардлагатай цусыг эмгэнээс авахыг даалгасан. Маргааш нь эмгэний цусыг хийлгэсний ачаар “Х”-н амь нас аврагдсан боловч “Ө” цусны дутагдлаар нас барсан хэрэг гарчээ.



III БҮЛЭГ. ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА

Бүлгийн зорилго: Энэ бүлэг эрүүгийн хариуцлага, түүний ойлголт, зорилго, үндэслэл, төрөл, хэмжээ, ял ногдуулах болон эрүүгийн хариуцага, ялаас чөлөөлөх үндэслэл, журмын талаар онолын суурь мэдлэг олох, практикт гарсан гэмт хэргийг шүүхээр иийдвэрлэсэн байдалд хууль зүйн үүднээс үнэлэлт, дүгнэлт өгөх, холбогдох тохиолдол, нөхцлүүдийг бие даан иийдвэрлэх дадал, чадвар эзэмших, эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй холбоотой Эрүүгийн хуулийн хэм хэтжээг зөв хэрэглэх хандлагатай болно.

СЭДЭВ 1. ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГЫН ОЙЛГОЛТ, ТӨРӨЛ, ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ ҮНДЭСЛЭЛ

Эрүүгийн хариуцлагын ойлголт, төрөл

Аливаа эрх зүй нь талуудын эрх, үүрэг, түүнийг дагаж мөрдсөн болон зөрчсөнөөс үүсэх үр дагаварыг тодорхойлсон хэм хэмжээний тогтолцоо байдаг бөгөөд

үр дагаварыг тодорхойлсон хэсгийг эрх зүйн (хууль зүйн) хариуцлага гэдэг. Эрүүгийн эрх зүй нь хамгаалах чиг үүрэг бүхий эрх зүйн салбар болох хувьдаа нийгмийн бүхий л төрлийн харилцааны нийгэмд аюултай буюу криминаль гэгдэх харилцаанаас хүмүүсийн нийтлэг эрх ашгийг хамгаалсан хориг тогтоож, тэрхүү хоригийг зөрчсөнийг улмаас үүдэн гарах хууль зүйн үр дагаварыг тодорхойлж байдаг. Тэрхүү **Эрүүгийн хууль зөрчсөн зан үйлтэй холбогдон үүсэх хууль зүйн үр дагаварыг эрүүгийн хариуцлага** гэнэ.

Эрүүгийн эрх зүйн хүний эрх, эрх чөлөө, нийгэм, төрийн ашиг сонирхолыг гэмт халдлагаас хамгаалах зорилтоос үүдэн эрүүгийн хариуцлага нь ихэвчлэн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хэрэглэх албадлагын арга хэмжээ байдлаар илрэн гардаг. Энэхүү эрүүгийн эрх зүй дэх албадлагын арга хэмжээг ял гэнэ.

Гэхдээ эрүүгийн хариуцлага ба ял нь тэнцүү агуулгатай гэж үзэж болохгүй. Эрүүгийн эрх зүйд олон төрлийн ялын бус (таслан сэргийлэх арга хэмжээ, ял тэнсэх, ял хойшлуулах, эмнэлэгийн болон хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ г.м) хариуцлагын арга хэмжээ хэрэглэж хүн, нийгэм, төрийг гэмт халдлагаас хамгаалж байдаг. Үүнээс үндэслэн эрүүгийн хариуцлагыг дотор нь:

- Ялын буюу ял ногдуулсан
- Ялын бус буюу ял ногдуулаагүй гэсэн төрөлд хуваадаг.

Ял ногдуулсан эрүүгийн хариуцлага

- торгох
- албадан ажил хийлгэх
- баривчлах
- хорих
- цаазаар авах

Ял ногдуулаагүй эрүүгийн хариуцлага

- таслан сэргийлэх арга хэмжээ
- ял тэнсэх
- ялтайд тооцох
- эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээ
- хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ

**Эрүүгийн хариуцлага
хүлээлгэх үндэслэл**

Монгол Улсын эрүүгийн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Энэ хуульд заасан гэмт хэргийн бүх шинжийг агуулсан хэрэг үйлдэгдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно” гэж заасан. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл нь гэмт хэрэг үйлдсэн байх явдал юм. Гэхдээ Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлд гэмт хэргийн талаар ерөнхий тодорхойлолт өгсөн боловч үүнийг практикт гарсан тодорхой хэргийг шийдвэрлэхэд ашиглах боломжгүй юм. Учир нь ерөнхий утгаараа гэмт хэрэг гэж байх боловч амьдралын тохиолддыг шийдвэрлэхэд Эрүүгийн хуулийн Тусгай ангид заасан (бусдын эд хөрөнгийг хулгайлах, дээрэмдэх, хээл хахууль авах г.м) тодорхой гэмт хэргийн шинжийг шалгасанаар гэмт хэрэг мөн эсэхийг тогтоодог. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн Тусгай ангид заасан тодорхой гэмт хэргийн объектив болон субъектив шинж нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болдог.

Мөн Эрүүгийн хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-д “Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу байгуулагдсан шүүхээс өөр байгууллага, албан тушаалтан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудааг шийдвэрлэхийг хориглоно” гэж заасан тул **эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл байгаа эсэхийг зөвхөн шүүх** шийдвэрлэх ёстой. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хариуцлагыг зөвхөн шүүхийн хуульд нийцүүлэн гаргасан шийдвэрээр хүлээлгэнэ.



Хяналтын асуулт

1. Яагаад гэмт хэргийн бүрэлдэхүүний бүх шинжийг агуулсан хэрэг үйлдэгдсэн байх явдал нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болдог вэ?
2. Тодорхой этгээдийн нийгэмд аюултай байдал (сэтгэцийн өвчтэй, онц аюултай гэмт хэрэгтэнээр тооцогдсон г.м) нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болж болох уу?
3. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор нь ялын бус эрүүгийн хариуцлагыг хүлээлгэж болох уу?



СЭДЭВ 2. ЯЛЫН ЗОРИЛГО, ТОГТОЛЦОО

Тодорхойлолт, шинж

Эрүүгийн эрх зүй нь **гэмт хэрэг** - ял гэсэн хоёр ухагдахуунд суурилан тогтолцоогоо бүрдүүлдэг. Ял бол гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдийн эрх, эрх чөлөөнд Эрүүгийн хуульд заасны дагуу **шүүхийн шийтгэх тогтоолоор хязгаарлалт тогтоож буй төрийн албадлагын арга хэмжээ**. Ялын төрөл, хэрэглэх хэмжээ хязгаарыг Эрүүгийн хуулиар тогтооно.

Ял нь хүн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой төрийн албадлагын арга хэмжээний хамгийн хатуу төрөл болохын хувьд эрх зүйн бусад албалаагаас ялгагдах шинжүүдтэй.

- Ял - албадлагын арга хэмжээ;
- Ялыг - гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ногдуулна;
- Ялыг - шүүхийн шийдвэрээр ногдуулна;
- Ял - хүний эрх, эрх чөлөөнд Эрүүгийн хуульд заасан хязгаарлалт тогтооно;
- Ял ногдуулсанаар - хууль зүйн үр дагавар бүхий ялтай байдлыг бий болно.

Ял нь өөрөө зорилго биш харин Эрүүгийн эрх зүйн зорилтод хүрэх хэрэгсэл юм. Ийм учраас ялын зорилго нь Эрүүгийн хуулийн зорилтоос үүдэн гарна. Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилт нь Монгол Улсын **тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам, энхтайван, хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалахад оршино**. Эдгээр зорилтыг хангах үүднээс ял нь хүн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой.

Ялын тогтолцоо

Эрүүгийн хуулиар тогтоосон ялуудыг хүнд хөнгөний байдлаар нь хэрэглэхийг харгалзан тодорхой дэс дараалалд оруулсан эрэмбэл. Эрүүгийн хуульд ялын төрлийг хөнгөнөөс нь хүнд рүү байрлуулсан байдаг. Ялын тогтолцоо нь:

- Үндсэн ял
- Үндсэн болон нэмэгдэл ялын чанартай ял
- Нэмэгдэл ялаас бүрдэнэ.

¹ Латины Punitur non (solum) quia peccatur, sed ne peccatur буюу ялыг зөвхөн гэмт хэрэг үйлдсэнийг шийтгэх гэж тогтоодоггүй, харин хожим гэмт хэрэг үйлдэхгүй байлгахын тулд тогтоодог гэсэн мөрдлөгөөг бүр Римийн эрх зүйд баримталж ирсэн

Үндсэн ял Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд нэг шийтгэх тогтоолоор ял оногдуулахад давхар хэрэглэж болохгүй ял.	• торгох • албадан ажил хийлгэх • баривчлах • хорих • цаазаар авах
Үндсэн ба нэмэгдэл ял Дангаар нь болон үндсэн ялд нэмэгдэл болгон оногдуулж болох ял	Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах
Нэмэгдэл ял Үндсэн ялтай хамт хэрэглэж болох ял. Хэд хэдэн таслан шийдвэрлэх тогтоолоор ял оногдуулж байгаа үед хэд хэдэн нэмэгдэл ялыг давхар хэрэглэж болно. Нэмэгдэл ялыг дангаар оногдуулахгүй.	• Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах • Эд хөрөнгө хураах

Ялын тогтолцооны практик ач холбогдол

Ялын тогтолцоо нь ялын үр нөлөөг дээшлүүлэх практик ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл хүнд хөнгөн ялыг оновчтой хослуулах, цэрлэлийг хэмнэлттэй ашиглахад үндсэн, нэмэгдэл, үндсэн ба нэмэгдэл ялын тухай ухагдахуун ач холбогдолтой байдаг. Түүнчлэн эрүүгийн хуульд ялыг хөнгөнөөс хүнд рүү шилжих дарааллаар байрлуулсан нь ял хөнгөрүүлэх, хүндрүүлэх журмыг хэрэглэхэд баримтлагдана.

Ялын төрөл

1. Торгох

Шүүхээс мөнгөн төлөөс ногдуулах

2. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах

Төрийн албан тушаал эрхлэх, тодорхой мэргэжлийн болон бусад үйл ажиллагаа явуулах эрхийг эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нэгээс таван жил хүртэл хугацаагаар хязгаарлах

3. Эд хөрөнгө хураах

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ногдох эд хөрөнгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж, төрийн өмчлөлд шилжүүлэх

4. Албадан ажил хийлгэх

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлсон газарт нийгэмд ашигтай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэх



5. Баривчлах

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой дэглэм бүхий байранд ганцаарчлан байлгах

6. Хорих

Эрүүгийн хуульд заасан хугацаагаар эрх чөлөөг нь хязгаарлаж, нийгмээс тусгаарлан хорих анги, гянданд байлгах

7. Цаазаар авах

Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ногдуулах ялын дээд хэмжээ

Торгох ялын хэмжээг гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тогтооно. Шүүх торгох ялыг ногдуулахдаа гэм буруутай этгээдийн үйлдсэн гэмт хэргийн хүнд, хөнгөн, эд хөрөнгийн байдлыг харгалзан үзэх бөгөөд торгох ял нь ялтны зөвхөн материаллаг эрх ашгийг хөндөнө. Хэрэв ялтан торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл уг ялын хэмжээнээс хамааруулан шүүх торгох ялыг баривчлах, гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар сольж болно. Албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ялыг торгох ялаар солихыг хориглоно.

Тодорхой албан тушаал эрхлэх/годорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг үндсэн болон нэмэгдэл ялын шинжтэй хэрэглэгдэнэ. Энэ ял нь Тодорхой абан тушаал эрхлэх эрхийг хасах, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах гэсэн хоёр төрөлтэй. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг баривчлах, хорих ялд нэмэгдэл ялын чанартай ногдуулсан бол хугацааг нь үндсэн ялыг эдэлж дууссан үеэс эхлэн тоолно. Энэ ялыг торгох, албадан ажил хийлгэх ялд нэмэгдэл ялын чанартай ногдуулсан бол хугацааг нь шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн тоолно.

Эд хөрөнгө хураах ялыг зөвхөн нэмэгдэл ялын чанартай хэрэглэнэ. Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгслийг эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураана. Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ гэдэг нь тухайн гэмт хэргийн шууд хохирол болж байгаа тэр зүйл биш юм. Ийм учраас гэмт этгээд өөрийн үйлдлээр бий болгож байгаа зүйл, Жишээлбэл; хуурамч бараа бүтээгдэхүүн, мөнгөн тэмдэгт зэргээс гэмт хэргийн шууд хохирол болж буй зүйл хоёрыг ялгаж ойлгох хэрэгтэй. Гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг гэдэг нь гэм буруутай этгээд тухайн хэрэг үйлдэхдээ хэргийн улмаас учруулж болох хор уршиг, аюулыг, түргэсгэх, хүч нэмэгдүүлэх, хохирогчийн зүгээс үзүүлэх эсэргүүцлийг няцаах, учирч болох саадыг арилгах, зайлуулахад ашигласан төрөл бүрийн галт болон хүйтэн зэвсэг, харин хэрэгсэл гэдэг нь гэмт үйлдлээрээ олж авсан зүйлийг тээж зөөвөрлөх, гэмт хэргийн газарт очсон, зугтсан зэрэгт хэрэглэсэн тээврийн төрөл бүрийн хэрэгсэл, хориотой үйлдвэрлэл үйлчилгээ явуулсан техник, тоног төхөөрөмж, түүхий эд, багажийг хамааруулна. Гэмт хэргийн хэрэгсэл нь гэмт хэрэг үйлдэх зорилгоор ашигласан, бэлтгэсэн, эд

зүйл болон бусад зүйл байна. Гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг хэрэгсэл нь гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь нотлогдсон тохиолдолд түүнийг эд хөрөнгө хураах ялын чанартайгаар хурааж төрийн өмчлөлд шилжүүлэх нь зүйтэй. Харин гэм буруутай этгээд бусдын өмчлөлд байсан зэвсэг, хэрэгсэлийг өөрийн өмчлөлд хууль бусаар шилжүүлж түүнийг гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан бол түүнийг жинхэнэ өмчлөгч, эзэмшигчид нь шилжүүлж өгнө. Шүүх эд хөрөнгө хураах ял ногдуулахдаа хураах эд зүйл, эд хөрөнгийг шийтгэх тогтоолдоо нэг бүрчлэн зааж өгнө.

Албадан ажил хийлгэх ял ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг хүчин төгөлдөр болмогц долоо хоногийн дотор шүүх шийдвэр гүйцэтгэх албанд хүргүүлнэ. Шийдвэр гүйцэтгэх алба нь шүүхийн шийтгэх тогтоолыг хүлээн авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор тухайн сум, дүүргийн Засаг даргад танилцуулж аль байгууллагад албадан ажил хийлгэхийг тогтоолгож ялтны ял эдлэх ажиллагаанд хяналт тавина. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ялтныг албадан ажил хийлгэх ажил олох, ажлын байраар хангах үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй. Энэ үүргээ хэрэгжүүлэхдээ сум, дүүргийн Засаг дарга нь: албадан ажил хийх тухай нийтэд мэдээлэх; орон нутаг дахь аж ахуйн нэгж, байгууллагатай хамтрах хэлбэрээр ажиллана. Энэ ял эдлэж буй ялтны цалин хөлсийг өөрийх нь үйлдсэн гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөхөд суутгана. Хэрэв ялтан өр төлбөргүй бол албадан ажил хийсэн ялтны цалин хөлсийг улсын төсөвт оруулна. Эрүүгийн хуульд зааснаар ял нь нэг зуугаас таван зуун цагийн хугацаатай, албадан ажил хийх нь нэг өдөрт гурван цагаас доошгүй хугацаагаар үргэлжилнэ. (Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуульд зааснаар нэг өдөрт албадан ажил хийлгэх хугацаа 3-12 цаг байна) Албадан ажил хийлгэх ял эдлэх хугацааг ялтан ажил хийж эхэлсэн цагаас тооцох бөгөөд шүүхээс ногдуулсан ялын хугацаанд ногдох ажлын цагт ажилласан байна. Ажиллаагүй цагийг хуульд зааснаар ял эдэлсэн хугацаанд оруулан тооцохгүй бөгөөд дутуу ажлын цагийг нөхөн ажиллуулна. Ялтан ял эдлэх хугацаанд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, хуурамчаар өвчлөх, бие эрхтэн, эрүүл мэнддээ санаатайгаар гэмтэл учруулах, захиргааны журмаар баривчлагдах, цагдан хоригдох зэргээр ажиллаагүй хугацааг уг ялтны ял эдэлсэн хугацаанд оруулан тооцохгүй. Ял эдлэх хугацаа дууссан бол тухайн өдрөөс, хуульд заасан бусад үндэслэлээр ялаас чөлөөлсөн бол уг шийдвэрийг хүлээн авмагц шийдвэр гүйцэтгэх газар ял эдэлж дууссан тухай цагаатгах тогтоол гаргах ба энэ өдрөөс эхлэн ялтны эрхийн хязгаарлалтыг зогсооно. Уг ял эдлэхээс санаатайгаар зайлсхийсэн ялтны эдлээгүй үлдсэн ялын хорин дөрвөн цагийн ажлыг нэг хоног баривчлах ялаар тооцож солино. Албадан ажил хийлгэх ялаас санаатайгаар зайлсхийх гэдэг нь ялтан ажлаа дур мэдэн орхих, ажил олгогч, шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгчээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй байх, зөрчих зэрэг ял эдлэхээс зайлсхийсэн идэвхтэй үйлдлийг ойлгоно. Дээрх тохиолдолд ажил хийлгэж байгаа байгууллага энэ тухай шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэх бөгөөд шийдвэр гүйцэтгэх газар зохих шалгалт хийж албадан ажил хийлгэх ялыг эрүүгийн хуульд зааснаар өөр ялаар (баривчлах) солих тухай саналаа холбогдох баримт бичгийн хамт шүүхэд ирүүлнэ мөн шүүхийн шийтгэх тогтоол гарсны дараа ялтан хөдөлмөрийн чадвараа байнга буюу удаан хугацаагаар алдсан бол албадан ажил хийлгэх ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих тухай саналыг шийдвэр гүйцэтгэх газар шүүхэд гаргаж шийдвэр гүйцэтгэх газрын санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх Эрүүгийн хуульд заасан дагуу албадан ажил хийлгэх ялыг өөр төрлийн хөнгөн ялаар, эсхүл баривчлах ялаар солих асуудлыг шийдвэрлэнэ. Хөдөлмөрийн чадваргүй этгээд,



жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэг, түүнчлэн тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй, цэргийн жинхэнэ хугацаат алба хааж байгаа этгээдэд энэ ялыг ногдуулж болохгүй.

Баривчлах ялыг нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар ногдуулна. Энэ ялыг шүүхийн шийтгэх тогтоол гарах үед арван зургаан насанд хүрээгүй этгээд, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, бага насны хүүхэдтэй ганц бие эх, эцэгт ногдуулахгүй. Баривчлах ялаар шийтгүүлсэн ялтан илгээмж авах, түр уулзалт хийх тоог хязгаарлахгүй бөгөөд удаан хугацааны уулзалт хийж болно. Цэргийн жинхэнэ хугацаат албан хаагчид ногдуулсан баривчлах ялыг сахилгын байранд ганцаарчлан эдлүүлнэ.

Хорих ялын үндсэн хугацаа нэгээс арван таван жил хүртэл байна. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хорин таван жил хүртэл хугацаагаар ногдуулж болно. Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, тавин таваас дээш насны эмэгтэй хүн, жараас дээш насны эрэгтэй хүнд арван таван жилээс дээш хугацаагаар хорих ял ногдуулж болохгүй. Хорих ялыг жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих анги болон гянданд эдлүүлнэ. Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй ялтан, түүнчлэн онц хүнд гэмт хэрэгт ял шийтгэгдсэнээс болон онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсоноос бусад эмэгтэй ялтны хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ. Хүнд гэмт хэрэг үйлдсэн, эсхүл урьд нь хорих ял эдэлж байсан эрэгтэй ялтан, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эмэгтэй ялтны хорих ялыг чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ. Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн буюу онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эрэгтэй ялтны хорих ялыг онцгой дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ. Хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй эрэгтэй ялтан, хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй эмэгтэй ялтны хорих ялыг насанд хүрээгүйчүүдийн жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ. Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон болон арван найман насанд хүрсний дараа онц хүнд гэмт хэрэгт арван таван жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн ялтны хорих ялын заримыг гянданд эдлүүлэхээр шүүх тогтоож болно.

Цаазаар авах ялыг буудаж гүйцэтгэнэ. Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээд Монгол Улсын Ерөнхийлөгчид хандаж уучлал хүсэх эрхтэй бөгөөд ерөнхийлөгч цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд гучин жилийн хугацаагаар гянданд хорих ялаар солино. Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн эмэгтэйчүүд, жараас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял ногдуулж болохгүй. Эрүүгийн хуулийн тусгай ангийн (Төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах), (Хорлон сүйтгэх), (Хүнийг хүндрүүлэх нөхцөл байдалтай санаатай алах), (Хүндрүүлэх нөхцөл байдалтай хүчиндэх), (Зандалчлах), (Төрлөөр устгах) зэрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд цаазаар авах ял ногдуулна.

Хорих ял Хорих ялыг жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих анги болон
эдлүүлэх дэглэм гянданд эдлүүлнэ. Хорих ял шийтгүүлсэн ялтны хорих ял эдлэх
ангийн төрөл, дэглэмийг шүүх тогтооно. Насанд хүрээгүй болон
эмэгтэй ялтны ялыг жирийн, чанга дэглэмийн, насанд хүрсэн эрэгтэй ялтны ялыг
жирийн, чанга, онцгой дэглэмийн хорих анги, гянданд тус тус эдлүүлнэ. Гянданд ял
эдлүүлэхээр шийтгүүлсэн ялтны ялыг жирийн чанга дэглэмийн гянданд эдлүүлнэ.

Шорон ба гяндан

Шорон. Ерөнхий утгаараа гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн этгээдийг
нийгмээс тусгаарлан хорих газар. Эртний Грек Ромд шоронд хорьж байгаа нь ялын
төрөл биш харин гэмт хэрэгтний гэм бурууг тогтоох, зодож занчих ял онгдуулахын
өмнө хорьж байцаах үед хамруулж үздэг байсан. Ийм учраас шорон болон хорих
ял нь харилцан хамааралтай хөгжиж ирсэн. Орчин үед шорон нь хорих анги гэсэн
нэр томъёогоор хэрэглэгдэж байна.

Гяндан. Хорих ялыг эдлүүлэх тусгай дэглэм. Онц аюултай гэмт хэрэгтнээр
тооцогдсон болон арван найман насанд хүрсний дараа онц хүнд гэмт хэрэгт
арван таван жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн ялтны хорих ялын
заримыг гянданд эдлүүлнэ. Гяндангийн хоригдлыг ганцаарчилсан тасалгаанд
хорино. Шаардлагатай гэж үзвэл хорих ангийн дарга прокурортой зөвшилцөж,
гяндангийн хоригдлыг нийтийн тасалгаанд хорьж болно. Гяндан нь жирийн
болон чанга дэглэмтэй байна. Жирийн дэглэмтэй гяндангийн хоригдол жилд хоёр
удаа түр уулзалт хийж, сард нэг удаа захидал явуулж болно. Чанга дэглэмтэй
гяндангийн хоригдол жилд нэг удаа түр хугацааны уулзалт хийж, хоёр сард нэг
удаа захидал явуулж болно. Гяндан хамгаалалтын дараахь бүстэй байна үүнд;
дотоодын хориотой бүс; телекамер; үндсэн хашаа; цахилгаан дохиолол бүхий
сийрэгжүүлсэн хөрстэй бүс; өнгөлөн далдлах хашаа тус тус хамаарна. Гяндангийн
амьдралын болон үйлдвэрлэлийн бүсийн гаднах дохиолол, харуул хамгаалалтыг
хорих байгууллагын ажилтны хүчээр хариуцан гүйцэтгэнэ.

Харуул хамгаалалтын болон ялтанд хяналт тавих журмыг хууль зүйн асуудал
эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно. Гяндангийн хоригдлыг тусгай
төхөөрөмжлөгдсөн газарт, зохих хяналт хамгаалалтын дор өдөрт нэг цагаас
доошгүй хугацаатай гадаалуулна. Гяндангийн хоригдол гадаалж байхдаа тогтоосон
журам зөрчвөл гадаалахыг даруй зогсооно. Хэрэв шүүх ялтны эдлэх ялыг гянданд
эдлүүлэхээр тогтоосон бол түүний урьдчилан хоригдож байсан хугацааг гянданд
ял эдэлсэн хугацаанд оруулж тооцохгүй.



Хяналтын асуулт

1. Эрүүгийн хуулиас өөр хуулиар хориглосон нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйн төлөө хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болох уу?
2. Албан тушаалын байдлаа ашиглан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ хүндрүүлэн үзэх нь “Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим” -тай зөрчилдөх үү?
3. Шударга ёсны болон энэрэнгүй ёсны зарчмын агуулгыг тайлбарла. Эдгээр зарчмууд хоорондоо зөрчилдөх үү?
4. Эрүүгийн хуулийг тайлбарлаж байгаа нь түүнийг төсөөтэй хэрэглэж байгаа хэрэг мөн үү?
5. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болох уу?



Сорил

1. **Ялын зорилго нь:**
 - a. Нийгмээс тусгаарлах
 - b. Урьдчилан сэргийлэх
 - c. Дахин хүмүүжүүлэх
2. **Аль нь үндсэн болон нэмэгдэл ял вэ?**
 - a. Эд хөрөнгө хураах
 - b. Торгох
 - c. Баривчлах
 - d. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах
3. **Цаазаар авах ялыг дараах тохиолдолд хэрэглэнэ:**
 - a. Хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдсэн
 - b. Хүнд гэмт хэрэг үйлдсэн
 - c. Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн
4. **Ямар ялыг зөвхөн нэмэгдэл ялын чанартайгаар хэрэглэх вэ?**
 - a. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах
 - b. Торгох
 - c. Эд хөрөнгө хураах
 - d. Албадан ажил хийлгэх
5. **Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял нь:**
 - a. Үндсэн ял
 - b. Үндсэн ба нэмэгдэл ял
 - c. Нэмэгдэл ял

6. Цаазаар авах ялыг ногдуулж болохгүй тохиолдлууд (хамааралтайг ол):
- a. Залуучуудад
 - b. Эмэгтэйчүүд
 - c. Ахимаг настай хүмүүст
 - d. 18 насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн эрэгтэйчүүд
7. Дараах гэмт хэрэг үйлдсэн этгээдийг онцгой дэглэмтэй хорих ангид ял эдлүүлнэ
- a. Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эмэгтэй
 - b. Урьд нь хорих ялаар шийтгүүлж байсан эрэгтэй ялтан
 - c. Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй ялтан
 - d. Хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдсэн ялтан
8. Насанд хүрээгүй байхдаа онц хүнд гэмт хэрэг үйлдсэн эмэгтэй ялтны ялыг ямар дэглэмд эдлүүлэх вэ
- a. Жирийн
 - b. чанга
 - c. онцгой
9. Торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл:
- a. Баривчлах, 3 жил хүртэл хорих ялаар солино
 - b. Албадан ажил хийлгэх ялаар солино
 - c. Ямар нэг ялаар солихгүй
10. Торгох ялыг хэрэглэхэд шүүхээс анхаарах гол нөхцөл:
- a. Үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюул
 - b. Шүүгдэгчийн эд хөрөнгийн байдал
 - c. Шүүгдэгчийн хувийн байдал
11. Торгох ялыг хэрэглэхээр заасан гэмт хэргийн ангилалт (хамааралтайг ол):
- a. Хөнгөн
 - b. Хүн дэвтэр
 - c. Хүнд
 - d. Онц хүнд
12. Эд хөрөнгө хураах ялын агуулга:
- a. Гэмт үйлдлийн улмаас буй болгосон эд зүйлийг хураах
 - b. Гэмт үйлдлийн замаар олсон ашиг, орлогыг хураах
 - c. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд оногдох хөрөнгийн хураах
13. Баривчлах ял нь
- a. Үндсэн ялын чанартай
 - b. нэмэгдэл ялын чанартай
 - c. үндсэн болон нэмэгдэл ялын чанартай



- 14. Баривчлах ял эдлүүлэх дэглэм нь**
- a. Жирийн*
 - b. чанга*
 - c. тусгай дэглэм байхгүй.*
- 15. Баривчлах ял эдлүүлж болохгүй субъектүүд**
- a. Гэмт хэрэг үйлдэх үед 16 насанд хүрээгүй байсан этгээд*
 - b. Бага насны хүүхэдтэй эх*
 - c. Бага насны хүүхэдтэй ганц бие эцэг*
 - d. Цэргийн албан хаагч*
- 16. Албадан ажил хийлгэх ялаас санаатайгаар зайлсхийвэл**
- a. Баривчлах ялаар солино*
 - b. Хорих ялаар солино*
 - c. Уг ялын хугацааг нэмнэ.*
- 17. Албадан ажил хийлгэх ял ногдуулж болохгүй хүмүүс /хамааралтайг ол/**
- a. 16 насанд хүрээгүй этгээд*
 - b. гурав хүртлэх насны хүүхэдтэй ганц бие эцэг*
 - c. эмэгтэйчүүд*
 - d. цэргийн жинхэнэ хугацаат алба хааж байгаа этгээд*
 - e. жирэмсэн эмэгтэй*

СЭДЭВ 3. ЯЛ НОГДУУЛАХ

Ял ногдуулах нийтлэг үндэслэл, зарчим Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял ногдуулахдаа **Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн хэм хэмжээнд чанд нийцүүлж, шударга ёс, эрх зүйн ухамсрыг удирдлага болгон тусгай ангад заасан төрөл, хэмжээний дотор ял ногдуулах** явдлыг нийтлэг үндэслэл болгодог. Ялыг Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан төрөл, хэмжээний дотор ногдуулах гэдэгт нь шүүх тодорхой гэмт хэрэгт ял ногдуулахдаа тухайн гэмт хэрэгт ногдуул ахаар заасан ялын төрөл, ялын доод бол он дээд хэмжээний хүрээнд сонгож хэрэглэх явдлыг ойлгоно.

Ял ногдуул ах зарчим гэдэг бол гэмт хэрэг үйлдсэн этгээдэд **шүүх ял ногдуулахад баримтлах үзэл баримтлал** юм. Ял ногдуулах нийтлэг зарчим нь ялын зорилгыг хэрэгжүүлэх хэрэгсэл болдог. Шүүх ял ногдуулахдаа *гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үлдсэн нөхцөл байдал, учруулсан хор уршгийн шинж чанар, хохирлын хэр хэмжээ, хариуцлагыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан үзэх* зарчмыг мөрдлөг болгоно.

Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар

Үйлдлийн чанарын шинжийг илэрхийлэх ба Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн ангилалд үндэслэгдэнэ. Өөрөөр хэлбэл гэмт хэргийг нийгмийн аюулын шинж чанараар нь хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэгт ангилдаг.

Гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээ

Үйлдлийн тооны шинжийг илэрхийлэх бөгөөд гэмт хэргийн сэдэлт, гэмт хэрэг үйлдсэн арга, нөхцөл байдал, гэмт хэргийн үе шат, учруулсан хор уршгийн байдал, гэмт хэрэгт хамтран оролцогчдын хэрэгт оролцсон байдал зэрэг үзүүлэлтээр хэмжигдэнэ.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал

Гэм хэрэг үйлдсэн этгээдийн сургалт, хөдөлмөрт хандах хандлага, хариуцлагаа ухамсарлах чадвар, зан төлөв, хөдөлмөрлөх чадвар, гэр бүлийн байдал, эрүүл мэнд, ялтай байдал зэргийг хамааруулан үзнэ. Түүнчлэн ялын төрөл, хэмжээг тогтооход согтууруулах болон мансууруулах бодис хэрэглэгдэг эсэх, гэр бүл, ажилдаа хэрхэн ханддаг, нийгмийн хэв журам зөрчиж байсан эсэхийг харгалзан үзэх ёстой.

Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх байдал

Гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал болон бусад нөхцлийг харгалзан ял ногдуулахад хөнгөрүүлж авч үзэж байгаа явдал юм. Шүүх ял ногдуулахдаа Эрүүгийн хуульд заасан хөнгөрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзнэ.



Эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх байдал

Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял ногдуулахад заавал харгалзан үзэхээр хуульд заасан нөхцөл байдал. Шүүх ял ногдуулахдаа Эрүүгийн хуулийн 56 дугаар зүйлд заасан дурдсан хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

Эрүүгийн хариуцлагыг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 55 дугаар зүйлд
хөнгөрүүлэх нөхцөл байдал дор дурдсан хөнгөрүүлэх нөхцөл байдлуудыг харгалзан үзэхээр заасан.

- **Тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас анх удаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдэх.** Эл хөнгөрүүлэх нөхцөл байдалд гурван шаардлага тавигдсан нь: 1) Тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг үйлдсэн; 2) анх удаа гэмт хэрэг үйлдсэн; 3) хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн байх явдал юм. Тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг үйлдсэн эсэхийг шүүх хэргийн нөхцөл байдал, хэрэгт авагдсан нотлох баримтыг үндэслэн шийдвэрлэнэ. Энэ ойлголтод субъект гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлыг буруугаар үнэлсэн, гэмт хэрэг бүлэглэн үйлдэх үйлдэх үед санамсаргүй байдлаар хамтран оролцогч болсон зэрэг нөхцөл байдлыг хамааруулж болох юм. Анх удаа гэмт хэрэг үйлдэх гэдэгт өмнө гэмт хэрэг үйлдэж байгаагүй этгээд гэмт хэрэг үйлдсэнийг болон өмнө гэмт хэрэг үйлдсэн боловч хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан, өмнө нь гэмт хэрэг үйлдсэн боловч өршөөл, уучлалаар, мөн хуульд заасан хугацаа өнгөрсөний улмаас ялгүй болсон этгээд гэмт хэрэг үйлдсэнийг ойлгоно. Хөнгөн, хүндэвтэр гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 17 зүйлд тодорхойлсон.
- **Гэмт хэргийн улмаас учирсан хор уршгийг зайлуулах.** Гэмт хэрэг үйлдсэн этгээд сайн дураараа гэмт хэргийн улмаас учрах боломжтой байсан хор уршгийг урьдчилан зайлуулсан, өөрөөр хэлбэл, заналхийлж байсан хор уршгийг бүрэн арилгасан эсхүл хор уршгийг багасгасан үйлдэл. Энэ үйлдэл нь гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзахаас ялгаатай. Гэмт хэрэгт бэлтгэх, завдах үедээ гэм буруутай этгээд үйлдлээ зогсоосоны гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзсанд тооцдог бол өгүүлэн буй хөнгөрүүлэх нөхцөл нь нэгэнт гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинжийг агуулсан үйлдэл хийгдсэний дараа учирч болох хор уршгийг арилгах буюу багасгахад чиглэсэн үйлдэлд хамаарна.
- **Гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо сайн дураараа нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгах.** Гэм хор учруулсан этгээд өөрийн эд хөрөнгөөр учруулсан материаллаг хохирол, бусад хохиролыг нөхөн төлсөн, хохиролыг арилгах бусад арга хэмжээг өөрийн санаачилгаар хэрэгжүүлэх явдал. Учруулсан хохиролоо нөхөн төлж байгаа нь гэмт хэргийн нийгмийн хор аюулыг багасгадаг тул хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцогдоно.
- **Хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэхэд автсан, эсхүл эд хөрөнгө, албан тушаалын болон өөр байдлаар эрхшээлд нь орсноос гэмт хэрэг үйлдэх.** Гэмт хэрэг үйлдэхгүй бол өөрийнх нь болон гэр бүлийн гишүүдийн амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулна гэж бодитой заналхийлсэний улмаас гэмт хэрэг үйлдэх явдал. Мөн албан тушаалын болон эд хөрөнгийн болон өөр бусад байдааар (ураг төрлийн болон гэр бүлийн харилцаа) бусдын эрхшээлд орсон этгээд тэрхүү байдалдаа захирагдан гэмт хэрэг үйлдэхийг ойлгоно.

- **Хохирогчийн хууль бус үйлдлээс болж санаа сэтгэл нь хүчтэй цочрон давчидсаны улмаас болон хохирогчийн хэт хайхрамжгүйгээс гэмт хэрэг үйлдэх.** Хохирогчид хүчээр дарлагдсан буюу хүндээр доромжлогдсон, эсхүл түүний хууль бус бусад үйлдлээс өөрт нь буюу ойр дотных нь хүмүүст хүнд хор уршиг учирсан, учирч болох байснаас санаа сэтгэл нь хүчтэй хямарсаны улмаас гэмт хэрэг үйлдсэн нь хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал болно. Гэхдээ харилцан зодоон үүсгэх, маргалдах зэрэг хоёр талын буруутай үйл ажиллагааны үед хийсэн хохирогчийн үйлдлийг дээрх нөхцөл байдалд хамааруулж үзэхгүй.
- **Өөрт нь болон гэр бүлийн гишүүнд нь, түүнчлэн бусад хүмүүст тохиолдсон хүнд нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг үйлдэх.** Амьдрах эх үүсвэргүй болсон, ажилгүй болсон, гэм буруутай этгээд өөрөө болон гэр бүлийн аль нэг гишүүн хүнд өвчнөөр өвчилсөн, амьдралын хүнд нөхцөлд байгаа зэрэг нөхцөл байдлыг хамааруулан үзнэ. Гэхдээ энэхүү нөхцөл байдал гэмт хэрэг үйлдэхэд гарцаагүй хүргэсэн байх ёстой. Жишээлбэл, өөрөө болон гэр бүлийн аль нэг гишүүн нь хүнд өвчнөөр өвчилсөний улмаас мансууруулах бодис хулгайлсан нь хөнгөрүүлэх нөхцөл байж болно. Харин ажилгүй болсон этгээд дээрх гэмт хэргийг үйлдвэл хариуцлагыг хөнгөрүүлэх нь зохисгүй юм.
- **Арван найман насанд хүрээгүй этгээд гэмт хэрэг үйлдэх.** 18 насанд хүрээгүй этгээд гэмт хэрэг үйлдэх явдал. Эл нөхцөл байдлыг хэрэглэхдээ мөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, оюун ухааны хөгжлийн төвшин зэргийг харгалзана.
- **Жирэмсэн буюу бага насны хүүхэдтэй эмэгтэй гэмт хэрэг үйлдэх.** Эл нөхцөл байдлын энэрэнгүй ёсны зарчмаас үүдэлтэй, хүүхэд болон эмэгтэйн эрүүл мэндийн төлөө зохицуулалт юм. Бага насны хүүхэд гэдэгт 7 хүртэл насны хүүхдийг ойлгоно. Үйлдсэн гэмт хэрэгтээ чин санаанаас гэмших буюу гэмт хэргээ сайн дураар илчилж ирэх. Үйлдсэн гэмт хэрэгтээ чин санаанаас гэмшсэн байдал нь гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн зан үйлийн бурууг ухамсарлаж түүнийгээ засах талаар бодитой үйлдэл хийсэн явдлаар илэрнэ. Гэмт хэрэгтэн үйлдсэн хэрэгтээ чин санаанаасаа гэмшиж буй эсэхийг тухайн этгээдийн зан төлөв, бие авч яваа байдлыг харгалзан шүүх шийдвэрлэнэ. Гэмт хэргээ сайн дураараа илчлэх гэж нь гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн санаачилгаар хууль сахиулах байгууллагад гэмт хэрэг үйлдсэн бол он гэмт хэрэгт бэлтгэж буйгаа хүлээн ирсэн байхыг хэлнэ. Хууль сахиулах байгууллага гэмт хэргийг шалгаж мөрдөх явцад сэрдэгдсэн этгээд анхны байцаалтаар хэргээ хүлээж байгаа нь гэмт хэргээ сайн дураараа илчилж байгаа хэрэг биш юм. Харин эл нөхцөл байдлыг үйлдсэн гэмт хэрэгтээ гэмшсэн явдал хэмээн үзэж болох юм.
- **Гэмт хэрэг болон гэмт хэрэг үйлдсэн этгээд, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг илрүүлэхэд идэвхтэй дэмжлэг үзүүлэх.** Үйлдсэн гэмт хэргийнхээ нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдэхэд хамтран үйлдэгчдийн болон өөрийн оролцсон байдал, гэмт хэргийн ул мөр, зэвсэг хэрэгсэл, гэмт хэргийн шалтгаан нөхцөл зэргийг тогтооход идэвхтэй дэмжлэг үзүүлэх нь эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал болно.

**Эрүүгийн
хариуцлагыг хүндрүүлэх
нөхцөл байдал**

Шүүх ял ногдуулахдаа Эрүүгийн хуульд заасан хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзнэ. Хуульд зааснаас бусад нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд ялыг хүндрүүлж болохгүй.



- **Гэмт хэрэг давтан үйлдэх.** Нэг буюу түүнээс дээш төрлийн гэмт хэргийг хоёр ба түүнээс дээш удаа үйлдэх явдал. Давтан үйлдэх гэдэгт урьд гэмт хэрэг үйлдээд ял шийтгүүлээгүй этгээд дахин гэмт хэрэг үйлдсэнийг болон гэмт хэрэг үйлдээд түүндээ ял шийтгүүлсэн боловч ялтай байх хугацаа нь дуусаагүй байхад дахин гэмт хэрэг үйлдэж буй явдлыг хамааруулан үзнэ.
- **Гэмт хэрэг бүлэглэж үйлдэх.** Хоёр буюу түүнээс дээш этгээд хамтран гүйцэтгэгчээр оролцож гэмт хэрэг үйлдэх явдал. Зөвхөн бүлэглэж үйлдэх төдийгүй аливаа хэлбэрээр гэмт хэргийг хамтран үйлдэх нь тухайн хэргийн нийгмийн хор аюулыг ихэсгэж байдаг учраас хариуцлагыг хүндрүүлж үзэх нөхцөл байдал болох ёстой. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 56 дугаар зүйлд зөвхөн бүлэглэж үйлдсэн гэмт хэрэгт хариуцлагыг хүндрүүлж үзэхээр заасан. Харин Тусгай ангийн тодорхой гэмт хэргийг гэмт хэргийг хамтран үйлдсэнийг хүндрүүлэх бүрэлдэхүүнд багтааж хуульчилсан.
- **Эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрээгүй этгээдийг гэмт хэрэгт татан оруулах, эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрээгүй, хэрэг хариуцах чадваргүй хүнээр гэмт хэрэг үйлдүүлэх.** Ятгах, сүрдүүлэх, хууран мэхлэх болон бусад аргаар насанд хүрээгүй этгээдэд нөлөөлж гэмт хэрэг үйлдүүлсэнийг насанд хүрээгүй этгээдийг гэмт хэрэгт татан оруулсан гэж үзнэ. Энэ үйлдлийн улмаас өсвөр үеийн зан суртахуунд ноцтой хор уршиг учирдаг учраас эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөлд тооцдог. Гэмт хэрэгт татан оруулж буй нь насанд хүрээгүй этгээдийг гэмт хэргийн гүйцэтгэгч болгож байгаагаар илэрнэ. Гэхдээ зөвхөн тодорхой гэмт үйлдэл хийх төдийгүй гэмт хэрэгт бэлтгэх, завдах үйл ажиллагаанд насанд хүрээгүй хүмүүсийг татан оролцуулж буй нь хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдалд мөн хамаарна. Насанд хүрээгүй этгээдийг гэмт хэрэгт татан оруулах нь насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах (ЭХ114) гэмт хэргээс ялгаатай. Хоёр буюу түүнээс дээш удаагийн үйлдээр нэг төрлийн гэмт үйлдэлд насанд хүрээгүй хүнийг татан оруулж буй нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бие даасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулна. Харин энэ үйлдлийг нэг удаа хийсэн нь эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдалд тооцогдоно. Хэрэг хариуцах чадваргүй хүнээр гэмт хэрэг үйлдүүлэх гэдэгт сэтгэцийн өвчтэй, мансуурах болон буюу согтуурах донгийн улмаас өөрийн үйлдлийг хариуцах чадваргүй этгээдээр гэмт хэрэг үйлдүүлэх явдлыг ойлгоно. Бусдаар дамжуулан гэмт санаа зорилгоо гүйцэлдүүлж байгаа нь эрүүгийн хариуцлагаас зайлсхийх зорилготой байдаг учраас хүндрүүлэх нөхцөл байдалд тооцогдоно.
- **Гэмт хэргийн улмаас хүнд хор уршиг учрах.** Эрүүгийн хуульд тухайн гэмт хэргийн улмаас учирч болох хор уршигын хэмжээг гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжид зааж өгөөгүй байтал тодорхой гэмт хэргийн улмаас бусдад хүнд хор уршиг учруулсан тохиолдолд энэхүү хүндрүүлэх нөхцөл байдлыг хэрэглэнэ. Тухайлбал, ЭХ 105 Дархлалын олдмол хомсдолын өвчин халдаах гэмт хэргийн улмаас олон (хоёр буюу түүнээс дээш тооны хүн) энэ өвчний халдвар авсан; 179 Нийтийн эмх замбраагүй байдал бий болгох гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон, эрүүл мэнд нь ноцтой сарнисан; 192 Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон зэрэг хүнд хор уршиг учирч болох юм. Гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирох, хүнд гэмтэх, байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах, онц чухал гэрээний үүрэг тасалдах зэрэг олон нөхцөл байдал хариуцлагыг

хүндрүүлэх үндэслэл болж болох ба шүүх үүсэж бий болсон нөхцөл байдлыг хүнд хор уршигт тооцох эсэхийг шийдвэрлэнэ. Энэхүү хүндрүүлэх нөхцөл байдал санаатай, болгоомжгүй гэмт хэргийн аль ч тохиолдолд үүсэж болох бөгөөд гагцхүү гэмт үйлдэл болон хор уршгийн хоорондын шалтгаант холбоо тогтоогдсон байх ёстой.

- **Гэмт хэргийг онц харгис хэрцгий аргаар буюу хохирогчийг тохуурхан даажигнаж үйлдэх.** Энэхүү хүндрүүлэх нөхцөл байдал үндсэндээ хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн үед үүсэх боловч дээрэмдэх, танхайрах, хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, мэдүүлэг өгөхийг албадах, хүнийг хууль бусаар баривчлах гэмт хэрэгт ч мөн илэрч болно. Онц харгис хэрцгий аргаар гэмт хэрэг үйлдэх гэдэгт хохирогчид бие махбодийн зовиуртай байдал үүсгэж буй үйлдлийг ойлгоно. Хохирогчийг тохуурхан даажигнаж гэмт хэрэг үйлдэх нь хохирогчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжлох, сэтгэл санааны зовиуртай байдал үүсгэж байгаа үйлдлээр илэрнэ.
- **Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эмэгтэй, бага насны хүүхэд, өндөр настан, биеэ хамгаалж чадахгүй хүн, түүнчлэн эдхөрөнгө, албан тушаалын болон өөр байдлаар эрхшээлдээ байсан хүний эсрэг гэмт хэрэг үйлдэх.** Хохирогчийн эрх ашгаа хамгаал ах чадваргүй байдл ыг ашигл ан гэмт хэрэг үйлдэж байгаа гэмт хэргийн зорилгоо гүйцэлдүүлэхэд хялбар замыг сонгож байгаа хэрэг учраас хүндрүүлэх нөхцөл байдалд тооцогдоно. Бага насны хүүхэд гэдэгт 14 хүртэлх насны хүүхдийг, өндөр настан гэдэгт 55 хүрсэн эмэгтэй, 60 хүрсэн эрэгтэй хүнийг, бие хамгаалж чадахгүй хүн гэдэгт сэтгэл мэдрэлийн өвчтэй, тахир дутуу, бие эрхтэний согогтой болон бусад өвчний улмаас бие хамгаалах чадваргүй болсон, согтуурсан буюу мансуурсан, мэдрэлийн үйл ажиллагаа нь түр сарнисан хүнийг тус тус ойлгоно.
- **Нийтэд учирсан гамшигт байдал, нийтэд хамарсан эмх замбараагүй байдлыг далимдуулан гэмт хэрэг үйлдэх.** Энэ нөхцөл байдал нь зарим төрлийн гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын хүндрүүлэх шинж болно. Гэмт этгээд гал түймэр, усны үер, газар хөдлөлт, хүчтэй шуурга, цас, зуд зэрэг байгалийн гамшиг тохиолдсон, түүнчлэн тахал болон гоц халдварт бусад өвчин дэлгэрсэн, хүчтэй дэлбэрэлт, үйлдвэрийн осол болсон зэрэг нөхцөл байдлын улмаас нийтийн анхаарал сарнисаныг ашиглаж гэмт хэрэг үйлдсэнийг хамааруулна.
- **Албаны үйл ажиллагаа буюу олон нийтийн үүргээ биелүүлж байгаа хүн, түүний ойрын төрөл садангийн хүний эсрэг гэмт хэргийг тэдний гүйцэтгэж байгаа үүрэгтэй нь холбогдуулан үйлдэх.** Эл үйлдэл нь төрийн албаны болон олон нийтийн үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг алдагдуулж байдаг тул хүндрүүлэх нөхцөл байдалд тооцогдоно.
- **Нийтэд аюултай аргаар гэмт хэрэг үйлдсэн буюу галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх үйлчилгээтэй галт хэрэгсэл, хорт бодис, эм бэлдмэл, химийн болон биологийн гаралтай бодис ашиглаж гэмт хэрэг үйлдэх.**
- **Согтуурсан буюу мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдэх.** Согтуурсан гэдэг нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэнээс хөөрлийн байдалд орсон, мансуурсан гэдэг нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бусад бодис хэрэглэсэнээс хөөрлийн байдал орох үйл явц юм. Согтуурсан буюу мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдэх нь тухайн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болох ёсгүй.



- **Өөр гэмт хэргийг нуун далдлах буюу үйлдэхэд хялбарчлах зорилгоор үйлдэх.** Гэмт хэрэг үйлдсэн, үйлдэхийг завдаж буй этгээд тэрхүү гэмт хэргийг илрүүлэхэд саад учруулах зорилгоор гэмт хэрэг үйлдэж буй нь (жишээлбэл, гэрчийг үнэн зөв мэдүүлэг өгүүлэхгүй байхын тулд айлган сүрдүүлэх, эд хөрөнгийг нь устгах, гэмт хэрэг үйлдэхэд нь саад учруулсан этгээдэд хохирол учруулах г.м) тухайн гэмт хэргийн нийгмийн аюулыг өсгөдөг тул хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдалд зүй ёсоор тооцогдоно.
- **Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан буюу ялыг тэнсэж хянан харгалзсан хугацаанд, эсхүл ялтай байхдаа гэмт хэрэг дахин үйлдэх.** Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан буюу ялыг тэнсэж хянан харгалзсан хугацаанд, эсхүл ялтай байхдаа гэмт хэрэг дахин үйлдэж буй нь тухайн этгээдэд авсан эрүүгийн хариуцлагын арга хэмжээг ухамсарлаагүй, гэм буруутай этгээд өөрийн үйлдэлдээ гэмшиж, засарч хүмүүжсэн байдалгүй байгааг илэрхийлдэг тул хүндрүүлэх нөхцөл байдалд тооцогдох ёстой.
- **Хариуцлагыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлыг хэрэглэхгүй тохиолдлууд.** Эрүүгийн хуулийн 55, 56 дугаар зүйлд заагдсан эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал нь зарим тохиолдолд тусгай ангид заагдсан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжид (үндсэн болон нэмэгдэл шинжид) багтсан байдаг. Жишээлбэл, гэмт хэрэг давтан үйлдэх, бүлэглэн үйлдэх г.м. Энэ тохиолдолд заагдсан нөхцөлд байдлыг тэрхүү тусгай ангийн гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжид тооцож зүйлчлэх бөгөөд ял ногдуулахдаа эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдал болгон давхардуулан хэрэглэхгүй.

Цагдан хоригдсон хугацаа Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээр хэрэг шийдвэрлэх хугацаа болон шүүхийн шийтгэх

тогтоолыг давж заалдах хүртэл хоригдож байсан хугацаанууд.

Шүүх цагдан хоригдсон хугацааг шүүгдэгчийн ял эдэлсэн хугацаанд оруулж тооцно. Гэхдээ гянданд ял эдлэх хугацаанд цагдан хоригдсон хугацааг оруулж тооцохгүй. Цагдан хоригдсон нэг хоногийг албадан ажил хийлгэх ялын хорин дөрвөн цагтай, баривчлах, хорих ялын нэг хоногтой тэнцүүлж ялын хугацаанд оруулж тооцно. Цагдан хоригдсон хугацаанд а) Баривчлагдсан хугацаа (72 цаг) б) Цагдан хоригдох таслан сэргийлэх арга хэмжээ авагдаж урьдчилан хоригдсон хугацаа. в) Цагдан хоригдож байхдаа эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хугацаа. г) Шүүхээс ял ногдуулсны дараа цагдан хорьсон хугацаа тус тус хамаарна. Сэжигтнийг цагдан хорьж мөрдөх хугацаа 14 хүртэл хоног яллагдагчийг хорьж мөрдөх хугацаа 2 сар хүртэл байна. Хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэргийн яллагдагчийг хэргийн төвөгтэй байдлыг харгалзан цаашид хорьж мөрдөх зайлшгүй шаардлагатай бол шүүх уг хугацааг сунгах боловч хорьж мөрдөх хугацаа 24 сараас хэтэрч болохгүй. Эрүүгийн хуулийн (Төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах), (Хорлон сүйтгэх), (Хүнийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар санаатай алах), (Хүндрүүлэхнөхцөл байдалтайгаар зандалчлах), (Төрлөөр устгах) зэрэг зүйлд заасан хэргийн яллагдагчийг Эрүүгийн хуульд зааснаас илүү хугацаагаар хорьж мөрдөх шаардлагатай бол шүүх 6 сар хүртэл хугацаагаар нэмж сунгаж болно. Цагдан хоригдсон этгээдэд торгох буюу тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг үндсэн ялын чанартай ногдуулсан бол цагдан хоригдсон хугацааг харгалзан шүүх уг ялыг хөнгөрүүлэх буюу ял эдэлсэнд тооцож болно.

**Хэд хэдэн гэмт хэрэгт ял
ногдуулах хэд хэдэн шийтгэх
тогтоолоор ял ногдуулах**

Хэд хэдэн гэмт хэрэг нь нийлмэл гэмт хэрэг юм. Эрүүгийн хуулийн тусгай ангийн өөр өөр зүйлд болон нэг зүйлийн тус бүрд нь ногдуулж болох өөр өөр хэсгүүдэд заасан хоёр, түүнээс дээш гэмт хэрэг үйлдсэн этгээд тэдгээрийн алинд нь ч ял шийтгүүлээгүй бол шүүх гэмт хэрэг тус бүрд нь ял ногдуулж, хөнгөн ялыг хүндэд нь багтаах, эсхүл хэрэг тус бүрт ногдуулсан ялыг хамгийн хүнд ялтай зүйлийн ялын дээд хэмжээний дотор бүгдийг буюу заримыг нэмж нэгтгэн уг этгээдийн биечлэн эдлэх ялыг тогтооно. Ялын хөнгөнийг хүндэд нь багтаах нь өөр өөр төрлийн ялуудын хувьд, ялыг нэмэх нь нэг төрлийн ялын хувьд яригдана. Шүүх гэм буруутай этгээдэд ял ногдуулахдаа энэ хуулийн тусгай ангийн зүйл, хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн нэмэгдэл ялыг үндсэн ялтай нь хамт ногдуулж болно. Ялтан шүүхээр ял шийтгүүлэхийн өмнө өөр гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн шийтгэх тогтоол гарсны дараа тогтоогдвол түүнд энэ зүйлд заасан журмыг баримтлан ял ногдуулна. Ингэж шийдвэрлэхдээ өмнөх шүүхийн шийтгэх тогтоолоор бүрэн буюу хагас эдэлсэн ялыг оруулан тоолно.

Шүүхийн шийтгэх тогтоол гарсны дараа буюу ногдуулсан ялыг бүрэн эдэлж дуусахын өмнө гэмт хэрэг шинээр үйлдэж шийтгүүлж байгаа бол шүүхийн сүүлчийн шийтгэх тогтоолоор ногдуулсан ял дээр өмнөх шүүхийн шийтгэх тогтоолоор ногдуулснаас эдлээгүй үлдсэн ялыг бүгдийг буюу заримыг нэмж нэгтгэн уг этгээдийн биечлэн эдлэх ялыг тогтооно. Хэд хэд шийтгэх тогтоолоор ял ногдуулахад ялыг нэмж нэгтгэх зарчмыг баримтлана. Эрүүгийн хуульд заасан журмаар ялыг хооронд нь нэмж нэгтгэхдээ биечлэн эдлэх ялын хугацааг тухайн төрлийн ялын Эрүүгийн хуулиар тогтоосон дээд хэмжээнээс хэтрүүлж болохгүй. Жишээлбэл, Хорих ялыг нэмсэн нийт хугацаа 15 жилээс, Эрүүгийн хуулийн тусгай ангид арван таван жилээс дээш хугацаагаар хорих ял ногдуулж болох гэмт хэрэгт нийт нэмсэн хугацаа нь 25 жилээс хэтэрч болохгүй. Албадан ажил хийлгэх, баривчлах ялыг хооронд нь нэмж нэгтгэхдээ албадан ажил хийлгэх ялын хорин дөрвөн цагийг баривчлах ялын нэг хоногтой тэнцүүлж тооцно. Албадан ажил хийлгэх, хорих ялыг хооронд нь нэмж нэгтгэхдээ албадан ажил хийлгэх ялын хорин дөрвөн цагийг хорих ялын нэг хоногтой тэнцүүлж тооцно. Баривчлах, хорих ялыг хооронд нь нэмж нэгтгэхдээ баривчлах ялын нэг хоногийг хорих ялын нэг хоногтой тэнцүүлж тооцно.

Ял тэнсэх Хүндэвтэр гэмт хэрэгт анх удаа хорих ял шийтгүүлсэн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан тохиолдолд түүнд ногдуулсан ялыг биечлэн эдлүүлэх шаардлагагүй гэж шүүх үзвэл уг ялыг тэнсэж, нэгээс таван жилийн хугацаагаар хянан харгалзахаар тогтоож болно. Тэнсэгдсэн ялтан шүүхээс тогтоосон хянан харгалзах хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдээгүй, засарч хүмүүжсэнээ харуулсан бол шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхгүй ялыг тэнсэнэ.

Хорих ялыг тэнсэх нь ялын төрөл бига харин уг ялыг биелүүлж байгаа онцгой журам юм. Ял тэнсэх гол үндэслэл нь гэмт хэргийн ангилал, нийгмийн хор аюулын шинж хэр хэмжээ, тухайн этгээдийн байдал, гэмт хэргийн улмаас учруулсан хохиролыг төлсөн, гэм хорыг арилгасан байдал, зэрэг байна. Тэнсэгдсэн ялтан шүүхээс тогтоосон хянан харгалзах хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдээгүй, засарч хүмүүжсэнээ харуулсан бол шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхгүй.

Засарч хүмүүжсэн гэдэгт хяналт тавьдаг байгууллагаас өгсөн үүрэг даалгаварыг 138



биелүүлсэн, ямар нэгэн захиргааны зөрчил гаргаж арга хэмжээ авагдаагүй байх зэргийг ойлгоно.

Ял тэнсэх нь ялын төрөл биш болох нь дараах шинжээр тайлбарлагдана. а) Эрүүгийн хуульд **ялын төрөл болон хуульчлаагүй** б) Зөвхөн хорих **ялыг тэнсдэг**. Бусад төрлийн ял тэнсэхгүй ийм учраас нийтлэг шинжтэй хэрэглэгдэхгүй в) Шүүхээс тогтоосон **хянан харгалзах хугацаа дуусахад мөн ялгүй** болно. Ялыг биечлэн эдэлсэн тохиолдолд хуульд заасан тодорхой хугацаанд ялтай байдал гэсэн хууль зүйн үр дагавар бий болдог. г) Хянан харгалзах хугацаанд **ялтны эрхийг ямар нэг байдлаар хязгаарладаггүй**. Хорих ял тэнсэх журмыг ялтай байгаа этгээдэд хэрэглэхгүй. Тэнсэгдсэн ялтан хянан харгалзах хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд Эрүүгийн хуульд заасан журмыг баримтлан ял ногдуулна.

Ял тэнсэх гол үндэслэл нь гэмт хэргийн ангилал, нийгмийн хор аюулын шинж хэр хэмжээ, тухайн этгээдийн байдал, гэмт хэргийн улмаас учруулсан хохиролыг төлсөн, гэм хорыг арилгасан байдал, зэрэг байна. Энэ журмыг хүнд болон онц хүнд гэмт хэрэгт хорих ял шийтгүүлсэн этгээдэд хэрэглэхгүй. Мөн давтан болон ялтай байх хугацаандаа гэмт хэрэг үйлдсэн этгээдийн ялыг тэнсэхгүй.

Ял хойшлуулах Одоо дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулиар насанд хүрээгүй этгээдэд ногдуулсан хорих ялыг болон жирэмсэн эх, ганц бие эцэгт ногдуулсан хорих ялыг хойшлуулах журам үйлчилж байна.

- **Насанд хүрээгүй этгээдэд хорих ял ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах.** Анх удаа гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан түүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр хүмүүжүүлэх боломжтой гэж шүүх үзвэл хорих ял ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Ийм тогтоол гаргасан үед нэмэгдэл ял биелүүлэхийг нэгэн адил хойшлуулна. Шүүх шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа тодорхой хугацаанд ажил, сургуульд орох, учруулсан хохирлоо нөхөн төлөх, гэм хорыг арилгах, ажлын газар, сургуулиа өөрчилсөн тухайгаа оршин суугаа газрынхаа цагдаагийн байгууллагад мэдэгдэж байх зэрэг түүний засрал хүмүүжилд дөхөм үзүүлэх үүргийг даалгаж, түүнийг хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэх үүргийг тодорхой хамт олон буюу төрийн бус байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садангийн хүн, тодорхой иргэнд тэдний хүссэнээр буюу зөвшөөрснөөр хариуцуулж болно. Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан этгээд шүүхээс тогтоосон хугацаанд даалгасан үүрэг биелүүлээгүй буюу захиргааны шийтгэл хүлээсэн бол шүүгч цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хорих ял ногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай захирамж гаргана. Хорих ял хойшлуулсан хугацаанд уг этгээд засарч хүмүүжсэнээ харуулсан бол цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн шүүх түүнийг ялаас чөлөөлж болно. Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд Эрүүгийн хуулийн зохих зүйлд заасан журмыг баримтлан ял ногдуулна.

- **Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэгт хорих ял ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах.** Шүүх анх удаа хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн жирэмсэн эмэгтэй, түүнчлэн гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэгт хорих ял ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Ганц бие эцэг гэдэгт гурав хүртэлх насны хүүхэдтэй, хүүхэд нь түүний шууд асрамжинд байдаг өрх толгойлсон хүнийг хэлнэ. Ялтан хүүхдээ асарч хүмүүжүүлэхээс зайлсхийсэн бол шүүх цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хорих ял ногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шүүгч захирамж гаргана. Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд Эрүүгийн хуулийн зохих зүйлд зааснаар ял ногдуулна.



Хяналтын асуулт

1. Шүүхийн ял ногдуулах ажиллагаа болон түүнд баримтлах нийтлэг зарчим гэж юу вэ?
2. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал гэдэгт юуг хамааруулан ойлгох вэ?
3. Тэнсэх ял мөн үү эсхүл?
4. Шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулах ямар журам, үндэслэлийг баримтлах вэ?



Сорил

1. **Шүүхээс ял оногдуулах нийтлэг зарчим (хамааралтайг ол):**
 - a. Гэмт хэргийн нийгмийн аюулын ийнж чанар, хэр хэмжээ
 - b. Хууль шүүхийн өтнө эрх тэгши байх
 - c. Хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал
 - d. Энэрэнгүй ёс
2. **Шүүхээс ял оногдуулахдаа дараах нөхцөл байдлыг харгалзана**
 - a. Гэмт хэргийн нийгмийн аюулын ийнж чанар, хэр хэмжээ
 - b. УДШ-ийн тайлбар
 - c. Яллах болон өмгөөлөх байдал
 - d. Гэмт хэргийн зүйлчлэл
3. **Ял хөнгөрүүлэхэд хамаарахгүй нөхцөл байдал**
 - a. Жирэмсэн эмэгтэй гэмт хэрэг үйлдсэн
 - b. Арван найман насанд хүрээгүй этгээд гэмт хэрэг үйлдсэн
 - c. Тэтгэвэрийн насны хүн гэмт хэрэг үйлдсэн
 - d. Хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэхэд автаж гэмт хэрэг үйлдсэн



4. Шүүх хуульд зааснаас хөнгөн ял оногдуулж болох уу?
 - a. Болно
 - b. Болохгүй
 - c. Шүүгч үзэмжээрээ иийднэ
5. Ял тэнсэхийг:
 - a. Бүх төрлийн ялд хэрэглэнэ
 - b. Зөвхөн хорих ялд хэрэглэнэ
 - c. Баривчлах, Албадан ажил хийлгэх болон хорих ялд хэрэглэнэ
6. Хуульд заагаагүй хүндрүүлэх нөхцөл байдлаар шүүх ялыг хүндрүүлэх эрхтэй:
 - a. Тийм
 - b. Үгүй
 - c. Шүүх үзэмжээрээр шийдвэрлэнэ
7. Хуульд заагаагүйхөнгөрүүлэх нөхцөл байдлаар шүүх ялхөнгөрүүлэх эрхтэй:
 - a. Тийм
 - b. Үгүй
 - c. Шүүх үзэмжээрээ иийдвэрлэнэ
8. Ялаас хугацаанаас нь өмнө тэнсэн суллахад эдгээр шинжийн чухам алинд илүү ач холбогдол өгөх вэ?
 - a. Ялыг хуульд заасан хугацаанд эдэлсэн
 - b. Засарч хүмүүжсэнээ харуулсан
 - c. Ял эдлэх байхдаа дахин гэмт хэрэг үйлдээгүй
9. Ялыг тэнсэх нь:
 - a. Ялын онцгой төрөл
 - b. Ялаас чөлөөлж байгаа хэлбэр
 - c. Ялыг биелүүлж байгаа хэлбэр
 - d. Шүүхийн шийтгэх тогтоолыг хойшлуулж байгаа хэлбэр
10. Тэнсэгдсэн ялтанд нэмэгдэл ялыг хэрэглэж:
 - a. Болно
 - b. Үндсэн ялыг тэнссэн учир нэмэгдэл ял нь үндсэн ялдаа багтаж тэнсэгдэнэ
 - c. Энэ тухай хуульд заагаагүй учир шүүх шийднэ
11. Гянданд ял эдлэх хугацаанд цагдан хоригдсон хугацаа орж
 - a. Тооцогдоно
 - b. Тооцогдохгүй
12. Цагдан хоригдсон нэг хоногийг албадан ажил хийлгэх ялтай хэрхэн тэнцүүлж тооцох вэ?
 - a. 24 цагтай
 - b. 48 цагтай
 - a. 72 цагтай

ДАСГАЛ 1. ЯЛ НОГДУУЛАХ ЖУРАМ

(Тохиолдол шинжлэх)

- Тохиолдол 1. 2005 оны 6 сарын 2 ний өглөө нэг ангийн найзууд болох Н, Ш нар тааралдан удаан уулзалдсангүй гээд иргэн Б-гийн хашааны гадна талын нийтийн сандал тухлан сууж ярилцаж байтал Б-ийн эхнэр 10 сартай хүүхэдтэй С гарч тэднийг хашааных гаднаас холдохыг шаардаж хэл амаар доромжилж улмаар Ш-ийн толгой тус газар цохиод авчээ. Харин үүнд эгдүүцсэн Ш түүнийг (С) түлхэж газар унагахад С хүндэвтэр гэмтэл авчээ. С цагдаад мэдүүлэхдээ: Би 3 сартай жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй тул Ш-ийн энэ үйлдэлд сэтгэл санаа ихэд цочирдон хоол ундаа сайн идэж чадахгүй, баруун хөл хугарсан тул явж чадахгүй байна гэжээ. Харин Ш энэ хэрэгтээ ихэд гэмшиж байна гээд С-н хөхүүл хүүхэдтэй болон жирэмсэн гэдгийг мэдэхгүй байсан ба хэрэв мэдсэн бол би С -г түлхэхгүй байсан гээд хохирогч түүнийг доромжилж цохиж авахад нь уурлаж түлхсэнээс болсон гэжээ. Ш нь урьд өмнө ямар нэгэн эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй, нэгэн барилгын газарт ажилладаг, ар гэртээ хөгшин эх, 2 - 6 насны 4 хүүхдийн хамт амьдардаг болно.
- Тохиолдол 2. 2003 оны 8-р сарын Замын-Үүд хотод оршин суудаг насанд хүрээгүй Р гэгч нь эхийгээ зоддоо гэж хойд эцэг С-тэй муудалцаж түүнийг согтуу байхад нь санаатай алсан гэмт хэрэг үйлджээ. Р нь хохирогч С-ийн толгой руу нь архины шилээр цохиж ухаан алдсаных нь дараа хайчаар хэвлий цээж руу нь арав гаруй удаа дүрж амь насыг нь хохироосон. Гэмт хэрэг үйлдэх үед Р нь 17 нас 8 сартай байсан. Р-д холбогдох хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91-р зүйлийн 91.2-т заасан хэд хэдэн хүндрүүлэх нөхцлөөр зүйлчилж 2004 оны 2-р сард шүүх хурлаар хянан шийдвэрлэсэн. Хэрэг шүүхээр шийдэгдэхэд шүүгдэгч Р 18 насанд хүрсэн байсан бөгөөд шүүх түүнд 15 жилийн хорих ял оногдуулсан Р-ийг ялаа эдлэж байхад нь 2003 оны 6 сард бусадтай хамтран бусдад их хэмжээний хохирол учруулсан хулгайн гэмт хэрэг мөн хятадын иргэн А-ийн 3000 юаныг О гэгчтэй хамтран дээрэмдсэн гэмт хэрэг нь тус тус илэрчээ.
- Тохиолдол 3. Эрхэлсэн ажил сургуульгүй Р, Н, Г нар нь 1 жилийн хугацаанд арав гаруй удаагийн үйлдлээр бусдын 10 сая гаруй төгрөгний эд зүйл хулгайлсан мөн хэд хэдэн удаа бусдын эд хөрөнгийг дээрэмдсэн гэмт хэргүүдийг үйлджээ. Дээрх этгээдүүд нь гэмт хэрэг үйлдэх үедээ бүгд насанд хүрээгүй байсан ба шүүхээр хэргийг шийдэх үед тэд 18 насанд хүрсэн байжээ. Шүүх Р, Н, Г нарт холбогдох хэргийг шийдвэрлэж тус бүрт нь 17 жилийн хорих ял оногдуулж, бүгдийг чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлэхээр тогтоосон.



- Тохиолдол 4. Л гэгч нь 2003 оны 11 сард иргэн Х-ийн эд зүйлийг дээрэмдсэн гэмт хэрэг үйлдсэн байна. Энэ хэрэгт шалгагдан цагдан хоригдож байхдаа нэг камерт хамт байсан Ч-г зодож хүнд гэмтэл учруулсан гэмт хэрэгт шүүхээр ял шийтгүүлсэн. Шүүх Л-д ял оногдуулахдаа ЭХ-ийн тусгай ангийн 96-р зүйлийн 96.1, 147-р зүйлийн 147.1, ерөнхий ангийн 57-р зүйлийн 57.1-ийг журамлан хэрэг тус бүрд нь дээрх гэмт хэргүүдийн хорих ялын хамгийн доод хугацаа болох 5 жил нэг хоногийн ял оногдуулж нийт ялыг нэмж жинхэнэ эдлүүлэх ялыг тогтоожээ.
- Тохиолдол 5. Төрийн өмчит компанид орлогын нягтлан бодогчоор ажиллаж байсан 3 нь байгууллагаас их хэмжээний бэлэн мөнгө гаргаж танил хүмүүстээ өгч тэднээр ОХУ-аас өөрийн байгууллагад хэрэглэгддэг бараа материалыг хямд үнээр захиж авчруулан өөрийн компаний харъяа засварын газруудад 2-3 дахин илүү үнээр зарж байгууллагад 20 гаруй сая төгрөгний хохирол учруулсан гэмт хэрэгтээ 3 жилийн хорих ялаар шийтгүүсэн. 3-г ялаа эдлээд хагас жил орчим болж байхад түүний шийтгүүлэхээсээ өмнө үйлдсэн залилангийн болон мөн эрх мэдлээ урвуулж байгууллагын мөнгөнөөс 2 сая гаруй төгрөг завшсан гэмт хэрэг нь илэрчээ.
- Тохиолдол 6. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон хурд хэтрүүлэн явсан Ж гэгч нь зам хөнддөн гарч явж байсан иргэн Ц-г мөргөж биед нь хөнгөн гэмтэл учруулсан гэмт хэрэг үйлджээ. Шүүх хуралд оролцсон хохирогч Ц мэдүүлэхдээ Ж нь намайг мөргөж гэмтэл учруулснаас би эмнэлэгт 14 хоног хэвтэж эмчлүүлсэн. Тэрээр надад нэг ч төгрөг өгөөгүй би өөрөө ч түүнээс нэхмжлээгүй. Эмчилгээний зардалд надаас 100 гаруй мянган төгрөг гарсан. Гэхдээ дээрх зардлыг Ж-ээс авахгүй ямар нэг санал гомдолгүй гэжээ. Хэрэв Ж-ийн үйлдсэн гэмт хэрэг нь зөвхөн хорих ялтай бол шүүх Ж-г төлөх төлбөргүй гэж ялыг нь тэнссэн?

СЭДЭВ 4. ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГЫН БУСАД АРГА ХЭМЖЭЭ

Тодорхойлолт, төрөл Ерөнхий утгаараа эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ гэдэгт эрүүгийн хэрэг үүсгэсэн цагаас эхлүүлэн эрүүгийн эрх зүйн үр дагавар бүхий нөлөөлөл дуусах хүртэлх үед авагдах ялын бус бүх арга хэмжээг хамааруулан ойлгож болно. Энэ утгаараа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд авагдах таслан сэргийлэх арга хэмжээ, ял тэнсэх, ялтайд тооцох зэрэг арга хэмжээг эрүүгийн хариуцлагад тооцож болно. Харин Эрүүгийн хуульд зөвхөн хоёр төрлийн албадлагын арга хэмжээг бусад гэдэгт хамааруулан хуульчилсан. Энэ эрүүгийн хуулинд заасан хэрэг үйлдсэн боловч хэрэг хариуцах чадваргүй болон хуулинд заасан насанд хүрээгүй этгээдэд хэрэглэж буй албадлагын арга хэмжээ юм. Эдгээрийг **эмнэлэгийн чанартай** албадлагын арга хэмжээ ба **хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ** хэмээн нэрлэдэг.



Эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээ

Сэтгэл мэдрэлийн өвчнөөр өвчилж өөрийн үйлдлийг хариуцаж буюу жолоодож чадахгүй байх үедээ нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэрэг үйлдэх үедээ эрүүл байсан боловч **шийтгэх тогтоол гарахын өмнө буюу ял эдлэж байх үедээ сэтгэл мэдрэлийн өвчнөөр өвчилж**, өөрийн үйлдлийг ухамсарл ан ойлгож чадахгүй болсон, **өөрийн үйлдлийг ухаан санаагаараа удирдаж чадахгүй болсон, түүнчлэн архаг архичин болон мансуурах донтой этгээдэд эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.** Тухайн этгээдийн сэтгэцийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан албадлагын арга хэмжээний төрлийг сонгоно. Эмнэлэгийн чанартай албадаагын арга хэмжээг Сэтгэцийн, эмгэг судлалийн ердийн эмнэлэг; Сэтгэцийн, эмгэг суддалын тусгай эмнэлэгт хэрэглэнэ. Гэмт хэрэг үйлдсэн архаг архичин, мансуурах донтой этгээдэд шүүхээс ял ногдуулахын зэрэгцээ эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

- **Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ ногдуулах, өөрчлөх, зогсоох.** Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ ногдуулах шаардлагатай гэж шүүх үзвэл тухайн этгээдийн сэтгэцийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан албадлагын арга



хэмжээний төрлийг тогтооно. Сэтгэцийн эмгэг судлалын ердийн эмнэлэгт байлгах арга хэмжээг сэтгэцийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан сэтгэцийн эмнэлэгт байлгаж, албадан журмаар эмчлэх шаардлагатай этгээдэд хэрэглэж болно. Сэтгэцийн эмгэг судлалын тусгай эмнэлэгт эмчлүүлэх арга хэмжээг сэтгэцийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан нийгэмд онц аюултай этгээдэд хэрэглэж болно. Тусгай эмнэлэгт байлгаж байгаа этгээдийг нийгэмд аюултай гэмт хэрэг шинээр үйлдэх боломжгүй, хүч нэмэгдүүлсэн хяналтын нөхцөлд байлгана. Шүүх эмчилж байгаа байгууллагын дүгнэлтээр эдгэрсэн буюу өвчний шинж байдал өөрчлөгдсөний улмаас уг этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг цаашид хэрэглэхийг зогсоохоор шийдвэрлэнэ. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрлийг эмчилж байгаа байгууллагын дүгнэлтээр шүүх өөрчилж болно. Шүүх уг этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагагүй гэж үзсэн, мөн тийм арга хэмжээ хэрэглэхийг зогсоосон бол уг этгээдийг эмчийн хяналтад заавал байлгахаар төрөл, садангийн нь хүнд, эсхүл асран хамгаалагчид нь шилжүүлж болно.

- **Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн хугацааг тооцох.** Гэмт хэрэг үйлдсэний дараа буюу ял эдлэж байх үедээ сэтгэцийн өвчтэй болсон, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, эсхүл өөр бусад хүнд өвчний улмаас сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн хор аюулын шинж чанарыг ухамсарлах буюу үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадваргүй болсон этгээдэд уг өвчнийг эдгэрсний дараа хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй буюу эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх бусад үндэслэл байхгүй бол шүүх түүнд ял ногдуулж болно. Өвчин нь эдгэрсний дараа ял ногдуулсан этгээдийн ялын хугацаанд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн хугацааг оруулж тооцно.
- **Архаг архичин буюу мансуурах донтой этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, тэдэнд харгалзан дэмжигч тогтоох.** Архаг архичин буюу мансуурах донтой этгээд гэмт хэрэг үйлдсэн бол эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн шүүх уг этгээдэд үйлдсэн гэмт хэрэгт нь ял ногдуулахын зэрэгцээ эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно. Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн архаг архичин буюу мансуурах донтой этгээдэд шаардлагатай гэж шүүх үзвэл эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно. Хорих ял шийтгүүлсэн архаг архичин буюу мансуурах донтой этгээдийг ял эдлэх хугацаанд нь шаардлагатай гэж үзвэл албадан эмчилж болно. Албадан эмчилгээг уг этгээдийг эмчилж байгаа байгууллагын саналыг үндэслэн шүүх зогсооно. Согтууруулах ундаа буюу мансууруулах зүйл хэрэглэж, гэр бүлээ эд хөрөнгийн хүнд байдалд оруулсан этгээд гэмт хэрэг үйлдсэн буюу уг гэмт хэрэгт нь шүүх хорихоос өөр төрлийн ял ногдуулбал түүний гэр бүлийн гишүүд, төрийн бус байгууллага, асран хамгаалагч, харгалзан дэмжигч буюу эрүүл мэндийн байгууллагын хүсэлтээр түүний эрх зүйн чадамжийг хязгаарлах эрхтэй бөгөөд шүүхийн шийтгэх тогтоолыг үндэслэн уг этгээдэд харгалзан дэмжигч тогтооно.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ Хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн насанд хүрээгүй этгээдэд ял ногдуулахгүй байх нь зохистой гэж шүүх үзвэл хүмүүжлийн чанартай албадлагын арга

хэмжээ ногдуулж болно: Үүнд: зургаан сараас нэг жил хүртэл хугацаа тогтоож засарч хүмүүжихийг даалгах; арван зургаан насанд хүрсэн этгээд бие дааж орлого олдог бол хохирлыг өөрийн хөдөлмөрөөр арилгах үүрэг хүлээлгэх; эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садангийн хүний хяналтад өгөх; хамт олон буюу төрийн бус байгууллага, түүнчлэн тодорхой иргэний хяналтад байлгах аар тэдний хүссэнээр буюу зөвшөөрснөөр шилжүүлэх, шаардлагатай гэж үзвэл хүмүүжүүлэгч томилох. Насанд хүрээгүй этгээд Эрүүгийн хуульд заасан арга хэмжээ авагдсаны дараа засарч хүмүүжихгүй байвал шүүх уг арга хэмжээг насанд хүрээгүй хүмүүсийн сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад явуулах арга хэмжээгээр сольж болно. Уг этгээдийг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад явуулах хугацааг уг этгээдийн зан төлөв, ахуй амьдралын байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан шүүхээс тухай бүр тогтоох эрхтэй боловч арван зургаан наснаас хэтрүүлж болохгүй. Насанд хүрээгүй этгээдийг тогтоосон хугацааны өмнө сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагаас чөлөөлөх асуудлыг тухайн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.



Сорил

1. Эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээ нь:

- a. Зөвхөн хууль зүйн арга хэмжээ*
- b. Зөвхөн эмнэлэгийн шинжтэй арга хэмжээ*
- c. Эрүүгийн хариуцлагын арга хэмжээ*
- d. Эмнэлэг, хууль зүйн шинжтэй арга хэмжээ*
- e. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ*

2. Дараах этгээдэд эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэж болно:

- a. Хэрэг хариуцах чадваргүй, захирааны зөрчил гаргасан этгээдэд*
- b. Эрүүгийн ял эдэлсэний дараа сэтгэцийн өвчин туссан этгээдэд*
- c. Сөгтуурсан буюу мансуурсан байдалтай үедээ гэмт хэрэг үйлдсэн этгээдэд*
- d. Архаг архичин буюу тансуурах донтой этгээд гэмт хэрэг үйлдсэн бол*

3. Хэрэг хариуцах чадваргүй, Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээг:

- a. Бүх тохиолдолд хэрэглэнэ*
- b. Зөвхөн хүнд гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хэрэглэнэ*
- c. Хэрэг хариуцах чадваргүй байдал нь өөр бусад хүнд хор уршиг учруулахаар байвал хэрэглэнэ*



4. **Эрүүгийн хуулин дахь насанд хүрээгүй хүн нь:**
- a. 8 нас хүрээгүй хүн
 - b. 18 нас хүрээгүй хүн
 - c. 14-16 насны хүн
 - d. 16 -18 насны хүн
5. **Хэрэв тухай этгээдийн төрсөн өдрийг тогтоох боломжгүй байвал ямар өдрөөр тооцох вэ?**
- a. Тухайн оны 1 сарын 1-ны өдрөөр
 - b. Тухайн оны 12 сарын 1-ны өдрөөр
 - c. Дараа оны 1 сарын 1-ны өдрөөр
 - d. Тухайн оны 12 сарын 31-ны өдрөөр
 - e. Тухай оны 6 сарын 1-ны өдрөөр
6. **Дараах төрлийн ялыг насанд хүрээгүй хүмүүст хэрэглэхгүй**
- a. Хорих
 - b. Баривчлах
 - c. Албадан ажил хийлгэх
 - d. Торгох
 - e. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах
7. **Насанд хүрээгүй этгээдэд хэрэглэх хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ нь**
- a. Ялын төрөл
 - b. Эрүүгийн хариуцлагын төрөл
 - c. Нэмэгдэл ял
 - d. Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх хэлбэр

СЭДЭВ 5. ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА, ЯЛААС ЧӨЛӨӨЛӨХ

Эрүүгийн хариуцлага болон ялаас чөлөөлөх үндэслэл

Ердийн журмаар эрүүгийн хариуцлага нь ял болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг ногдуулах, хэрэглэх арга хэмжээний нэгдэл юм. Гэвч нийгмийн шударга ёсыг сэргээн тогтоох, зөрчигдсөн эрхийг сэргээх, ерөнхий болон тусгай урьдчилан сэргийлэх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд энэхүү журмаасаа гажих шаардлагатай болдог. Гэмт хэрэг үйлдэгдсэн боловч нийгэмд учруулсан хор уршиг нь ялимгүй байх, эсхүл нэгэнт үйлдсэн гэмт хэргийн нийгмийн учир холбогдол ноцтой биш болсон, гэмт хэрэг үйлдсэн этгээд засарч хүмүүжсэн, бусдад учирсан хохиролоо нөхөн төлсөн, зэргээс тэдэнд ял, эрүүгийн хариуцлагын арга хэмжээг зайлшгүй хэрэглэх шаардлагагүй болсон зэрэг болон бусад шалтгаанууд эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх үндэслэл болдог.

Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх арга хэмжээг эрүүгийн хэрэг үүсгэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд буюу шүүхийн шийтгэх тогтоол гарахын өмнө авдаг бол ялаас чөлөөлөх нь шүүхийн шийдвэр гарсаны дараа авагдах арга хэмжээ байдаг.

Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх төрлүүд

Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх гэдэг нь гэмт хэргийг нийгмийн аюулын хэр хэмжээ болон гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдлыг харгалзан түүнд хуульд заасан үндэслэлийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байхыг хэлнэ.

Эрүүгийн хариуцлагаас чөлөөлж байгаа үндэслэл нь **сонгох** болон **заавал чөлөөлөх** гэсэн хоёр төрөлтэй.

Эрүүгийн хариуцлагаас заавал чөлөөлөх үндэслэл нь шүүхээс үл хамааран бий болдог бөгөөд Монгол Улсын Эрүүгийн хуульд **хөөн хэлэлцэх хугацаа** буюу **эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа өнгөрсөн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас заавал чөлөөлөхөөр** заасан.

Доор дурдсан хугацаа өнгөрсөн бол гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй.

Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн
Хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн
Онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш гучин жил өнгөрсөн
Хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн





Анхаарах зүйл

Гэмт хэрэг үйлдсэн этгээд Эрүүгийн хуульд заасан хугацаа өнгөрөөгүй байхад гэмт хэрэг давтан үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасрах бөгөөд энэ тохиолдолд уг хугацааг сүүлчийн хамгийн хүнд гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тоолно.

Шүүхийн өмнөх шат болон шүүхийн шатнаас гэмт хэрэг үйлдсэн этгээд оргон зайлсан бол хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг оргон зайлсан өдрөөс зогсоож уг этгээд баригдсан буюу хэргээ өөрөө илчилж ирсэн өдрөөс хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолно.

Эрүүгийн хуульд зааснаар цаазаар авах ял шийтгүүлж болох гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв шүүх тухайн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрвэл цаазаар авах ял ногдуулж болохгүй бөгөөд уг ялын оронд хорих ял ногдуулна.

Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй.

Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэлийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх өөрийн дотоод итгэлдээ тулгуурлан шийдвэрлэнэ. Эрүүгийн хуульд зааснаар

- Үйлдсэн гэмт хэргээ илчилж ирсэн;
- Хохирогчтой эвлэрсэн;
- Цаг үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болохоор заасан. Эдгээрээс гадна Тусгай ангид заасан тодорхой үндэслэлүүдээр (ЭХ 108, 112, 177, 185, 258, 269, 270) эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

Үйлдсэн гэмт хэргээ илчилж ирсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх. Хэдийгээр үйлдсэн гэмт хэргээ сайн дураараа илчилж ирэх нь хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцогддог боловч а) хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн; б) учруулсан хохирлоо бүрэн төлсөн; в) гэм хорыг арилгасан тохиолдолд гэмт хэргээ илчилж ирсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас бүрэн чөлөөлөх үндэслэл болгосон. Хэргээ илчлэн ирэх нь 1) сайн дураараа хууль сахиулах байгууллагад гэмт хэргээ хүлээсэн; 2) бэлтгэсэн буюу үйлдсэн гэмт хэргийнхээ талаар үнэн зөв мэдүүлсэн байдлаар илэрнэ.

Хохирогчтой эвлэрсэн үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх. Хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн гэм буруутай этгээд хохирогчтой сайн дураараа эвлэрсэн бөгөөд учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болно.

Цаг үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй холбоотойгоор эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх. Хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хэргийг шүүхээр хянан хэлэлцэх үед цаг үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас гэмт

хэргийн шинжийг агуулсан үйлдэл нийгэмд аюултай шинж чанараа алдсан буюу уг этгээд нийгэмд аюулгүй болсон нь тогтоогдвол шүүх эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно. Цаг үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөн гэдэг нь шүүхээр хэргийг хянан хэлэлцэх үед тухайн хэрэг гэмт хэргийн шинж чанараа алдсан ,уг хэргийг үйлдсэн этгээд нийгэмд аюулгүй болсон, тухайн улсад гарсан нийгэм ,улс төр, эдийн засгийн өөрчлөлт гарсныг хамааруулна. Ийм өөрчлөлт нь агуулга, шинж чанар, хамрах хүрээгээрээ тухайн үйлдэл, эс үйлдлийг гэмт хэрэгт тооцох, тухайн этгээдийг эрүүгийн хариуцлагад татах нь эрүүгийн хуулийн зорилт зарчим, гэмт хэргийн ойлголт, ялын зорилгод нийцэхгүйд хүрсэн нөхцөл байдал хамаарна. Хэрэг нийгэмд аюултай шинж чанараа алдсан гэдэг нь хэрэг үйлдэх үеийн нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөнөөр тухайн үйлдэл, эс үйлдэл эрүүгийн хуулийн тусгай ангид гэмт хэрэгт тооцогдсон хэвээр боловч бодит байдалдаа гэмт хэргийн бусад шинж чанараа алдсаныг ойлгоно. Энэ нь эрүүгийн хуульд холбогдох өөрчлөлт орсны дараа гэмт хэрэгт тооцогдохоо больсон зэрэгтэй дүйцэхээр нөхцөл байдлууд орно. Уг этгээд нийгэмд аюулгүй болсон гэдэг нь гэмт хэрэг үйлдсэнээс хойш хэргийг шүүхээр хэлэлцэх хүртэл хугацаанд цаг үеийн байдал дээр дурьдсанаар өөрчлөгдсөнөөс гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд нийгэмд аюулгүй болсныг ойлгоно.

Ялаас чөлөөлөх Гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдийн ялыг эдлүүлэхээс татгалзсан шийдвэр гаргаж байгааг ялаас чөлөөлөх гэнэ. Эрүүгийн хуульд дараах төрлийн ялаас чөлөөлөх үндэслэлүүдийг хуульчилсан.

Үүнд:

- **Хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах.** Хорих ял шийтгүүлсэн ялтан засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулж, гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлсөн, гэм хорыг арилгасан бол түүнийг шүүх ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллаж болно. Шүүх ялтанг хугацаанаас нь өмнө тэнсэн суллахдаа эдлээгүй үлдэж байгаа ялын хугацаатай тэнцүү хянан харгалзах хугацаа тогтоож, түүнд Эрүүгийн хуульд заасан тодорхой үүрэг хүлээлгэж болно. Ялтан оногдсон ялынхаа дор дурдсан хувийг эдэлсэн тохиолдолд Эрүүгийн хуулийн зохих зүйлд заасан журмыг хэрэглэнэ: хүндэвтэр гэмт хэрэгт ногдуулсан хорих ялын хоёрны нэгээс доошгүй хувийг; хүнд гэмт хэрэгт ногдуулсан хорих ялын гуравны хоёроос доошгүй хувийг; онц хүнд гэмт хэрэгт ногдуулсан хорих ялын тавны дөрвөөс доошгүй хувийг. Цаазаар авах ял шийтгүүлж уучлагдсан, онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон, түүнчлэн гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлөөгүй этгээдэд ял эдлэхээс хугацаанаас өмнө тэнсэн суллах журмыг хэрэглэхгүй. Ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах асуудлыг хорих ял эдлүүлж байгаа байгууллагын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэнэ. Ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээдэд цагдаагийн байгууллага, цэргийн албан хаагчид цэргийн анги, нэгтгэлийн дарга хяналт тавина. Хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн сулласан явдал нь ялтныг тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах нэмэгдэл ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй. Ялтан хянан харгалзах хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг биелүүлэхээс зайлсхийсэн, захиргааны зөрчил гаргаж шийтгэгдсэн бол шүүгч цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн сулласан шийдвэрийг хүчингүй болгож, үлдсэн ялыг эдлүүлэхээр захирамж



гаргана. Ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээд хянан харгалзах хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял ногдуулах журмыг баримтлан ял ногдуулна.

- **Өвчний учир ялаас чөлөөлөх.** Шүүхийн шийтгэх тогтоол гарахын өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд сэтгэцийн өвчтэй, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, эсхүл оюун ухааны хомсдолтой болсон буюу өөр бусад хүнд өвчний улмаас сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаж буюу үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадваргүй болсон нь сэтгэцийн эмгэг судлалын шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон бол шүүх ялаас чөлөөлнө. Шүүхийн шийтгэх тогтоол гарсны дараа ялтан сэтгэцийн өвчтэй, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, эсхүл оюун ухааны хомсдолтой болсон буюу өөр бусад хүнд өвчний улмаас сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаж буюу үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадваргүй болсон нь сэтгэцийн эмгэг судлалын шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон бол шүүх ял эдлэхээс чөлөөлнө. Ялтан ял эдлэхэд саад учруулахуйц хүнд өвчнөөр өвчилсөн бол шүүх үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдлыг харгалзан ялаас чөлөөлж болно. Ял эдлэхэд саад болох сэтгэл мэдрэлийн өвчин гэдэг нь ялтан өөрийн үйлдлийг хариуцаж буюу жолоодож чадахгүй болсноос ялын зорилгыг биелүүлэх боломжгүй байдалд хүргэхийн хамт ялтныг хорих газар байлгах нь түүний өөрийн болон бусдын амь бие, эрүүл мэндэд хүнд хохирол учруулж болох сэтгэл мэдрэлийн өвчнийг ойлгоно. Ял эдлэхэд саад болох бусад хүнд өвчинд эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтанд заасан ялын зорилгыг биелүүлэх боломжгүй байдалд хүргэхийн хамт ялтныг хорих газар байлгах нь түүний эрүүл мэнд, амь биед хүнд хохирол учруулж болох бусад өвчнийг хамааруулна. Ял эдлэхэд саад болох сэтгэл мэдрэлийн буюу бусад хүнд өвчний жагсаалтыг ЭБШХ, Дээд шүүхийн тогтоолын дагуу Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дангаараа буюу эрх бүхий бусад байгууллагатай хамтран батална.

- **Шийтгэх тогтоол биелүүлэх хугацаа өнгөрсөн тохиолдолд ялаас чөлөөлөх.** Шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш дордурдсан хугацаа өнгөрсөн бол ялтны үндсэн ба нэмэгдэл ялыг эдлүүлж болохгүй: хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн боловч нэг жил өнгөрсөн; таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн боловч таван жил өнгөрсөн; таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн боловч арван жил өнгөрсөн; арван жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн боловч арван таван жил өнгөрсөн. Ялтан ял эдлэхээс зайлсхийсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсооно. Энэ тохиолдолд ялтан цагдан хоригдсон буюу өөрөө сайн дураараа хэргээ илчлэн ирсэн өдрөөс уг хугацааг сэргээн тоолно. Цаазаар авах ял ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг арван таван жил өнгөртөл биелүүлээгүй бол хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв шүүх хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрвэл тухайн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ногдуулсан цаазаар авах ялыг гүйцэтгэхгүй бөгөөд уг ялын оронд хорих ял ногдуулна. Ялтан Эрүүгийн хуульд заасан хугацаа өнгөрөөгүй байхад шинээр гэмт хэрэг үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасрах бөгөөд энэ тохиолдолд уг хугацааг сүүлчийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тоолох бөгөөд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны

эсрэг гэмт хэрэгт шийтгэгдсэн ялтанд энэ зүйлд заасан хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй.

- **Өршөөл үзүүлж эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх.** Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар өршөөл үзүүлэх нь Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарна. Улсын Их Хурлаас өршөөл үзүүлэх тухай хууль гаргаж гэмт хэрэг үйлдсэн болон ял шийтгүүлсэн хүмүүст нийтлэг шинжтэй хэрэглэнэ. Өршөөл үзүүлэх тухай хуулиар дараах асуудлыг шийдвэрлэнэ. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө. Энэ нь Өршөөлийн хууль хүчин төгөлдөр болж үйлчлэхээс өмнө үйлдэгдсэн уг хуульд заасан зарим гэмт хэргийн өрдөн байцаалт болон шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгсэхгүй болгож байгаа явдал. Гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлэн ялаа эдлэж байгаа хүмүүсийг ялаас бүрэн чөлөөлж болно. Жнь: (Гэмт хэрэг үйлдэж анх удаа хорих ял шийтгүүлсэн өөрийн шууд асрамжинд байгаа арван зургаа хүртлэх насны хагас өнчин хүүхэдтэй буюу өрх толгойлсон эмэгтэйчүүдэд ногдуулсан ялын хугацааг харгалзахгүйгээр эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялаас чөлөөлж болно). Гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлэн ялаа эдлэж буй этгээдийн ялыг хасаж болно. Шүүхээс ногдуулсан ялын зохих хувийг эдэлсэн бол хуульд заасан хэмжээгээр эдлээгүй үлдсэн ялаас хасах буюу гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийн ял шийтгэлгүй болох хугацаа, ялыг тэнсэн харгалзсан хугацаа, хорих ял ногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацааг хэрэгсэхгүй болгож болно. Өршөөл нь гэмт хэрэг үйлдсэн этгээд болон ялтанг эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх үндэслэл болно.
- **Уучлал үзүүлж ялаас чөлөөлөх.** Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар уучлал үзүүлэх нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхэд хамаарна. Уучлал үзүүлэх тухай Ерөнхийлөгчийн зарлиг гарч тодорхой этгээдэд ганцаарчлан үзүүлнэ. Уучлал үзүүлэх зарилгаар дараах асуудлыг шийдвэрлэнэ: Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучлах, гэмт хэрэг үйлдэж ял эдлэж байгаа этгээдийг ял эдлэхээс бүрмөсөн чөлөөлөх, ял эдлэж байгаа этгээдийн ялаас хасах, ял эдэлсэн этгээдийн ял шийтгэлгүй болох хугацааг хэрэгсэхгүй болгох.

Ялтай байдал Гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэний дараа уг этгээдэд тодорхой хууль зүйн үр дагавар бүхий эрх зүйн байдал үүсдэг. Үүнийг ялтай байдал гэх бөгөөд эрүүгийн ялын цээрлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоос үүдэлтэй нөлөөллийн арга хэрэгсэл юм. Хууль зүйн үр дагавар бүхий эрх зүйн байдал буюу ялтай байдал:

- хариуцлагыг хүндрүүлэх;
- ялын дэглэмийг тодорхойлох;
- онц аюултай гэмт хэрэгтэнээр тооцох;
- эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх журмыг хэрэглэх үндэслэл болно.



Гэмт хэрэгт ял шийтгүүлсэн ялтан дараах тохиолдолд ялгүй болно

Тэнсэж хянан харгалзсан, хорих ял ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдээгүй
Хөнгөн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээд ялаа эдэлж дууссанаас хойш нэг жилийн дотор гэмт хэрэг шинээр үйлдээгүй
Хүндэвтэр гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээд үндсэн ба нэмэгдэл ялаа эдэлж дууссанаас хойш таван жилийн дотор гэмт хэрэг шинээр үйлдээгүй
Хүнд гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээд үндсэн ба нэмэгдэл ялаа эдэлж дууссанаас хойш найман жилийн дотор гэмт хэрэг шинээр үйлдээгүй
Онц хүнд гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээд буюу онц аюултай гэмт хэрэгтэн үндсэн ба нэмэгдэл ялаа эдэлж дууссанаас хойш арван жилийн дотор гэмт хэрэг шинээр үйлдээгүй



Анхаарах зүйл

Эрүүгийн хуулиар тогтоосон журмын дагуу ялаас хугацааны өмнө суллагдсан этгээдийн ялгүй болох хугацааг үндсэн ба нэмэгдэл ял эдлэхээс чөлөөлөгдсөн үеэс тоолно.

Ялаа эдэлж дууссан этгээд ялгүй болох хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдвэл ялгүй болох хугацаа тасрах бөгөөд сүүлчийн гэмт хэрэгт ногдуулсан үндсэн ба нэмэгдэл ялыг эдэлж дууссаны дараа түрүүчийн гэмт хэрэгт ялгүй болох хугацааг хамтатган эхэлж тоолно. Тэгэхдээ аль хүнд ялтай хэрэгтээ ялгүй болох хугацаа дуустал уг этгээд аль алинд нь ялтайд тооцогдоно.



Хяналтын асуулт

1. Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай ойлголтыг тодорхойлж, төрлүүдийг нэрлэ
2. Ялаас чөлөөлөх тухай ойлголтыг тодорхойлж, төрлүүдийг нэрлэ
3. Эрүүгийн хариуцлагаас болон ялаас чөлөөлөхийн ялгаатай талыг тодорхойл
4. Эрүүгийн хариуцлагад татаж болохгүй болон шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааг нэрлэж, ялгааг гарга
5. Өршөөл, уучлалаар ялаас чөлөөлөхийн төсөөтөй болон ялгаатай тал
6. Хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах үндэслэл, журмыг тодорхойл
7. Ялтай байдлын эрүүгийн болон эрх зүйн бусад үр дагаврыг нэрлэ.
8. Ялгүй болох болон ялгүйд тооцохын ялгаатай талыг тодорхойл
9. Хохирогчтой эвлэрсэн үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх журмыг ямар хэрэгт хэрэглэж болохгүй вэ?
10. Эрүүгийн хуулийн 73-р зүйлд заасан цаг үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөн гэдэгт юуг ойлгох вэ?



Сорил

1. **Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх төрөл (хамааралтайг ол):**
 - a. Хугацаанаас өмнө тэнсэн суллах
 - b. Өвчний улмаас чөлөөх
 - c. Хохирогчтой эвлэрсэн
 - d. Цаг үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй холбоотойгоор
 - e. Үйлдсэн гэмт хэргээ илчилж ирсэн
2. **Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш доорх хугацаа өнгөрсөн тохиолдолд эрүүгийн хариуцлагад татаж болохгүй:**
 - a. Хоёр жил
 - b. Таван жил
 - c. Арван жил
 - d. Арван таван жил
3. **Хүнд гэмт хэрэгт хорих ял шиттэгдсэн ялтанг хугацаанаас өмнө тэнсэн суллахад:**
 - a. Оногдуулсан ялын гуравны нэгээс доошгүй хувийг эдэлсэн байх шаардлагатай
 - b. Оногдуулсан ялын хоёрны нэгээс доошгүй хувийг эдэлсэн байх шаардлагатай
 - c. Оногдуулсан ялын гуравны хоёроос доошгүй хувийг эдэлсэн байх шаардлагатай
 - d. Оногдуулсан ялын тавны дөрвөөс доошгүй хувийг эдэлсэн байх шаардлагатай
4. **Торгох ял шийтгүүлсэн этгээдийн ялгүйд тооцогдох хугацаа:**
 - a. Торгууль төлсөнөөр
 - b. Ялаа эдлэж дууссанаас хойш 1 жил өнгөрсөн
 - c. Ялаа эдлэж дууссанаас хойш 5 жил өнгөрсөн
 - d. Торгуульд ялгүйд тооцох хугацаа байдаггүй
 - e. Ямар гэмт хэрэгт уг ялаар шийтгүүлснээс хамаарна.
5. **Дараах тохиолдолд хохирогчгой эвлэрсэн гэх үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно:**
 - a. Анх удаа гэмт хэрэг үйлдсэн
 - b. Хохирогчоос уучлал гуйсан
 - c. Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн
 - d. Бүх хариулт буруу
6. **Хэргээ илчлэн ирвэл эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх гэмт хэрэг**
 - a. Хөнгөн
 - b. Хүндэвтэр
 - c. Хүнд
 - d. Онц хүнд



ДАСТАЛ 2. ЯЛ НОГДУУЛАХ ЖУРАМ

(Тохиолдол шинжлэх)

- Тохиолдол 1. Олон хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэй “Ө” амьдралын эрхээр бусдын аар саар эд зүйлийг хулгайлан амьдардаг байв. Энэ талаар түүний хөршүүд хэсгийн байцаагчид удаа дараа гомдол мэдүүлсэний дагуу түүнд эрүүгийн хэрэг үүсгэн гэрт нь нэгжлэг хийх болсон. Нэгжлэгийн үеэр “Ө”-н гэрээс дүүргийн тамгын газраас 1997 оны эхээр алдагдсан зарим эд зүйлс олдсон ба дээрх хулгайн гэмт хэргийг үйлдсэн болохоо хүлээжээ. Тухайн үед дүүргийн ЗДТГ-н байрнаас 2 сая орчим төгрөгийн эд зүйлс алдагдаж ЭХ-н 123.4 дэх хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг үүсгээд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэсэн үндэслэлээр түдгэлзүүлсэн хэрэг баисныг “Ө”-н хэрэгтэй нэгтгэн шалгаж яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорт шилжүүлсэн. “Ө”-н өмгөөлөгч прокурорт хандан гаргасан хүсэлтэндээ ...өмнөх хулгайн хэрэг нь 1997 оны өршөөлийн хуульд багтаж байгаа тул хэрэгсэхгүй болгож өгөхийг хүсчээ.
- Тохиолдол 2. “Нарантуул” зах дээр 15 настай Н, 16 настай “А” нар нь бүлэглэн иргэн “Б”, “М” нарын халаас болон цүнхнээс 300000 мянган төгрөг, гар утасыг нь хулгайлсан гэмт хэрэг үйлдэж баригдсан байна. Шүүхээс тэдний хэргийг ЭХ-ийн 145-р зүйлийн 145.2-р зүйлчлэн ЭХ-ийн ЕА-ийн 69-р зүйлийн 69.1.3-ийг журамлан ял оногдуулалгүйгээр тэднийг эцэг эхийх нь хяналтанд өгөх хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авчээ. Хохирогч “Б”, “М” нар нь шүүх “Н”, “А” нарт зохих ёсны ял оногдуулаагүй энэ арга хэмжээ нь хэт хөнгөдсөн гэдэг үндэслэлээр гомдол гаргажээ.
- Тохиолдол 3. Х гэгч нь 2002.07 сард бусдын 3 сая төгрөгийг залилж авсан гэмт хэрэг үйлдсэн. Түүнд холбогдох хэргийг 2002.09.15-ны өдөр шүүхээр шийдсэн бөгөөд энэ үед “Х” нь гэмт хэргийн хохирлын мөнгөнөөс 1 сая төгрөгийг барагдуулаагүй байсан. Шүүх түүнд 2 жилийн хорих ял оногдуулсан ба тэрээр 1 жил ялаа биечлэн эдэлсний дараа ялын Эрүүгийн хуульд заасан зохих хувийг эдэлсэн учир хугацааны өмнө тэнсэн суллаж өгнө үү гэж ял эдлэж байгаа хорих ангийн удирдлагад хүсэлт тавьсан.
- Тохиолдол 4. “Б” гэгч нь бусдын эд хөрөнгийг булаасан гэмт хэрэг үйлдэж 2 жилийн хорих ялаар шийтгүүлж шүүхээс оногдуулсан ялын тал хувийг биечлэн эдэлсний дараа хорих ялаас 8 сарын өмнө тэнсэн суллагдсан. Тэнсэн суллагдсан ялын хугацаа дуусаагүй байхад “Б” нь хүний бие махбодид санаатай хүнд гэмтэл учруулсан гэмт хэрэг үйлдэж 6 жилийн хорих ялаар шийтгүүлсэн. Тэрээр ял эдлэж байхдаа хорих ангийн мод бэлтгэдэг хөрөө раман дээр ажилладаг

байсан бөгөөд хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлыг өөрөө хангаж ажиллаагүйгээс болж нэг нүдээ гэмтээж тэр нь хараагүй болсон. Улмаар энэ нь нөгөө нүдэнд нь нөлөөлж түүний 2 нүд нь бүрмөсөн сохорсон. Энэ үед “Б” нь ялын хугацаанаас 2 жилийг биечлэн эдэлсэн байжээ.

Тохиолдол 5. 1987 онд Улаанбаатар хотын Найрамдалын районы нутаг дэвсгэрт Гутлын үйлдвэрийн ажилчин “Ж” нь орой ажлаасаа тарж яваад бусдад хутгалуулан амь нас нь хохирсон гэмт хэрэг гарсан байна. Энэ хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан боловч уг хэргийг үйлдсэн этгээдийг олж чадаагүй байсан. Харин дээрх хэргийг тухайн үед хорих ангиас суллагдаж гарсан “Н” гэгч нь хохирогчийг дээрэмдэх явцдаа алсан болохыг нь 2003 онд илрүүлж тогтоожээ. Гэмт хэрэг илрэх үед “Н” нь 65 настай байсан.

Тохиолдол 6. Хулгайн гэмт хэрэг үйлдэж хорих ял эдлэж байсан ялтан “У” нь 2003 оны 09 сарын 10-нд хорих ял эдлэхээс 6 сарын өмнө тэнсэн суллагдсан. Тэрээр тэнсэн суллагдсан хугацаа дуусаагүй байхад буюу 2004 оны 3 дугаар сарын 20-нд дахин хулгайн гэмт хэрэг үйлдэж сүүлчийн үйлдэлдээ шүүхээр 3 жилийн хорих ял шийтгэсэн.